1949 оны тэргүүн хагаст манай улсын зүүн өмнөд хязгаараар Хятадын гоминданы болон Японы байгуулсан Да вангийн армийн цэргүүд манай улсын хилийг хаагуур ч хамаагүй зөрчих, хилийн манаатай буудалцах явдлууд гаргасаар байлаа. Харин 1949 онд нэг удаа хилийн эрэл явагдсан байдаг.

Баруун зүгийн хилд мөн тийм байсан боловч Байтагийн будлианы үеэс эхлэн хилийн эрэл явагдсан юм.

Баруун хязгаарт явагдсан хилийн эрлүүдээс дөрвөн зүйлийн сургамж харагдсан байдаг.

Нэгдүгээрт: -хилийн зөрчлийн мэдээ хугацаа хоцорч ирэх, холбоо хангалтгүй, мэдээ тодорхой биш байх, хилийн зөрчлийг илрүүлсэн тэр чиглэлийн заставууд хил зөрчигчийг мөрдөх, эрэх ажил зохиодоггүй байлаа.

Хоёрдугаарт: -нэгэнт үүссэн цагийн байдлыг бүрэн судалж, дүгнэж, үнэлж, оновчтой, зөв шийдвэр гарган ажиллах удирдлагын дадлага, туршлага туйлын дутмагаас нэн хохиролтойгоор (дайсан) хил зөрчигчдийг буцааж алддаг байсан.

Гуравдугаарт: -бүлгүүдийн хурдан шуурхай ажиллагаа хангалтгүй байснаас хил зөрчигчдийг гүйцэж ажиллахгүй байсан.

Дөрөвдүгээрт: -дотоодоос гадагш гарах гэсэн хил зөрчигчид (оргодлууд, урвагчид, тагнуулчид)-тай хийх тэмцэлд бүр ч их хохирол үзсэн юм.

...Манай Хилийн Цэргийн хэмжээнд тэр үед хилийн эрэл явуулж байсан туршлагаас үзэхэд хилийн ангиуд нь:

1. Хил зөрчигчийг мөрдөх,
2. Хил зөрчигчийн явж болзошгүй чиглэлийг хаах,
3. Байж болзошгүй хэсгийг нь бүслэн хаах,
4. Энэ бүслэн хаасан хэсэг дотроо эрлийн олон тооны бүлгүүдийг явуулж хил зөрчигчийг эрэх,
5. Хил зөрчигчийн байгаа газар нь мэдэгдсэн тохиолдолд эргэн тойронд нь бүрэн бүслэх ба саатуулан баривчлах зэрэг цэргийн ажиллагааны аргуудыг хэрэглэж ирсэн байна.

Хил хамгаалах алба бол хилийн

зөрчлийг илрүүлж, мөрдөн хөөж саатуулснаар зорилгоо биелүүлж байдаг учраас өдөр тутмын хил хамгаалалт, хилийн эрэл хоёр бол нэг ажлын хоёр тал гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл нэг зоосны хоёр тал билээ.

Улсын хил хамгаалалтын чанар үр дүн нь Монгол Улсын хил хязгаарыг зөрчилгүй байлгах, гарсан зөрчлийг цаг тухайд нь илрүүлэн хууль зүйн дагуу шийдвэрлэж, таслан зогсоох, үүргээ хир зэрэг биелүүлж байгаагаар хэмжигдэнэ.

Улсын хил дээр гарсан зөрчлийг цаг тухайд нь илрүүлэхийн тулд хилийн отряд, тусгай анги, салбарууд нь улсын хилийн хамгаалалтыг газар дээр нь тасралтгүй зохион байгуулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хилийн зөрчил гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох арга хэмжээ авч байх ёстой бөгөөд энд л хилийн эрэл чухал үүрэгтэй билээ.

Хил хамгаалах удирдамж шийдвэртээ үндэслэн эрлийн ажиллагааны урьдчилсан төлөвлөгөө гаргадаг нь 1989 онд улсын хил зөрчигчдийг найдвартай илрүүлэн саатуулахын тулд хилийн эрлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн түүхэн уламжлал байна.

Зах зээлийн үеийн нийгмийн үед буюу 1990-ээд оны эхний жилүүдэд Монгол-Хятадын хил дээр хилийн цагийн байдал нилээд тайван тогтвортой байсан боловч хилийн зөрчлийн тоо улам бүр нэмэгдсээр байжээ. Үүнийг 10 жилийн өмнөх 1980-аад оны үетэй харьцуулахад хил зөрчин саатуулагдсан хүний тоо олон дахин нэмэгдэж манай улсаар дамжин гуравдагч орон руу гарах суваг болгон ашиглах, эрүүгийн гэмт хэрэг өдүүлсэн зарим этгээдүүд хуулийн хариуцлагаас зайлах зорилгоор улсын хил зөрчих, зөрчихийг завдах зэрэг хэлбэрийн хилийн зөрчлүүд гарах магадлал бий болсон. Энэ мэтчилэн улсын хилийн гадаад, дотоод нөхцөл, хилийн цагийн байдлын өрнөл түүнд орсон өөрчлөлт, хил зөрчих явдал ихсэж байгаатай холбоотойгоор зэргэлдээ улсуудын хил хамгаалах байгууллагуудтай хамтарч буюу харилцан ажиллах явдал өсч манай удирдах газар, хилийн отряд, заставуудаас хил зөрчигчийг саатуулах болон хилийн эрлийн ажиллагаанд бэлэн байх шаардлага, ач холбогдол эрс нэмэгдсээр ирсэн. Үүнтэй холбогдуулан манай яам, командлал бэлэн байдалд ялангуяа эрлийн урьдчилсан ажиллагаанд онцгой ач холбогдол өгч, бэлэн байдлын удирдамж, үнэлэх заавар, сургуулийн программд тодотгол хийж, эрлийн сургуулийг ангиудад янз бүрийн хэлбэрээр явуулж байсан байна.

Хилийн Цэргийн хэмжээнд 1980 оны эхэн үед болон сүүлийн гурван жилд 10 гаруй удаа томоохон хилийн эрэл явагдаж, үр дүнгээ өгсөн байна. Жишээлбэл: -1982-1983 онд гурван аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан томоохон хэмжээний хилийн эрэл явагдсан нь хуулийн хариуцлагаас зайлсхийсэн оргодол этгээд Шаазанхүүг баривчилсан хилийн эрэл билээ. 1982 онд дуусч, 1983 оны шинэ жил гарах гээд Овоотын отрядынхон шинэ жилийн бэлтгэлээ базаагаад тун завгүй байлаа. Ийнхүү завгүй байх арванхоёрдугаар сарын 30-ны үдээс хойш Хилийн ба Дотоодын цэргийг удирдах ерөнхий газраас тушаал ирэв. Танай отрядын баруун хэсгээр дотоодоос улсын хил зөрчиж болзошгүй тул заставуудаа

хүчлэн хамгаалалтанд шилжүүлэн, эрлийн ажиллагааг газар дээр нь зохион байгуулах оператив бүлгийг томилж, Зам бэлгэхийн заставт ажиллуул гэсэн байлаа. Отрядын дарга, хурандаа Ц.Дашням ээлжийн амралттай учир штабын дарга, ахмад Х.Ранжинням орлож байв. Тиймээс улс төрийн хэлтсийн дарга, ахмад Ц.Дамцагдорж миний бие отрядын оператив бүлгийг удирдах болов. Ингээд тусгай ангийн төлөөлөгч, ахмад Н.Очирдарь, нэгдүгээр тасгийн туслах, дэслэгч Ж.Бакет, холбооны хөдөлгөөнт зангилааны машины жолооч байлдагч Банзрагч, холбоочин, бага түрүүч Алтангэрэл нарын хамт 31-ний 01.40 цагт Зам бэлтгэхийн застав руу гарлаа. Улмаар өдрийн 15.00 цагт зорьсон газраа очсон юм.

Арванхоёрдугаар сарын 26-27-нд шилжих шөнө Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг Идрэнгийн нурууны Улаантолгойд өвөлжиж байсан Баярмагнай гэдэг айлын гаднаас тохоштой хоёр тэмээг нэг явган хүн хулгайлан авч, хилийн зүг явсныг тогтоолоо. Улмаар сумын удирдлагад хэл яаравчлан хүргүүлэв. Сумын намын үүрийн дарга Бор, хэсгийн төлөөлөгч Цэрэндоо нар Халзангийн нуруу хүртэл мөрдөөд орхилоо. Дараа нь аймгийн нийгмийг аюулаас хамгаалах хэлтэст мэдэгдэж улмаар Хилийн цэргийн командлалд энэ мэдээ хүрч манай отряд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин, эрлийн цагийн байдал үүссэн юм. Энэ үед Алтайн отрядоод Хилийн хэлтсийн дарга, хурандаа Д.Шажинбат, зургалаач Зундуй, Пүрэв яруу найрагч С.Оюун, Ми-8 нисдэг тэрэгний багийн ахлагч, хошууч П.Пүрэв, хоёрдугаар нисгэгч Ц.Чулуунбаатар, ерөнхий инженер, дэд хурандаа Ш.Барс, техникч, ахлах дэслэгч Г.Ганболд нар Хилийн цэргийн тухай баримтат кино хийж таарсан юм. Ингээд энэ баг Говь-Алтай аймгийн төвөөс хөөрч Атас Ингэс уул, Шар хулстай, Цагаан бургасны баян бүрдийн орчим үзлэг хийж агааранаас тандалт хийсэн боловч юм илэрсэнгүй. Бид цагийн байдлыг ажиглан заставын хилд нэмэгдэл манаа гаргаж, зарим өндөрлөгт хянах манаа, Данхын сайр, Булган хошууны чиглэлд шалгах манаа томилж 31-нийг дуусгалаа. Шинэ он ч гарав. 1983 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр хилийн дугаар заставын эрлийн бүлгийг ахлах дэслэгч П.Батмөнх удирдан тус заставын заагт үзлэгт шалгалт хийв. Орой нь Баянхонгор аймагт ажиллаж явсан тусгай ангийн дарга, хошууч О.Базаррагчаа, Баян-Өндөр сумын намын үүрийн дарга Бор, хэсгийн төлөөлөгч Цэрэндоо газарч нарын хамт застав ирж оргодол этгээдийг мөрдөн, мөрийг Шар хулстай руу оруулж орхилоо. Айлын илүү гэрээс шуудай борц, цагаан тос, дах хулгайлж авсныг илрүүлж мэдэв. Улмаар хэт өлсөж явснаа гэнэт мах, тос идэж гүйлгэн ойр ойрхон бууж яваагч нарийн мэдээлсэн юм. Энэ үед отрядоос ангийн техникийн орлогч, ахлах дэслэгч Ж.Ганжирваа, нэгдүгээр тасгийн дарга, ахмад Ю.Нямдорж, хоёрдугаар тасгийн дарга, ахмад Г.Базарсад, холбооны дарга, хошууч Ц.Санзайдорж, тээвэр хотын техникийн орлогч, ахлах дэслэгч Х.Халх нар 60 гаруй цэргийн хамт Зам бэлгэхийн заставт хүч нэмэгдүүлж ирсэн юм. 2-ны өдөр гурван эрлийн бүлгийг томилж ажиллууллаа. Алтайн отрядоос нисдэг тэрэгний түлш ирмэгц хурандаа

Д.Шажинбат нисдэг тэргээр хайлт явуулахаар тогтож ийнхүү бүлгүүд тус тусын хариуцсан чиглэлд гарсан юм. Шар хулстай, Баянбүрд, Зам бэлгэхийн заставаас 60 километрийн гүнд байх бөгөөд хошууч О.Базаррагчаагаар ахлуулсан хэсэг гарсан байв. Өдөр 12.00 цагийн орчим Шар хулстайн нуруу Ингэс уулын заагаар даван ар бэл рүү ортол хоёр тэмээний мөрийг манай ГАЗ-66 машинтай ахлах дэслэгч П.Батмөнхийн ахалсан бүлэг мөрдөн хөөснийг олж илрүүлэв. Гэвч Атас уулын савд орохтой зэрэгцэн бензин дуусч, Тооройн нуруунд бидний эрэл мухардав. Өглөө нар ургасны дараа нисдэг тэрэгтэй холбоо тогтоовол оргодлыг барьсан байлаа. Энэ эрлийн ажиллагаанд Хилийн ба Дотоодын цэргийн удирдах ерөнхий газар, Баянхонгор аймгийн Нийгмийг аюулаас хамгаалах хэлтэс, хилийн отрядын 190 хүн 12 мянга шахам цаг үүрэг гүйцэтгэж, 18 радио станц, 15 машин, 40 уналгын тэмээ, нисдэг тэрэг оролцсон 17.550 квадрат метр нутаг дэвсгэрт эрлийг явуулсны үр дүнд барьж авсан юм. Увс аймгийн Цагаан Хайрхан сумын харъяат тус этгээд 1980 онд 40 гаруй бодын хэргээр Өвөрхангай аймгийн Хархоринд ял эдэлж байгаад 1981 оны 8-р сард оргожээ. Улмаар Өвөрхангай, Архангай аймгийн заагт орогнож байгаад Баянхонгор аймгийн нутагт орж ирэн морьтой явж байгаад явгалж, айлаас хоёр тэмээ хулгайлан унаж улсын хил даван гадаадад гарахыг завдсан Гүнсэнжавын Шаазанхүү гэгч байсан аж. Түүнийг хилийн шугамаас 44 километрийн гүнд байхад нь нисдэг тэргээр илрүүлэн баривчилсан юм. Энэ эрлийн ажиллагаанд амжилттай оролцогчдыг Хилийн цэргийн даргын 1983 оны 16 тоот тушаалаар шагнаж урамшуулсан билээ. Техникийн орлогч Ж.Ганжирваа, эрлийн бүлгийг зөв сайн удирдсан заставын дарга П.Батмөнх, Зам бэлгэхийн заставт ганцаараа ажиллаж байсан заставын туслах Б.Чулуунбаатар нарт ахмад цолыг хугацааны өмнө олгов. Мөн ахмад Ю.Нямдорж, Г.Базарсад, байлдагч Ц.Ганболд, Борчулуун, Болдбаатар нарт "Онц хилчин" тэмдэгээр байлдагч Баяртогтох, Моломцэнд нар орон нутгийн 10 хоногийн чөлөөгөөр, ахмад Н.Очирдарь, балдагч Гансүх, Банзрагч, ахлах түрүүч Со.Баатар, Пүрэвдорж, байлдагч Баясгалан бид нар сайшаалын үнэмлэхээр шагнагдаж байлаа хэмээн ахмад хилчин бэлтгэл хурандаа Ц.Дамцагдорж гуай "Эх орны манаа" сонинд өгсөн ярилцлагадаа тодорхой дурьдсан нь энэ бөлгөө.

Монгол-Зөвлөлтийн хил дээр хоёр талаас хамтарч хилийн эрэлд бэлтгэх эрлийн урьдчилсан ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, түүний дагуу амжилт олсон баримт ч олон бий.

Манай Хилийн Цэргийн анги, салбарууд хилийн эрэлд туршлагажиж амжилт олж байсан удаа их бөгөөд хил дээр үүсч бий болоод байгаа бодит цагийн байдал нь хилийн эрлийг жинхэнэ ёсоор зохион байгуулан явуулахын тулд түүнд цаг ямагт бэлтгэлтэй байхыг шаардаж, хүч хэрэгслийн өсөн нэмэгдсэн боломж нь ч хилийн анги, салбарууд эрлийг явуулж чадах чадвартай болоод байгааг харуулж байна.

Бас алдаа дутагдал гаргаж байсан нь ч цөөнгүй бөгөөд гол нь эрлийн ажиллагаанд бэлэн бус төдийгүй өрөөсөө

эрэл урьдаас зохион байгуулагдаагүй байсанд гол алдаа байсан.

Иймд хилийн эрэлд жинхэнэ шинжлэх ухааны үндэслэлтэй, бүтээлч бэлтгэж, түүнийг сайн зохион байгуулан удирдаж, явуулах нь Хилийн Цэргийн командлал, анги, салбарын удирдлага, нийт хилчин офицеруудын тулгамдсан асуудлын нэг билээ.

Би, "Оператив чиглэлд хилийн эрэл явуулахажиллагаагболовсронгуйболгох нь" сэдвээр докторын зэрэг горилсон судалгааны ажил хийж байгаагийн хувьд ...миний бие Сүхбаатар аймгийн Онгон сум дах ХЦ-ийн 0184, Дорноговь аймгийн Хатанбулаг сум дах ХЦ-ийн 0168, Дорнод аймгийн Халх гол сум дах ХЦ-ийн 0198 дугаар ангиудад ...хилийн заставын дарга, отрядын штабын хил хамгаалалтын тасгийн дарга, захирагчийн нэгдүгээр орлогч штабын даргаар тус тус томилогдон ажиллаж байх хугацаандаа хэд хэдэн хилийн эрэл зохион байгуулж, явуулах явцад хуримтлагдсан туршлага, сургамж, хилийн эрэл явуулахад анхаарах зарим практик асуудлын талаар ХСИС-ийн ХС-ийн "Хил судлал" сэтгүүлийн 2014 оны 03-04/39-40 "Хилийн эрэл зохион байгуулж явуулсан туршлага, сургамжаас өгүүлэх нь-1", ХХБ-ын "Хилчин" сэтгүүлийн 2014 оны 10 дугаар сар №10 (73) дугаарт "Хилийн эрэл зохион байгуулж явуулсан туршлага, сургамжаас өгүүлэх нь-2", ХСИС-ийн УС-ийн "Хууль сахиулахуйн удирдлага" сэтгүүлийн 2014 он 12 дугаар сарын №4,5 дугааруудад "Хилийн эрэл зохион байгуулж явуулсан туршлага, сургамжаас өгүүлэх нь-3" зэрэг сэдэвт нийтлэлүүдийг бичсэн болно.

СОЛОНГОСЫН ХОЙГ ДАХЬ БОЛЗОШГҮЙ ДАЙНЫ ТАЛААРХ ТААМАГЛАЛ

Д.Жавхлант. Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, Аюулгүй байдлын ухааны магистр, дэд хурандаа

Солонгосын хойгийн цэрэг, улс төрийн хамгийн хурцадмал хэлбэр бол хоёр Солонгосын хооронд дайн гарах, түүнд том гүрнүүд өөрсдийн эрх ашгийг хамгаалан оролцох явдал юм.

Хэрэв дайн гарвал Өмнөд Солонгос, Японы энгийн хүн амыг хамгаалах асуудалд илүү түлхүү анхаарах шаардлагатай гэж Оросын технологийн төвийн шинжээч Василий Кашин үзэж байна.

Мөн тэрээр Умардын хамгаалалтыг төдийлөн сайн биш, мөргөлдөөний үед өөрийгөө хамгаалах бодит боломжууд нь хязгаарлагдмал гэж үзэж байна.

Ихэнх шинжээчдийн үзэж байгаагаар хэрвээ Солонгосын хойгт мөргөлдөөн гарвал Умард Солонгос Америкийн агаарын цохилтуудад өртөх бөгөөд хэдхэн хоногийн дотор холбооны бүх системүүд эвдэрч, цахилгаан гэрэл тасарч, удирдлагын бүх хэрэгслүүд жагсаалаас гарч, тээврийн хэрэгслүүд зогсоно гэж үзэж байна.

Судлаачийн байр суурьнаас харахад хүчтэй бүслэлтэд орсон Солонгосчууд өлсгөлөнд нэрвэгдэх агаад дүрвэгсдийг Хятадын нутгаар дамжуулан Монгол руу оруулах аюул нүүрлэж болзошгүй юм.

Ингэхдээ Хятад өөрөө олон улсын өмнө энэ ажиллагаанд оролцоогүй мэт дүр эсгэж Орос, Монгол руу Солонгосын дүрвэгсдийг илгээх магадлал бий юм. Сүүлийн жилүүдэд бага багаар монголд дүрвэгсэд оруулж "энэ ажиллагааны" бололцоог туршсаар байгаа билээ.

Нөгөө талаас Умард Солонгос нь "Коксан" их буугаар Сөүлийн дүүргүүдэд цохилт өгөх боломжтойн дээр "Нодон", "Scud", "Точка" загварын пуужингуудаар 120 км хүртэлх зайд цохилт хийж эдийн засгийн асар их хохирлыг учруулах боломжтой.

Гадаадын мэргэжилтний үзэж байгаагаар эдгээр пуужингууд нь цэц муутай боловч унасан газартаа энгийн иргэдэд хохирол учруулах магадлалтай ажээ.

Хэрэв дайн эхлэвэл Умард Солонгосын гэнэтийн цохилтоор эхлэж болзошгүй. Учир нь дайнд давуу байдал олж авах ганц боломж байгаа бөгөөд тэр нь Америкийн цэргийн болон Өмнөдийн цохилтын хүчийг "түрүүлж дарж авах" явдал юм.

Түрүүлж дарахын тулд радио электрон тэмцлийн хэрэгслийн хүчийг бүрэн дэлгэж Америк, Өмнөдийн холбоо, удирдлагын хэрэгслийг радио долгион илгээх замаар жагсаалаас гаргах шаардлагатай.

Үүний зэрэгцээ эсрэг талын пуужингийн баазууд, нисэх онгоцны буудал, нисэх онгоц тээгч хөлөг онгоцууд, тэдний удирдлагын системийг гэмтээх зорилгоор маш олон тооны пуужингийн цэцэн цохилтуудыг хийх шаардлагатай.

Энэ олон мэргэн цохилтуудыг хийхийн өмнө цохилт хийх газруудыг цэргийн тагнуул илрүүлэх ёстой. Умардын цэргийн тагнуулыг 50 гаруй жил Өмнөдийн болон Америкийн эсрэг ажилласан их мэдээлэлтэй гэж үзвэл дээр хэлсэн бүхэн биелэх боломжтой.

Түүнчлэн хоёр этгээдийн цохилтууд нь цөмийн эрчим хүчний болон химийн аж үйлдвэрийг онож экологийн сүйрэлд хүргэж болно. Умардын нэг давуу тал нь олон арван жилээр дайнд бэлтгэж, газар доогуур байгууламжуудыг барьж бүхэл бүтэн сүлжээг бий болгожээ.

Эдгээр нь хангамжийн баазууд, хүн амын хоргодох байрууд юм. Мөн түүнчлэн байлдааны ажиллагаа Умардын нутагт өрнөвөл Өмнөдийн тал ихээхэн хохирол амсах магадлалтай.

Учир нь Умард олон арван жилээр дайнд бэлтгэж олон тооны бэхлэлтийг барьж байгуулжээ. Түүнчлэн Умард улархаг газар байлдах зориулалт бүхий 200 гаруй мянган хүнтэй "Уулын хөнгөн явган цэргийн ангиудтай" юм.

Умардын цэргүүдийн сэтгэл санаа ямар байх нь тодорхойгүй хүчин зүйл хэвээр байна. Гэхдээ цэргүүд оргон зайлах болон ухран зугатаах бодолтой байна гэж хэлэх үндэс байхгүй.

Тэд түгжигдмэл амьдралтай учир Өмнөдийн "хангалуун" амьдралыг үзээгүй юм. Хэрэв үзсэн бол түүн лугаа тэмүүлэх ч байсан байж болзошгүй.

Тэр тэмүүлэл нь оргон зайлах үндэс суурь болох ёстой байсан биз. Хэрэв дайн өдүүлвээс Умардын хувьд энэ нь ердөө л ялагдлын эхлэл болох бүрэн магадлалтай.

Харин Умардынхан цохилт өгөхөөр сүрдүүлж хүнс тэжээл, гадаадын тусламж дэмжлэг олж авдаг аргад дадлагажиж байгаа гэж хэлж болохоор байна.

Өмнөдийн болон Америкийн хувьд

болзошгүй дайн олон мянган цэрэг, иргэдийн амийг авч одохын дээр дайны зардал сүйтгэл гээд эдийн засгийн хохирол амсахаар байгаа юм.

Олон мянган цэрэг, иргэдийн амь нас гэдэг үгийн цаана Америкийн улс төрийн бодлогод итгэх итгэл алдрах асуудал бий. Энэ нь АНУ-ын хувьд дайнд ялагдсанаас өөрцгүй, олон арван жилээр ганцаар эх дэлхий дээр тэргүүлж байсан АНУ-д Хятад гэдэг нэн аюултай өрсөлдөгч гарч ирээд байхад АНУ эдийн засгийн хүч нөөцөө Солонгосын хойг дээр барж үрэх ёсгүй билээ.

АНУ-ын цэргийн хүч, хурд, чадвар нь эх дэлхий дээр тогтоон барих хүч болсоор байна. Энгийн үгээр хэлвэл АНУ-ын тэргүүлэх хүч нөөц шавхагдвал энэ дэлхий дээр олон улс орон өөр хоорондоо зөрчилдөж, онцгой нөхцөл байдал үүсгэх нь олон зүйл дээр харагддаг.

Байлдааны ажиллагаа нь Орос, Хятад хоёрын амин чухал эрх ашгийг хөндөх бөгөөд энэ хоёр улс өөрсдийн "бөөрөн дор" АНУ-ын цэргийн хүч орж ирэхийг яавч зөвшөөрөхгүй нь мэдээж юм. Ийм учраас Солонгосын хойг дээр зэвсэгт тэмцэл өрнөвөл Орос, Хятад хоёр ил, далд "өөрсдийн халхавч" улс болох Умардыг дэмжинэ гэдгийг өмнөх дайны туршлага, сургамж харуулж байна.

Дэмжлэг нь олон янз байж болно. Улс төрийн төвшинд дайн гаргуулахгүй байхын төлөө, эдийн засгийн төвшинд Умардад зээл, тусламж өгөх, цэргийн зэвсэг, байлдааны техник, сум, галт хэрэгслийг ч нууц байдлаар өгөх нь гарцаагүй.

Дайн бүхэлдээ Зүүн Хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдалд ноцтой хор уршиг авчрахын зэрэгцээ хоёр Солонгосын хувьд нөхөж баршгүй хүнд хохирол авчрах болно. Хоёр Солонгосын аль нь ч асуудлыг шийдэх арга зам биш гэдгийг ойлгож байгаа.

Ингэхээр дайн гарах магадлал тун бага байна. Үүнийг Умардынхан сайтар тооцоолж байгаа учраас "хүчтэй сүржигнэж" байж болох юм.

Хоёр талын энх тайванч яриа хэлцэл, гэрээ, хэлэлцээр

БНАСАУ үндсэн хуулийнхаа 9-р зүйлд "...эх орноо бие дааж, энх тайвны замаар нэгтгэхийн төлөө тэмцэнэ" гэсэн бол БНСУ Үндсэн хуулийнхаа 4-р бүлэгт "...Чөлөөт ардчилалын үндсэн зарчимд нийцүүлэн энх тайвны замаар нэгтгэх бодлого баримталж, энэ зорилтыг урагшлуулна" хэмээн тус тус заасан байна.

Өнгөрсөн жилүүдэд Умард, Өмнөдийн талууд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад харилцааны болон Дэд бүтцийн сайд нарын өндөр хэмжээнд олон удаа уулзалт, яриа хэлэлцээ хийж цөөнгүй гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулжээ.

Үүгээр ч зогсохгүй Умард, Өмнөдийг нэгтгэх асуудлыг хариуцсан Хороог хоёр талдаа байгуулжээ. Зарим гол гэрээ, хэлэлцээрүүдийг дурьдваас, 1972 оны 7 дугаар сарын 4-ны өдөр гаргасан "Хоёр солонгосын хамтарсан тунхаглал, 1991 оны 12 дугаар сарын 13-нд байгуулсан Умард, Өмнөдийн хоорондох Шар тэнгисийн халдашгүй байдал ба хамтын ажиллагааны тухай хэлэлцээр, 1992 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр гаргасан Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай хамтарсан тунхаглал,2000 оны

6 дугаар сарын 15-ны өдөр гаргасан Умард, Өмнөд Солонгосын хамтарсан тунхаглал" зэргийг дурьдаж болно.

Хоёр орны аюулгүй байдал, эх орноо нэгтгэх болон хамтын ажиллагааны чиглэлээр гаргасан эдгээр баримт бичгүүдэд энх тайвнаар зэрэгцэн орших, бусдын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, газар нутгийн халдашгүй дархан байх, улс орны тусгаар тогтнолыг хүндэтгэх, бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөх, маргаантай асуудлыг энх тайвнаар зохицуулах,хүний эрхийг хүндэтгэх, улс үндэстний өөртөө засан тогтнох, харилцан үл довтлох, улс орнуудын тэгш эрхийн тухай зэрэг олон улсын хууль, эрх зүйн зарчимуудыг тусгасан, нэг үндэстэн нэгдэх ёстой гэсэн үзэл санааны дагуу байгуулагдсан байна.

Дээрх хэлэлцээр, хамтарсан мэдэгдлүүдэд олон улсын хууль, эрх зүйн бараг бүх зарчмуудыг тусгасан байгаа нь солонгос үндэстний улс, үндсээ нэгтгэх гэсэн их хүсэл зоригийг илэрхийлж байна.

Хэлэлцэн тохиролцсон асуудлуудыг судалж үзвээс,

1. Хоёр Солонгосыг энх тайван замаар нэгтгэх,

2. Эх орноо нэгтгэх асуудлыг гадны оролцоогүйгээр шийдвэрлэх,

3. Эх орноо нэгтгэхэд цэргийн хүчийг хэрэглэхгүй байх,

4. Эх орноо нэг үндэстэн гэдэг үндэсний үзэл санааны дор нэгтгэх,

5. Эх орноо нэгтгэхэд хоёр өөр нийгмийн тогтолцоог үл харгалзан үндэстний нэгдэх гэсэн итгэл найдварыг бий болгох,

6. Умард, Өмнөдийн хооронд түгшүүрт байдлыг намжааж энх тайвны уур амьсгалыг бий болгох,

7. Бие биенээ гүтгэхгүй байх,

8. Их, бага ямар нэг шалтгаанаар буудалцаан, зэвсэгт мөргөлдөөн гаргахгүй байх,

9. Хоёр тал бие биеэндээ албан ёсоор мэдэгдэхгүйгээр цэргийн шилжилт хөдөлгөөн хийж бүлэглэхгүй байх,

10. Үндэстний тасарсан харилцааг сэргээх, ах, дүүгээ олоход нь туслах,

11. Умард, Өмнөдийн хооронд бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлэх,

12. Санаандгүй бий болж болзошгүй осол, эрсдэл дагуулсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хоёр улсын удирдлагуудын хооронд шууд харилцах утсан холбоог бий болгох,

13. Эх орноо нэгтгэх асуудлыг зохицуулах хороог байгуулах,

14. Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох асуудлаар хамтран ажиллах,

15. Цөмийн эрчим хүчийг энх тайвны зорилгоор ашиглах асуудлаар хамтран ажиллах,

16. Эх орноо нэгтгэх асуудлыг бодитойгоор хэрэгжүүлэх зорилгоор хоёр орны удирдагчид ард түмнийхээ өмнө гарч амлалт үүрэг авч, батлан тангараглах,

17. Хоёр тал цөмийн зэвсгийг туршиж, үйлдвэрлэж, хадгалж, хэрэглэхгүй байх,

18. Цөмийн эрчим хүчийг энх тайвны зорилгоор ашиглах асуудлыг зохицуулах хамтарсан Хороо байгуулж ажиллах,

19. Ураны үйлдвэрлэлтэй холбоотой тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж, хадгалж, ашиглахгүй байх,

20. Ард түмний амьдралын төвшинг тэнцвэржүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн үр ашигтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

21. Умард, Өмнөд Солонгос улсууд нийгэм, түүх, соёл иргэншил, урлаг, биеийн тамир, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах,

22. Хоёр улсыг нэгтгэх асуудлаар хойш суун цаг хугацааг алдахгүй байх, зэрэг асуудлуудаар харилцан тохиролцсон байгаа нь хоёр улс үндэстнийг нэгтгэх асуудалд ихээхэн ач холбогдол өгч, бүхий л арга замыг эрэлхийлж буй харуулж байна.

Түүнчлэн хоёр тал эх орноо нэгтгэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж байгааг гэрчлэх баримт юм.

Эдгээр асуудлууд дотроос амьдрал дээр хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэхээр яригдаж байгаа, хэрэгжүүлсэн зүйлүүдийг ялган салгаж үзвээс: Хоёр Солонгосыг энх тайван замаар нэгтгэх асуудал түр зуур хойш тавигдсан, эх орноо гадны оролцоогүйгээр нэгтгэх асуудлаар харилцан тохиролцсон боловч Өмнөд Солонгосын тал АНУ-тай, Умард Солонгосын тал Хятадтай хэт нягт харилцаанд орсон учраас төдийлөн амжилтад хүрэхгүй байгаа, эх орноо нэгтгэхэд цэргийн хүчийг хэрэглэхгүй байх асуудал хэрэгжих ирээдүйтэй, нэгтгэх дээрээ хүрвэл цэргийн хүч хэрэглэхгүй нь ойлгомжтой, хоёр үндэстнийг нэгтгэх үзэл санааг үндэсний үзэл гэж тодорхойлсон нь үзэл суртлын их зөрүүтэй хоёр улсын хувьд том ололт гэж хэлж болно, үндэстний нэгдэх гэсэн үзэл санаа ард түмний дунд аль хэдийнээ бүрэлдэн тогтсоныг харуулж байна.

Түүнчлэн Солонгосын дайнаас хойш олон арван жил өнгөрсөн учраас ард түмний дунд дайны үеийн түгшүүрт байдал намжиж, энх тайван уур амьсгал бий болсон нь үзэл суртлын их ялгаатай Умардынханд ашиггүй байна.

Ийм ч учраас байн байн хурцадмал байдал үүсгэж Умардын ард түмнийг "дайсагнасан үзэл суртлаар" хүмүүжүүлж байна. Өдөөн хатгалга хийж бие биеэ гүтгэдэг асуудлыг зогсоохын тулд хэлэлцээрт тэмдэглэн оруулжээ.

Орчин үед хяналтын техник хэрэгсэл их хөгжиж "гүтгэн гүжирдэх"-ээс сэргийлэх боломжтой болжээ. Зэвсэгт мөргөлдөөний хууль, эрх зүй өндөр хөгжиж "буудалцаан, өдөөн хатгалга, зэвсэгт мөргөлдөөнд" турхирах боломж хязгаарлагдсаар байна.

Нийгмийн өөр өөр байгуулалтай олон улс, үндэстэн нэгдсэн нь үндэстний нэгдэх итгэл найдварыг төрүүлж байна. Орчин үед нууцаар цэргийн шилжилт хөдөлгөөн хийж, цэргийн хүчийг бүлэглэх боломж хязгаарлагдсан.

Үндэстний тасарсан харилцааг сэргээх арга хэмжээг хоёр талаас авч хэрэгжүүлж байгаа. Хоёр талын хамтын ажиллагаа аажим боловч өргөжих хандлагатай болсон. Умардынхны хүнс, хоолны дутагдал, зах, зээлийн түгжигдмэл байдал нь бүс нутгийн орнуудын худалдаа, эдийн засгийн өргөн харилцаанд хамрагдахыг аяндаа шаардаж байгаа юм.

Хоёр улсын хооронд шууд харилцах утсан холбоо тавигдсан. Эх орноо нэгтгэх асуудлыг зохицуулах хороо байгуулагдаад ажиллаж байгаа.

Тухайлбал 14 дүгээр заалт буюу Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох асуудлаар хэлэлцээртэй.

Харин энэ гэрээгээ зөрчин цөмийн зэвсгээр хөөцөлдөж байгаа асуудлыг зохицуулах шаардлагатай. Цөмийн эрчим хүчийг энх тайвны зорилгоор ашиглах асуудлаар тохиролцоонд хүрсэн.

Хоёр улс Эрчим хүчний яамдын шугамаар холбоотой байдаг. Мөн хоёр орныг нэгтгэх асуудлыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд удирдагч нар нь ард түмний өмнө гарч ирж эх орноо нэгтгэнэ гэж андгайлсан.

Ураны боловсруулалтыг зогсоох талаар хэлэлцээр хийсэн. Ард түмний амьдралын түвшинг тэнцвэржүүлэх асуудал хоёр талын уулзалтаар яригдсан. Нийгэм, түүх, соёл, урлаг, спортын салбарт хамтран ажиллаж байгаа.

Хоёр орныг нэгтгэх асуудлаар хойш цаг алдахгүй байх талаар уриалга гаргасан гээд тоочоод байвал дээрх хэлэлцээрүүд, хамтарсан мэдэгдлүүдийн үзэл санаа хэрэгжих бүрэн боломж бүрдсэн байна.

Ийнхүү хоёр улс орноо нэгтгэх, хамтран ажиллах талаар тодорхой тохиролцоонд хүрсэн нь Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаах бүрэн үндэс суурь тавигдсаныг харуулж байна.

Намжмал байдал бий болгох арга зам

Өнөөгийн хурцадмал байдал нь "цэргийн хүчний сөргөлдөөний" шинж чанартай байна. Тиймээс юуны түрүүнд цэргийн итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ шаардлагатай гэж үзнэ.

Хоёр Солонгосын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээр, хамтарсан албан мэдэгдлүүдийг задлан шинжилж үзвэл нь Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаах, түүгээр ч зогсохгүй хоёр улсыг нэгтгэх үзэл баримтлал баттай бий болж, үндэстний нэгдэх үйл явц эхэлсэн байна.

Гэвч энэ үйл явцад хоёр улсын гэрээ, хэлэлцээрийн үзэл санааны дагуу цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн хөндлөнгийн оролцоо, зуучлалын асуудал дутагдаж байна.

Юуны өмнө хоёр Солонгосын хооронд цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд юу дутагдаж байгааг тодорхойлох нь чухал байна. Судалгаа, шинжилгээнээс үзвэл:

Нэгд, Гадаадын цэргийг Солонгосоос гаргах шаардлагатай байгаа нь ил тодоор харагдаж байна. Америкийн цэргийг Өмнөд Солонгосоос гаргаснаар хоёр орны цэргийн итгэлцэл бэхжих үндэс суурь тавигдана.

Америкийн цэргийн хүч заавал Өмнөдийн нутаг дээр байрлах шаардлагагүй. Хэрэв Өмнөдөд үнэхээр цэргийн тусламж хэрэгтэй болдог юмаа гэж бодвол Номхон далайд байгаа АНУ-ын цэргийн бүлэглэл яаралтай тусламжийг үзүүлж чадах юм.

Орчин үеийн цэргийн хэрэгт гарсан их өөрчлөлт, Иракийн дайн зэрэг алс нутагт хийсэн Америкийн цэргийн байлдааны ажиллагаанууд нь Өмнөд Солонгосын аюулгүй байдлыг шаардлагатай цагт хамгаалж чадна гэдгийг нотолж байна.

Хоёрт, Мэдээжийн хэрэг хоёр Солонгосын хооронд цэргийн дээд хэмжээний айлчлалуудыг тогтмолжуулах нь чухал. Цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд цэргийнхний хооронд "найрамдлын төлөөлөгчид

солилцох, харилцан айлчлал хийх" явдал их чухал байдаг нь амьдрал дээр ажиглагдсан зүйл юм.

Жишээ нь: 1992 он хүртэл Монгол, Хятадын харилцаа маш муу байсан. ЗХУ, Монгол хоёрын заналт дайсан нь Хятад, Хятадын заналт дайсан нь Зөвлөлт, Монгол хоёр байлаа. Одоо Орос, Хятад хоёр бүр стратегийн түнш болсон байна.

Монгол, Хятадын цэргийн харилцаа, хамтын ажиллагаа хэвийн хөгжиж байна. 1992-1994 оноос Монголын БХЯ-ны урилгаар Хятадын ардын чөлөөлөх армийн удирдах бүрэлдхүүн Монголд ирж "Амарч зочилдог" хариуд нь Монголын цэргийн удирдлагын хүмүүс БНХАУ-д айлчилж, сайн хөршийн харилцаа бэхжиж ирсэн.

Жишээ нь: дэлхийн II дайны эцэст Хятадыг чөлөөлөх байлдаанд оролцсон Монголын ахмад дайчдыг Батлан хамгаалах яамны сайд байсан хурандаа генерал Ж.Ёндон тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчилж байлаа.

Эдгээр арга хэмжээ нь Монгол, Хятадын хооронд цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд томхон хувь нэмэр оруулсан юм.

Гуравт, Хоёр Солонгосын хувьд Хуурай замын цэргийнхний болон тэнгисийн цэргийнхний хооронд харилцан айлчлал зохион байгуулах шаардлагатай.

Дөрөвт, Солонгосын дайнд оролцсон ахмад дайчдын уулзалт хийх хэрэгтэй. Энэ нь дайны уршгийн талаар хамтарсан сурталчилгаа хийх нөхцөл бүрдүүлж болох юм.

Тавд, Цэргийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгтэй. Цэргийн болон цэрэг, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх арга замыг хайх хэрэгтэй.

Зургаад, Цэргийн эрдэмтдийн төлөөлөгчдийг харилцан солилцох, ялангуяа цэргийн эмч нарыг солилцож туршлага солилцох нь чухал. Гэхдээ Монголын тал санаачлага гарган хоёр Солонгосын эрдэмтэд, эмч нарыг хүлээн авч уулзалт хийсэн ч болно. Энэ нь нийтлэг эрх ашгийг илэрхийлсэн асуудал юм.

Долоод, Дайны хөлд төөрөлдсөн хоёр Солонгосын хүмүүсийн уулзалт наадмыг Монголд зохион байгуулсан ч болно. Үүнд Япон, Хятад, Орос, Монголын ахмад дайчдыг оролцуулсан "Их Наадам" хийсэн ч болох юм. Одоо харилцан уучлал гуйж дайны өш хонзонгоо мартаж, хамтран ажиллах цаг нь болсон байна.

Наймд, Цэрэггүй бүсийг өргөжүүлж, хоёр талын цэргийг хилээс нүүлгэх /Умард Солонгосын цэргийг нүүлгэхдээ Өмнөдөөс эдийн засгийн туслалцаа үзүүлэх/.

Есд, Цэргийн ангиудыг харилцан цомхотгож цэргийг хорогдуулах,

Хамтын ажиллагаа

Нэгд, Улс төрийн салбарт хамтран ажиллах шаардлагатай. Ерөнхийлөгч нарын, парламентын гишүүдийн, Ерөнхий сайд нарын, Яамдын сайд нарын хэмжээнд уулзалт ярилцлага зохион байгуулж, улс орноо нэгтгэх асуудлыг улс, төрийн бүх төвшний асуудал болгох шаардлагатай,

Үүний тулд хоёр талын харилцаа нэг үе ойртон, зогсонги байдалд орох, эргээд сэргэх, дахиад сөргөлдөх, дайсагналцах зэргээр тогтворгүй байсан нь Өмнөд Солонгосын удирдагчдын байр суурьнаас ихээхэн хамааралтай

байсныг анхаарах. Тухайлбал, Ким Дэ Жүн, Но Мү Хёны Засгийн газрын 10 жилд хоёр тал Засгийн газрын шугамаар 253 удаа уулзалт хийсэн, харилцаа ойртсон 10 жил байсан бол И Мён Бакын үед бүрэн зогсонги байдалд орж байсан жишээтэй.

Хоёрт, Өмнөд, Умардын ард түмний их наадам, соёл, урлаг, спортын уралдаан тэмцээнийг Пхеньян, Сөүлд ээлжлэн зохион байгуулах хэрэгтэй байгаа юм.

Гуравт, Өмнөдөөс Умардад хөрөнгө оруулалт хийж Умардад дутагдалтай байгаа эрчим хүч, түлш шатахууны гэх мэт салбарыг нь хөгжүүлэхэд туслах хэрэгтэй,

Дөрөвт, Соёл, урлагийн салбарт хамтран ажиллаж хоёр солонгосын сэтгэлгээний ялгааг ойртуулах арга хэмжээг авах хэрэгтэй,

Тавд, Умардаас гадаадад ажилчин гаргахыг хөхүүлэн дэмжих /Тэд нийгмийн өөр байгуулалтыг үзэж, ардчиллыг мэдрэх нь чухал/

Зургаад, Хоёр улсын хооронд хурдны авто зам тавих нь хоёр Солонгосыг ойртуулахад түлхэц өгөх болно.

Харилцан буулт хийх

Яриа, хэлэлцээний нэг гол зүйл нь харилцан буулт хийх явдал юм. Үүнийг олон улсын хэмжээнд "компромисс" гэж нэрлэдэг. Үүнд:

Нэгд, Ялангуяа эх орноо нэгтгэх асуудлаар хоёр хуваагдсан үндэстэн харилцан буулт хийхэд хэн ч гайхахгүй.

Хоёрт, Харилцан буулт хийхгүйгээр Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаах, хоёр улсыг нэгтгэх асуудлыг урагшлуулах боломжгүй.

Гуравт, Хоёр Вьетнам, хоёр Герман нэгдсэн, Солонгосчууд яагаад нэгдэж чадахгүй байна вэ гэсэн санал асуулгыг бүх ард түмний дунд явуулах хэрэгтэй.

Германы туршлагаас харж байхад, хоёр герман нэгдээд хэдэн арван жил өнгөрсөн боловч адилхан улс болох үйл явц олон жилээр үргэлжилдэг.

Тухайлбал, хуучин Зүүн Германы нутагт ороод ирмэгц авто замуудын чанар муудаж, дэлгүүрийн бараа бүтээгдхүүн өөрчлөгддөг байх юм.

Энэ бүгдийг хэрэгжүүлэх санал тавихад бусдын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг санаархсан мэт сэтгэгдэл төрүүлэх нь мэдээжийн хэрэг.

Эцэст нь Солонгосын хойгийн хурцадмал байдлыг намжаах бас нэг арга зам бол энх тайван, тогтвортой байдал бүрдүүлсний дараа системээ харилцан хүлээн зөвшөөрч, эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн шаталсан интеграцийн замаар үйл явцыг аажуу өрнүүлвэл нөхцөл байдлыг хурцатгахгүй эрсдэл багатай зам байж болох юм. Энэ тохиолдолд Умард Солонгосын дэвшүүлдэг "Холбооны улс" Өмнөд Солонгосын дэвшүүлдэг "Эвслийн улс" байгуулах саналын аль нь ч байж болох талтай.

Монгол Улс хоёр Солонгостой хамтарсан, аль эсвэл тус тусд гэрээ, хэлэлцээр байгуулах зэрэг олон хэлбэрээр ажиллах өргөн боломж байгааг зөв зохистой ашиглаж чадвал хоёр солонгосыг нэгтгэх үйл явдалд хувь нэмрээ оруулах боломжтой юм.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛ

Д.Алтангэрэл. ХСИС-ийн Хилийн сургуулийн хилийн албаны тэнхимийн ахлах багш, магистр, хошууч

Оршил

Нэгдмэл, суурь шинжлэх ухааны хүрээнд системчилсэн тайлбар хийх онцгой шаардлагатай байсан хил хамгаалалтын талаарх мэдлэгийг харьцангуй саяхныг болтол цэргийн, тагнуулын, нийгмийн болон бусад шинжлэх ухаанд тараангуй байдлаар салбарлуулан авч үздэг байсан. Энэхүү байдал нь бие хүн, нийгэм, улс орны эрх ашгийг хилийн орон зайд хамгаалах тухай бие даасан шинжлэх ухаан бүрэлдэн төлөвшихөд саад учруулж, түүний үүрэг роль, тэр тусмаа хилийн үйл ажиллагааны онол, практикийг шинжлэх ухааных нь хувьд ихээхэн бууруулдаг байлаа. Хориод жилийн тэртээ ЗСБНХУ-ын УАХХ-ны хилийн командын дээд курсын профессор Виктор Александрович Сальников хилийн тухай тусгай шинжлэх ухааныг бүрэлдүүлэн төлөвшүүлж түүнийг хил судлал хэмээн нэрийдэх санааг дэвшүүлсэн юм. Харин 1993 оноос (Хил судлалын талаарх анхны газар хоорондын бага хурал болох үед) хилийн орон зайд бие хүн, нийгэм, улс орны эрх ашгийг хангах, хамгаалах үүрэг бүхий нийгэм улс төрийн үзэгдлийн шинж, хууль, зуй тогтлыг судалдаг шинэ шинжлэх ухаан болох "хил судлал" хэмээх ухагдахуун шинжлэх ухаан, практикийн эргэлтэд орж ирсэн юм. Энэ үед хил судлал шинжлэх ухаан болохынхоо хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн гэж хэлж болно. Түүхийн урт хугацааны туршид хил судлал цэргийн болон чекистийн шинжлэх ухааны олон тооны онолуудаас аажмаар салж бүрэлдэн хөгжсөн. 80-90-ээд онуудад хил хамгаалалтын талаарх орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг зохион байгуулалтад орж, нэг талаас онолд дүн шинжилгээ хийж өөрчлөх, нөгөө талаас түүний хэтийн агуулгыг үндэслэн хөгжүүлэх хүчтэй тулхэц болсон шинжлэх ухааны хувьд өөрийгөө танин мэдэх, хурдацтайгаар бүрэлдэн тогтох үе шат явгдсан юм.

Өнөө үед онолын олон салаа тогтолцоог багтаасан шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар болохынхоо хувьд хил судлалыг институтчлах процесс явгдаж байна. Дэлхий дахинаа соёл иргэншлийн үйл явц эргэлтэд орж , "хүйтэн дайнд" ялагдал хүлээсэн ЗХУ задран бутарсан өнөө үед энэ нь бүр ч чухал юм. Олон улсын гэрээ хэлэлцээр бэхжүүлсэн баталгаат хил бүхий ертөнц нутаг дэвсгэр эрх зүйн баталгаагүй ертөнцөөр солигдож байна. Өмнө нь дэлхийн хоёр тогтолцооны хоорондын харилцааг тодорхойлогч түгээмэл аюулгүй байдлын асуудалд төвлөрч байсан цэрэг, улс төрийн ухаанууд түгээмэл болон бүс нутгийн аюулгүй байдал хоорондоо хэрхэн нийцэж холбогдох, *геополитикмн* нэгдмэл нэг орон зай үүсгэж буй хүчтэй /цэрэг-улс төрийн/ , жижиг хэмжээний /хилийн/ нийгэм

соёлын болон бусад хамтын ажиллагаа ямар хамааралтай байх ёстой зэрэг асуултад хариулт өгч чадахгүй байна.

Улс төрийн байдал өөрчлөгдөж, шинээр боловсруулагдан бий болсон дэлхийн соёл иргэншлийн туулан өнгөрч буй энэ хямралын үед бусад орон болон олон улсын байгууллагуудтай харилцах тухайн орны харилцаа улам эмзэг байдалтай болж байна. Ийм нөхцөлд аюулгүй байдлыг хангах найдвартай хэрэгслүүдийн нэг нь хил судлалын онол арга зүйд үндэслэсэн улсын хилийн бодлого юм. Шинжлэх ухааны үндэстэй хилийн бодлого нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, оюуны болон биет соёл, эдийн засаг болон нийгмийн бүтцийг хамгаалах Оросын өөрийн хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэх болон даяаршлаас үүдэлтэй хилийн харилцааг өөрчлөхөд тодорхой хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгож байгаа юм.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах төрөөс хилийн талаар баримтлах бодлого чиглэл

Хил хамгаалалтын түүхэн хөгжил, ирээдүйн чиг хандлагаас үзэхэд улсын хилийн аюулгүй байдлыг хангах асуудал нь улс төр, эдийн засаг, цэрэг, экологи, хүмүүнлэгийн зэрэг олон талт үйл ажиллагаатай нягт холбоотой байх агаад үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл, нийгэм-улс төрийн өргөн агууламж бүхий судлагдахуун мөний хувьд улс төрчдийн анхаарлыг татаж, улс төрийн байгууллагуудын бодлогын төвд оршсоор ирлээ.

Хилийн улс төрийн бодлого нь улс төрийн бодлогын ерөнхий зүй тогтол, зарчимд суурилах бөгөөд үйлчлэх хүрээндээ улстөрийн нөлөө үзүүлэх субьектуудын өвөрмөц байдлыг нөхцөлдүүлсэн үйл ажиллагаа байдаг билээ.

Энэ ч утгаараа Монгол Улсын Их Хурлын 2002 онд баталсан "Төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого" үзэл баримтлал, түүний хэрэгжилт нь эрх барьж ирсэн нам, улс төрийн хүчнүүдийн мөрийн хөтөлбөр, үйл ажиллагаатай салшгүй холбоотой байсаар байна.

Хилийн талаар баримтлах төрийн энэхүү тулгуур баримт бичиг нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэсэн, улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүнийг хэрэгжүүлэх зорилго, зорилт, зарчим, үндсэн чиглэлийг тусгасан үзэл санааны тогтолцооноос бүрдэж буй бөгөөд төрийн бодлогын залгамж чанарыг хангах чухал үүргийг гүйцэтгэж, үе үеийн засгийн газрын хил хамгаалах бодлогын үндсийг бүрдүүлж ирэв.

2008-2012 онд үйл ажиллагаагаа явуулсан Монгол Ардын Хувьсгалт Нам (өнөөгийн МАН), Ардчилсан Намын хамтарсан Засгийн газрын хөтөлбөр нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон дээрх намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, бусад намуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн зарим зорилт, төрийн бус байгууллагатай хийсэн баримт бичгүүдэд үндэслэгдсэн бөгөөд засгийн

газрын энэхүү хөтөлбөрт хил хамгаалах бодлогыг тусгайлан томъёолж хэрэгжүүлсэн нь хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ баталгаатай биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал алхам болсон юм.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монгол улсын хил хамгаалалтанд орчин үеийн техник технологи нэвтрүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан, хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог баталгаажуулах:

Улсын хилийн бүсчилсэн /уулын, ой тайгын, говь цөлийн, тал хээрийн хэсгийн/ хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх:

Улсын хилийг "Хугацаат цэргийн алба хаагч"-аар хамгаалуулдаг тогтолцоог өөрчилж, хил хамгаалах албыг удирдан зохион байгуулах үүргийг мэргэжлийн байгууллагаар, улсын хилийг хамгаалах үүргийг мэргэшсэн гэрээт хилчин" -ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх:

Хил хамгаалах байгууллагын холбоо мэдээллийн тогтолцоо, хил хамгаалалтын техник хангамж, зэвсэглэлийг шинэчлэх цогц арга хэмжээ авах:

Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хөрш орнуудын жишигт хүргэж, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх,

Хилийн боомт болон хилийн зурвас, бүсэд олныг хамарсан эмх замбараагүй байдал, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах зэрэг онцгой нөхцөл үүсвэл сөрөг тусгай ажиллагаа явуулах салбар, нэгжийг байгуулж, зориулалтын тусгай хэрэгслээр хангах

Монгол Улс, БНХАУ-ын хилийн Буйр нуурын хэсэгт усан хилийн тэмдэгт хийж, усан хилийн хамгаалалтыг илүү боловсронгуй болгох:

Хилийн боомтод ажиллаж байгаа цагдаа, хил, гааль, гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх болон улсын мэргэжлийн хяналтын байгууллагын алба хаагчдын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр заасан байна.

Хамтарсан Засгийн газрын хөтөлбөрт тусгасан дээрхи улс төрийн намуудын хилийн аюулгүй байдлыг хангах талаар тавьсан зорилтууд үндсэндээ хэрэгжсэн гэж дүгнэж болох бөгөөд улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах бодитой, үр ашигтай арга хэмжээ болсон гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт:

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчилж, тус тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн байгууллагуудын ажлын уялдаа холбоог шинэ түвшинд гаргана.

Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоодын цэргийн албанд үүрэг хүлээж тангараг өргөсөн офицер, албан хаагч, ажилтануудын ар гэр, ахуй амьдрал, ажиллах нөхцөлийн баталгааг олон улсын түвшинд хүргэж сайжруулах ажлыг үе шаттайгаар

хэрэгжүүлнэ хэмээн заасан билээ.

Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт, хилийн аюулгүй байдлыг хангах асуудал тусгайлан томъёлогдоогүй ч хил хамгаалах байгууллага, түүний үйл ажиллгаа өөрчлөлт шинэчлэлт хөгжил дэвшлийг дэмжих болно гэсэн санаа тод харагдаж байна. Ялангуяа улсын хил хамгаалалтын чанарыг ахисан түвшинд гаргахад нөлөөлөх чухал хүчин зүйл болох албан хаагчдын амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах асуудлыг тусгасан нь оновчтой болжоо.

Дээрхи хөтөлбөрүүдэд тусгасан заалтууд нь тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдсан, хилийн талаар цаашид шат дараалан хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий хандлага, чиглэл, бодлогыг тодорхойлсон тулгуур үзэл баримтлал шинжтэй байгаа юм.

2012 оны Улсын Их Хурлын сонгуульд улс төрийн нам, хүчин, эвсэл, холбоод, бие даан нэр дэвшигчид өөрийн мөрийн хөтөлбөртэйгээр оролцсон бөгөөд хилийн талаар баримтлах бодлогыг дийлэнх нь томъёолсон байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогод шинэ засгийн газраас баримталж буй бодлого чиглэл

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож, улсын хилийг шинэжлэх ухааны олоотод тулгууласан бүсчилсэн байдлаар хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ. Цэргийн албаа хаагчдын эрх зүй, нийгмийн хамгааллын баталгаа-цэрэг, цагдаа, онцгой байдлын албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг улс орны эдийн засгийн чадвахийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.

Цэргийн албан хаагчдыг тэтгэвэр, чөлөөнд гарахад нь орон сууцаар хангах, ажил мэргэжлээс хамаарах өвчин эмгэгээс нь эрүүлжүүлэх, иргэний нийгэмд ажиллаж амьдрахад зайлшгүй шаардлагатай мэргэжил эзэмжихүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Нийт офицер, ахлагч нарыг албан тушаалын орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заажээ.

2008-2012 оны хамтарсан Засгийн газрийн хөтөлбөрт тусгагдан биелэлээ олж эхэлсэн хилийн бүсчилсэн хамгаалалтын тогтолцооны асуудлыг монгол ардын намын 2012 оны сонгуулын мөрийн хөтөлбөрт дахин тусгасан нь хил хамгаалах тогтолцоог боловсроэнгуй болгох, түүний шуурхай найдвартай байдлыг хангах чиглэлээр эхлүүлсэн ажлаа үргэлжүүлэх, дараагийн шатны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд чиглэгдсэн гэж үзэх үндсэнтэй бөгөөд хилийн аюулгүй байдлийг хангах оновчтой бүтэц бий болгох, түүний зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд шат дараатай хэрэгжүүлэх олон ажлууд тулгамдаж байгаа нь амьдралаас харагддаг.

Мөн хөтөлбөрт хилийн цэргийн албан хаагчдын нийгмийн халамжын асуудал, хувь хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулсан байх бөгөөд энэ нь хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын үр ашгийг дээшлүүлэх, эцсийн дүндээ хил хамгаалалтын чанарыг шинэ шатанд гаргах чухал ач холбогдолтой ажил

болох юм хэмээн дүгнэж болохоор байна.

Түүнчлэн "Хилийн халдашгүй дархан байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох, улсын хил хамгаалалтыг шинжлэх ухааны ололтод тулгуурлах" асуудал мөрийн хөтөлбөрт тусгагдсан нь хилийн аюулгүй байдлыг найдвартай хангах цаг үеийн шаардлагаас урган гарсан гэж үзэх үндэстэй.

Улсын хилийг инженер-техникийн хэрэгслийн тусламжтайгаар хамгаалснаар хил хамгаалалтыг бага хүчээр үр дүнтэй, шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах нөхцөл бүрдэх бөгөөд ийм аргаар хилээ хамгаалж буй өндөр хөгжилтэй улс орнуудын туршлагыг бид сайтар судалж бодлогын хэмжээнд томъёолж цогц байдлаар хэрэгжүүлэх ёстой юм.

Хил хамгаалах бодлогыг шинээр тодорхойлж, улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлнэ гэж хил хамгаалах бодлогыг томъёолсон байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндэс нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүнийг хэрэгжүүлэх зорилго, зорилт, зарчим, үндсэн чиглэлийн талаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үзэл санааны тогтолцооноос бүрддэг бол, бодлогын мөн чанар нь төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн тал бүрийн үүргээ хил орчимд хэрэгжүүлэхэд оршдог бөгөөд тэр нь тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн аюулгүй байдал, улсын эрх ашгийг өөрийн хил орчимын нутаг дэвсгэрт хамгаалахад чиглэгдэж байдаг билээ.

Монгол Улсын Их Хурал "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг 2002 онд баталсан бөгөөд уг бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд үндэсний язгуур эрх ашгийг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахиулах, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр бодитой ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого ийнхүү ямар нэгэн хэлбэрээр хэрэгжиж, түүний үр шимийг манай хил хамгаалах байгууллага, хилчид, хил орчимын нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч буй ард иргэд, тэнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн байгууллага хүртэж, үүний үр дүнд хил хамгаалалтын нягтрал, чадавхи нэмэгдэж, эрх зүйн орчин, хамтын ажиллагаа, хилчидийн нийгмийн асуудал сайжирчээ.

Гэвч дэлхий нийтэд өрнөж буй даяаршилын үйл явц өрнөж, терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн аюул нүүрлэхийн хэрээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь өсөн нэмэгдэж байгаа, түүнчлэн хил хамгаалалтын нөхцөл байдал өөрчлөгдөж буйтай холбоотойгоор төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дүгнэлт

Дээрх сэдвийн хүрээнд дүгнэхэд цаашид төр засгаас доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлбэл Хил хамгаалах байгууллага үйл ажиллагаагаа явуулахад ямар нэгэн саад бэрхшээл, хүндрэл тулгарахгүй юм болов уу? гэсний үндсэн дээр доорх саналуудыг тусгаж байна.

Үүнд:

- Улсын хилийг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах асуудлыг шийдвэрлэх
- Улсын хил хамгаалалтын болон хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх;
- Улсын хил хамгаалалтын орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлэх, (бүх хилийн отрядуудын хариуцсан хэсгийг камержуулах, дулаан мэдрэх систем гэх мэт)
- Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт улсын язгуур эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн эдийн засгийн тогтолцоог бий болгон хөгжүүлэх;
- Улсын хил хамгаалалтын болон хилийн аюулгүй байдлыг хангах талаар гүйцэтгэх засаглалын бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

Хилийн цэргийн алба хаагчдын болон хил орчмын нутаг дэвсгэрийн ард иргэдийн нийгмийн хамгааллыг хөгжүүлэх зэрэг чиглэлээр бодит ажлууд тусгалаа олж хэрэгжвэл Монгол Улсын хилийн аюулгүй байдал жинхэнэ утгаараа хангагдах болно.

Улс төрийн намуудын хил хамгаалах талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа нь тухайн намуудын үзэл баримтлал, төлөвшил, төр барьсан туршлага зэргээс ихээхэн хамаарч байгаа нь ийнхүү мөрийн хөтөлбөрөөс нь харагдаж байгаа бөгөөд цаашид төрийн бодлогын залгамж чанарыг хангах эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэхийн тулд төрийн институцууд, нам, улс төрийн хүчнүүд хамтарч ажиллах шаардлагатай болж байна.

УЛСЫН ХИЛ ХЯЗГААРЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙХ ДҮГНЭЛТ

Ч.Чулуунхүү. ХСИС-ийн Хилийн сургуулийн хилийн албаны тэнхимийн багш, хошууч

Монгол улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчимын нутаг дэвсгэрт Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхолыг хангах асуудлын талаарх бүх үзэл баримтлал, чиг хандлага, хуримтлагдсан туршлагыг нэгтгэн дүн шинжилгээ хийж тохирсон хамгаалалтын тогтолцоог шинжлэх ухааны үндэслэлтэй гаргаж ирэх шаардлага нэгэнт буй болжээ.

Орчин үеийн улсын хил дээрх нөхцөл байдал, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашигт халдсанаас үүдэн гарч буй нарийн төвөгтэй, оршин тогтнохуйн аюулгүй байдалтай холбогдсон асуудлыг улсын болон хил хамгаалах байгууллагын хэмжээнд иж бүрнээр шийдвэрлэх шаардлага байнга дэвшигдэн гарч, байгаа нь түүнийг хэвшсэн, хилийн дагуу жигд тархан

байрлуулсан одоогийн хүч хэрэгслээр шийдвэрлэхэд хүндрэл учирч, энэ нь зарим бүс нутагт хилийн зөрчил даамжирч зохион байгуулалтай гэмт хэргийн шинжтэй болж байгаагаар илэрч байна.

Хилийн цэрэг дахин байгуулагдсанаас хойш улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилт хил хамгаалах байгууллагын нэн тэргүүний чиг үүрэг болон 1974, 1994 оны хил хамгаалах болон хилийн тухай хуулиудаар хуульчлагдан батлагдаж энэхүү зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан нь гаднаас үйлдэх хилийн зөрчлийг шийдвэрлэхэд бүрэн нийцэж байсан.

Улсын хил хамгаалалт, хил хамгаалах урлагт дотоодоос үйлдэгдэх эдийн засгийн зорилго бүхий хилийн зөрчлүүд, эдгээр нь хил дамнасан гэмт бүлэглэлийн үйлдэл болон өргөжсөнөөр хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, иргэдийн сэтгэл санаанд хүчтэй нөлөө үзүүлснээр хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах асуудал шинэ зорилт болон дэвшигдсэн.

Дотоодоос үйлдэж буй эдгээр хилийн зөрчлүүдийг таслан зогсоохоор ихээхэн хүч хэрэгсэл оролцсон, хилийн опериацуудыг хэд хэдэн удаа зүүн болон баруун бүс нутагт зохион байгуулж явуулсан хэдий ч зохион байгуулалттай үйлдэгдэж буй хилийн зөрчил таслан зогсоогдохгүй байна. Ийм нөхцөл байдлаас улбаалан 2002 онд Монгол Улсын Их хурал тогтоол гарган "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого" хэмээх улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх Монгол Улсын хууль үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичгийг батлан гаргасан.

Эдгээр нөхцөл байдлаас үндэслэн хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хил орчимын нутаг дэвсгэрт хувь хүн, нийгэм, төрийн эрх ашгийг хангах, гэсэн нийгэм-улс төрийн энэхүү үзэгдлийн шинж чанар, зүй тогтоол, эрх зүйг судлан "улсын хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт" гэсэн хамгаалалтын үйл ажиллагааны төрөл, арга хэмжээний хэлбэрийг шинэчилсэн, шинэ хандлага буй болж эрдэм шинжилгээ болон практик үйл ажиллагааны эргэлтэд орж оновчтой шийдлээ хүлээсээр байна.

Энэ хугацаанд "хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт" гэсэн ухагдахууныг төр нийгэм хүлээн зөвшөөрөн хил хамгаалах байгууллагыг бэхжүүлэх арга хэмжээг улсын нутаг дэвсгэрийн хил хязгаарын хүрээнд авч хэрэгжүүлсэнээр хойд хилийн хамгаалалтын боломж урьд хилийн нэгэн адил түвшинд хүрч бэхжсэн нь хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалтын тухай шинжлэх ухааны ойлголт, хил хамгаалах урлагын асуудалд шинэ санаа, сэдлийг авч ирсэн, энэ талаарх үзэл баримтлал бүрэлдэн тогтож буй үе шат болно.

Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт хэмээх нийгэм-улс төр, цэрэг-эдийн засгийн нарийн төвөгтэй үзэгдэл нь шинж чанар, зүй, тогтоол, эрх зүйн мэдлэгийн цогц тогтолцоо бүхий үйл ажиллагаа болно. Хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт нь тагнуул, цэргийн, цэрэг-техникийн, цэрэг-эдийн засгийн, нийгэм-улс төр, эрх зүй зэрэг шинжлэх ухааны мэргэжлийн

салбаруудын уулзвар дээр явагдаж буй цэргийн тагнуулын, дэглэмийн улс төр-дипломатын, инженер-техникийн арга хэмжээнүүдийн цогц шинж чанарыг илэрхийлж буй нэг нь нөгөөтэйгээ харилцан уялдсан, байгуулага иргэдийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагааны нэгдэл болно.

Улсын хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт нь олон улсын болон дотоодын гэрээ эрх зүйн үндсэн дээр хэрэгжидэг, учир Монгол улсын хил хязгаарын аюулгүй байдлын түвшинг улсын хилийн баталгаажилт, улсын хилийн хамгаалалтын түвшингээр судлан үзлээ.

Монгол улсын хилийн баталгаажилтийг хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн хүрээнд судлахад хилийн баталгаажилт, хил хамгаалалтын эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн гэж дүгнэж байна. Хилийн талаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээний хувьд хил тогтоон тэмдэглэгдэж хилийн болон дэглэмийн гэрээ байгуулагдсан, хилийн боомтын хэлэлцээртэй, Монгол-Оросын хил хамгаалах байгуулагуудын хоорондын хамтын ажиллагааны талаар засгийн газрын түвшинд хэлэлцээр байгуулагдсан. Харин Монгол, Оросын хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх, Монгол-Хятадын хил хамгаалах байгууллагын хооронд хамтын ажиллагааны хэлэлцээрийг засгийн газрын түвшинд байгуулах, хилийн дэглэмийн гэрээ, хилийн тухай хуулийн дагуу хилийн төлөөлөгчийн байгууллагыг бүсчилэн бие даасан байдалтай байгуулах зэргээр төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

Улсын хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалтын түвшинг авч үзэхийн тулд дотоодын хууль тогтоомжинд түүний одоогийн тусгагдсан тодорхойлолт цаг үеийн нөхцөл байдал, хил хамгаалах урлаг, хил судлалын шинжлэх ухааны үзэл баримтлалд хэрхэн нийцэж байгааг үзлээ.

Монгол Улсын хилийн тухай хуульд /4-р бүлэг, 30 зүйл/[1] "Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг мөн " гэсэн нь улсын хилийн манах, сэргийлэн хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын, хориглон хамгаалах нь батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг байхыг өгүүлж буй агуулга болно.

Улсын хил манах, сэргийлэн хамгаалах асуудал нь оршин тогтнохуйн аюулгүй байдалд шууд хамааралтай Монгол Улсын мөнхийн ашиг сонирхолын ухагдахуун бөгөөд энэ агуулгаар Монгол улсын хил байнга манаатай, хил дээр үүссэн асуудал зохицуулалттай байхыг хэлж буй асуудал болно. Энэ ойлгоцоор улсын хилийг манах, сэргийлэн хамгаалах асуудал нь улсын хил хязгаарын аюулгүй байдлын гол суурь ухагдахуун, улсын хилийн хориглон хамгаалах үйл ажиллагаа нь "дайн бүхий" болон "дайны" үеийн улсын хил халхлалтын хүрээнд явагдах цэргийн ажиллагаа бөгөөд цаг үеийн шинжтэй ухагдахуун мөн.

Одоо мөрдөж буй хилийн тухай хуулийн зорилтод Монгол улсын төрөөс

[1] Монгол Улсын хилийн тухай хуульд /4-р бүлэг, 30 зүйл/ "

хилийн талаар баримтлах бодлогын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах тухай заалт ороогүйн улмаас хил хамгаалалтын тодорхойлолт нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахаар хязгаарлагдсан, мөн тодорхойлолтын агуулгаар хил хамгаалах байгууллага, хилийн бүс зурваст улс төрийн, дипломатын болон эдийн засгийн арга хэмжээг хилийн зөрчлийг илрүүлэх таслан зогсоохоор явуулах гэсэн шинжлэх ухааны үндэслэл муутай, практикт хэрэгжүүлэх арга нь тодорхой буй томъёолол орсон зэргээс төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд хуульд заагдсан (хил хамгаалалтын дүрэмд ч байгаа) хил хамгаалалтын тодорхойлолтыг дахин нягтлах шаардлага буйг илтгэж байна.

Үүнээс үүдэн "хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт гэж улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахаар явуулж буй улс төр-дипломатын, дэглэмийн болон хилийн бүс, зурваст хил хамгаалах байгууллагаас явуулж буй цэргийн, тагнуулын, инженер-техникийн арга хэмжээний цогц үйл ажиллагааг хэлнэ. Улсын хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалт /цаашид хил хамгаалалт гэх/ нь улсын хилийг манах, улсын хилийг сэргийлэн хамгаалах болон улсын хилийн хориглон хамгаалах үйл ажиллагаанаас бүрдэнэ" гэсэн томъёоллыг дэвшүүлж үүний дагуу үнэлэлт дүгнэлтийг хийж байна.

Хилийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд "улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам" гарч байгууллагуудыг хил хамгаалалтад оролцуулах талаарх зохицуулалт дутмаг байгаагаас орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн засаг дарга нар хил хамгаалалтын талаарх бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хил хамгаалах байгууллагатай хамтарч хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахын тулд "улсын хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавьж, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах"/хилийн тухай хууль 5 дугаар бүлэг, 39 дүгээр зүйл/[2] асуудлыг хэрхэн хэрэгжүүлэх нь тулгамдаж буй асуудлын нэг болж байна.

Монгол улсын хил хамгаалалтын дүрэмд ч гэсэн анхаарах, засаж залруулах зүйл заалтууд нилээд бий. Жишээ нь: байлдааны зэвсэг, техник хэрэглэх хуулийн заалтын зөвхөн зэвсэг хэрэглэх байдлаар хязгаарласан нь хоёрдмол ойлголтыг төрүүлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хил хамгаалах байгууллагаас байлдааны техник, зэвсэг хэрэглэх тухай хуулийн заалт нь хоёр өөр агуулгыг илэрхийлдэг бөгөөд хилийн тусгай анги, салбар байлдааны техник хэрэглэх асуудал онцгой нөхцлийн үед террорист халдлагын эсрэг байлдааны хуягт болон тусгай зориулалтаар техник хэрэглэх, улсын хилийн хориглолт хамгаалалтын үед зэвсэгт халдлагыг няцаах, өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг тас цохих үед өөрийн орон тооны болон дэмжих хэрэгслийн галыг болон цохилтын техник, хэрэгслийг ашиглах асуудал болно.

Хуульд байгаа "хилийн манаа

[2] Ххилийн тухай хууль 5 дугаар бүлэг, 39 дүгээр зүйл

гэсэн дээр хил хамгаалалтын дүрмээр нэмж бүлэг"гэж оруулжээ. Бүлэг нь хил хамгаалалтын үед янз бүрийн нөхцөлд анги, салбараас томилогддог эрлийн болон байлдааны журмын элемент бөгөөд хуулинд дурьдсан анги салбар гэсэн ойлголтод багтах ухагдахуун болно.

Хил хамгаалалтын дүрэмд зэвсэг хэрэглэх асуудлыг хилийн манаа, бүлэг гэсэн хязгаарлалтаар оруулсан, бид ийм байдлаар хичээл зааж байна. Гэтэл ХХБ-хилчид галт зэвсэг хэрэглэх тохиолдлууд, хуулиар олгогдсон эрх бий жишээ нь: онц байдал тогтосон үед онцгой нөхцлийн хор уршигийг арилгахын тулд ХЦ-ийн зарим ангийг татан оролцуулах ба энд татан оролцуулж байгаа анги салбар нь дотоодын цэргийн болон цагдаагийн эрх үүргээр алба гүйцэтгэнэ. Галт зэвсгийг цагдаагийн тухай хуулийн дагуу хэрэглэнэ.

2008 оны 7-дугаар сарын 1-ний үйл явдалд хилийн цэргийн дээд сургууль татагдан оролцсон, зэвсэг олгосон, сонсогч нар маань ямар хуулийн дагуу зэвсэг хэрэглэхээ мэдэхгүй байсан. Иймд асуудал хилийн аль ч хэсэгт хил хамгаалах байгууллага, хилчдэд тохиолдож болзошгүй. Энэ ажиллагаанд урьдчилсан бэлтгэхгүйгээр тухайн үед нь сургалт явуулсан цагдаагийн хуулийн дагуу зэвсэг хэрэглэх чадвар хилчдэд олгох боломж байхгүй.

ЦАХ-ын эрх зүйн байдлын хуулийн дагуу ангийн захирагчийн тушаалаар томилогдсон ангийн жижүүр, харуул манаа галт зэвсэг хэрэглэх тухай заасан байдаг.

Хилийн отряд, анги, бүр хоногийн тушаалаар жижүүр, харуул манаа томилдог, тэд буу зэвсэг агсадаг, хэрэглэх эрхээ мэдэж байгаа эсэх нь бүрхэг байна.

Зэвсэг хэрэглэх ийм өргөн хүрээний эрх цагдаад байхгүй, армийханд ч байхгүй, зөвхөн хилчдэд байна. Энэ нь хил хамгаалалтын эрх зүйг төгөлдөржүүлэх нэг шаардлага мөн.

Улсын хил хязгаарын аюулгүй байдалд доорх хүчин зүйлүүдийн нөлөөлөл байгаа ба түүнийг зайлшгүй харгалзах шаардлага байна гэж үзэж байна. Үүнд:

1. Газар зүйн тогтолцооноос үүдэлтэй нөлөө
2. Экологийн шинжтэй нөлөө
3. Хил тогтоолтоос үүдэлтэй болзошгүй нөлөө
4. Нийгэм эдийн засаг, хүн амын суурьшлаас үүдэлтэй нөлөө
5. Хил хязгаарын аюулгүй байдлын хүрээн дэх болзошгүй нөлөө
6. Нийгмийн сэтгэл зүйн үүдэлтэй нөлөө
7. Хил хамгаалалтаас үүдэлтэй нөлөө

1. Газар зүйн тогтолцооноос үүдэлтэйгээр хил хязгаарын зарим хэсэг байгаль, газар зүйн онцлогоос хамаарч хамгаалалтгүй буюу хамгаалах боломжгүй болж буй нөхцөл байдал үүсч байна.

Уул нуруудын усны хагалбараар хил тогтоосноос үүдэн Монгол Улсын баруун хил, Хөвсгөл, Булган, Хэнтий хилийн хэсэг улирлын шинжтэй / өвөл, хавар/ хилийн шугамын дагуу хамгаалалтгүй орхидсоноос хулгайн анчид, алт, бусад баялаг хайгчид хилийн халдашгүй дархан байдлыг зөрчих үйлдэл таслан зогсоогдохгүй байна. Усан хилийг Буйр нуурын хэсэгт

тэмдэглээгүй, хилчид хөвөх хэрэгсэлгүй зэргээс улсын хил зөрчин агнуур эрхлэн хилийн халдашгүй дархан байдлыг зөрчих асуудал таслан зогсоогдохгүй байнгын шинжтэй болж хилчид энэ байдалд дасаж эхэлж байна. Говь цөлд нүүрлэж буй цөлжилт, хил хязгаарын дагуу эзэмшилгүй нутаг дэвсгэрийг үүсгэж байна.

2. Экологийн шинжтэй хил дамнасан байгалийн баялгын сүйрэл, хилийн бус зурвас дахь хайгуул олдворлолтоос үүдсэн нөхцөл байдал.

Ой тайга, тал хээрийн бүсэд гарч буй хил дамнасан, хил орчмын нутаг дэвсгэрт гарсан түймрийн улмаас хүн мал, амьтан амьдрах боломж түр болон удаан хугацаагаар алдагдах.

Газар хөдлөлт, цөлжилтөөс үүдсэн байгалийн тогтоц, ургамлын аймагт орж буй өөрчлөлтөөс хилийн дагуух бэлчээр нутаг, ус ховордон байгалийн унаган төрх нь өөрчлөгдсөнөөс хүн амын суурьшил сийрэгжих.

Хайгуул олдворлолтод тэсэрч дэлбэлэх болон хортой химийн бодис ашигласны улмаас бэлчээр, усны эх булаг, хөрс хордсоноос хүн, мал, амьтан амьдрах аргагүй болох зэрэг болно.

3. Хил тогтоолтоос үүдэлтэй үүсэж болох нөлөөлөл

Хилийн маргаан харьцангуй боловч Монгол-Оросын хилийн гэрээ НҮБ-д бүртгэгдээгүй, улсын хилийг хамтран шалгах явцад хилийн зарим тэмдэг / багана/-ыг босгоогүй орхих, буруу газар байрлуулах, хил шалгасан протоколд тусгахгүй байх, улсын хилийг арчлан хамгаалах асуудлын хүрээнд хилийн отряд эвдэрсэн баганыг сэргээн засварлах, сэргээн босгохгүй байх болон усан хилийн эргийн хэмжилтийг хийдэггүйгээс салхины аясаар манай талын эргийн эвдрэлээс үүдэн голын гольдролд өөрчлөлт орж энэ хэсэгт хилийн шугамын явалт дотогшлох, ойн зурвасыг сэргээгүйгээс хилийн шугамын явдалт бүдгэрэх зэрэг нөхцөл байдал гарах магадлал байсаар байна.

4. Нийгэм эдийн засаг, хүн амын суурьшлаас үүдэлтэй үүсч болох нөлөөлөл.

Хил орчмын баялаг ихтэй болон амьдрах нөхцөл сайтай газар, хүн амаар хүч түрэн суурьших.

Хил орчмын эдийн засаг чөлөөт бүсийн хамгаалалт, хил орчмын нутаг дэвсгэрийг түрээслэх асуудал

Иргэд хилийн бүс зурвасаас дайжин нүүх, хил хязгаар эзэнгүйдэн, эзэмшлийн ор мөр алга болох.

Гадаадын хөрөнгө оруулалттай томоохон талбай хамарсан үйлдвэр хилийн бүс зурваст олноор төвлөрсөнөөс хил орчмын дэглэм алдагдах.

Хилийн зарим хэсгийг дамнасан дамжин өнгөрөх зам буй болох, нэг талын зориулалттай боомт нээгдэн тэдний ашиг сонирхолд хилийн алба үйлчлэх.

Хил дамнасан гоц халдварт хүн малын өвчний тархалт зэрэг болно.

5. Хил хязгаарын аюулгүй байдлыг зөрчсөнөөс үүсэж болох нөлөөлөл

Хил дамнуулан хориотой бараа сэм нэвтэрүүлэх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйлдэл.

Хил дамнасан малын хулгай, зэвсэглэсэн дээрмийн халдлага

Хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугчид өмчөө зэвсэглэн хамгаалах чадваргүй байдал

Хил хязгаарын нутгийн захиргаа хил орчмын дэглэм сахиулах үүргээ

хэрэгжүүлэхгүй байх.

Хил давуулан хулгайлагдсан мал, өмчийг олж эргүүлэн өгөх, хохиролгүй болгох талаарх хууль хяналтын байгууллагуудын урагшгүй ажиллагаа

Хил хязгаарын аюулгүй байдлыг хангах талаарх цэргийн болон хууль сахиулагч хэрэгжүүлэгч байгууллагын харилцан болон хамтын ажиллагааны доголдол зэрэг болно.

6. Нийгмийн сэтгэл зүйн үүдэлтэй үүсэж болох нөлөөлөл.

Хилийн харилцааны таагүй уур амьсгал, хил нэвтрэх виз, бараанд тавих хязгаарлалт.

Хилийн арилжааны хязгаарлагдмал байдал, хил орчмын нутаг дэвсгэр дэх бараа таваарын өндөр өртөг.

Хил орчмын нутаг дэвсгэрийн дэд бүтцийн хоцрогдонгуй байдал

Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар ХХБ, нутгийн захиргааны ажлын доголдол.

ХХБ нутгийн захиргаа, хилчид иргэдийн хоорондын тааламжгүй харьцаа зэрэг болно.

7. ХХБ-аас үүдэлтэй үүсэж болох нөлөөлөл

ХХБ-ын хүч хэрэгслийн байгуулалт, оновчтой биш цэвээрааажилт.

Хүч хэрэгслийг бүс нутгийн хилийн нөхцөл байдал байгаль цаг уурын онцлогыг харгалзахгүй жигд тархаан байрлуулах. Улсын хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалтын төрлийг оновчтой сонгоогүйгээс хилийн дэглэмийн зөрчил даамжирч хил дамнасан гэмт бүлэглэлийн шинжтэй, болох хандлага.

Улсын хил хамгаалалтын цэргийн, тагнуулын, инженер техникийн арга хэмжээний уялдаа тэдгээрийг ашиглах талаарх бодлогын доголдол, санхүүжилтийн нөлөө.

Улсын хил хязгаарын аюулгүй байдлын улс төр дипломатын, дэглэмийн арга хэмжээ, хилийн асуудлыг зохицуулах, хилийн төлөөлөгчийн байгууллагыг ашиглах талаар гарч буй доголдол.

Улсын хил хязгаарын аюулгүй байпдын хамгаалалтад шинжлэх ухааны ололтыг ашиглах арга хэмжээний удааширал.

Хилийн тухай хууль тогтоомж, гэрээ хэлэлцээргийн хэрэгжилтэд төрийн захиргааны төв байгууллагуудаас тавих хяналт, хамтын ажиллагааны уялдааны доголдол зэрэг болно.

Улсын хил хязгаарын аюулгүй байдлын түвшин.

Улсын хил хязгаарын аюулгүй байдлын түвшинг үнэлэхдээ улсын хил манах үйл ажиллагааг улс орны хэмжээнд, улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагааг бүсчилсэн байдлаар авч үзэх нь улсын хилийн нөхцөл байдал, түүний зохицуулалтанд нэн тохиромжтой гэж үзэж байна.

Улсын хил манах нь улсын хил халдашгүй дархан байдлыг хангах гол нөхцөл бөгөөд үндэсний аюулгүй байдлын мөнхийн ашиг сонирхолоос үүдэн улсын хил нь ямарч үед тасралтгүй манаатай байх асуудал бөгөөд улс орны бүх нутаг дэвсгэрийг хамарсан үйл ажиллагаа болно.

Монгол улсын хил нь нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн тогтоогдсон, хил залгаа улстай гэрээгээр баталгаажсан бөгөөд түүнийг манах асуудалд цэрэг улс төр, эрх зүйн шинжтэй сөрөг нөлөөлөл байхгүй гэж үзэж байна.

Улсын хил манах үйл ажиллагаанд газар зүйн тогтоц, экологиос үндсэн улсын хилийг арчилан хамгаалахтай холбоотой асуудлууд байсаар байна.

Газар зүйн тогтоцтой холбоотой нөлөө нь баруун, хойд хилд голлон үүсч байгаа бол экологийн шинжтэй нөлөө нь өмнөд хилд голлон үзэгдэж байна.

Улсын хилийг арчлан хамгаалах асуудал уулархаг ой тайга бүхий хилийн хэсэгт хүндрэлтэй бол говь, тал хээрийн бүсэд сөрөг нөлөө бага.

Улсын хилийг манах цэргийн хүч хэрэгсэл боломжтой хэдий ч уналга, тээврийн хэрэгслийн хүрэлцээ, хүчин чадлаас хамааралтай нөлөөлөл байнга оршсоор байна.

Ялангуяа хилийн манааны уналга, усанд хөвөх, ус гатлах хэрэгсэл, өндөр туулацтай техник, уулын тоног хэрэгслийн хангалт улсын хил манах үйл ажиллагаанд тулгамдсан асуудал хэвээр байгаа ба үүнийг улсын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх асуудал бөгөөд ХХБ өөрийн нөөц, урсгал төсвөөр гүйцэтгэх боломж хязгаарлагдмал болно.

Одоогийн ХХБ /ХЦ/-ын байгуулалт, цэргийн мэргэжлийн удирдлагын тогтолцоо хил манах үйл ажиллагааг улс орны хэмжээнд удирдах боломжийг хангаж байгаа болно.

ХХБ өөрийн хүч хэрэгслийг хилийн зурваст байрлуулан улсын хилийг хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэдэг ба хилийн зурвасыг хил хамгаалалтын эрх ашигт нийцүүлэн бүс нутгийн онцлог, хүн амын суурьшил зэргийг харгалзан ХХБ оновчтой тогтоох асуудал улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангахад чухал нөлөөтэй болно.

Улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагаа нь хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа бөгөөд энэ нь тухайн бүс нутагт Монгол улсын аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол хангагдсан байдлаар тодорхойлогдоно.

Улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагаа нь бүс нутгийн тодорхой цаг үеийн хамгаалалт бөгөөд үйл ажиллагааныхаа цар хүрээгээр орон нутгийн хамгаалалтанд хамаарах асуудал болно.

Улсын хилийг сэргийлэх хамгаалах үйл ажиллагааг тухайн бүс нутгийн газар зүйн тогтоц, нийгэм эдийн засаг, хүн амын суурьшил, хил хязгаарын аюулгүй байдал зэргээс үүдсэн нөлөөлөлтэй холбон судалж үзлээ.

Улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагааг хилийн бүх хэсэгт зохион байгуулах хүч хэрэгслийн боломж хараахан бүрдээгүй, хилийн нөхцөл байдал ч үүнийг шаардаагүй болно.

Улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагаанд улсын хилийн эрх зүйн зохицуулалтын асуудал чухал байр суурь эзлэнэ.

Хил залгаа улстай гэрээгээр тогтоосон хил нь зохицуулалттай байж, хилийн аливаа асуудал даамжирч хилийн маргаан, будлиан, цаашилбал мөргөлдөөн үүсэхээс сэргийлэн, хилийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх нь Монгол Улсын гадаад бодлого, батлан хамгаалах номлол, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж буй хил хамгаалалтын улс төр-дипломатын арга хэмжээ болно.

Улсын хилийн сэргийлэн хамгаалалтанд хилийн түүх, цаг

хугацааны хүчин зүйл тодорхой нөлөө үзүүлнэ. Хэдэн зуун жилийн улбаатай, судалгаатай тогтсон хил нь дөнгөж тогтосон болон маргаан бүхий хилээс эрс ялгаатай.

Манай улсын хойд хил нь Манж-Оросын хооронд хил орчмын бүс нутагт хүмүүсийн идэвхтэй үйл ажиллагаа, суурьшил явагдахаас өмнө тогтсон тул хүчээр тулган хүлээлгэсэн болон шинээр тогтоогдсон хилтэй харьцуулахад хүндрэл маргаан багатай.

Баруун хойд хилийн Увс Тувагийн хилийн хэсэг нь Тува улс ЗХУ-д нэгдсэний дараа дахин тогтоогдсон, хил тогтоох үйл ажиллагаа 1932 оноос Тува улстай, 1944-оос ЗХУ-тай явагдаж тогтоогдсон ба газар нутгийн зарим хэсгийн талаарх санал санагалзлага хүн амын дотор одоо ч оршсоор байна. Өмнөд хил нь олон жилийн улбаатайгаар аймаг, хошуудын хилийн дээс, хилийн цэсээр тогтоогдсон учир маргаан үүсэх шалтаг, шалтгаан байхгүй.

Баруун өмнөд хил говь цөл бүхий өргөн зурвас газраас зааглагдаж байгаад тогтсон ба хүн амын суурьшил байхгүй байсан нь маргаан гаргах үндсийг хааж байна. Улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагаанд хүн амын суурьшил, нутагшлын асуудал нөлөөлөхүйц хүчин зүйл хэвээр байна.

Хоёр улсын хилийн дагуу нийтлэг нэг, соёл, хэл угсаа нэгтэй хүмүүс суурьшсан тохиолдолд улсын хил нь нийгэм, эдийн засгийн харилцаанд хүчтэй түлхэц өгч найрсаг хамтын ажиллагааг тогтооход хөрс нь болж өгнө.

Гэвч улсын хил дээр угсаа зүйн ийм таатай нөхцөл байгаа хэдий ч хил хаалттай, нэвтрэхэд саадтай байвал иргэдийн найрсаг харилцаанд саад болдог төдийгүй эдийн засгийн сонирхол бүхий хил дамнасан гэмт бүлэглэл үүсэх шалтаг, шалтгаан нь болно.

Тагны урайнхайчууд Увс нуур орчмын нутаг дэвсгэрт нутагшиж байсныг Манжийн үед 1680 оноос Хан Хөхийн нуруунаас хойш татан нутаг шилжүүлснээс үүдэлтэй хилийн маргаан гарч байснаас хил тогтоох ажиллагаа 1932 онд эхлэн 1958 онд ЗХУ-ын дарамт шахалтын дор тогтоогдсон.

Хил тогтооход нөлөөлсөн нутаг суурьшлын байдал, хил хаалттай болсны улмаас энэ бүс нутгийн хилийн нөхцөл байдал бусад хэсэгтэй харьцуулахад төвөгтэй болж хил зөрчсөн үйлдэл нь хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалд халдаж байгаагийн улмаас 1990 оны эхнээс энэ бүс нутгийн хилийн хэсгийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагаанд шилжихэд хүрсэн.

ХХБ-аас үүдэлтэй хүчин зүйлийн нөлөөнд улсын хилийг сэргийлэн хамгаалах үйл ажиллагааг явуулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг улсын хилийг манах ажиллагаатай адилтгах байдлаар авч үзэж байгаагаас хилийн дэглэмийн зөрчил даамжирч хил дамнасан гэмт бүлэглэлийн үйлдэл болж өргөжсөн үүнээс үүдэн хил орчмын нутаг дэвсгэрт хулгай дээрмийн зорилгоор халдан хилийн бүс зурваст амьдарч буй иргэдэд эдийн засгийн хохирол учирч улмаар амьжиргаанд нь ноцтой нөлөөлснөөс сэтгэл санаа алдагдан хилийн бүс зурвасаас дамжин нүүх болон манай зарим иргэд үгсэн хуйвалдаж малыг сүргээр нь хил давуулан сэм худалдах

зэргээр Монгол улсын язгуур ашиг сонирхолыг хөндсөн зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэл таслан зогсоогдохгүй үргэлжилсээр байна.

10 жилийн давтамжаар хийсэн судалгаагаар хил манаж буй хилийн зарим тусгай анги /хилийн 6-р отряд/-ын хилийн хэсгээр жилд дунджаар 6 орчим хилийн зөрчил гарч байхад Увс Завханы хилийн хэсгийг хариуцдаг хилийн тусгай ангиудын хилийн хэсгээр 45-47 хилийн зөрчил гарч тэдгээрийн 80 хувь орчим нь зэвсэглэн, бүлэглэн халдсан зохион байгуулалттай гэмт хэргмйн шинжийг агуулж улсын хилийг сэргийлэн хамгаалах шаардлага байгааг харуулж байна.

Ийм өөр өөр нөхцөлд алба хааж буй хилчдийн цалин хангамж, хилийн тусгай анги, салбарын хүч хэрэгсэл ижил төдийгүй хилийг сэргийлэн хамгаалж буй хилчдийн хилийн албаны нэмэгдэл нь 20%-аар доогуур байна.

Улсын хил ялангуяа Буйр нуурын хилийн хэсэгт эдийн засгийн зорилготой хилийн зөрчил байнга гарч улсын хилийг сэргийлэн хамгаалах шаардлага байгаа хэдий ч хөвөгч хэрэгслийн хомсдлоос үүдэн хилийн зөрчил таслан зогсоогдохгүй даамжирсаар байна.

Улсын хилийг сэргийлэн хамгаалж буй бүс нутгийн хүч хэрэгслийг шат дараалан нэмэгдүүлж байгаа хэдий ч байгаль цаг уур, албаны ачаалалд нь тохирсон удирдлага, хүч хэрэгслийн хангалт, уналга тээврийн хэрэгслийн хүрэлцээ, хилчдийн цалин хангамж урамшуулал хил манах үйл ажиллагаа явуулж буй хилийн тусгай анги, салбарын түвшинд байгаа нь хил хамгаалах үйл ажиллагаа нь хангалт бус анги салбарт тэгшитгэсэн хувиарлалтаар материаллаг хэрэгсэл олгож байгаа түгээлт болж энэ нь хил хамгаалалтын шаардлагуудтай нийцэхгүй.

Хил хамгаалах үйл ажиллагаанд чиглэсэн, түүний төрлөөр хийгдэх хангалт чухал байна. Улсын хилийг сэргийлэн хамгаалж байгаа бүс нутгийн хэмжээнд гарсан хилийн зөрчил бусад хэсгүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр /5-8 дахин их/ байгаа нь 1998-2007 оныг хамруулан хийсэн судалгаагаар харагдаж байна.

Улсын хил дээр цэрэг улс төрийн нөхцөл байдал хурцадсан үед улсын хилийг хориглон хамгаалах тохиолдолд тухайн хэсгийг хамгаалж буй хилийн тусгай анги, салбаруудыг галын болон цохилтын хэрэгслээр хангах хилийн тактикийн бүлгүүдийг байгуулах, галын болон цохилтын, хүч хэрэгсэл давамгайлсан дэмжих отряд, хүч хавсаргасан салбаруудаар хүч нэмэгдүүлэх цаашид дайчилгаагаар өргөтгөсөн зохион байгуулах шаардлагатай болно.

Дүгнэлт

1. Улсын хил нь улс гүрний нутаг дэвсгэрийн заагийг, хязгаар нь газар нутгийн захыг тодорхойлж буй орон зайн хувьд нэгдмэл хил хязгаар гэсэн ойлголт, бөгөөд хилийн тухай, Монгол улсын олон улсын гэрээ, дотоодын хуулиар тогтоосон дэглэм бүхий хилийн дагуух зурвас газар бөгөөд түүхэн явцад "тусгаарлагч" агуулгыг илэрхийлж байснаа нийгмийн хөгжлийн аясаар "холбогч" үүрэг гүйцэтгэх болж өнөөгийн даярчлалын үед олон улсын анхаарлыг татсан улс төр, цэрэг, эдийн засгийн ач холбогдол бүхий шинжлэх ухааны судлагдахуун болж байна.

2. Улсын хил нь тогтоон тэмдэглэгдсэнээр бүрэн баталгаажиж бус хилийн асуудлыг зохицуулах гадаад /хилийн дэглэм/, хилийн бүс, зурвасын асуудлыг зохицуулах дотоод /хил орчмын дэглэмтэй/ байж олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалтаар төгөлдөржих, өөр хоорондоо нягт хамаарал бүхий судалгааны объект болно.

3. Улсын хилийн зохицуулалтад хил хамгаалалтын эрх зүйн, түүхэн цаг хугацааны болон хүн амын суурьшил зүй, ХХБ-ын үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлүүд голлон нөлөө үзүүлж байгаа бөгөөд эдгээрийг хил судлал,хил хамгаалах урлагын үүднээс шинжлэх ухааны үндэстэй нарийвчилсан судлах шаардлага байгаа. Хил хамгаалах үйл ажиллагааг "алба" хэмээн жижигрүүлсэнээр тусгай тактик ажиллагаа шаарддаг хил сэргийлэн хамгаалах, байлдааны ажиллагааны тактик шаарддаг хил хориглон хамгаалах асуудалд хүрээ хязгаар тогтоон ийм сэтгэлгээрүү хөтлөлж байна.

4. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийнхаа бүрэн бүтэн, хилийнхээ халдашгүй дархан байдал, хүн амынхаа удмын сан, соёл иргэншлээ хамгаалан үлдэх ариун албыг урьдаас харж, зэхэхийн тулд Үндэсний аюулгүй байдал гол нөлөө үзүүлэнэ гэж дүгнэж байна

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

Ц.Одбаяр. БХИС, БХУА-ын ЦСТ-ын ахлах багш, ,
ЦУ-ны магистр, докторант, дэд хурандаа

Нэг. Улсын хилийн аюулгүй байдлын тухай.

Улсын хилийн түүх нь ард түмний түүхийн салшгүй хэсэг бөгөөд эртний улсуудын, дундад зууны үеийн, уламжлалт буюу төрт улсын үеийн гэх мэт хөгжлийн урт удаан хугацааг туулан өнөөгийн төвшинд хүрчээ.

Орчин үеийн улсын хилийн үүслийг төрт улсын байгуулалтын үүсэлтэй холбож үздэг бөгөөд энэ үеэс хил нь улсын салшгүй шинж тэмдэг болсон гэж үздэг ба хилийн асуудлаас болж газар нутгийн маргаан нь нэг бус удаа цэргийн мөргөлдөөнд хүргэж тэр нь заримдаа дайн болон өргөжиж байв. Нутаг дэвсгэрийн бэрхшээлтэй асуудлуудад дэлхийн янз бүрийн бүс нутгуудын улс төрийн үйл явц нөлөөлж үүний үр дүнд дэлхийн улс төрийн газрын зураг тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж байжээ.

Даяаршиж буй өнөө цагт хилийн тухай ойлголтууд нь улмажлалт ойлголтоос халин газар нутгийн хил хязгаар, ашиг сонирхолын хил хязгаар, нийтлэг хил хязгаар, газар нутгаас ангид хил хязгааргэж мөн чанараар нь ангилагдах болж байна.

Монгол Улс хилийн орчин, хил хамгаалалт, хязгаар нутгийн талаар хууль тогтоомжид дараах байдлаар тусган баталгаажуулжээ.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд "Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь Монгол Улсын их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон

нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнуудаас бүрдэнэ"[3].

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 10 дугаар зүйлд "... үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах"[4]гэж тэмдэглэжээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын гуравдугаар бүлэгт "Оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм"[5], "Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно"[2.3] , "Хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана"[2.3]. гэжээ.

Улсын Их Хурлаас баталсан "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого" баримт бичигт "Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ" [2.5], "Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг, дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно" [2.7] гэж илэрхийлэгджээ.

Хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Хил залгаж байгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хил орчмын нутаг дэвсгэр" [3.29] гэж тодорхойлогдсон байна.

Дээр дурьдсан хууль, эрх зүйн заалтууд нь хилийн орчин болон хилийн аюулгүй байдалд нөлөөлөх,хөгжүүлэх асуудлыг төрийн хэмжээний бодлогод тусгалаа олсон байна.

Дэлхийн улс орон бүр өөртөө янз бүрийн хил хамгаалалтын системийг байгуулж хилийнхээ аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг явуулж байгаагийн дотор манай улс шиг өргөн уудам нутагтай, олон мянган километр урт хилтэй улсад хил хязгаар нутаг түүний хамгаалалтын асуудал чухал байр эзлэхийн дээр эдгээр асуудлууд нь улс орнуудын дотоодын хууль дүрмийн хүрээнээс халин гарч олон улсын шинж чанартай болж, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хилийн аюулгүй байдлын асуудал нь "Үндэсний аюулгүй байдал"-тай салшгүйхолбоотой бөгөөд улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал ба дотоодын тогтвортой, дэвшилттэй хөгжлийг хангаж, бүрэн эрхтэй, бие даасан байдлаар олон улсын харилцаанд оролцох боломжийг бүрдүүлэн[6], амьдрал, үйл ажиллагааны бүх салбарт гадаад, дотоодын аюул заналаас төр, нийгэм, хувь хүмүүсийн

[3] Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он. УБ хот

[4] Монгол улсын хилийн тухай хууль. 1993 он. УБ хот.

[5] Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он. УБ хот

[6] Правовая основа обеспечения национальной безопасности РоссийскойФедерации: Монография/Ю.И.Авдеев,С.В.Аленкин,В.В.Алешин и др/Подред. А.В.Опалева М.2004.с.15

язгуур эрх ашиг хамгаалагдсан байдал"[7] гэж тодорхойлсон нь бодит байдалтай тохирч байна.

Аливаа улсын төрийн бодлогын үндсэн зорилго нь хүн амынхаа элбэг хангалуун амьдрах орчин, нөхцөлийг хангах, үүнтэй зэрэгцэн эх орон ард түмнээ элдэв халдлагаас хамгаалах явдал юм. Энэ зорилгоор өөрийн үйл ажиллагааны бүхий л салбарт, гадаад, дотоод бодлогын хүрээнд төрөл бүрийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү үйл явцын амин чухал бүрэлдэхүүн хэсэг буюу хүчин зүйл нь улсын хил хамгаалалтаар тодорхойлогдох, улс орны нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах асуудал юм.

Хоёр: Хилийн аюулгүй байдалд нөлөөлөх орчин, ангилал.

Монгол Улсын хилийн орон зай нь улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал хангагдаж байгаа улсын хил, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэр, агаарын орон зайнаас бүрдэнэ.

Эдгээрийн аль нэг нь үгүй болох бол энэхүү үйл явц аяндаа мөн чанараа алдана. Үнэхээр ч эсрэг тал, сөрөг хүчин байхгүй бол өөрийн хүчээр үр ашиггүй хамгаалах шаардлагггүй юм.Эсрэг, тэсрэг хоёр хүчин нь орон зай, цаг хугацааны хувьд сөргөлдөх орчингүй бол мөн л үүнтэй адил аль аль нь хэрэггүй болно.

Өөрөөр хэлбэл бусад аливаа үйл ажиллагааны адилаар улсын хил хамгаалалт нь харилцан тэнцвэржсэн үйл явц учраас энэ үйл явц, үзэгдлийн шалтгаан үр дагаврын зүй тогтол нь мэдээжээр аль систем нь илүү сайн байна, тэр нь илүүтэйгээр хүссэн үр дүндээ хүрнэ гэсэн үг.

Эдгээр эсрэг, тэсрэг талуудын үйл ажиллагаанд шууд оролцогч гуравдагч хүч болох "хилийн орчин" онцгой чухал нөлөөтэй болно.

Энэхүү хүчийг шууд ба шууд бус нөлөөлөх орчин гэж авч үзэж болно.[8]

А. Шууд нөлөөлөх орчин нь:

1. Физик газар зүй, цаг улирал;
2. Байгаль-экологи;
3. Хүн амын тоо, нягтрал;
4. Хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжил, аж байдал;
5. Эсрэг тэсрэг талуудын хүчний харьцаа болон төрөл, хэлбэр;
6. Цэрэг, техникийн хүчин чадал;
7. Хилийн орон зай дахь сөргөлдөх талын үйл ажиллагааны төрөл, хэлбэр, давтамж, далайц;

Б. Шууд бус дам нөлөөлөх орчин:

1. Улс төрийн;
2. Нийгэм-эдийн засгийн;
3. Хууль эрх зүйн орчин;
4. Хил залгаа улсын харилцаа, хамтын ажиллагаа;
5. Улс орны хөгжлийн байдал зэрэг болно.

Эдгээр "орчин"-ыг ерөнхийд нь гадаад, дотоод орчнуудад хуваан авч үзэх бөгөөд тэдгээрийн нэгдмэл байдал нь аль болох ойр байх нь чухал.

Хилийн аюулгүй байдалд дээрх орчнууд нь дараах байдлаар нөлөөлж байна.

1. <u>Шууд нөлөөлөх орчин:</u>

а. Физик нөлөөлөл, цаг улирлын орчин:

[7] Возженников А.В. Парадигма национальной безопасности реформирующейся России.М.2000.с.48

[8] Н.Наранжамц. Улсын хил хамгаалалтын онол практикийн үндсэн асуудлууд. УБ. 2008 он. т-7

Монгол Улсын байгаль цаг уурын онцлог, нөхцөл байдал нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулахад зайлшгүй анхаарвал зохих чухал хүчин зүйл, хөдөлгөгч хүч юм.

Байгаль цаг улирлын өөр өөр нөхцөл байдал нь хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулах, улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчигчдийн үйлдлийг таслан зогсооход эерэг болон сөрөг хүчин зүйлсийг үзүүлж байдаг. Зарим тохиолдолд эцсийн үр дүнд ч нөлөөлдөг онцлогтой

Цаг улирлын нөлөөллийн орчны аюул нь:

- Цаг агаарын эрс тэс байдал нь хил хамгаалалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.

б. Байгаль-экологийн орчин;

Бид газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлын төлөө хоёр хөрш хийгээд бусад улстай дайтаж явсан. Энэ түүх одоо мартагдах учиргүй одоо хэр бидний дунд байсаар байгаа бодит түүх. Монгол Улс байгалийн баялгийн нөөцөө ашиглаж эхэлсэн цагаас хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдлын тухай асуудал хөндөгдөж ирсэн.

Газар зүйн хувьд Монгол улсын бүх аймагт лиценз олгогджээ. Нийт лицензийн 80 гаруй хувь нь буюу 4205 нь хайгуулын, харин үлдсэн 20 гаруй хувь буюу 1063 нь ашиглалтын лиценз байна.

Товчхон дурьдсан эдгээр тоо баримт нь Монгол Улсын хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал алдагдах, малчид нь малаа бэлчээх газаргүй, иргэд нь өмчлөх газаргүй, аялагчид нь аялах газаргүй болох нөхцөл үүсч байна.

Аюул нь:

- Нийт газар нутгийн дал гаруй хувь нь цөлжиж, ан амьтан үгүй болж, биологийн төрөл зүйл устан үгүйрч, усны нөөц хомсдон бохирдож, нийслэл хотын төдийгүй аймаг, сумдын агаарын бохирдол үндэсний гамшиг болж, алт, зэс, үнэт метал, байгалийн баялагаа ашиглах нэрээр газар шороогоо эрэмдэг зэрэмдэг болгоод зогсохгүй, лизенц нэрийн доор харийнханд нутаг усаа алдах аюулд нэрвэгдсэн.

в. Хүн амын тоо, нягтралын байдал;

Хил орчмын нутаг дэвсгэр тодорхойлогдож, өнөөгийн байдлаар хилийн бүс, зурваст хилийн 21 аймгийн 70 шахам хувь буюу 14 аймаг нь, Монгол улсын бүх 339 сумын тавны нэг буюу 70 сум байрлаж, тэнд ойролцоогоор 285 мянган хүн ам буюу Монгол улсын хүн амын 10 орчим хувь нь оршин амьдарч байна. Гэтэл 1.3 сая хүн ам буюу 48 орчим хувь нь Монгол улсын нийслэлд төвлөрөн амьдарч байна.

Аюул нь

- Хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйдэх,
- Хязгаар нутгийн хөгжил зогсонги байдалд орох, хөгжихгүй байх,

г. Хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжил, аж байдал;

Монгол улсын эртний түүхээс харахад хүн амын дийлдэнхи хувь нь хил, хязгаарын нутаг дэвсгэрт амьдарч хилийн аюул гарч болзошгүй чиглэлүүдэд овог, аймаг, хошууг тухайн чиглэлд шилжүүлэн суурьшуулан аюулгүй байдлыг хангаж ирсэн сайхан уламжлал, түүх байдаг. Ингэж үзвэл

Монгол улсын хүн ам, эдийн засаг, соёл, боловсрол, хот байгуулалт, дэд бүтэц төвдөө бус хил, хязгаартаа онцгой анхаарал хандуулан төвлөрсөн байдаг эртний уламжлалт бодлого, зарчим алдагдаж байгаа байдал ажиглагдаж байна.

Аюул нь:

- Хот суурин газарт хэт төвлөрөл үүссэнээс ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, нийгмийн бухимдал эцсийн цэгтээ хүрэх.

д. Эсрэг тэсрэг талуудын хүчний харьцаа болон төрөл, хэлбэр;

Манай улсын мөнхийн хөрш ОХУ, БНХАУ нь иргэдээ аль болохоор хилийн шугам, хязгаар нутагтаа ойр байршуулах системтэй арга хэмжээ авч тэнд хот, тосгодуудыг өргөнөөр бий болгон хягаар нутагт оршин суугчдын эрх эрх чөлөө, аюулгүй байдал, нийгэм хангамж, эдийн засгийн боломжийг дээшлүүлэх системтэй арга хэмжээ авч байна. Түүний тод жишээ бол БНХАУ-ын 120 гаруй мянган хүн амтай, дэлхийн хилийн тэргүүлэх арван хот маягын тосгонд багтах Эрээн хотыг жишээ болгон хэлж болно.

ОХУ нь холбооны хилийн албаны үйл ажиллагаанд эрс шинэчлэлийг хийж, хил хамгаалалтад техник, технологийн ололт, хяналтын сансар, агаарын системийг нэвтрүүлэн, мэргэшсэн чадварлаг бүрэлдэхүүнийг гүйцэтгэх ажлын хэлбэртэй хослуулан ашиглаж байгаа ба улсын хилийн багана тэмдэг, шугамыг байгаль цаг уурын нөлөөллийг үл харгалзан өдөр шөнөгүй байнгын хяналтад авч хамгаалалтандаа нисэх онгоц нисдэг тэрэг, нисгэгчгүй аппаратыг өргөн ашиглаж байна. Түүнчлэн улсын хил хязгаарын дэд бүтэц, зэвсэглэл техникийн хангалт үйлчилгээг хариуцсан тусгай агентлагыг засгийн газрын дэргэд байгуулан ашиглаж байна.

Хятадын тал хилийн хамгаалалтын анги, салбаруудыг цэрэг, орон нутгийн цагдаа, ард иргэдийн оролцоотойгоор хилийн шугам руу аль болох ойрхон байрлуулж, хамгаалах төрийн бодлого баримтлан, улсын хилийн дэд бүтэц, хилийн инженер, техникийн төхөөрөмжлөлийг идэвхитэй явуулан хамгаалалтад техникийн хэрэгсэлийг өргөн ашиглаж байна.

е. Цэрэг, техникийн хүчин чадал;

Монгол Улс бусад улс орон, олон улсын байгууллагуудтай цэргийн салбарт хамтран ажиллаж, өөрийгөө болзошгүй түрэмгийллээс урьдчилан сэргийлэх, хамтын хүчээр батлан хамгаалах бодлогодоо хөрш зэргэлдээ, гурав дахь улс гүрэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын бусад нэгдсэн зэвсэгт хүчнийг ашиглах чиг баримтлан, Улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах чадвартай үндэсний зэвсэгт хүчин, бусад цэрэгтэй байх;[9]

Дэлхийн улс орнууд өөрийн батлан хамгаалах, цэрэг, техникийн хүчин чадлаа нэмэгдүүлснээр тухайн бүс нутагтаа өөрийн нөлөөллөө дээшлүүлж, тэргүүлэх чиг хандлагтай болж байна.

2. <u>Шууд бус дам нөлөөлөх орчин:</u>

а. Улс төрийн орчин;

Улс төрийн бодлого гэдэг бол үндсэндээ төрийн, намын, эрх баригч

[9] Оршин тогтнохуйн аюулгүй байдал. http://www.kyzyl.mfa.gov.mn/index.php?option=com_content&view

байгуулгын бодлого юм. Хилийн аюулгүй байдлыг хангахад улс төрөөс баримтлаж байгаа бодлого, түүний хэрэгжилтийг хангах асуудал тулгамдсан асуудал болж байна. Хил хамгаалах байгууллагаас улс төрийн орчинд үйл ажиллагаагаа танилцуулах, хилийн талаар тулгамдсан асуудлаа ойлгуулах асуудал чухал байна. Яагаад гэвэл хилийн асуудлыг улс төрийн аль ч хүчин гарч ирсэн аль нэг салбарын хавсрага байдлаар явуулах, үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулах, задлах, хүчгүйдүүлэх байдал гарч байгаагын нэг илрэл нь хилийн шалган нэвтрүүлэх албыг салгасан явдал юм.

б. Нийгэм-эдийн засгийн орчин;

Энэ асуудал нь хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, хилийн аймаг, сумдыг хөгжүүлэх байдлаар илэрхийгдэнэ.Нийгмийн эрх ашиг нь ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн зөвшилцөлд хүрч, нийгмийн амьдралыг тогтворжуулах, улс төрийн сэргэн мандалт, ардчиллыг бүтээн байгуулах идэвхийг өрнүүлэхэд оршино.улс орны эдийн засаг хөгжлийнхөө дараачийн шатанд шилжиж байгаа одоогийн нөхцөлд улсын хил хамгаалах байгууллага, үйл ажиллагаандаа нөлөөлөх сөрөг орчнуудыг хэрхэн арилгах, төр нийгэм, байгууллага, хуулийн этгээдээс үйл ажиллагааныхаа орчинг төгөлдөршүүлэхэд ашиглаж болох ямар боломж байгааг судлан шинжилж, төрөөс хилийн талаар баримтлах бодлогод зохих өөрчлөлтийг оруулан стратеги, оператив тактикийн төвшинд хэрхэн дэс дараатай бодлого, үзэл баримтлал болгон явуулж

- ***Хууль эрх зүйн орчин;***

Хил хамгаалалт, хилийн орон зайд үйлчилэх хууль эрх зүйн орчин нь бүрдсэн гэж үзэж болно. Хамгийн гол нь батлагдсан, хүчин төгөлдөр байгаа хуулиудыг хэрэгжүүлэх ажиллагаа хангалтгүй байна.Улсын хилийн халдашгүй дархан байдалтай холбоо бүхий асуудлыг улс бүр дотооддоо тогтоосон эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж байдаг бөгөөд үүнд чиглэгдсэн улсын хил орчмын дэглэм, хилийн боомтод мөрдөх журам, улсын хил нэвтрэх журам зэрэг эрх зүйн актуудыг боловсруулан хэрэгжүүлдэг.

- ***Хил залгаа улсын харилцаа, хамтын ажиллагаа;***

Хил залгаа улсууд болон бусад улстай харилцаа хамтын ажиллагааны шинэ түвшинд хөгжиж байна. Энэ үйл явцыг 2014 онд болсон хөрш улсын тэргүүнүүдийн Монгол улсад хийсэн айлчлал, айлчлалын үр дүнд хийгдэж байгаа ажлуудаар илэрхийлэглдэж байна. Мөн Хил хамгаалах байгууллагын гадаад хамтын ажиллагаа ч тодорхой хэмжээнд хөгжиж байна.

<u>Гурав. Санал дүгнэлт:</u>

Улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, орчныг бүрдүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах чиглэлээр анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

1. Хилийн аюулгүй байдлын орчин, хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх асуудлыг төвөөсөө буюу улсын нийслэлээс бус хил хязгаар нутгаас эхлэн хөгжүүлэх, хил орчмын иргэдийг тогтвор суурьшилтай, амьдралын баталгаатай, ирээдүйдээ итгэлтэй байх нөхцлийг хангах асуудалд төрийн бүх байгууллагууд болон яамдын үйл

ажиллагааг уялдуулах

2. Монгол улсын бүсчилсэн хамгаалалтын үзэл баримтлалын дагуу бүсүүдийн төвүүдийг зохих журмаар бий болгон тухайн бүсийн нутаг дэвсгэр, орон нутгийн болон хил хязгаарын хамгаалалт, эдийн засаг, нийгмийн хангамж, дэд бүтцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх механизм, арга хэлбэрийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх.

3. Аливаа улсын хил, хязгаар нутаг аюулгүй тайван, амар амгалан байх нь тухайн улсын оршин тогтнохуйг тодорхойлогч тулгуур асуудал болсон өнөөгийн нөхцөлд улсын хил халдашгүй дархан байх; Улсын хил бүрэн бүтэн байх; улсын нутаг дэвсгэр нь бүрэн бүтэн байх тухай шинэ зарчмууд эрх зүйн хүрээнд буй болж улмаар улс үндэстний аюулгүй байдлын баталгааны үндэс суурь болох тул батлагдан гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд онцгой анхаарах.

4. Хөрш зарим улс, улсын хилийн халдашгүй дархан байдлаа хангах тогтолцоог төрийн бодлогоор зохицуулан "Хил баян бол улс баян", "Хил амгалан бол улс амгалан", "Хил хүчтэй бол улс хүчтэй байна" гэх зэрэг уриан доор өөрийн улсдаа хэрэгжүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ИННОВАЦИ

Н.Батдэлгэр. БХИС-ийн БХУА-ийн магистрант, хошууч

Товч агуулга. Монгол Улсын 8252,6 км урт хил, тэрхүү хилийн шугамаар зааглагдсан Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаар хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдал, тэр тусмаа хилийн аюулгүй байдлыг хангах асуудалыг нэн чухал, тэргүүлэх чиглэлийн хэмжээнд авч үзэх нь зүйтэй. Хилийн аюулгүй байдлын асуудал нь хөрш ОХУ, БНХАУ-ын хил орчимын зах хязгаарт оршдог аймаг, хошууд, районууд түүнчлэн олон улсын зэрэглэлтэй хилийн боомтуудын бодлого үйл ажиллагаатай шууд холбогдох учраас олон улсын шинж чанар ач холбогдолтой юм.

Үндсэн хэсэг:

Улсын хил, хязгаарын аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа түүнтэй холбогдсон оюуны бүтээлийн үр дүн, практикийн үр ашгийн цогцыг хүчний байгуулагын байр сууринаас авч үзвэл инновацид хамаарахгүй гэж үзэх үзэгдэл хандлага цөөнгүй гардаг. Яагаад гэвэл материалаг баялаг бүтээдэггүй, харин материалаг баялгийг зөвхөн ашиглагчид мэтээр хандах явдал гардаг. Бодит байдлыг обьектив мэдлэгийн хүрээнд улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын үр дүнтэй холбон авч үзвэл тэгж авч үзэх нь өрөөсгөл, оновчтой бус гэж хил судлалын олон эрдэмтэд үздэг.[1]

Олон Улсын хил судлалын эрдэмтэн Боярский.В.И. тэмдэглэхдээ "хилийн албыг материалаг баялгыг эзэмшигч бөгөөд юу ч үйлдвэрлэж гаргадаггүй гэсэн алдаатай үзэл баримтлал байдаг. Харин судалгаа шинжилгээнээс харахад хилийн албаны үйл ажиллагаа нь улсын хил болон хязгаарын орон зайн эрх зүйт дэглэм, эцсийн эцэст улс, нийгэм, хувь

хүний аюулгүй байдал хил хязгаарт хангагдсан түвшинг багтаасан бодит бүтээгдэхүүн болох нь батлагдсан юм"[10] гэжээ. Эцсийн энэхүү бүтээгдэхүүнийг үнэ мөнгөн талаас нь авч үзвэл улсын хилийг зөрчих, аюул учруулах үйлдлүүдийг таслан зогсоосон үнэ цэнэ, улсын хилээр нэвтрэх зорчигчид хил хязгаарт оршин суудаг иргэдэд үзүүлсэн тус дэм үйлчилгээ, байгаль, соёл, эдийн засгийн баялагийг хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс сэргийлэн хамгаалсан үнэ цэнээр хэмжигддэг. Энэ бүхэн яван явсаар хилийн албанд зориулан зарцагдах мөнгөн эквивалент, үнэн чанартаа нөгөөх л улсын хилийн тухай шинжлэх ухаан, судалгаа шинжилгээг хэвийн явуулж хөгжүүлэхэд зориулагдсан үнэ цэнээр хэмжигддэг тухай энэхүү эрдэмтэн өөрийн санааг илэрхийлжээ. Иймээс Улсын хилийн халдашгүй дархан байдал, улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь шинжлэх ухааныг нийгмийн хөгжлийн тодорхой үе шатанд тодорхой орон зайд хэрэгжүүлж байгаа баялаг болох нь илэрхий байгаа юм. Энэхүү баялаг нь аливаа тусгаар тогтносон улсын байгалын ба нийгмийн баялагыг улсын хил, хязгаарт хамгаалж байгаа онцлог, шинж байдлаар мөн чанар нь илэрдэг байна. Энэ байр сууринаас авч үзвэл хил хамгаалалт нь улсын хилийн тухай шинэ мэдлэгийг XXI зуунд баялаг болгон хувиргаж байгаа нэгэн хэлбэрийн инновации гэж хэлж болохоор байна. Монгол Улсын жишээн дээр авч үзвэл энэ нь орчин үед онол эрх зүй, практикийн тодорхой үндэслэлээр батлагдаж байгаа юм.

Монгол Улсын шинжлэх ухаан технологийн тухай хуульд "Инновации гэж эрдэм шинжилгээний үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгож зах, зээл, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа юм"[11] гэж тодорхойлжээ. Харин Монгол Улсын инновацийн тухай хуульд "шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явц", "шинэ мэдлэг гэж шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны бүтээлийг хэлнэ"[12] гэж тэмдэглэжээ. Монгол Улсын төрөөс Улсын хилийн талаар баримтлах бодлогод "хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого үйл ажиллагааны үндэс болгох"[13] тухай хууль эрх зүйн баталгаа бий болгожээ.



Инновации гэдэг нь шинэлэг гэсэн санааг илэрхийлсэн гэсэн утга бүхий англи үг юм.

Инновации хэрэгжүүлэхэд илүүтэй анхаардаг орнууд: Инновацийг төрийн бодлогоор дэмжин улс орноо хөгжлийн өндөр түвшинд хүргэж, улмаар иргэдийнхээ амьдралын түвшинг эрс дээшлүүлж чадсан улс

[10] Олон улсын эрдэм шинжилгээний хурал. А.Муратхан "Улсын хил хязгаарын орон зайд үндэсний аюулгүй байдлыг хангахад, инновацийг ашиглах зарим асуудал"

[11] Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль.

[12] Монгол Улсын инновацийн тухай хууль 2012.

[13] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар. тогтоол

орон олон бий. Энд Өмнөд Солонгос, Нидерланд, Канад, Англи, АНУ, Швед, Франц, Япон, Герман, Австрали улсууд дэлхийд эхний аравт ордог. Өмнөд Солонгос 1960-аад оны үед дэлхийн хамгийн ядуу буурай орны нэг байсан бол технологи дамжуулалтыг төрийн бодлогоор дэмжиж, гадаадаас оруулж ирсэн технологийг хэрэгжүүлэн үйлдвэрлэлээ хөгжүүлж чадсан юм.

Инновацийн хөгжил бусад оронд: Орчин үед олон орны засгийн газар шинжлэх ухааны судалгаа, инновацийн үйл ажиллагаанд ихээхэн хөрөнгө оруулдаг. Жишээлбэл Герман улс шинжлэх ухааны салбарт ДНБ-ний 2,7%, АНУ — 2,8 %, Япон — 3,5 % зарцуулдаг бол, шилжилтийн эдийн засагтай орнууд харьцангуй бага хэмжээтэй хөрөнгө оруулдаг: Белорусс — 0,74 %, Орос — 1,04 %, **Монгол улс 0,2% зарцуулдаг.**

Инновацийн хөгжлөөр Хүний хэрэгцээг мэдэж, түүгээрээ шинэ технологи бүтээж байгаа, чадварлаг хүний нөөцтэй Энэтхэг, өмнөд Солонгос зэрэг орнууд өндөр хурдаар инноваци гарган авч байна. Инновацийн индексээр өмнөд Солонгос улс дэлхийд тэргүүлдэг. Энэтхэгийн хувьд биотехнологийн салбарыг түшиглэсэн инноваци хурдаа авч байна.

Инновацийн сөрөг тал: Бодлогогүй шинэ зүйл хохиролд хүргэдэг, манай улс 1990-иэд оны эхэнд эдийн засгийн шинэчлэлтийг цочир эмчилгээ" загвараар эхэлсэн нь хямралд хүргэсэн гэж эрдэмтэд, эдийн засагчид үздэг.

✓ Шинэ мэдлэг, мэдээллээс инноваци гаргаж авахад үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг нь мэдээллийн технологи, биотехнологи, нанотехнологи зэрэг нь түргэн хөгжиж байгаа салбарт ажиглагдаж байна.

✓ Шинэ зүйл өмнөхөө шахан зайлуулдаг. Телевиз, интернет дэлгэрснээр номын хэрэглээ, театрын үйлчилгээ багасав. Гэтэл одоогоор мэдлэгийн үнэт баялаг номын хуудсанд, номын санд хадгалагдсан хэвээр байгаа нь үнэн билээ.

УАБ-г хангахад, улсын хилийн орон зайд инновацийг ашиглах талаар: Эрдэмтэн судлаач, доктор, профессор, хурандаа А.Муратханы "Улсын хил, хязгаарын орон зайд үндэсний аюулгүй байдлыг хангахад инновацийг ашиглах нь" сэдэвт олон улсын онолын бага хуралд тавьсан илтгэл, судалгаанаас үзвэл улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах ерөнхий инновацийг дараах байдлаар авч үзсэн байна:

➢ Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах чиглэлийн инноваци;

➢ Хил орчмын нутаг дэвсгэр буюу хязгаарийг бүрэн эзэмшилтэй болгож, тэнд улс, нийгэм, иргэний эрх ашгийг хамгаалах таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлийн инноваци;

➢ Мөн хил хамгаалах мэргэжлийн ба боловсролын байгууллагуудын бодлого үйл ажиллагааны чиглэлийн инноваци гэсэн гурван салбар системд багтаан авч үзсэн байна. Энэхүү илтгэл нь МУ-н хилийн орон зайд Үндэсний аюулгүй байдлыг хангахад инновацийг ашиглах талаар тавигдсан хамгийн анхны бөгөөд шинэлэг судалгааны ажил юм. Би дээрхи инновацийн 3 чиглэлээс улсын хил нь олон улсын

статус бүхий шинж байдал онцлогтой уялддагийг харгалзан **"Хоёр улс - нэг хил" гэдэг зарчмаар инновацийг хөгжүүлэх боломж"** гэсэн сэдвийн хүрээнд судаллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна"[14] гэж заасан. Улсын хил өөрчлөгдөх, зөрчигдөх нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн нэг нь болдог гэж үздэг. Улсын хилийн тухай ойлголтыг Монгол Улсын хилийн тухай хуульд тодорхой зааж өгчээ. Тэнд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр, хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уг шугамаас эгц дээшээ агаарын, мөн шугамаас эгц доошоо газрын хэвлийн хил байна"[15] гэжээ. Эндээс харахад Улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн инноваци байх нь зүй тогтолтой юм.

Монгол Улс нь ОХУ-тай 3543 км, БНХАУ-тай 4709,6 км бүгд 8252,6 км урт хилтэй. Хилийн шугамыг геодезийн аргаар мадаггүй тогтоож нэг тэмдэгээс нөгөө тэмдэг хүртэл 2,4 км дундаж нягтралтайгаар байгуулж төхөөрөмжилсөн юм. Хилийн үндсэн тэмдгүүдийн ихэнхэд Монгол Улс, хөршлөх хоёр улсын төрийн далбааны өнгөөр чимэглэж улс бүрийн төрийн сүлд тухайн улсын нэрийг багана тэмдгийн дээд хэсэгт соёрхон байрлуулж баганы оноосон дугаар, хэдэн онд байгуулсан огноог тодорхой харуулан тэмдэглэдэг. Өөрөөр хэлбэл хилийн багана тэмдэг нь нэг ёсны хоёр улсын бүрэн эрхэт этгээдээс өөр хэн ч халдахгүй, халдашгүй дархан эрхтэй нандин эрдэнэ онцгой төрлийн баялаг болж байгаа юм. Монгол Улсын хилийн шугам багана, тэмдэгт холбоос авсан зүйлсүүд нь зөвхөн манай улс төдийгүй хөршлөх улсуудын онцгой анхаарал татдаг, олон улсын багана тэмдгийг манаж хамгаалах, чанарыг нь сулруулахгүйгээр засаж хэвийн байлгах, улсын хилээр гарах, орох, дамжин өнгөрөх, нэвтрэх, хилийн асуудлуудыг энхийн журмаар хамтарч шийдвэрлэх гэх мэт нарийн дэглэм журмыг Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажуулсан байдаг онцлогтой. Улсын хилийн гэрээнд ямар нэгэн хугацаа заадаггүй. Энэ нь гэрээний хэрэгжилтийн мөнхийн шинжийг илэрхийлдэг. Улсын хилийн хувьд Монгол Улсад шийдвэрлэгдээгүй асуудал байхгүй. Харин Улсын хилийн хэн ч халдашгүй дархан байдлыг хангах чиглэлээр манай улсын хүлээсэн чиг үүрэг, тэр тусмаа инновацийн түвшинд тулгамдсан асуудал багагүй байгаа юм. Тухайлбал, Монгол Улсын баруун ба умард хэсгийн хилийн үлэмж хэсэг нь уулархаг, байгалын бэрхшээл ихтэй учраас хилийн багана тэмдгийг анх тавьж байршуулхад түүнчлэн явцад бүрэн бүтэн байдлыг нь хянах шалгах, засварлахад нисдэг тэргээс өөр төрлийн тээврийн хэрэгсэл ашиглагдах бололцоогүй байдаг юм. Хилийн тэрхүү хэсэг мөн улсын хилийн зөрчлийг бусад зарим хэсэгт шийдвэрлэхэд нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэх хэрэгсэл бусад тусгай хэрэгсэл ашиглах бололцоо бүрдэж чадаагүй байна. Энэ асуудлыг

[14] Монгол Улсын Үндсэн хууль УБ.1992.

[15] Монгол Улсын хилийн тухай хууль. 1993.

шийдвэрлэх нь инновацитай холбогдож байгаа тулгамдсан асуудлын нэг нь болж байна. Гэтэл манай хоёр хөрш улс энэ асуудлыг цаг хугацааны хувьд биднээс өмнө шийдэж, хил хамгаалалтандаа ашиглаж байгаа бөгөөд бид энэ тал дээр хамтран үр дүнтэй ажиллах хэрэгтэй байна.[1]

1990-2013 оны хоорондох 13 жилд дунджаар нэг жилд 1197 этгээд хил зөрчиж долоо дахин өсжээ. Улсын хилийг хууль бусаар нэвтэрэх нь нэгэн зэрэг хоёр улсын хилийг зөрчиж байгаа ноцтой хэрэг.

XXI зуунд хилийн шугамыг өдөр шөнөгүй техникийн хяналтад авах шаардлага зүй ёсоор гарч байна. Шаардагдах хөрөнгө их байгаа нь мэдээж. Олдсон хөрөнгийг үр ашигтай ашиглах үүднээс зөрчил гарч болзошгүй гэж тооцсон онцгой чиглэлд энэ төрлийн инновацийг эхний ээлжинд хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Одоогийн байдлаар дохилол хяналтын системд Монгол Улсын хилийн шугамын 9,6% хамааруч мөн олон улсын онцгой анхаарал татдаг шалган нэвтрүүлэх боомтууд энэ системд шилжив. Монгол Улсын хилийн албанд нэвтэрсэн инновацийн үр дүн нь цаашид энэ чиглэлээр шат дараатай бодлого үйл ажиллагааг хөгжүүлэх итгэл найдвар төрүүлж байгаа юм.

Улсын хил нь олон улсын статус бүхий шинж байдал онцлогтой уялдагийг харгалзан "хоёр улс- нэг хил" гэдэг зарчмаар инновацийг хөгжүүлэх боломж

Улсын хилийн инновациар манай хоёр хөрш улсууд өндөр хэмжээнд үнэлэгдэх арвин туршлагатай. Хөрш улсууд улсын хилээр зааглагдсан тус тусынхаа нутаг дэвсгэрийн зах хязгаарыг эзэмших, тэндэх хөгжлийг эрчимжүүлж төр, нийгэм, иргэдийнхээ язгуур эрх ашгийг хамгаалах чиглэлээр бидэнд сайхан үлгэр дууриал үзүүлж байгаа юм.

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нэгэн эрх ашиг зорилгод нийцүүлэн инновацийг харилцан туслаж хамтран ажиллах чиглэлээр хөгжүүлэх өргөн боломж бий болсоор байна.

Саяхан БНХАУ-ын дарга Си Зиньпин, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар манай улсад зочилж Монгол Улс БНХАУ-ын хооронд стратегийн иж бүрэн түншилэл, Монгол Улс ОХУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг өргөн дэлгэр болгох талаар гаргасан шийдвэрүүд, боломжийг улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйлсийг улам төгөлдөр болгож хил хязгаарт үндэсний аюулгүй байдал хэрэгжих таатай нөхцөл бүрдүүлэх ялангуяа энэ салбарт инновацийг бүтээлчээр хэрэгжүүлж хөгжүүлэх олон талын үр ашигтай нөлөөлөл боломж нээгдэж байна. Улсын хилийн асуудлыг хөршлөх улсууд олон улсын эрх зүйг баримтлан ёс мэт хамтран шийдвэрлэдэг зүй тогтолтой. Харин хилээр зааглагдсан газар нутгийг нь тухайн улс өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх эрхтэй байдаг.

Манай өвөг дээдсийн олон мянган жилийн түүхэн уламжлал, эмпирик байр суурьнаас судлан үзэхэд Монголын Төр Улсын хилд ойр байгаа хязгаар нутгийг "гэр цэрэг" буюу "өрх"-өөр, аравтаар, зуутаар, мянгатаар хилээ манах

хамгаалах тогтолцоонд үндэслэгдсэн овог, аймгаараа нутаг дэвсгэрийнхээ зах хязгаарыг хамгаалах харин нутгийнхаа гүний болон төв хэсгийг ариун тагшин байдлаар хадгалж өөрөөр хэлбэл нөөц баялаг болгон ашиглах бодлого үйл ажиллагаа баримталж иржээ.

Гэтэл гадаадын бодит байнгын аюул занал болон дотоодын субьектив олон хүчин зүйлүүдээс шалтгаалан зүй тогтолт энэ бүтээлч тогтолцоо алдагдахад хүрсэн гэм бий. Орчин үед Монголын хүн амын 60 шахам хувь нь Монгол Улсын нийслэл, түүний ойр орчмын төвлөрсөн газруудад оршин сууж амьдарч байна. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хил хязгаар талаас нь харгалзан үзэж үндэсний аюулгүй байдлыг нэн тэргүүнд улсын хил хязгаарт хангах таатай нөхцөл бий болгох онол, бодлого үйл ажиллагааг багтаасан инноваци хэрэгтэй байгаа бөгөөд хөгжлийн хэрэгжилт нь эхний шатанд явж байгаа юм.[1]

Улсын хил өөрчлөгдөхгүй, зөрчигдөхгүй байх материалаг орчин бүрдүүлэх төвшинд хилийг төхөөрөмжлөх зайлшгүй шаардлага гарч байна. Хил манах, хамгаалахад шаардлагатай техник, тусгай хэрэгслийг үйлдвэрлэх бололцоогүй манай улсын хувьд харин хувь, заяагаар мөнхийн хөрш болсон өндөр хөгжилтэй хоёр гүрэнтэйгээ айлсан оршиж **"нэг хил хоёр улс"** гэсэн өндөр эрх ашгийн зарчимд нийцүүлэн ОХУ, БНХАУ-ын техник, технологийг хилийн албанд түлхүү ашиглах чиглэлээр инновацийг хөгжүүлэх нь аль аль талдаа үр ашигтай ач холбогдолтой гэж манай эрдэмтэн судлаачид үздэг. БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад айлчлах үеэр хэлэхдээ "Хятад Монгол хоёр улс бие биедээ тустай сайн хөрш болох ёстой", "Хятад Монгол хоёр улс харилцан ашигтай хамтдаа хожих сайн тунш болох ёстой", "Хятад Монгол хоёр улсын иргэд үргэлж харилцан зочилсон сайн найзууд болох ёстой"[16] гэдгийг тэмдэглэсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В Путин манай улсад айлчлах үеэр хэлэхдээ "цаашид Монгол Улсын бүх салбарт хамтран ажиллахад бэлэн байна" гэж онцолсон нь Монгол Улс ОХУ-ын хооронд Улсын хилийн харилцааг хөгжүүлэхэд түүхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага, албыг шинэ зууны өнгө төрхөөр өөрчлөн хөгжүүлэхэд АНУ, Япон, БНСУ, ХБНГУ, Энэтхэг, Израйль зэрэг гурав дахь хөрш улсуудын туршлага дэмжлэг туслалцааг авч хамтын ажиллагааг үр ашигтай хөгжүүлэх ажил бас өрнөж байна.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого гэсэн эрх зүйн баримт бичигт "Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна" гэж туйлын чухал заалт орсон байна. Мэргэжлийн байгууллагын хувьд Монгол Улсын засгийн газрын тохируулагч агентлаг болох хил хамгаалах ерөнхий газар нь төрийн хилийн бодлогыг

[16] өнөөдөр сонин. 2014.08.25. №195 (5289)

хэрэгжүүлэгч субьектүүд, шинжлэх ухаан боловсролын байгууллагууд, тэр дундаа техник технологи, инновацийг үйлдвэрлэгч, бүтээгчидтэй сайтар хамтран ажиллаж, шаардлагатай тохиолдолд тэднийг өөрийн төсвөөс санхүүжүүлж дэмжих, бүтээл хийх орчныг нь бүрдүүлэх зэрэг цогц уялдаатай арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд Шинжлэх ухаан технологийн зөвлөл, улсын хил ба түүх судлал, холбоо мэдээллийн төв, хилийн музей, архив зэрэг судалгаа шинжилгээний байгууллага, 30 гаруй эрдэмтэн, 123 магистрын бүтээлийн сан ажиллаж байна. Монгол Улсын хууль сахиулахын их сургууль, Батлан хамгаалах их сургууль, мөн ОХУ, БНХАУ, АНУ, БНЭУ, Египет, Таджикстан зэрэг улсууд түүнчлэн Европын холбооны гишүүн улсуудын гадаад хилийн хамтын ажиллагааны менежментийн агентлаг-фронтекс (Frontex) зэрэг боловсролын байгууллагатай ажил хэргийн холбоо тогтоон туршлага солилцон ажиллаж байна. Хил хамгаалах байгууллагын менежментийг хөгжүүлэх шинжлэх ухаан, технологи боловсролын, түүнчлэн инновацийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр урт хугацааны болон мастер төлөвлөгөөтэй ажиллаж үр дүнг тооцож хэрэгжилтийн механизмыг боловсронгуй болгох дэс дараатай арга хэмжээ авч байгаа юм. Манай олон эрдэмтэн судлаачид Монгол Улсын үндсэн хууль (1993), Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого (2002), Монгол Улсын хилийн тухай хууль (1993)-ийн эх үндэслэлийг боловсруулахад идэвхитэй оролцсон төдийгүй инновацийн хэлбэрээр хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд тэргүүлэх хэмжээнд идэвхитэй ажиллаж байна.[1] Эдгээр эрдэмтэдийн үйл ажиллагаа, судалгаа бүтээлүүдийн бодит санааг улсын хилийн аюулгүй байдлыг хангах улмаар нийгмийн баялаг бүтээх онцгой шинж байдал агуулгатай уялдсан инновацийн нэгэн хэлбэр гэж үзэж байна.

Дүгнэлт:

Эцэст нь тэмдэглэхэд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын бүрэн илэрхийлэл болсон улсын хилийн аюулгүй байдлыг хангах, таатай нөхцөлийг бүрдүүлхэд, түүний эд эс бүхэнд нь "инноваци" хэрхэн нэвтэрч үр дүнгээ өгснөөс маш ихээр шалтгаалах болно гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Цаашид хил хамгаалах албанд ашиглагдаж байгаа зэвсэглэл, техник, тоног төхөөрөмжүүдийг улам бүр сэргээн сайжруулах, боловсронгуй болгох, хөрш улсуудын хил хамгаалалтанд нэвтрүүлсэн дэвшилтэт техник, технологийг нутагшуулах замаар хил хамгаалалтын алба үйл ажиллагааны бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлийн инновацид суурилсан судалгааг эрчимтэй хийж, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтыг хил хамгаалалтанд үр дүнтэй, оновчтой ашиглаж чадсанаар улсын хилийн аюулгүй байдлыг хангах, улмаар улс эх орныхоо үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлэх нь дамжиггүй юм аа.

ХИЛИЙН БООМТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

В.Пүрэвбаасан. ХСИС-ийн Удирдлагын Сургуулийн магистрант, дэд хурандаа

ЗОРИЛГО: Улсын хил, Хилийн аюулгүй байдлын удирдлагын тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, онолын үндэс, практик туршлагыг эрдэм шинжилгээ, сургалт, судалгаанд ашиглах, багш, эрдэмтэн, судлаачдын дэвшүүлж буй онол, арга зүйн асуудлууд нь бодит биеллээ олоход оршино.

1. Аюулгүй байдал, Хилийн боомтын аюулгүй байдлын тухай

Хүнтөрөлхтөний үүсэл, хөгжлийн бүх үе шатад хувь хүн, нийгэм, улс орон, хамтын нийгэмлэгийн амьдрал үйл ажиллагааны салшгүй дагуул нь аюул, занал байсаар ирсэн. Аюулгүй байдлын асуудалд төдийлөн анхаарал тавьж байгаагүйгээс өрх гэр, компани, улс орон бутран сөнөж, дайн самуун дэгдэж, гай гамшиг тарьж байв.

Аюул нь аюулгүй байдлын объектыг устгах, тонон дээрэмдэх, хүлцэнгүй захирагдах байдалд оруулах, дарамтлан дээрэмдэх, устгахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, уг үйлдлийг гүйцэтгэхийг санаархах зэрэг янз бүрийн хэлбэрээр илэрдэг байна.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй асуудлын нэг бөгөөд түүнийг хөрш зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллага хооронд хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулдаг онцлогтой.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяаршил, нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна.

Орчин үеийн дэлхий ертөнцөд гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд хурцаар илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитойгоор нөлөөлөх болов.

Улсын хил зөрчих, зэвсгийн наймаа, алан хядах ажиллагаа, мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг хүрээгээ тэлж байгаа нь түүнтэй тэмцэх Хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг шаардаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад Хил хамгаалах байгууллага, Хилийн цэргийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдсээр байна. 2001 онд Улсын Их Хурлаар батлагдсан "Үндэсний аюулгүй байдлын тухай" Монгол Улсын хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлд "Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь Монгол Улсын их хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн

байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнуудаас бүрдэнэ"; мөн "Монгол Улсын хилийн тухай" хуулийн 10 дугаар зүйлд" ...үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах"[33.74] гэж тэмдэглэжээ.

Энэ бүхэн Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын төрийн захиргааны байгууллага болон гүйцэтгэх үүргийн онцлогоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд багтаж аюулгүй байдлыг хангах хэрэгт оролцон тодорхой үүрэг, хариуцлага хүлээх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байхыг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог.

Мөн **хилийн аюулгүй байдал** гэдэг нь "улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр,(хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал" гэж манай эрдэмтэд үздэг билээ.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага, хилчдийн үндсэн үүрэг нь улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын найдвартай байдлыг ямарч нөхцөлд хангах явдал юм. 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гэсэн гуравдугаар бүлэгт: оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал" юм гэжээ.

Эндээс "Хилийн боомтын аюулгүй байдал"-ын асуудал нь **нэгдүгээрт**: "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна"[1] гэсэн Үндсэн хуулийн заалт, дээрх үзэл баримтлалын дагуу "Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдал"-д, **хоёрдугаарт**: "Хил зөрчигч, завдагчийг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл, тээвэрлэж байгаа бараанд үзлэг хийх, манаагаар дагалдуулах, Улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл, бараанд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх явцад илэрсэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан эд зүйлсийг хураан авч холбогдох байгууллагад мэдэгдэх, хамтран шийдвэрлэх;"[2] гэж Хил хамгаалалтын дүрэмд зааснаар манай улсын эдийн засгийн аюулгүй байдалтай шууд холбогдож байгаа болно.

Улсын хил нь өөрөө агуулгын хувьд ***хоёр улс, нэг хил*** гэсэн утгаараа аливаа хөрш улсууд зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцаа тогтоож, дэлхийн улсуудтай Олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад

[1] Монгол улсын Үндсэн хууль 1992 он

[2] Монгол улсын хил хамгаалалтын дүрэм

бодлого баримтлахыг шаарддаг ба манай улс болон дэлхийн улс орнууд ч энэ харилцааг эрхэмлэдэг.

Манай улс хөрш орнууд болон олон улсуудтай олон талт харилцааг хөгжүүлж буй өнөөгийн нөхцөлд дэлхийн эдийн засгийн хурдацтай хөгжил, гадаадаас улсын хил, хязгаар нутаг дахь хилийн асуудлыг зохион байгуулж буй өөрчлөлт, дотоодоос хилийн бүс, зурваст хувийн өмчит аж ахуйн нэгжийн ажил, үйлдвэрлэл явуулах ажиллагаа ихэсч, улсын хилийн боомтоор түүхий эд, бараа материал тээвэрлэх, иргэдийн зорчих хөдөлгөөн хурдацтай өсөн нэмэгдэж, энэ нь улс орны эдийн засгийн үзүүлэлтэд шууд нөлөөлж байгаа зэрэг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, түүний нэн чухал хэсэг болох хилийн аюулгүй байдал, тэр тусмаа хилийн боомт (боомтод илэрч буй үзэгдлүүдийг тодорхой тусгах, шууд болон шууд бусаар нөлөөлж буй нөлөөллийг гаргаж ирэх)-ын аюулгүй байдалд нөлөөлөх болсон.

2. ХБАБ-ыг хангаж буй эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн хилийн боомтыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор "Хилийн боомтын тухай" хуулийг Улсын Их Хурал 2013 оны 12 дугаар сарын 26-нд батласан.

Энэ хуулиар хилийн боомтын удирдлагын бүтцийг өөрчлөн, "боомтын хяналтын байгууллага болон боомтын аюулгүй байдлыг хангах байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, ерөнхий зохицуулалтаар хангах үүрэг бүхий **Боомтын нэгдсэн захиргаа** нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд ажиллана. **Боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмын хэрэгжилтийг хил хамгаалах байгууллага хариуцна**"[3] гэж тус тус хуульчилсан.

Уг хуульд **"боомт"** гэж зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх зориулалттай, тусгай журмаар зохицуулагддаг нутаг дэвсгэрийг, **"боомтын аюулгүй байдлыг хангах байгууллага"** гэж боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэх хил хамгаалах, тагнуулын байгууллагыг[4] хэлнэ гэж тодорхойлжээ.

Хил хамгаалах байгууллага шинээр батлагдсан дээрх хуулийн дагуу хилийн боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмыг сахиулж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь "Улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах" ХХЕГ-ын даргын удирдамж, хилийн тусгай ангийн захирагчийн болон хилийн тусгай салбарын даргын тушаал зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд захирамжлагдан, хэрэгжиж байна.

Хилийн боомтын тухай хуульд "Боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага гарах, гоц халдварт өвчин тархах зэрэг онцгой

[3] Хилийн боомтын тухай хууль 2013 он

[4] Хилийн боомтын тухай хууль 2013 он

нөхцөл үүссэн үед боомтыг хил хамгаалах байгууллага хамгаалалтад авч, холбогдох байгууллагатай хамтран тусгай дэглэм тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулна"[5] гэж заасны дагуу ХХБ-аас хилийн боомтын аюулгүй байдлыг хангах талаар хөрш орнууд, харилцан ажиллагаатай байгууллагууд, орон нутгийн ард иргэдтэй харилцан, хуульд заасан дээрх нөхцөл үүссэн үед ажиллах урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөнүүдийг шинэчлэн боловсруулах ажиллагаа явагдаж байна.

Өнөөгийн байдлаар энэ хуулийн дагуу Хил хамгаалах байгууллагын мэргэжлийн хэлтэс, хилийн отрядуудын албан тушаалтнуудын нэр, бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсон. Мөн боомтын аюулгүй байдлыг хангах албан тушаалтнууд дутмаг, тээврийн хэрэгслийг шалгах цаг хугацаа зэргээс хамаарч тээврийн хэрэгсэлд хийх үзлэг шалгалт хангалтгүй явагдаж, улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлдэг бүлэг, этгээдүүдийн үйл ажиллагаа ихсэх хандлагатай байна гэж дүгнэж болохоор байна. Энэ нь дараахь судалгаагаар харагдаж байна.

Хавсралт-1.

Зөрчлийн хэлбэр

/2014.04.01-11.25/

№	Зөрчлийн хэлбэр	Тоо	Нийт
1	ИХШХА-нд шалгагдаагүй	168	**168**
2	Гааль, ХМХА-нд шалгуулаагүй	19	**19**
3	Штампны чиглэл буруу дарсан	20	**20**
4	Паспортын хугацаа дууссан	4	**4**
5	Бусдын баримт бичиг ашигласан	3	**3**
6	Тээврийн хэрэгсэлд нуугдсан	1	**1**
7	Бусад	9	**9**
Нийт		**224**	**224**

Тээврийн хэрэгсэлд нуугдсан, бусдын баримт бичиг ашигласан, баримт бичгийн хугацаа дууссан зөрчлийг ИХШХБ-ын албан хаагчдаас илрүүлэлгүй хил нэвтрүүлсэн болон штамп дараагүй, он, сар, өдөр, чиглэлийг буруу дарсан, **боомтын хяналтын байгууллага** /ХМХА, Гааль, ИХШХБ/-ын шалгалтад хамрагдаагүй зөрчлийн судалгаа

[5] Хилийн боомтын тухай хууль 2013 он

/2014.04.01-11.25/

№	Боомтын нэр	Гадаадаас	Дотоодоос	Нийт
1	Алтанбулаг	3	7	**10**
2	Замын-Үүд /төмөр зам/	0	3	**3**
3	Замын-Үүд /авто зам/	3	4	**7**
4	Цагааннуур	85	65	**150**
5	Өлгий	0	2	**2**
6	Боршоо	24	0	**24**
7	Арцсуурь	4	0	**4**
8	Шивээхүрэн	0	5	**5**
9	Гашуунсухайт	0	3	**3**
10	Булган	3	4	**7**
11	Ханги	0	9	**9**
Нийт		**122**	**102**	**224**

Хилийн боомтын албаны чиглэлээр 2014 онд зонхилон гарсан зөрчлүүд:

- Хилийн тагнуулын албанаас 2014 оны 04 дүгээр сараас хойш бусдын баримт бичиг ашиглах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, бусдын нэр, регистрийн дугаарыг ашиглан гадаад паспорт, Монгол Улсад буцах үнэмлэх гаргуулах хэлбэрээр Буянт-Ухаа, Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур боомтуудаар улсын хил зөрчсөн 68 хүнд хойшлуулшгүй ажиллагаа явуулсан.

- Мөн ИХШХБ-ын алба хаагчдаас ажлын хариуцлага алдаж, хил нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр бус баримт бичгээр улсын хил нэвтрүүлж буцаагдсан 3, хилийн уулзалтаар хүлээн авсан 37 зөрчлийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн.

- Хилийн боомтын журамд хяналт тавих манааны хяналтаар хилийн боомтын хяналтын байгууллага болох Гааль, Мэргэжлийн хяналтын алба, Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагуудын шалгалтаар ороогүй хил нэвтрэхийг завдсан 224 иргэнийг илрүүлж гарч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан.

- Хилийн 0218 дугаар анги болон "Чингис хаан" олон улсын нисэх буудлын хамгаалалтын алба хооронд боомтын аюулгүй байдлыг хангах асуудалтай холбоотойгоор үүссэн үл ойлголцол даамжирч Засгийн газрын хэмжээнд хүрсэн бөгөөд уг асуудлыг ЗГХЭГ-ын дарга, ЗТЯ-ны сайд нар хамтран "Чингис хаан олон улсын агаарын замын боотмод аюулгүй байдлыг хангах, боомтын журам сахиулах,

хамтран ажиллах журам" баталснаар шийдвэрлэгдсэн.

- Буянт-Ухаа, Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги, Бичигт, Булган, Хавирга, Алтанбулаг, Сүхбаатар, Цагааннуур боомтуудаар улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан эд зүйлс болох алт, байгалийн үнэт чулуу, төмрийн хүдэр, зэс, ноолуур, ургамал, ан амьтны мах, арьс, эвэр, бурхан шашны эд зүйл, хар тамхи, сэргээшийн төрлийн бэлдмэл, бууны сум болон гаалийн татвараас зайлсхийсэн эд зүйлсийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг тус тус илрүүлэн шийдвэрлэсэн.

- Монгол Улсын Засгийн газрын "11-11" төвд иргэдээс боомтын ачаалал, алба хаагчдын харьцааны зөрчил болон иргэд Хил хамгаалах байгууллага болон Иргэний харъяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагын албаны үйл ажиллагааг ойлгоогүйгээс гомдол, саналаа харъяаллын бус байгууллагад хандан гаргах зэрэг хэлбэрээр ..... гомдол ирсний дагуу албаны шалгалт хийж, тухайн иргэнд хариуг нь өгч шийдвэрлэсэн.

Дээрх байдлаас дараах цагийн байдал үүсэж болзошгүй байна.[6] Үүнд: **Цаашид үүсч болзошгүй цагийн байдал:**

1. Улсын хил нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр бус баримт бичигтэйгээр улсын хил нэвтрэх, нэвтрэхийг завдах үйлдэл үргэлжлэн гарч, түүнийг ИХШХБ-ын шалгагч нарын хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалан илрүүлэхгүй хил нэвтрүүлэх

2. Ачаа, тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, шалгалт суларсантай холбогдуулан улсын хил нэвтрүүлэхийг хориглосон буюу хязгаарласан эд зүйл, тээврийн хэрэгсэлд нууж хил нэвтрүүлэх / завдах/

3. Хилийн боомтоор нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалал:

Монгол-Оросын иргэд харилцан визгүй зорчих тухай 2014 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Монгол Улсын иргэд, Оросын Холбооны Улсын иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" 11 дүгээр сарын 14-нөөс хэрэгжиж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор энэ оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс "Алтанбулаг" боомт 24 цагийн ажиллагаанд шилжсэн болон уг тогтоолоор "Хавирга", "Баянхошуу", "Ханги", "Бургастай" боомтуудыг байнгын ажиллагаанд шилжүүлэх, Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг дэвсгэрт "Цагаан дэл" байнгын ажиллагаатай авто замын боомтыг шинээр нээх зэрэг асуудлуудтай холбоотойгоор хилийн боомтуудын ачаалал нэмэгдэх

4. Өмнөдхилийн "Гашуунсухайт", "Шивээхүрэн", "Бичигт", "Сүмбэр" боомтуудад төмөр замын боомт шинээр байгуулагдахтай холбоотойгоор албаны ачаалал нэмэгдэж, хүн хүч, техник хэрэгслийн

[6] ХХБ-ын удирдах ажилтны цугларалтад заасан хичээлээс

нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

5.Боомтын захиргаанаас өмнөд хилийн "Гашуунсухайт", "Шивээхүрэн" зэрэг зарим боомтод тээврийн хэрэгслээс хураамж авах тухай асуудал тавьсан

6. Хилийн боомтоор хүн, мал, ургамлын гаралтай гоц халдварт өвчин орж ирэх зэрэг асуудлууд үүсч болзошгүй.

Иймд хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зохимжтой гэж үзэж байна. Үүнд:

1.Дээрх цагийн байдал, өөрчлөлтүүдийг тухай бүр нь судлан дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээ, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах,

2. ХБАБ-ын хангахад шаардагдах хүн хүчний тооцоог боомт тус бүрийн онцлогт тохируулан хийж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх, тэдгээрт шаардагдах техник хэрэгслээр хангах,

3. Хөрш улсын талтай хилийн төлөөлөгчийн шугамаар тогтмол хамтран ажиллаж, мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, тэдний ХБАБ-ыг хангаж буй байдлыг судлан, тагнуул гүйцэтгэх ажлын хүчийг түлхүү ашиглах

4. Хилийн боомтын аюулгүй байдал хангах албаны урьдчилсан ажилллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх, шаардлагатай бол тодотгол хийх

5. Боомтын захиргаа болон боомтын хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах

6. Боомтын аюулгүй байдлын албанд ажиллагсдыг тусгай зориулалтын хувцас, аюулгүй байдлыг хангах тусгай хэрэгсэл, албаны нохойг хангах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх

7.Үндэстэн дамнасан корпорациуд, гэмт бүлэглэлийн эсрэг тэмцэх ажиллагаанд тагнуул, цагдаа, гаалийн байгууллагуудтай хамтран ажиллах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх,

8.Харилцан ажиллагааны төлөвлөгөөний дагуу сургалт, дадлагыг тогтмол явуулах

9. Гааль, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, хяналт шалгалтыг цаг хугацаанд нь чанартай явуулах зэрэг болно.

Дээрхээс гадна боомтын захиргаанд шинээр алба хааж буй албан хаагчдын ихэнх нь төрийн тусгай албанд ажиллаж байгаагүй, тэднээс албанд хандах хандлага хангалтгүй, албаны мэдлэг, ур чадвар дутмаг зэргээс албан хаагчдын хооронд үл ойлголцох байдал үүсэж байна.

Энэ бүгд нөхцөл байдлаас **дүгнэхэд** Хил хамгаалах байгууллага одоогоор хилийн боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашид хуулиар хүлээсэн үүргээ чанаржуулах, үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөхийн тулд бид бүгд хамтдаа боомтод үүрэг гүйцэтгэж буй хилчдийнхээ мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, холбогдох хуулийн дагуу уйгагүй идэвхтэй ажилласнаар үйл ажиллагаагаа төр засгийн хэмжээнд бодитойгоор үнэлүүлж зохих амжилтад хүрэх боломжтой гэж үзэж байна.

ХИЛИЙН БООМТЫН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ

Г.Галбадрах. Хилийн сургуулийн ХБАБТ-ийн багш, магистр, хошуу

Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 74, 75 тоот тушаалаар Хил нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгслийг бүртгэх, хянах зориулалт бүхий "Иргэний бүртгэл, паспорт- хяналтын нэгдсэн сүлжээ" төслийн хүрээнд хийгдсэн "Вогех" програм, тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулсны дагуу ХХЕГ, УБЕГ, ГИХАЭГ, Буянт-Ухаа, Дорноговь аймгийн Замын үүд, Ханги шалган нэвтрүүлэх боомтуудад ажиллан, ИБПХНС-ний аюулгүй байдлын түвшинг тодорхойлоход дараах байдалтай байв. Үүнд:

1. Хамгаалалтын чиглэлээр:

• Анти-вирусийн програм хангамжийн хувьд: тогтсон хортой код эсэргүүцэгч програм байхгүй.

2. Файрвол буюу галт ханын бодлогын чиглэлээр:

• "Cisco 2800" төрлийн төхөөрөмж ашигладаг боловч сүлжээний хаягаар хандалт хийж байгаа, мөн гадагш хандаж байгаа хандалт нь (бүх өгөгдөл мэдээлэл) файрволоор дамждаггүйн улмаас сүлжээнд халдсан тохиолдлуудыг болон нэвтрэх оролдлого хийсэн талаарх мэдээллийг гаргаж дүгнэх боломжгүй байна.

3. Сүлжээний бүрдэл хэсгүүдийн чиглэлээр:

• Системийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор аналоги горимд шилжүүлэх төлөвлөгөө хийгдээгүй байна.

4. Сүлжээний кабелийн чиглэлээр:

• Сүлжээний холболтын бүдүүвч зураг байгаа боловч кабелийн байршлыг харуулсан бүдүүвч зураг байхгүй, үүний улмаас хэрэв сүлжээний кабель тасрах болон гэмтсэн тохиолдолд засварлах үйл ажиллагаа удаашрах, барилгын хийцийг эвдэх магадлал өндөртэй байдал гарч болзошгүй байна.

5. Сүлжээний бүртгэлийн хувьд:

• Сүлжээнд холбогдсон бүх тоног төхөөрөмжийн бүртгэлийн хөтлөлт хийгдэж байгаа ололттой тал байна.

6. Тог баригчийн чиглэлээр:

• Сүлжээнд холбогдсон бүх компьютер болон сүлжээний тоног төхөөрөмж (рутер, свич, хаб) тог баригчтай байгаа боловч өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй хуучирсан байна.

7. Интернет сайтыг блоклох чиглэлээр:

• ШНБоомтын компьютерүүд интернэт орчинд ажиллах горимгүй тул зохисгүй веб сайтуудыг файрвол ашиглан хаах тохиргоо хийгдэх шаардлагагүй болно.

8. Сүлжээний хандалтын чиглэлээр:

• Сүлжээний хандалтыг хянах зориулалт бүхий програм хангамж, тоног төхөөрөмж байхгүй.

9. Мэдээллийг хадгалах болон нөөцлөлтийн чиглэлээр:

• Өгөгдөл мэдээллийн хүртээмжтэй байдал, нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах болон байгаль, хүнээс хамаарсан аюул ослын үед

түргэн шуурхай, бүрэн сэргээлт хийх зорилгоор өгөгдөл мэдээллийн нөөцлөлт хийдэг ч үйлдлийн системийн хоцрогдлоос шалтгаалж системийн нөөцлөлтийг хийх боломжгүй байна.

10. Програм хангамжийн чиглэлээр:

• Програм хангамжийн хөгжүүлэлтийн бүртгэлд нэмэгдсэн болон хасагдсан баримтжуулалт байхгүй, програм хангамж нь дотоодын болон нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрийн дизайны стандарттай уялдаж чадахгүй хуучирсан байна.

• Гадны байгууллагаас (3 дахь талаас) нийлүүлсэн програм хангамжийг зохих стандартын дагуу хүлээн авдаг эсэх, энэ талаар нотолгоо байхгүй зэрэг дутагдал байна.

11. Сүлжээний баримтжуулалтын чиглэлээр:

• Баримтжуулалтыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн баримтжуулалтгүй байна.

12. Сүлжээний хамгаалалтын чиглэлээр:

• Сүүлийн 24 сарын хугацаанд сүлжээний хамгаалалтыг хөндлөнгийн мэргэжилтнээр хянаж шалгуулаагүй,

• Хэрэглэгчийнкомпьютерүүдийн нэршил (тогтоосон стандартын дагуу)-д ороогүй,

• ИБПХНСүлжээнд дотоод мэйл систем (outlook)-ийг ашигладаг боловч хэрэглэгч мэдээлэл зөөвөрлөхдөө хэрэглэгч тус бүрдээ шэйр, зөөврийн диск, төхөөрөмжүүдийг ашиглах боломжтой байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг ноцтой дутагдлууд илэрсэн болно.

13. Нэмэлт:

• Програм хангамжийг нийлүүлэгчээс системд хандаж засварлах үйлчилгээ хийгдэж байгаа нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

• Програм хангамжийн сул талыг ашиглан тухайн баримт бичгийн шалгалтыг гүйцэтгэж байгаа албан тушаалтан хилээр нэвтрүүлэхийг хориглосон иргэнийг хилээр нэвтрүүлэх боломжтой байна.

• Шаардлагатай тохиолдолд гүнзгийрүүлсэн шалгалт хийхэд цахим үнэмлэхний зураг гардаггүй.

• Шинэчилсэн иргэний цахим үнэмлэхний зураг болон мэдээлэл бүрэн хэмжээнд ороогүйн улмаас шалган нэвтрүүлэх боомтын ажилтнууд хуучин мэдээллийг үндэслэн оруулж байна. Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт ашиглаж буй "ATIS" програм нь “Borex” програмтай уялдахгүй байгаа, мөн хүчээр оруулахад “Borex” програм хангамж дээр гацалт үүсдэг юм байна.

• Зарим тохиолдолд програмын дутагдлаас болж шалгагдаж байгаа хүний зураг гардаггүй.

• Програм хангамжийн сул талаас болж регистрийн дугаар нь О үсгээр эхэлсэн паспортыг таньж чаддаггүй.

• Системийн буруу зохион байгуулалтаас болж мэдээллийн хоцрогдол үүсдэг.

• Програм хангамжид оруулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байдаг.

• BOREX програм нь зөвхөн Windows XP үйлдлийн систем дээр ажиллах боломжтой бөгөөд уг үйлдлийн системийн цаашдын хөгжүүлэлт нь 2014 оноос зогсож байгаатай холбогдуулаад уг програм хангамжийг цаашид ашиглах боломжгүй болох эрсдэл үүсч байна.

• BOREX програм нь UNICODE

дэмждэггүй учраас регистрийн дугаарыг мэдээллийн санд латин тэмдэгтээр орлуулдаг бөгөөд ингэж оруулснаас болж мэдээлэл буруу орох эрсдэлтэй байна. Түүнчлэн 2005 оны 12 дугаар сард батлагдсан MNS 5552:2005 стандартыг албан бичиг хэрэг хөтлөлтөнд дагаж мөрдөх тухай Засгийн газрын тогтоолыг дагаж мөрдөх боломжгүй зэрэг дутагдлууд илэрсэн.

Хилийн боомтын компьютер, мэдээллийн сүлжээнд дүн шинжилгээ хийж, кибер орон зай дахь халдлагаас хилийн боомтын компьютер, мэдээллийн сүлжээг хамгаалах арга зам, програм, техникийн хангамжийн талаар дараах санал, зөвлөмжийг боловсруулсан. Үүнд:

1. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд:

- Хилийн боомтын мэдээллийн нэгдсэн сүлжээг кибер довтолгооноос хамгаалах мэргэжлийн баг ажиллуулах.
- Тус багийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- Шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангах.
- Сүлжээнд хандах эрхийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох. /Сүлжээнд хандах эрхийг ялгавартайгаар тогтоох, хандах эрх аль болох цөөн байх гэх мэт/

2. Компьютер, мэдээллийн сүлжээнд дараах програм болон техникийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь хилийн боомтын компьютер, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Сүлжээний хандалтыг илрүүлэх систем IDS /Intruction Detection Sistem/, сүлжээний хандалтаас сэргийлэх систем IPS /Instruction Prevention Sistem/. Эдгээр системүүд нь техникийн болон програмын хэлбэртэй байх ба сүлжээг хянаж, илэрсэн учрал тохиолдлуудыг зогсоон, сүлжээний ашиглалтын зөрчлүүдийг илрүүлэн, энэ тухай бүртгэл хийж байдаг.

- Галт хана /Firewall/ Галт ханыг 2 сүлжээний хооронд хяналт хийхийн тулд хэрэглэх ба ямар нэгэн зүй бус нэвтрэлт хийсэн тохиолдолд түүнийг илрүүлж, таслан зогсооно. Сүлжээний урсгалыг хянах тогтоогдсон дүрэм байх бөгөөд тухайн хэрэглэгч нь ямар хэлбэрээр тухайн сүлжээгээ ашиглахаас хамаарч өөр өөр байдаг.

- Сүлжээнд хандах эрхийн хяналт /Network Access Control/ Сүлжээний хэрэглэгчдэд тухайн сүлжээнд хандах эрхийг ялгавартайгаар тогтоож, хяналтыг хэрэгжүүлнэ.

- Вирусын эсрэг хамгаалалтын програм ашиглах. Вирус нь програм бөгөөд байнга шинэчлэгдэж, өдөрт хэдэн зуун мянгаараа шинээр бий болж байдгаас вирусын зарим програм болон шинэчлэлт хийгдээгүй нөхцөлд вирусыг илрүүлж чаддаггүй. Иймээс лиценз бүхий програм зайлшгүй ашиглах шаардлагатай бөгөөд түүний шинэчлэлтийг тогтмол хийж байх нь чухал юм.

Хилийн боомтын компьютер, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлын түвшинг тооцоолох аргачлал

Дээрх 13 үзүүлэлт бүрэн хангагдсанаар хилийн боомтын мэдээллийн аюулгүй байдлын түвшин 100 хувьд хүрнэ гэж үзэхэд нэг үзүүлэлтийн коэффициент /Кхт/ 7,69 болж байна. /хамгаалалтын түвшний коэффициент/ Нэмэлт гэсэн үзүүлэлтэд хэд хэдэн асуудлыг хамтатгасан учраас

Кхт-г 7,72-оор тооцсон.

1. Хамгаалалтын вирусын: Кхт=7,69
2. Файрвол буюу галт ханын бодлогын: Кхт=7,69
3. Сүлжээний бүрдэл хэсгүүдийн: Кхт=7,69
4. Сүлжээний кабелийн: Кхт=7,69
5. Сүлжээний бүртгэлийн: Кхт=7,69
6. Тог баригчийн: Кхт=7,69
7. Интернетэд холбогдох боломжийг хаах: Кхт=7,69
8. Сүлжээний хандалтын чиглэлээр: Кхт=7,69
9. Мэдээллийг хадгалах болон нөөцлөлт: Кхт=7,69
10. Програм хангамж: Кхт=7,69
11. Сүлжээний баримтжуулалтын чиглэлээр: Кхт=7,69
12. Сүлжээний хамгаалалтын чиглэлээр: Кхт=7,69
13. Нэмэлт: Кхт=7,72

Өнөөгийн байдлаар дээрх 13 үзүүлэлтээс 8 үзүүлэлт нь /3, 4, 5, 6, 7, 9, 12, 13/ бүрэн хангагдсан тул Кхт=61,55 хувьтай байна.

Хамгаалахаар санал болгосон буй арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 1, 2, 8 дугаар үзүүлэлт бүрэн, 10 дугаар үзүүлэлт хагас хангагдаж Кхт=88,46 хувь болно.

Хилийн боомтын компьютер, мэдээллийн нэгдсэн сүлжээг хамгаалах удирдлага, зохион байгуулалт, програм хангамжийн арга хэмжээг цогц байдлаар авч хэрэгжүүлснээр хилийн боомтын компьютер, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлын түвшин өнөөгийн байдлаар 61,55 хувь байгаагаас 88,46 хувь болж сайжирна гэж үзэж байгаа юм.

ГАР АРГААР ХИЙСЭН ТЭСРЭХ ХЭРЭГСЭЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭ


Х.Асхар. Хилийн сургуулийн хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн дэд профессор, магистр, хошууч



Улс орнуудад алан хядах /террорист халдлага/ халдлага гарах болсон нь ард иргэдийн аюулгүй байдал, амьд явах эрх алдагдаж байна. Үүнээс үүдэн алан хядагчдын гол хэрэгсэл болох гар аргаар хийсэн тэсрэх хэрэгслийн талаар энгийн ойлгомжтойгоор тайлбарлах, үүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлохыг зорилоо. Энэхүү материалыг АНУ-ын Хил, гаалийн байгууллагын албан хаагчдад сургалтад ашигладаг материалыг орос хэлнээс орчуулан хэсэгчлэн хүргүүлж байна.


Энгийн тэсрэх хэрэгсэл: бүтэц


Үндсэн цэнэг Өдөөгч




Энгийн тэсрэх хэрэгсэл: шинж тэмдэг

Өдөөгчний гал, утас байгаа эсэхийг хайх






Салдаггүй түгжигчтэй эсэхийг хайх.



Гар аргаар хийсэн тэсрэх хэрэгслийн шинж тэмдэг

Анхаарах зүйлс:

- цагаар тохиргоо хийсэн байдал
- автомашины аккумляторт холбосон ер бусын цахилгаан утас, хянах самбарт гар аргаар хийгдсэн унтраалга эсвэл өөр ямарваа нэгэн зангууд (мэдэгдэхгүйгээр татсан утас)
- Бөөрөнхий хэлбэрээр хийгдсэн зүйлс (динамит)
- пластикан тэсрэх бодисыг илэрхийлэх барималтай төстэй бодис
- цагаан нунтаг болон талст хэлбэрийн хар тамхитай холбоогүй бодис





Алан хядагч, амиа хорлогчдын үйл ажиллагааны шинж байдал

Шинж байдлууд:


- тэсрэх бодисыг эрэгтэй, эмэгтэй, насанд хүрсэн болон бага насны хүүхдэд зүүлгэн авч явуулдаг.
- тэсрэх бодисыг бүс, үүргэвч, хантааз, цүнх, чемоданд авч явдаг.
- гэнэтийн байдалд ашиглах.

Алан хядах ажиллагааны шинж тэмдэг – амиа золиослогч
Хувцсан дахь сэжигтэй шинж тэмдэг:






- том хэмжээтэй, улирлын бус хувцас
- ер бусын болон сэжиг бүхий хөөсөн байдал
- цүнх эсвэл биеийн бусад хэсэгт эд зүйлийг тогтоосон байдал
- утас болон олс илүү гарсан байх
- Бүсээр тогтоосон байдал нь илт мэдэгдэх
- хулгайн цэргийн хувцас эсвэл эмэгтэй хүний хувцас өмссөн байх
- Алан хядах ажиллагааны шинж тэмдэг – амиа золиослогч
- Хувийн онцлог эсвэл шинж төрх
- Сэтгэл санаа тогтворгүй болох эсвэл санаа зовсон байдал
- Хөдөлгөөний болон уян хатан байдал нь алдагдсан байх
- Үсээ засуулсан, богино халимаг тависан, сахлаа саяхан хуссан байдал
- Цэцгийн эсвэл ургамлын үнэр үнэртэх



Суудлын болон ачааны автомашиныг минэжүүлсэн шинж тэмдэг Автомашины гаднах төрх



- ачааны хэсэг, бүхээгний хэсгийн хоосон орон зай
- цагаан эсвэл хүрэн ягаан өнгийн нунтаг
- ер бусын зэв тогтсон байдал
- хөнгөн байх

- дотоод орчинг далдалсан бүрэнхий болгосон
- ачааг буулгах гидро өргөгчтэй
- саяхан будсан байдал
- нэмэлт шатахууны банктай байдал

Хууль бус хар тамхины шинж тэмдгээс ялгагдах шинж тэмдгүүд

Суудлын болон ачааны автомашиныг минжүүлсэн шинж тэмдэг

Зорчигчид

- Хаалга болон тээшний хэсгийг болгоомжтой хаах
- тухайн газар нутгийн онцлог эсвэл улирал цаг агаарт тохируулаагүй ер бусын хувцас өмссөн
- ачаа ачих хэсэгт байрлах, гэхдээ ачаа ачих буулгах ажиллагаанд оролцоогүй байдалтай байх


Автомашин

- цоожтой буюу хүнгүй үлдээх
- аваарын гэрэл ассаалттай
- холгүй байрлуулсан эсвэл байнд аль боломжтой байдлаар зогсоосон байх
- автомашинаа буруу байрлуулсан эсвэл зогсоолд тависан

Гар утсан дахь тэсрэх бөмбөг

Москвагаас худалдан авсан гар утас

- асаах үед дэлбэрсэн
- 23 настай эмэгтэй нас барсан




Гар аргаар хийгдсэн тэсрэх бөмбөгтэй холбоотой бариmтууд

- Ямар ч төрлийн цацраг идэвхит материалаар хийгдсэн ердийн тэсрэх бодис эсвэл тэсрэх бөмбөг
- Дэлбэрэлтэнд өртөж удаан үхлээр буюу хүнд шархдах бүрэн магадлалтай
- Сэтгэл санаанд үлэмж нөлөөлнө -айдас, цочролд орох

Урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд





➢ Тэсрэх хэрэгслийг хаана ч, ямарч аргаар нуух эсвэл биедээ ч нуух боломжтойг санаж явах хэрэгтэй.

➢ Сэжиг бүхий баглааг байрлуулах, онгойлгохоос өмнө тусламж заавал хүсэх хэрэгтэй. Тухайн газар нутаг дэвсгэрийг аюулаас тусгаарлаж аюулгүй болгох.

➢ Хэрэв хар тамхи бус сэжигтэй талст болон нунтаг хэлбэрийн бодисыг анхааралтай шалгах хэрэгтэй.

➢ Хэрэв тэсрэх хэрэгслийг мөн эсэхэд сэжиглэж байгаа тохиолдолд радио станц эсвэл гар утсаа ашиглахгүй байх



Хоёрдагч хэрэгсэл

Террорист бүлэглэлүүд ихэвчлэн ашиглахдаа:

➢ олон удаагийн эсвэл нэг удаагийн дэлбэрэлтүүдэд.

➢ 2 дагч хэрэгслийг хууль хяналтын байгуллагуудын ажилтнууд эсвэл аврагчдын эсрэг хэрэглэх.

Нэг удаагийн дэлбэрэлтийн дараа аюулаас ангид болсон гэж бодож болохгүй.

Эрсдэлд орох магадлал их тул гар утас, гар радио станц эсвэл бусад хэрэгслүүдийг ашиглахгүй байх.

Дүгнэлт

Эдгээр гар аргаар хийгдсэн тэсрэх хэрэгслийг ихэвчлэн алан хядах, хомроглон устгах үйл ажиллагаанд хэрэглэдэг байна. Тэсрэх хэрэгслийг гар аргаар хийхэд түүний түүхий эд, бусад шаардлагатай хэрэгслүүдийг хэрхэн, хаанаас, ямар аргаар олж авч байна вэ гэдэг нь одоог хүртэл бүрхэг байсан хэвээр л байна. Сүүлийн үед дэлхийн зарим нэг улс оронд алан хядагчдын үйл ажиллагаа идэвхжиж байгаа нь эдгээр тэсрэх хэрэгслийг хийх аргачлал, мэргэжилтэнгүүдийг хэн бэлтгээд байна вэ гэдэг асуулт мөн адил тавигдах болно.

Санал

1. Хууль сахиулах их сургуулийн зарим мэргэжлийн тэнхимүүдийн багш нарыг энэ чиглэлээр тодорхой сургалтад хамруулж, энэ төрлийн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга барилд сургахад бодитойгоор дэмжлэг үзүүлэх;

2. Зэвсэгт хүчний анги, салбаруудтай хамтран гар аргаар хийгдэж буй тэсрэх хэрэгсэл, түүнийг саармагжуулах арга барилд сургах сургалтыг зохион байгуулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ТАЛААР

Т.Баяраа. Хилийн сургуулийн ХТТ-ийн дэд профессор, дэд хурандаа, боловсрол судлалын ухааны магистр

Үндэсний аюулгүй байдал, хүний эрх чөлөөг аливаа халдлагаас хамгаалах нь төрийн үүрэг байдаг. Энэ талаар Монгол улсын үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1-д : " Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэж заасан байна.

Монгол төрийн тусгай албанд андгай тангараг өргөн хүчин зүтгэж, улсын хилийн халдашгүй дархан байдлыг сахин хамгаалах үүргээ чанд биелүүлж байгаа хилчдийн өмнө үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх нэн чухал зорилт тавигдаж байна.

Өнөөгийн даяаршил, мэдээллийн эрин зуунд дэлхийн улс орнууд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, үндэсний аюулгүй байдлын асуудлаар нийгмийн бүхий л салбарт хамтран ажиллаж байна.

Энэхүү харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд улс орнуудын хоорондын хүчин чармайлт, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг сайжруулж, хамтын хүчээр тэмцэх нь хамгийн оновчтой аргын нэг гэж үзэх болсон байна.

Олон улсын терроризм, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус наймаа, зэр зэвсгийн худалдаа, мөнгө угаах, хүн худалдах зэрэг зохион байгуулалттай гэмт хэргээс ард иргэдээ хамгаалах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох чиглэлээр манай улсын холбогдох хууль хяналтын байгууллагууд шаардлагатай арга хэмжээнүүдийг цаг тухайд нь авч, бодитой ажлуудыг хэрэгжүүлэн, идэвхитэй эрчимтэй ажиллаж байна.

Аливаа гэмт хэргийг илрүүлэх арга ажиллагаа нь хууль хяналтын байгууллагын албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг боловсролын түвшингээс ихээхэн хамааралтай байдаг.

Энэ утгаар нийгэмд санаа зовоож байгаа хар тамхи, мансууруулах бодисын асуудлыг хөндөж байна.

Манай улсын хувьд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүд нийгмийн шилжилтийн үе болох 1990 –ээд оноос эхлэн гарах болж, улмаар энэ төрлийн гэмт хэргийн тоо цаашид өсөх хандлагатай байна.

Гэмт хэргийн нөхцөл байдлаас харахад Монгол улсад тодорхой тооны хар тамхи хэрэглэгчид бий болсон. Ялангуяа донтох өвчтэй хүний тоо өсөх хандлагатай байгаа. Хэрэглэгчийн тоо нарийн гараагүй байгаа.

Манай улсад каннабис, эм үрэл хэлбэрээр бэлтгэсэн экстати, метаамфетамины төрлүүдийн хар тамхийг ихээр хэрэглэж байна.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүд нь урьдчилан төлөвлөсөн, нарийн зохион байгуулалттай, далд аргаар үйлдэгддэг тулд түүнийг илрүүлэх нь төвөгтэй байдаг.

Хар тамхи, мансууруулах бодис гэдэгт Мансууруулах эмийн тухай НҮБ-ын 1961 оны конвенци, түүний 1,2 –р жагсаалтанд заасан эмийн найрлагаас агуулсан, түүний байгалийн болон нийлэгжүүлж гаргаж авсан бөгөөд онцгой төрлийн мансууруулах үйлчилгээ үзүүлж хүч тамир барагдуулдаг удаан хэрэглэвэл сэтгэцийн хүнд хэлбэрийн өвчнөөр өвчлүүлдэг бодисыг хамааруулан ойлговол зохино.

Монгол хэлний хэл зүйн үүднээс тайлбарлавал: Намуу цэцгийн төрөл урт бөгөөд том навчтай, шар буюу улаан цэцэгтэй ургамал бөгөөд түүнийг гүйцэт боловсроогүй байхад үйлчилж болохуйцаар огтолж, сүү мэт шүүсийг авч хатаасныг ойлгоно гэжээ.

Англи хэлний толь бичигт дурьдсанаар: "Хар тамхи нь грек үгнээс гаралтай бөгөөд хөнөөх болон мэдээ алдуудах, мансууруулах, нойрсуулах чанартай тодорхой зүйлийн ургамлын гаралтай болоод химийн бодис ,хортойгоор хэрэглэвэл хар тамхинд донтох өвчин болно гэж тодорхойлсон байна.

Шинжлэх ухааны үүднээс: "Хар тамхи мансууруулах бодис гэдэг нь байнга хэрэглэснээр хараат байдалд оруулдаг, сэтгэл зүйг өөрчлөх чадалтай ургамлын буюу нийлэг химийн бодисыг ойлгоно гэжээ. Дээрх байдлаас авч үзвэл хар тамхи тодорхой зүйлийн байгалийн болоод нийлэг бодис бөгөөд түүнийг шинжлэх ухааны үндэстэйгээр бага хэмжээгээр хэрэглэвэл нойрсуулах, өвчин намдаах үйлчилгээтэй, хэтрүүлэн их хэмжээгээр хэрэглэвэл донтох өвчинд нэрвэгдэх аюултай юм. Энэ авчин нь эхэн үедээ уйтгар гунигийг түр мартуулж, сайхан ааш зантай, сэтгэл тайвшруулах боловч яваандаа түүнд хүний бие организм дасал болж, улам ихээр хэрэглэхийг шаардсаар үе мөч , яс нь янгинан өвдөж шаналсаар сэтгэл мэдрэлийн эмгэгт нэрвэгддэг байна.

Дэлхийд 150 мянган төрлийн мансуулах бодис байдаг ба үүнээс 500 төрлийн мансууруулах бодисыг хэрэглэдэг байна.

Хар тамхины ангилал

Олон улсын хяналтад байдаг мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг үүсэл гарлын хувьд :

1. Байгалийн гаралтай
2. Хагас нийлэгжүүлсэн
3. Нийлэгжүүлэх аргаар гаргаж авсан гэж 3 ангилдаг.

Сүүлийн үед гарал үүслээр нь бус хүний сэтгэцэд үйлчлэх байдлаар нь ангилах хандлага ажиглагдаж байна. Үүнд:

1.Төв мэдрэлийн системийг дарангуйлагч буюу оюуны идэвхийг сааруулах, хэт тайвшруулах, нойрсуулах үйлчилгээтэй бодисууд

2.Төв мэдрэлийн системийг өдөөгч бодисууд буюу сэтгэцийн идэвхийг сэргээж, сэтгэл санааг хий хөөрөлд оруулах үйлчилгээтэй бодисууд

3. Солио үүсгэгч буюу хий юм үзэгдүүлж, сонсогдуулах үйлчилгээтэй бодисууд

4.Сэтгэцийн хосолмол үйлчилгээтэй буюу дээрх шинж тэмдгүүдийн аль алиныг нь үзүүлэх үйлчилгээтэй бодисууд гэж ангилж

болно.

Хар тамхины үйлчлэл

Хар тамхи нь тайвшруулах, саатуулах үйлчлэл бүхий мансууруулах бодис мөн. Мансуурал гэдэг нь сэтгэцэд нөлөөлөх бодис, мансууруулах үйлчилгээтэй эм бодисуудаас хараат байдалд орсноос үүсдэг өвчин юм. Бие махбодийн хараат байдал гэдэг нь хүний бие мансууруулах бодисгүйгээр хэвийн байж чадахаа байгаад уг бодис байхгүй бол амьдрах боломжгүй мэт сэтгэгдэл төрөх шинжүүд тод илрэн даамжрахыг хэлнэ. Хамгийн их тархсан хар тамхи бол геройн юм.

Энэ бодис маш хүчтэй мансууруулах үйлчилгээтэйгээс гадна туйлын хүчтэй хордуулж, бие махбодийг хараат байдалд богино хугацаанд оруулах чадвартай хар тамхины бүлэгт морфин тест нэгдлийг агуулсан байгалийн гаралтай болон нийлэг бодисууд орно. Ихэнх тохиолдолд судсаар тарьж хэрэглэдэг. Каннабисыг зэрлэг олс, марихуана, гашиш, анаша гэж улс орнуудад өөр өөрөөр нэрлэж, татаж хэрэглэдэг. Татаж хэрэглэдэг учраас уушиг, зүрх сэтгэцэд маш хортой нөлөө үзүүлдэг байна.

Хар тамхины хууль бус тээвэрлэлт

Хар тамхийг бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгч улсаас хэрэглэгчдэд түгээхийн тулд хүний бие болон бүх тээврийн хэрэгслийг ашиглаж байна. Үүнд:

1. Хүн (хувцсанд, биеийн гадна , дотор буюу залгих)

2.Зорчигчийн биедээ авч яваа ачаанд (лаазтай зүйлс дотор зөөлөн тоглоом чемодан, цүнхэнд давхар ёроол хийх бэлэг дурсгалыг зүйлс дотор)

3. Биеэс тусдаа явуулсан ачаанд (сав боглоо боодлын хөндийг хуурамчаар доторлох, гадарлах, мебель модон эдлэл дотор)

4. Суудлын автомашинд (хаалга, давхар шаланд, хананд, дээвэрт, дугуйнд суудал болон бусад зүйлд)

5.Суудлын галт тэргэнд (тамборт, зорчигчдын купенд, бие засах газарт, ресторан, люкнуудад)

6. Онгоцонд (зорчигчийн кабинд, бие засах газарт, нисгэгчийн кабинд, ачаа тээвэрлэдэг хэсэгт) гэх мэт газруудыг ашиглан гэмт этгээдүүд хар тамхи, мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлдэг байна.

МАНЛАЙЛЛЫН ТУХАЙ БИШ, ХАРИН МАНЛАЙЛАГЧИЙН ТУХАЙ Л ИЛҮҮ ИХ МЭДЭЭЛЭЛ БАЙДАГ.

Н.Бат-Итгэл: ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Эрх мэдлийг тодорхойлох нь:

Менежмент, манлайлал гэсэн ойлголтууд хоёул эрх мэдлийн хүчин зүйлийг агуулдаг. Эрх мэдэл нь бусдад нөлөөлөх, бусдаар бодол санаагаа хүлээн зөвшөөрүүлэх чадавхи бөгөөд эрх мэдлийг ухаалгаар ашигласнаар бусдад эрх мэдэл олгож болно.

Манлайлал нь хүмүүсийн харилцааны хэлбэрүүдийн дотроос хамгийн их судлагдсан ч энэ асуудлыг тэгтлээ сайн ойлгосон нь цөөн байдаг. Манлайлалын 130 гаруй тодорхойлолтыг тоолон жагсаасан улс төр судлаач, түүхч Жеймс Мак Грегор Бөрнс ингэж хэлсэн билээ.

Харин манлайллыг хамгийн их судлагдсан сэдэв болоход нөлөөлсөн олон шалтгаан бий. Юуны түрүүнд, манлайлал нь сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, удирдах ур чадвар, хүний зан үйлийг хамарсан олон сонирхолтой сэдвийг хамарсан судлагдахуун юм.

Нөгөө талаар манлайлал нь хүмүүний амьдралын нэгэн чухал хэсэг мөн бөгөөд хүмүүс яагаад, яаж хоорондоо харилцдаг тухай ойлголт авахын тулд бид манлайллын талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх шаардлагатай байдаг.

Ерөнхийдөө манлайлагч-дагагч хоёрын хоорондын харилцаа, харилцан ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар манлайллын асуудлыг илүү гүнзгий ойлгох боломжтой юм. Гэхдээ энэхүү дүн шинжилгээ нь тухайн цаг үе, онолчдоос шалтгаалан харилцан адилгүй байж болох талтай.

Манлайлал гэдэг нь манлайлагч болоод түүний араас дагагчдын мотиваци, хэрэгцээ, хүсэл, итгэл найдвар, сэтгэл ханамжтай байдал-хүсэн хүлээж буй бүхэн зэргийг төлөөлсөн зорилтуудыг хангахын тулд манлайлагчийн зүгээс дагагчдын үйл ажиллагаанд нөлөөлөх хүний нийтлэг үйлдэл мөн. Тэрээр дагагчаа өөрийн хүсч буй арга замаар ажиллах хэмжээнд хүртэл нөлөөлөхын тулд зорилго, сэдэл, эрхэмлэн дээдлэх зүйлсийг нь дагаж мөрдөхийг дагагчдадаа уриалдаг. Энэ уриалгыг түүний араас дагагч нар нийгэм болоод улс төрийн үйл ажиллагаанд хамтран оролцож эхэлдэг байна.

Манлайлалгч болоод дагагчдыг хоорондох харьцаа, харилцан ажиллагаа амиа хичээсэн болон бусдыг хичээсэн шинжтэй байдгийг Мак Грегор Бөрнс 1978 онд торхойлжээ.

Амиа хичээсэн манлайлал \ transactional leadership\ гэдэг нь харилцан солилцох буюу би чамд, чи надад гэсэн хэлбэрээр өрнөх манлайлал юм. Амиа хичээсэн манлайлагч өөрийг нь дагах хүмүүсийн хэрэгцээг хүлээн зөвшөөрч, нэг хэрэгцээг нь нөгөө хэрэгцээгээр орлуулж болно гэдгийг иш үндэс болгон ажилладаг. Улс төрд

нийтлэг ажиглагддаг нэгэн жишээ нь сонсогчдын саналыг ажлын байраар наймаалцаж болно гэж үзэх явдал юм.

Иймэрхүү харилцааны хүрээнд талууд өөрийн ашиг тусыг дээд зэргээр хангахыг хичээдэг ажээ.

Амиа хичээсэн манлайлагч эрх мэдлийн төлөө амиа өгөхөөс наагуур тэмцэж, яваандаа түүний хувьд эрх мэдлийн хойноос хөөцөлдөх нь ёс суртахуунаас ч илүү зүйл болж хувирдаг байна.

Амиа хичээсэн манлайлагч зөвхөн шагнал хүртэхийг санаархаж юу хийж гүйцэтгэх ёстойг өөрийн удирдлаганд ажиллагч хүмүүст зааварлаж орхидог. Манлайлал гэдэг нь бүрэн эрх бол манлайлагчийн өмч гэдгийг нотолж буй эрх мэдлийн нэгэн хэлбэрийн илэрхийлэл мөн.

Амиа хичээсэн манлайлал ноёрхож буй орчинд манлайлагч-дагагчийн харилцаа ихэнхдээ түр хугацаагаар үргэжлэх бөгөөд учир нь тэдний хэн ч харилцан солилцох үйл явцыг тодорхойгүй хугацаагаар үргэлжүүлэхийг хүсдэггүй юм.

Хэрэгцээг хангахад гол анхаарлыг хандуулдаг амиа хичээсэн манлайлал нь дэндүү ов мэх дүүрэн, ёс үйлдэл болно.

Бусдыг хичээсэн манлайлал / transformational leadership\ нь харилцан бие биенийхээ өсөлт, хөгжлийн зарчимд үндэслэдэг. Бусдыг хичээсэн шинж агуулсан манлайлагч дагачийнхаа хэрэгцээг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй наад захын хэрэгцээг нь хангахаас ч илүүг хийж чаддаг ажээ.

Тэрээр өөрөө өөрийгөө илэрхийлэх, ухамсарлах, хүндлэгдэх, хамт олонд харьяалагдах зэрэг өндөр дээд хэрэгцээгээ хангах урам зоригийг дагагчддаа олгож байдаг юм байна.

Амиа хичээсэн хэв шинж бүхий манлайлагч нь зорилгоо хангахыг чухалчилдаг бол бусдыг хичээсэн хэв шинж бүхийн манлайлагч зорилгоо хангахыг чухалчилдаг бол бусдыг хичээсэн хэв шинж бүхий манлайлагч хүн бүхний хүрэх эцсийн цэгийг анхаарч, дагагчид нь олон хувилбаруудын дундаас сонголт хийхэд хүрэлцэхүйц мэдээлэл, чадавхитай байх явдлыг баталгаажуулан ажилладаг.

Бусдыг хичээсэн хэв шинж бүхий манлайлагч алсын хараа, стратеги мэдрэмжтэй байж бэрхшээлийг даван туулах тодорхой бөгөөд оновчтой арга замыг олж чаддаг, байгууллагын зүгээс иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанарт сэтгэл зовниж бусдыг ч мөн ийм байхад уриалан ажиллах чадварыг эзэмшсэн байдаг билээ.

ИХ МОНГОЛ УЛСЫН ҮЕД БАРИМТАЛЖ БАЙСАН ХИЛИЙН БОДЛОГЫН ТАЛААРХ ЭРДЭМТДИЙН ДҮГНЭЛТ

Х.Баясгалан: ХСИС-ийн Удирдлагын сургуулиийн магистрант, дэд хурандаа

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан Монгол Улсын Хил Хамгаалах Ерөнхий Газрын дэргэдэх Шинжлэх Ухаан Технологийн Зөвлөлөөс Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академи, Мэдээдэл Судлалын Монголын Академитай хамтран зохион байгуулсан "Улсын хил, хязгаарын талаар Чингис хаанаас баримталсан бодлого, сургамж" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал дээр эрдэмтэн судлаачид тавьсан илтгэлүүддээ Монгол Улсын хилийн хамгаалалт, баталгаажилтыг төгс төгөлдөр байлгах, хилийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бололцоог бүрдүүлэхтэй холбоотой байгууллага, иргэн бүхэн өөрт оногдсон үүрэг, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд онол арга зүйн талаас туслаж дэмжих зорилгоор дараах дүгнэлтүүдийг хийжээ. Үүнд:

МОУА-ийн академич, доктор, профессор, хошууч генерал П.Сүндэв:

- Их монгол улсыг байгуулсны 800 жилийн ойг даян дэлхийд тэмдэглэхээр НҮБ-аас шийдвэрлэсэн нь Монгол улсын нэр хүнд, эзэн богд Чингис хааны гавьяаны бодит илрэл бөгөөд түүнд улсын хил, хязгаарын баталгаажилт, хамгаалалт, шийдвэрлэх нөлөөлөх хүчин зүйлийн нэг нь болж байжээ.

- Улсын хилийг баталгаажуулах, хамгаалах онол, арга зүй үүсэж хөгжихөд Чингис хаан, түүний залгамжлагчдын оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэл нь Монгол улс төдийгүй дэлхий нийтийн ач холбогдолтой, тэр нь өөрийн хүчтэй адил хэмжээний буюу олон дахин давуу илүү хүчнээс улс орон, ард түмнээ найдвартай хамгаалах чадвараар илэрч байжээ.

МОУА-ийн тэргүүлэгч гишүүн, академич, ЦШУ-ны доктор, профессор, дэслэгч генерал Ш.Арвай:

- Улс орон, цэргээ нэгдмэл тогтолцоогоор бэлтгэх, явуулах иж бүрэн шинжтэй олон төрлийн арга хэмжээнүүдээс бүрдсэн маш нарийн тогтолцооны үндэс нь цэргийн бүтэц, зохион байгуулалтад оршиж байжээ. Энэ тогтолцооны үндэс нь гуравт, аравт, зуут, мянгат, түмтийн тогтолцоо байв. Тус тогтолцоог хүмүүн төрөлхтөн оршин байгаа өөрийн улс орны өвөрмөц тогтолцоонд нийцүүлэн найман зууны турш хэрэглэж иржээ.

- Чингис хааны цэргийн байгуулалтад цэргийн ноёд, бидний хэлж заншсанаар боловсон хүчнийг бэлтгэх, сонгох, томилох, үр дүнг үнэлж дүгнэх бүхэл бүтэн шинэ мэдлэг, хүний нөөцийн тогтолцоог бий болгожээ.

- Чингис хааны цэргийн байгуулалтын нэгэн үнэт сургамж бол улс орон цэргийн хүчийг хил хязгаараа хамгаалахад байнгын бэлтгэлтэй байлгах зүйрлэшгүй өвөрмөц ухаан бодол, бүтээлч үйл ажиллагаа байлаа.

- Орчин үед улсын хил хамгаалах хүчний хэрэглэж байгаа цэргийн байгуулалтын үндэс нь Чингис хааны үүсгэж ашигласан бодлого ухааны үргэлжлэл үр шим бөгөөд хүн төрөлхтөн

өөр өөрийн улс гүрний хэмжээнд баяжуулан хэрэглэж ирснээрээ онцлогтой.

ШУА-ийн дэд ерөнхийлөгч НСИСОУХ-ийн захирал, МОУА-ийн жинхэнэ гишүүн, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич Б.Энхтүвшин:

- Монголчууд бол төрийн үндэс нь газар нутаг гэсэн алтан сургааль түүхтэй ард түмэн. Чингис хаан "Бүтэн бие минь алжааваас алжаатугай. Бүрэн улс минь бүү алдартугай" гэжээ. Мандан бадрах, доройтон сульдахын аль алиныг туулан өнөөгийн бидэнд өвлүүлсэн хөрсөн дооров эрдэнэ агуулж, хөрсөн дээрээ арвин буянт мал сүрэгтэй өргөн уудам нутгаараа өнөөдөр Монгол улс дэлхийн нийт улс орны дотор эхний 20-д багтаж байна.

- Эзэн Богд Чингис 800 жилийн тэртээ нэн тэргүүнд гаднаас учирч болзошгүй аюулаас улс орон, ард түмнээ хамгаалахын тулд 95 мянгатыг хил хязгаарын дагуу байрлуулж ашигласан нь тохиолдлын чанартай байгаагүй бөгөөд энэ нь улсын хилийн тухай шинжлэх ухааны үндэстэй онол анхлан тавигдсан байж болох юм.

- Хилийн талаарх ойлголт өөрчлөгдөж байна. Зэр зэвсгийн зэрэгцээ оюун ухааны ач холбогдол өсч байна. Дэлхийчлэгдэн буй ертөнцөд нэг улсын хилээс хамт гарсан үндэстэн дамнасан эдийн засаг, мэдээллийн бүтэц буй болж байхад нөгөө талаар нэг улсаас үл хамаарах терроризмын сөрөг үр дагавар гарах болов.

- Их Монгол улс байгуулагдсан үе өнөөгийн нөхцөл байдлын хооронд бараг бүхэл бүтэн эриний зааг гарч байгаа ч гэсэн Чингисээс улсын хил хамгаалахад оруулсан уламжлалт өвөрмөц онол арга зүй их байгаа нь маргаангүй.

Чингис судлалын төвийн тэргүүн, МСМА-ийн дэд ерөнхийлөгч, МОУА болон Монгол улсын ШУА-ийн академич, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Далай:

- Эзэн Чингис 1206 онд Их Монгол улсаа тунхаглаад юуны урьд цэрэгжсэн хүчнийхээ 90 шахам хувийг хил хязгаартаа байрлуулж ашиглажээ. Энэ бол шинжлэх ухааны үндэстэй төрийн тодорхой бодлого яах аргагүй мөн. Улсын хилийн дагуу байрладаг сум, аймаг нь хилийн цэрэгтэйгээ хамт тухайн чиглэлийн аюулгүй байдлыг хангахад бэлэн байх учиртай. Тэр үеийн тогтолцоо цэрэг-иргэний хосолсон шинжтэй байсан учраас бүхнийг нэг зорилгод чиглүүлэн ашиглахад арай хялбар байсан.

- Эзэн Чингис бусдыг эзэрхэхийн тулд хөрш зэргэлдээ улс орондоо довтолж байгаагүй. Харин эсрэг талаас халдаж, түрэмгийлж доромжилж өдөөн хатгадаг учраас тэдний эсрэг тэмцэх зайлшгүй бодит шаардлагаас урган гарч байв. Харин ч Чингис хаан итгэл үнэмшил, эв эеийг туйлаас эрхэмлэн, түүнээс үндэслэсэн хөршүүдийн удирдлагатай ураг төрлийн холбоо тогтоохыг эрхэмлэж байсан түүхтэй

- Чингис дайчин эрчүүдийг нэг зорилгын төлөө ах дүүгийн ёс зарчим баримтлан нэгэн аавын хүү шиг эвтэй найртай бие биенээ дэмжин туслаж зүтгэх нөхцөл бололцоог бүрдүүлсэн том бодлого баримтлан тодорхой үйл ажиллагаа явуулж ирсэн.

- Монгол орны өвөрмөц байгаль,

монголын соёл иргэншлийн онцлог, цөөхөн хүн хүчээр өөрийгөө хамгаалах улсын бодлого үйл ажиллагаанд, түүнчлэн улсын хилээ хамгаалахад оногдож зохицсон зарчим, арга барил зүй тогтлын шинжтэй бодол санаа юутай ч харьцуулашгүй амьдралд ч байдаг, бас улс, нийгэм, хүн ардынхаа эрэлт хэрэгцээнд илүү бүтээлчээр нийцдэг талтай.

- Чингис эрдэмтэн мэргэдийг бараг бүхний дээр онцгойлон тавьж бараг бүх шатанд зөвлөх болгон ашиглаж байсан.

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, МОУА-ийн жинхэнэ гишүүн, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Л.Хайсандай:

- Одоо даян дэлхийн хэмжээнд 300 орчим улс орон оршин тогтнож байгаа гэж эрдэмтэд тооцсон байдаг. Эдэн дотор бие даасан ч улс байна. Нэг нь нөгөөтэйгөө нэгдсэн улс ч байна. Нэгдэж байгаад эргээд салж байгаа нь цөөн биш байна. Энэ бол манай жижигхэн гариг дээр байгаль, нийгмийн зүй тогтлын дагуу явагдаж байгаа бодит үзэгдэл яах аргагүй мөн. Харин улс бүхэнд ажиглагддаг нэг онцлог байна. Энэ бол улсын хил юм. Хилгүй улс гэж байхгүй, улсгүй хил гэж байхгүй. Энэ нь яван явсаар найрамдал, сөргөлдөөн тэмцлийн гол обьект болж ирсэн түүхтэй.

- Улсын хил дээр найрамдал нөхөрлөлийг онцгойлон үзэх, улсын хязгаар нутгийг улсын сүр хүч, өнгө үзэмж гэж үзэн шилдэг хүчээр бэхжүүлж, нийгэм эдийн засгийн хөгжлийг нь онцгойлон дээшлүүлж, халдах дайсныг няцаахад хязгаар нутгаар гүнд цөмрүүлэхгүй барьж шийтгэхээр цэргээ бэлэн байлгах зэрэг онол, арга зүйг үндэс болгож байсан нь Чингисийн бидэнд үлдээсэн нэг сургамж нь эрдэмтэнгүүдээ дээдлэх, тэдний оюуны их боломжийг ашиглах, зөвлөхөөр авч ажиллуулах уламжлалт сургамж юм.

- МОУА-ыйн жинхэнэ гишүүн, Шинжлэх ухааны доктор, профессор Ш.Паламдорж:

- Хил хязгаар нутгийг эзэнгүйрүүлэхгүй байх бодлого юм. Чингис хаан "газар бол улсын үндэс мөн" гэсэн Маодунь Шаньюйн сургаалийг мэдэхгүй ч баримталж байсан бодлого, явуулсан үйл ажиллагаагаараа улс гүрнийхээ оршин тогтнох аюулгүй байдлаа хангахын нэг эх сурвалжийг нутаг дэвсгэрийн хил хязгаар, гадаад орчныг айх аюулгүй, амгалан байлгах явдал хэмээн үзэж байсанд оршино.

- Хил хязгаарыг хамгаалах цэргээс гадна "тама" цэргийг эзэлсэн улс оронд суулгадаг байсан юм. Энэ нь эзэнт гүрний гадаад, дотоод дахь аюулгүй байдлыг хангахад чиглэж байсан бөгөөд өнөө үеийн "түргэн байрлах цэрэг"-тэй тун төстэй ажиллагаа явуулдаг байсан байна.

- Хилийн бүс, хил орчмын аюулгүй байдлыг хангаснаар гадаад аюул заналыг багасгадаг байжээ.

- Гадаад аюулгүй байдлыг хангахад улс төр, дипломатын арга нэн чухал хэрэгсэл нь болж байжээ.

Эрдэмтдийн хийсэн дүгнэлтүүдээс үзэхэд Чингис хаан, түүний залгамжлагчид улсын хилийн асуудлыг нэн тэргүүн ээлжинд авч үзэж, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой бодлого хэрэгжүүлж байжээ.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, СУРГАЛТЫН ТАЛААР ЗАРИМ АСУУДАЛ

Ж.Нямдорж: ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Байгууллагын амжилттай үйл ажиллагааны нэг чухал хүчин зүйл нь хүний нөөцийн хөгжил юм. Иймд хүний нөөцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх нь бусад нөөцөд хөрөнгө оруулалт хийснээс илүү үр ашигтай байдаг. *Учир нь хүнийг хөгжүүлэх тусам чадвар нь жилээс жил ирэх тутам нэмэгдэж үнэ цэнэ нь өсөж, боловсорч хөгжихийн хирээр сэтгэж, сэтгэхийнхээ хирээр бүтээдэг онцлогтойгоор бусад нөөцүүдээс дувуу талтай байдаг.* Хүний нөөц бол бусад нөөцүүдтэй харьцуулахад хамгийн шавхагдашгүй арвин баялаг байдаг бөгөөд хүн байнга хөгжихийг өөрөө шаардаж байдаг.

Хувь хүний хувьд ч гэсэн өөрийгөө байнга хөгжүүлж байх нь нэр хүнд, үнэ цэнэтэй, өрсөлдөх чадвартай, цаг үеэсээ хоцрохгүй байхын баталгаа болж байна.

Орчин үеийн олон байгууллага хүний нөөцийн менежмент зөвхөн өөрсдийн ажиллагсадын асуудлыг удирдан зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаа биш, харин ирээдүйд байгууллагын төлөө ажиллах хүмүүсийг удирдах асуудлыг хамрах болж байгаа билээ. Хүний нөөцийн менежментийн үйл ажиллагаа зөвхөн тухайн байгууллагын ажилчдаар хязгаарлагдахгүй, дэмжигч, сонирхогч, харилцагч, түншлэгч бүх талуудыг хамрах болжээ.

Байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдийн гарт бүх үйл ажиллагааг төвлөрүүлэхээс татгалзан удирдлагын нэгдсэн тогтолцоотой байх хандлага бий болж байгаа. Иймээс хүний нөөцийн менежмент захиргааны үйл ажиллагаанаас стратегийн шинжтэй асуудалд тулгуурлан хөгжиж байна.

Хүний нөөцийн төлөвлөлтийн гол зорилго нь байгууллагын зорилго, стратегид хүрэхийн тулд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, хангалтыг үнэлэх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх явдал юм.

Хүний нөөцийг хөгжүүлэх гэдэг ойлголтод ажилтны гүйцэтгэлийг сайжруулахын тулд мэдлэг, ур чадвар, туршлагыг хөгжүүлэх үйл явц хамаарна. Үүний тулд байгууллага нь хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгцээ шаардлагыг нь сайтар тогтоох шаардлагатай. Энэ хөтөлбөртөө зорилго, зорилт, хугацаа, хөгжүүлэх арга, үнэлэх хэлбэр, эргэх холбоог тусгадаг байна. Сургалт бол хүний нөөцийг хөгжүүлэх үндсэн арга бөгөөд ажилтны ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн байх нь чухал юм. Иймээс тэргүүн ээлжинд сургалтын хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, зорилт, арга, үнэлгээний хэмжүүрийг боловсруулах нь чухал.

Сургалт хэрэгцээг тодорхойлох: Сургалтын үйл ажиллагааг удирдах үйл явц нь түүний хэрэгцээг тодорхойлхоос

эхэлдэг. Сургалтын хөтөлбөр нь 3 үндсэн үе шаттай байдаг.

Үнэлгээ суралцагчдын шинэ ханлдлага, ур чадвар, чадавхийг үнэлж сургалтын үр дүнгийн талаар дүгнэлт гаргана.

Сургалтын хөтөлбөрт дараах зүйлүүдийг багтаасан байвал зохино. Үүнд:

- Сургалтын хэрэгцээнд тулгууралсан үндэслэл, зорилго, зорилтыг тодорхойлох.
- Сургалтын агуулгыг тодорхойлж боловсруулах.
- Сургалтын төвшинг нарийвчлан зааж өгсөн байх.
- Ямар арга хэрэглэх, нөөц шаардагдахыг тодорхойлох.
- Сургалтын явц, үр дүнг хэрхэн үнэлэх талаар төлөвлөж тусгах.
- Цаашид энэ хөтөлбөрыг яаж өргөжих, хөгжүүлэх боломжийг тодорхойлох.

Ажиллагчдын сургалтын хэлбэрүүд: Мэргэжлийн сургалт бол байгууллагын хүний нөөцийг сургаж хөгжүүлэх үндсэн хэлбэр юм.

Сургалтын зорилго, зохион байгуулах хэлбэрээс хамаарч үйлдвэрлэлийн сургалтыг 2 төрөлд хуваана. Үүнд:

Тодорхой мэргэжлийн бус сургалт - суралцагчдын мэргэжлийн төвшинөөс үл хамаарч ямар нэгэн өргөн хүрээний ерөнхий мэдлэг олгох зорилгоор зохион байгуулдаг сургалт.

Тодорхой мэргэшүүлэх сургалт - үндсэн мэргэжлээс гадна мэргэжлийн тодорхой чиглэлээр нарийн мэргэшүүлэх зорилготой сургалт.

Ажилд авах үеийн сургалт - Сургалтын хугацаа ихэвчлэн 1-2 долоо хоног байдаг.

Жил бүрийн тогтмол сургалт - Тухайн жилийн мэргэжлийн зэрэг, ангилалалыг тогтоож өгдөг. Жил бүрийн тогтмол сургалт нь хэд хэдэн үе шат, ангилалаар зохион байгуулагддаг ба ихэвчлэн 1-3 эсвэл 3-7 өдрийн богино сургалтууд юм.

Дадалгажилт – дахин сургах сургалтын төлөвлөгөөний нэг хэсэг байх

Мэргэжлийн дахин бэлтгэл *(мэргэшүүлэх сургалт)* Мэргэжлийн үйл ажиллагааны өөр төрлийн ажлыг гүйцэтгэхийн тулд энэ чиглэлийн шинжлэх ухааны онол, техник, технологийг судалхаар тусгасан боловсролын хөтөлбөрийн дагуу ажжиллагчдад нэмэлт мэдлэг , ур чадвар, туршлага эзэмшүүлхэд чиглэсэн сургалт юм.

Дахин бэлтгэл. Зах зээлийн харилцаа гүнзгийрэх тусам ийм сургалтын хэрэгцээ өсдөг байна.

Сургалт явуулах байршилаар нь ажлын байран дээрх ба ажлын байрны гадуурах гэх мэтээр ангилдаг байна.

Аливаа байгууллага хөгжих эсэх нь хувь хүний бүтээлч сэтгэлгээнээс ихээхэн хамааралтай тул байгууллага зорилтоо хэрэгжүүлэхэд ажиллагсадын чадварыг тасралтгүй хөгжүүлэх нь чухал. Хүмүүсийнхээ бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхийн тулд төрөл бүрийн сургалтад хамруулах, шинэ санал санаачилгыг дэмжиж түүнийг ажил хэрэг болгох бололцоогоор хангаж ажиллах шаардлагатай.

Хил хамгаалах байгууллагын удирдлагаас сүүлийн жилүүдэд бие бүрэлдэхүүнээ гадаад, дотоодын төрөл бүрийн сургалтад хамруулж байна. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын сүүлийн 5 жилд сургалт, дамжаанд хамрагдсан байдлыг тоон үзүүлэлтээр авч үзвэл **2010** онд 675 албан хаагч, **2011** онд 1882 албан хаагч, **2012** онд 2793, **2013** онд 2960, **2014** онд 3850 албан хаагчдыг сургалтад хамруулсан байна.

Хил хамгаалах байгууллагын цэргийн мэргэжлийн боловсон хүчний нөхөн хангалт боломжийн түвшинд байгаа харин тусгай мэргэжлийн боловсон хүчний нөхөн хангалт шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа. Энэ тал дээр нэлээд анхаарч ОХУ, БНХАУ-ын төрөл мэргэжлийн цэргийн академи, их, дээд сургуулиуд, ЭМШУИС, МУИС, БХИС, Хөгжим бүжгийн коллеж, Барилгын коллеж болон бусад их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, цэргийн инженер, ар тал, холбоо, эмч, хөгжим, барилгын гэх мэт мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байна.

Хил хамгаалах байгууллага нь бие бүрэлдэхүүнээ сургах, давтан сургах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Хил хамгаалах ерөнхий газрын даргаар батлуулж, төсөв хөрөнгийг шийдэж өгсөөр байтал төлөвлөгөөнд тусгагдсан сургалтууд тасарч байна. Энэ нь сургалтын хэрэгцээг бодитой тодорхойлоогүй, хилийн зарим ангийн удирдлага албан хаагчдаа сургах талаар анхаарч ажилладаггүй зөвхөн Хил хамгаалах ерөнхий газрын даргаар батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан сургалтад албан хаагчдаа хамруулж, суралцах хугацааны цалин, чөлөөг олгохгүй байх зэрэг шалтгаанаас хамаарч байна.

Иймд албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээг зөв тодорхойлон хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж, сургалтад хамрагдсан албан хаагчийн сургалтын үр дүнг тооцож, сургалтад хамрагдах албан хаагчдыг сайтар сонгон шалгаруулж, үр дүнг тооцож байх нь зүйтэй гэж үзэж байна.

БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ

Д.Пүрэвням. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Хүн төрөлхтөн үүсч бий болсон тэр цаг үеэс аюулгүй байдлаа хангах зайлшгүй шаардлага тулгарч түүнийгээ хэрэгжүүлэх арга замыг бий болгон улам боловсронгуй болгон тэмцсээр өнөөдрийг хүрсэн.

Өнөө цагийн шинжлэх ухаан, техник технологи, эдийн засаг, нийгэм, соёлын хурдацтай хөгжил, даяршилын нөлөөгөөр дан ганц хүний аюулгүй байдал бус улс орон, бүс нутаг, дэлхийн нийтийн хэмжээнд улс төр, нийгэм, эдийн засгийн хүрээнд олон салбар бүхий аюулгүй байдлын талаар ярьж, авч үзэх болсон билээ.

Үүний нэг нь ***байгууллагын аюулгүй байдал*** юм.

Менежментийн шинжлэх ухаанд ***байгууллага гэдэг нь өмнөө тавьсан тодорхой зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартай зохицуулж байгаа бүлэг хүмүүс бөгөөд гадаад орчны нөлөөллөөс хамааардаг нээлттэй систем*** гэж тодорхойлсон байдаг.

Эндээс харахад байгууллагад нөлөөлдөг орчны асуудал аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлдэг нь харагдаж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд янз бүрээр нөлөөлж буй хүчин зүйлийг ***байгууллагын орчин*** гэх бөгөөд нөлөөлөх байдлаар нь ***шууд*** болон ***шууд бусаар нөлөөлөх хүчин зүйл*** гэж ангилдаг.

Шууд нөлөөлдөг хүчин зүйлийг байгууллагын *дотоод орчин*, шууд бус буюу дам нөлөөлдөг хүчин зүйлийг байгууллагын *гадаад орчин* гэнэ.

Байгууллагын аюулгүй байдлын талаар удирдахуйн ухааны доктор, хурандаа Ц.Цэрэндорж "Бидний менежмент" номондоо бичиж хүчний байгууллагуудад анх удаа энэ асуудлыг гаргаж тавьсан.

Тэрээр байгууллагын аюулгүй байдлын талаар "*...Аливаа байгууллага нь улс төр, эдийн засаг, соёл, боловсрол,шинжлэх ухаан технологийн хөгжил, хүн ам зүй, байгаль экологи зэрэг нийгмийн амьдралын бүхий л хүрээний шууд болон шууд бус нөлөөлөл дор оршин тогтнож байдаг.Эдгээр нөлөөллийн эерэг болон сөрөг талуудыг хэрхэн хүлээн авч шийдвэрлэснээр тухайн байгууллага үүргээ амжилттай биелүүлж нэр хүнд нь өснө.*

Байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах гэдэг нь үндсэн үүргээ биелүүлэхэд шууд, шууд бусаар нөлөөлж буй сөрөг, таагүй хүчин зүйлүүд тэдгээрийг даван туулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын цогц үйл ажиллагаа юм.

Байгууллагад нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг нөлөөллөөр нь гадаад дотоод, үүсэх үр дагавараар нь шууд ба шууд бус хүчин зүйлс гэж ангилж болно. Өөрөөр хэлбэл улс орны төрийн байгууламж, эдийн засгийн байдал, соёл боловсролын түвшин, байгаль экологи, гэмт хэргийн өсөлт, бууралт болон дээд

шатны байгууллагын удирдлага зохион байгуулалт, харилцагч байгууллагуудын байдал зэрэг нь ***гадаад хүчин зүйлс*** *болно.*

Тухайн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, салбар нэгжүүдийн харилцан ажиллагаа, уялдаа холбоо, удирдлагын арга барил, хамт олны боловсрол, эрүүл мэнд, амьдралын түвшин, мэргэжлийн ур чадвар, тогтоосон дэг журам, мэдээлэл, материаллаг үнэт зүйлсийг хэрхэн хуваарилан ашиглаж байгаа, технологийн горимыг нарийн чанд мөрдөж буй эсэх, сахилга бат зэрэг нь ***дотоод хүчин зүйлс*** *болно...”* гэж дээрх бүтээлдээ өгүүлэхийн хажуугаар өөрийн байгууллагын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох 16 гадаад хүчин зүйлс, 12 дотоод хүчин зүйлсийг тодорхойлжээ.

Онолын хувьд байгууллагын *дотоод орчинг /Internal Environment/* дотор нь

1. Зорилго, зорилтууд
2. Технологи
3. Удирдлагын бүтэц
4. Ажиллах хүч буюу хүний нөөц

гадаад орчинг /External Environment/ нөлөөлөх байдлаар нь ***макро*** ба ***микро орчин*** гэж 2 ангилдаг бөгөөд *макро орчинд:*

1. Засгийн газар буюу улс төр
2. Олон улсын байдал
3. Эдийн засгийн байдал
4. Технологи
5. Нийгэм ба соёлын хүчин зүйл

микро орчинд:

1. Зохицуулагч
2. Нийлүүлэгч
3. Хэрэглэгчид
4. Өрсөлдөгчид гэсэн хүчин зүйлүүдэд хуваажүзсэн байна.

Дээрх хүчин зүйлсийн сөрөг, таагүй үзэгдлүүд нь байгууллагын оршин тогтнох, хөгжих, амжилт гаргах үйл явцад саад учруулж байдаг бөгөөд тэдгээрийг урьдчилж харан сэргийлэх, эрсдэл багатайгаар давж гарах, цаашид дахин давтаж гаргахгүй байх талаар удирдлагын зүгээс зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гардаг.

Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх аваас байгууллагын аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

1. Удирдах ажилтнуудын ажлын арга барил, мэдлэг, чадварыг тасралтгүй хөгжүүлж байх.
2. Төр, засгийн бодлого, шийдвэр, үйл ажиллагааг зөв таниулж ойлгуулах.
3. Хууль, эрх зүй, удирдлагын баримт бичгийг сурталчилах, судлуулах.
4. Мэдээ, мэдээлэлд ямар нэгэн хязгаар тавихгүйгээр ач холбогдол өгч цуглуулан, судлаж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, алив үйл ажиллагааны хэтийг төлөвлөх.
5. Хүний нөөцийн менежментийг оновчтой зохион байгуулах. /хүнээ судлах, сонгон шалгаруулах, сургах, давтан сургах, албан тушаалд томилох/
6. Байгууллагыг эдийн засаг, санхүүгийн хувьд бэхжүүлэх.
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангахад хөрөнгө харамгүй зарцуулах.
8. Техник, технологийн дэвшлийг түлхүү ашиглах.
9. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

10. Хамт олны идэвхи санаачилга, гар нийлэмжтэй ажиллагааг идэвхижүүлэхэд урамшуулалын болон биеийн тамир, урлаг соёлын ажлыг чиглүүлэх.

11. Хяналт шалгалтын үр ашигтай тогтолцоог нэвтрүүлж, эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллах. /дотоод хяналт шалгалт, хяналт шинжилгээ үнэлгээ, аудит/

12. Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн сахилгыг чанд мөрдүүлж, хариуцлагын тогтолцоог тэгш хэмтэй байлгах.

13. Байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэх.

14. Байгалийн гамшиг, осол аваараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах үйл ажиллагаа нь эцсийн дүндээ хамт олны, хүн нэг бүрийн аюулгүй байдал, түүнийг хангаж байгаа явдал юм.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮНДСЭН АГУУЛГЫН ТУХАЙ

Г.Батсүх. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

"Бид эрсдэлийг удирдахгүй бол тэр биднийг удирдаж эхлэнэ..."

Дэлхийн улс орнуудын гашуун туршлагууд үнэмшилтэйгээр улсын хилийн аюулгүй байдлын хөгжлийн тогтвортой байдлыг хангах болон удирдлагын үр дүнг дээшлүүлэх нь түүний хэмжээнээс болон цагийн байдлын хийгээд үйл ажиллагааны өвөрмөц онцлогоос үл хамааран улсын хил хамгаалалтын удирдлагын системийн бүрэлдэхүүн хэсэг болох эрсдэлийн менежментийг идэвхитэй ашиглахгүйгээр боломжгүйг баталж байна.

Эрсдэлийн менежментийн систем (эрсдэлээр удирдах систем) нь улсын хилийн аюулгүй байдлыг хангахад хүрсэн үр дүн болон тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэх аливаа оролдлогыг болон гадаад улс орнуудын тусгай албадын тагнуул, хил зөрчигчдийн үйл ажиллагааг дээд зэргээр таслан зогсоосон буюу бууруулсан хоёрын хоорондын зайлшгүй шаардлагатай тэнцвэрт чиглэгдэх бөгөөд хил хамгаалалтын менежментийн/ удирдлагын системийн бүрэлдэхүүн хэсэг болох ёстой, өөрөөр хэлбэл улсын хилийн хамгаалалтын ерөнхий бодлогод, түүний төлөвлөгөө, үйл ажиллагаанд зангидагдсан байх ёстой. Зөвхөн ийм нөхцөл бүрдүүлсэн үед эрсдэлийн менежментийн системийн хэрэглээ нь үр дүнтэй байна.

Эрсдэлийн менежмент нь хил хамгаалалтын зайлшгүй шаардлагатай соёлыг болон дэд бүтцийг шаардана:

- эрсдэл үүсэх шалтгаануудыг болон үндсэн хүчин зүйлүүдийг илрүүлэх;
- эрсдэлийг тодорхойлох, шинжлэх ба үнэлэх;
- хийгдсэн үнэлгээн дээр шийдвэр

гаргах;

- эрсдэлийн эсрэг удирдах нөлөөг боловсруулах;
- хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл эрсдэлийг бууруулах;
- төлөвлөсөн хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах;
- төлөвлөгдсөн ажиллагаануудын биелэлтийг хянах;
- эрсдэлийн шийдвэрийн үр дүнг шинжлэх ба үнэлэх.

Улсын хил хамгаалалтын практикт эрсдэлийн менежментийг нэвтрүүлэх нь түүний хөгжлийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлтэй нөхцөл байдалд шийдвэр гаргалтын үндэслэлийг дээшлүүлэх, хяналтын нөхцөлүүд дэх үйл аиллагааны бүх төрлийг хэрэгжүүлснээр хилийн аюулгүй байдлыг хангах боломж олгоно.

Улсын хилийн орон зайд хилийн аюулгүй байдлыг хангах бүхий л процессуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх үед хилийн бүх байгууллагууд буюу хилийн отряд, заставууд эрсдэлийн янз бүрийн төрлийг удирдах зайлшгүй шаардлагатай тулгарна. Иймд хил хамгаалалтын дээд удирдлага нь хил хамгаалах байгууллагын бүх офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчид, ажилтнууд эрсдэлийн менежментийн зайлшгүй байдлыг нэн тэргүүний амин чухал хүчин зүйлүүдийн нэг гэж хүлээн зөвшөөрсөн байхад хүрэх ёстой.

Хил хамгаалалтын эрсдэлийн удирдлагын үндсийг эрсдэлийн менежментийн дараах үндсэн өвөрмөц онцлогууд бүрдүүлнэ.

1. Хил хамгаалалтын эрсдэлийн удирдлага нь сөрөг ч, таатай ч үр дагавартай холбоотой. Эрсдэлийн удирдлагын мөн чанар нь төлөвлөгдсөн үр дүнд гарч болох хазайлтуудыг тодорхойлоход болон хэтийн төлвийг сайжруулах, гаргасан шийдвэрийн алдааг багасах ба үндэслэлийг сайжруулахын тулд эдгээр хазайлтыг удирдахад оршино.

2. Хил хамгаалалтын эрсдэлийг удирдах нь хэтийн төлөвийг тодорхойлохыг болон үйл ажиллагааг сайжруулах боломжуудыг илрүүлэхийг, мөн түүнчлэн үйл явдлын хүсээгүй явцын магадлалыг зөвшөөрөхгүй буюу багасгахыг илэрхийлнэ.

3. Хил хамгаалалтын эрсдэлийн удирдлага нь шийдвэр гаргахад зориулсан нөхцөлийн нарийвчилсан анализыг шаардана.

4. Хил хамгаалатын эрсдэлийн удирдлага – энэ нь цаашид үйл ажиллагааг сайжруулах болон хил хамгаалалах байгууллагуудын албаны процессуудын үр дүнг дээшлүүлэх арга замыг сонгоход хэрэглэж болох логикийн хийгээд дэс дараалсан процесс. Энэ нь хилийн аюулгүй байдлыг хангах баталгааны үр дүнтэй байдлыг хангахад хөтлөх арга зам.

5. Хил хамгаалалтын эрсдэлийн менежмент нь хил хамгаалалтын өдөр тутмын ажиллагаанд нэгтгэгдсэн байх ёстой.

Хил хамгаалах байгууллагын удирдлагын системд эрсдэлийн менежментийн нэгтгэх үндсэн чиглэлийг зураг 1-т үзүүлэв.



удирдлагын системд эрсдэлийн менежментийн нэгтгэх үндсэн чиглэлүүд

Эрсдлийн удирдлага дэвшилтэт сэтгэлгээг шаарддаг. Эрсдэлийн удирдлага – энэ нь юу болж өнгөрч болохыг хурдан тодорхойлох болон түүнд бэлэн байдлыг нэгэн зэрэг хангах, үйл ажиллагаагаар мэдрэмжгүй удирдлагыг халах процесс. Эрсдэлийн менежментийн албан ёсны систем нь болзошгүй асуудлуудыг урьдчилан сэргийлэхээр ажиллаж байгаа, хил хамгаалах байгууллагын удирдлагын системийг байгуулах боломж олгодог.

Эрсдэлийн удирдлага удирдлагын шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай, маш тодорхой хариуцлагыг болон бүрэн эрхийг шаарддаг. Дээд удирдлага хил хамгаалах байгууллага дахь эрсдэлийн удирдлагын төлөө ерөнхий хариуцлагыг хүлээдэг. Түүний онцгой асуудал нь холбогдох албан хаагчдын хооронд хариуцлагыг болон эрх мэдлийг хуваарилах явдал. Эрсдэлийн удирдлагын процесст гардаг шийдвэрүүд хууль тогтоомжийн шаардлагуудыын хүрээнд байх ба нэгж, салбаруудын зорилгод хариулт өгөх ёстой. Иймд, эрсдэлийн төлөө хүлээх хариуцлага, энэ эрсдэлийг хянах чадвар хоёрын хоорондын оновчтой тэнцвэрийг тодорхойлох нь маш чухал.

Эрсдэлийн удирдлага нь эрсдэлийн менежментийн оролцогчдын хоорондын харилцан ажиллагааны үр дүнтэй процессоос хамаарна. Эрсдэлийн менежментийн процесс хил хамгаалах байгууллагын дотоод болон гадаад орчинд хэрэгждэг учир энэ процессын дотоодын болон гадаадын оролцогчидтой харилцан ажиллах зайлшгүй шаардлагатай. Эрсдэлийн бүрэн үнэ цэнэтэй удирдлагыг хангахын тулд эхний ээлжинд хил хамгаалах байгууллагын дотор үр дүнтэй харилцан ажиллагааг бий болгох нь чухал. Эрсдэлийн удирдлага тэнцвэржсэн шийдвэр гаргахыг шаарддаг. Эрсдэлийн менежментийн процесст эрсдэлийн зэргийг бууруулах болон төлөвлөгдсөн үр дүнд хүрэх хэмнэлийн зохимжтой байдлыг тодорхойлох шаардлагатай. Эрсдэлийн менежментийн тооцогдсон онцлогууд нь түүний үндсэн хүчин зүйлүүд болно (зураг 2).



Зураг 2. Эрсдэлийн менежментийн үндсэн хүчин зүйлүүд

Улсын хил хамгаалалтын эрсдэлийн менежментийн давуу талууд

Улсын хил хамгаалалтын эрсдэлийн эрсдэлийн менежментийн үндсэн давуу талуудыг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1

Давуу тал	*Тодорхойлолт*
Улсын хил хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед тодорхой бус байдлын хүчин зүйлийг бууруулах	Сөрөг үйл явдлууд дээр тавих хяналт нь тэдгээрийн үүсэх магадлалыг бууруулах болог тэдгээрийн нөлөөг багасгах тодорхой ажиллагаанууд болно. Түүнчлэн даван туулшгүй үйл явдлууд тохиолдох үед хил хамгаалах байгууллага нь зохистой төлөвлөлтийн болон бэлтгэгдсэн байдлын ачаар тогтвортой байдлын шаардлагатай зэрэгт хүрч болно.
Сайжруулах хэтийн төлвийн боломжуудыг ашиглах	Эрсдэлийн менежментийн процесст эрсдэлийн нөхцөл байдалд тааламжтай үр дагаврууд тохиолдох магадлал үнэлэгддэг. Албан хаагч эрсдлүүдийг ухамсарлаж, тэдгээрийг удирдахын тулд шаардлагатай чадваруудыг эзэмшсэн бол хайлтын хэтийн төлөв үр дүнтэй болно.
Сайжруулагдсан төлөвлөгөө болон үйл ажиллагааны үр дүнгийн дээшлэлт	Хил хамгаалах байгууллагын, түүний зорилтот үзүүлэлтүүдийн, операцийн/ажиллагааны, болон хэтийн төлвийн талаарх бодит өгөгдөхүүнүүд байгаа нь илүү их хэмжсэн бөгөөд үр дүнтэй төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломж олгодог. Эхний ээлжинд тааламжтай хэтийн төлвийг ашиглах, сөрөг үр дагварыг багасгах, үйл ажиллагааны сайжруулалтад хүрэх хил хамгаалах байгууллагын чадварыг дээшлүүлэх боломж олгодог.

Нөөцүүдийн хэмнэлт	Улсын хилийн аюулгүй байдлыг хангах аливаа нэг ажиллагаа/операци явуулах эдийн засгийн зохистой асуултуудад онцгой анхаардаг. Байгаа нөөцүүдийн хэмжээний тооцоо, активуудын төлбөрийг түргэн гүйцэтгэх чадварын дээшлүүлэлт нь томоохон алдаанаас зайлс хийх төдийгүй албаны үйл ажиллагаанаас олох ашгийг дээшлүүлэх боломж олгоно.
Сонирхогч талуудтай харилцааг сайжруулах	Эрсдэлийн удирдлагын процесс нь хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнээс түүний сонирхсон дотоодын болон гадаад талуудыг илрүүлэхийг болон тэдний болон удирдлагын хооронд хоёр талын гэрээг боловсруулахыг шаарддаг. Ийм харилцааны суваг нь хил хамгаалах байгууллагыг сонирхогч талууд түүний үйл ажиллагаанд гарах өөрчлөлтийг хэрхэн мэдрэх талаарх мэдээнүүдээр хангадаг.
Шийдвэр гаргахын тулд мэдээллийн чанарыг дээшлүүлэх	Эрсдэлийн менежментийн процесс удирдлагын янз бүрийн түвшин дээр стратегийн шийдвэр гаргахад шаардлагатай, мэдээллийн болон шинжилгээний үнэн зөв байдлыг дээшлүүлдэг.
Ажил хэргийн нэр хүндийн өсөлт	Төрийн болон ашгийн ба ашгийн бус байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, ялангуяа цэрэг, цагдаа, тагнуул зэрэг хууль хүчний байгууллагууд нь улсын хилийн аюулгүй байдал болон хил хамгаалалтанд учирч болзошгүй эрсдэлүүдийг удирдаж байгаа, олон улсын өнөөгийн түгшүүртэй үед найдвартай түнш гэдгээ сурталчилсан, хил хамгаалах байгууллагуудтай ажиллах дуртай байдаг.
Төр засгийн дэмжлэг	Эрсдэлийн чанартай удирдлага нь болзошгүй эрсдэлийн өгөгдахүүнүүдийн байгаа дэлгэрэнгүй үндэслэлээс болон хил хамгаалалтын байгаа хяналтын нөхцөлийг харуулснаас төр засгийн нүдэн дээр удирдлагын нэр хүндийг өсгөдөг.
Хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн хяналт	Эрсдэлийн менежментийн явцад онцгой анхаарлыг хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тодорхой хяналтыг хангадаг, хил хамгаалалтын процессын параметрүүдийн мониторингтой болон өөрчлөлттэй холбоотой асуудлуудад хандуулдаг.

Улсын хил хамгаалалтын эрсдэлийн менежментийн хэрэглээний салбар /МУЖ/

Эрсдэлийн менежментийн процесс нь хил хамгаалах байгууллагын менежментийн бүх түвшин дээр удирдлагын шийдвэрийг дагалддаг (жишээ нь, дээд түвшин дээр, бүтцийн салбаруудын буюу төслийн бүлгийн түвшин дээр) учир эрсдэлийн удирдлагыг хил хамгаалалтын буюу түүний бүрэлдэхүүн хэсгийн (үе шатуудын) менежментэд интеграцчлах шаардлагатай.

Эрсдэлийн удирдлагын процесс илүүчухаласуудлынтөлөвлөлтийгболон шийдвэр гаргалтыг дагалдах ёстой. Энэ нь юуны өмнө улс төр дэх өөрчлөлтөд, шинэ стратегийг болон процедурыг танилцуулахад, төслүүдийг, ихээхэн мөнгөн хөрөнгө оруулалтыг буюу дотоод зохион байгуулалтынзөрчил, зөрчилдөөнүүдийг удирдахад хамаарна.

Хэрэглээний аспектад эрсдэлийн менежментийн процесс нь хэрэглээний хэд хэдэн практикийн хүрээтэй. Тэдгээрийн баримжаатай жагсаалтыг гаргая:

- Стратегийн, операцийн болон төсвийн төлөвлөлт,
- Активуудын удирдлага ба нөөцүүдийн хуваарилалтын төлөвлөлт,
- Хил хамгаалалтын үйл ажиллагааны өөрчлөлт (стратегийн, технологийн болон зохион байгуулалтын)
- Хил хамгаалалтын шинэ арга, тактикийг зохиох ба боловсруулах,
- Хил хамгаалалтын чанарын менежмент,
- Олон нийттэй хамтран ажиллах нийгмийн салбарууд,
- Хүрээлэн буй орчны экологи ба хамгаалалт,
- Ажил хэргийн болон мэргэжлийн ёс зүйн дүрэм
- Мэдээллийн аюулгүй байдал,
- Бие бүрэллдэхүүний хариуцлагын асуудлууд, тэдгээрийг биелүүлэх боломжуудыг үнэлэхийн тулд төр, засгийн шаардлагуудыг шинжлэх, тавигдсан шаардлагуудад тохирох хил хамгаалалтын процессуудын үнэлгээ,
- Мэргэжлийн болон албаны аюулгүй байдлын хамгааллыг удирдах,
- Төслүүдийг удирдах,
- Гэрээ, хэлэлцээрүүдийг удирдах (хил, түүний хамгаалалттай холбогдолтой),
- Туслан гүйцэтгэгч байгууллагуудыг удирдах,
- Хүний нөөцийн менежмент,
- Хамтын удирдлага,
- Эрсдэлийн менежментийн процессын далайц нь хил хамгаалтын үйл ажиллагааны явцад гарсан байх ёстой, удирдлагын шийдвэрүүдийн ач холбогдлоос хамаарна.

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН ХАНГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

М.Эрдэнэбуян. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Дэлхийн улс орнууд шинжлэх ухаан техник технологийн өндөр хөгжилд хүрэхийн зэрэгцээ түүнийг гэмт хэрэгтэн,гэмт хэргийн бүлэглэлүүд санаа зорилгодоо ашиглан үйл ажиллагаа нь нарийн зохион байгуулалттай улс дамнасан хэлбэрт шилжиж, байгаа нь аюулгүй байдалд эрсдэл учруулах өндөр магадлалтай нь, хилийн зөрчил, хилийн цагийн байдал, хөрш орнуудын нөхцөл байдлуудаас харагдаж байна.

Жишээ нь: /Монгол улсын археологийн үнэт олдвор Т-батаар буюу Үлэг гүрвэлийн ясыг улс, тив дамнуулан хилээр гаргасан хэргийг дурьдахад хангалттай юм. /

Түүнчилэн хил орчмын бүс нутагт улсын болон бүс нутгийн хөгжилд ач холбогдол бүхий уул уурхай, ашигт малтмалын орд газруудын хайгуул, олборлолт нэмэгдэхийн хирээр тэдгээрийг дагасан хууль бус үйлдэл, гэмт хэрэг, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил өдрөөс өдөрт нэмэгдэж, тэдэнтэй тэмцэхэд ганцхан хил хамгаалах байгууллагын хүч бүрэлдэхүүн хүрэлцэхгүй, эрх хэмжээний хувьд ч хязгаарлагдмал байгаа ба үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий бусад байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт,уялдаа холбоог нь хангах, үүрэг эрх, оролцоог нэмэгдүүлэх чухал шаардлагатай байгааг дурдья.

Ийм нөхцөл байдалд улсын хилийн хэсгийг, эдийн засгийн чадавхаас үл хамааруулан бэхжүүлэх, хязгаар нутгийг эзэнтэй байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, орчин үеийн инженер техникийн хэрэгслээр төхөөрөмжилөн шинэ хандлага, хангалтыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлыг түргэвчлэх хэрэгтэй ба цаашид, улсын хил хамгаалалтын өнөөгийн тогтолцоог шинэчилж хил хамгаалалтын арга хэлбэр хангалт үйлчилгээг тухайн бүсүүдийн онцлогт нийцүүлэх шаардлага тулгарч байна.

Бүсчилсэн хил хамгаалалтад, уламжлалт инженер техникийн хангалт, арга хэмжээтэй хослуулан, техник технологийн зарим шийдлийг хил хамгаалах албанд нэвтрүүлэн ашиглаж болох хувилбаруудыг доорхи байдлаар зохион байгуулж болох юм.

"Хил хамгаалах арга бол "хүч хэрэгслийг ашиглах сонголт"[1]


а/ Говь цөлийн бүсийн хил хамгаалалтад ашиглах технологийн шийдэл

Хилийн застав, харуулын байрлалаас өндөр хүчин чадлын харааны болон хяналтын орчин үеийн хэрэгсэл /дулаан мэдрэгч камер, радарын систем/ ашиглан тогтвортой хяналт явуулах арга хэмжээг хамгаалалтын үндсэн арга

[1] Д.Нямдорж"Улсын хилийг инженер техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгох нь"сэдэвт докторын ажил –УБ ., 2004.9 дэх тал

болгоно. Газарзүйн байрлал тогтоох хэрэгсэл бүхий тоон радио холбооны хэрэгсэл болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжөөр хангах.


- Инженерийн торон саад
- Инженерийн дохиолол бүхий торон саад
- Мөр хянах зурвас
- Камерийн хяналт /дулаан мэдрэгч, өдөр шөнийн/
- Радарын систем
- Шилэн кабелийн дохиолол дамжуулагч
- Хяналтын цогцолбор/хянах цамхаг/
- Байршил тодорхойлогч, мэдээлэл дамжуулах төхөөрөмж
- Холбоо зохион байгуулалт, өндөр хурдны сүлжээ/өөрийн холбооны шаардлага ,сонирхолд ашиглагдах



б/ Тал хээрийн бүсийн хил хамгаалалтад ашиглах технологийн шийдэл

Хил орчмын нутагт хүн, малын нягтаршил харьцангуй их байдгийг харгалзан ердийн торон саад, мөр хянах зурвасын/сэргээнэ/.

- Инженерийн торон саад
- Инженерийн дохиолол бүхий торон саад
- Мөр хянах зурвас
- Нам явалттай хамгаалалтын торон саад
- Камерийн хяналт /дулаан мэдрэгч, өдөр шөнийн/
- Радарын систем
- Шилэн кабелийн дохиолол дамжуулагч
- Хяналтын цогцолбор/хянах цамхаг/Байршил тодорхойлогч, мэдээлэл дамжуулах төхөөрөмж




в/ Уулын бүсийн хил хамгаалалтад ашиглах технологийн шийдэл

Хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлд теле-хяналт, дохиоллын системийг ашиглан тасралтгүй хяналтад байлгаж, хяналтад хамрагдадгүй хилийн хэсгийн хамгаалатад хөдөлгөөнт харуул, бүлэг ажиллуулах арга хэмжээнээс гадна нисгэгчгүй нисэх хэрэгсэл, өндөр уулын ХЗГБЧ-д инженерийн саад байгуулах зэрэг инженер техникийн арга хэмжээг хэрэгжүүлэх

- Камерийн хяналт /дулаан мэдрэгч, өдөр шөнийн/
- Радарын систем
- Нисгэгчгүй нисэх хэрэгсэл
- Байршил тодорхойлогч, мэдээлэл дамжуулах төхөөрөмж





г/ Ой тайгын бүсийн хил хамгаалалтад ашиглах технологийн шийдэл

Хилийн застав, харуулыг орчин үеийн хяналтын хэрэгслээр хангаж, хяналтын цогцолбор байгуулах ба газарзүйн байрлал тогтоох хэрэгсэл бүхий тоон радио холбооны хэрэгсэл болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжтэй байхаар зохион байгуулагдна.

- Ойн зурвасын дохиолол бүхий шилэн кабель
- Мөр хянах зурвас
- Камерийн хяналт /хөдөлгөөнт/
- Радарын систем
- Байршил тодорхойлогч, мэдээлэл дамжуулах төхөөрөмж

д/ Усан хилийн хил хамгаалалтад ашиглах технологийн шийдэл

Буйр нуурын хэсэгт усан хилийн застав, зогсоол, харуулын цогцолбор байгуулна. Буйр, дөрөө нуурын хэсэгт хил хамгаааалалтад хөнгөн хөлөг,усны мотоциклотой байхаас гадна.

- Камерийн хяналт /дулаан мэдрэгч, өдөр шөнийн/
- Радарын систем

е/ Хилийн боомтын хил хамгаалалтад ашиглах технологийн шийдэл

- Инженерийн торон саад
- Камерийн хяналт /дулаан мэдрэгч, өдөр шөнийн/
- Радарын систем
- Шилэн кабелийн дохиолол дамжуулагч
- Агаарын бөмбөлөг бүхий теле-хяналтын систем
- Байршил тодорхойлогч, мэдээлэл дамжуулах төхөөрөмж

Жич: Нисгэгчгүй нисэх хэрэгслийг хилийн эрэлд, хөдөлгөөнт бүлгүүдэд, төрөл бүрийн мөрч, илрүүлэгч, саперчин нохой ашиглах зэргээр албаны хангалтыг хил хамгаалалтын үндсэн шаардлагат нийцүүлэн зохион байгуулах зэрэг болно.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН "ГЭРЭЭТ ХИЛЧИН"-ИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Тэмүүжин. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Хил хамгаалах байгууллага нь 82 жилийн хөгжлийн түүхтэй, өнөр бүрэлдэхүүнтэй, баялаг уламжлал, бахархах үйлстэй хамт олон билээ. Монгол Улсын гадаад, дотоод байдал 1930-аад оны эхээр хурцадсаны улмаас төр, засгаас улс орноо батлан хамгаалахын тулд 1933 онд хилийн харуулын цагдааг татан буулгаж, улсын хилийг мэргэжлийн цэргийн хүчээр хамгаалах болж хилийн отряд, комендатуруудыг байгуулж эхэлжээ.

1933 оны нэгдүгээр сард БНМАУ-ын СнЗ-ийн тогтоолоор Дотоодыг хамгаалах газарт баруун ба өмнөд хязгаарыг хамгаалах үүрэг өгч, анхны хилийн отряд, комендатуруудыг байгуулснаар орчин үеийн Хил хамгаалах байгууллага үүссэн юм.

Эх орны дайн дуусч, улс түмний найрамдал хамтач ажиллагааны шинэ үе эхэлсэн 1950 иад оны эхээр Хязгаарын цэргийг татан буулгаж, хилийн пункт, байцаан өнгөрүүлэхүүдээр улсын хилийн дэглэм, журмыг сахиулж байсан түүхийн нэгэн зурвас үе байсан бөгөөд "Хүйтэн дайн"-ы үе болох 1960-аад оноос олон улсын цэрэг, улс төрийн нөхцөл байдал төвөгтэй болох үед Хязгаарын цэргийг дахин байгуулах шаардлага зүй ёсоор тавигджээ. 1959 онд НАХЯ байгуулагдснаар түүний бүтцэд Хилийн албаны хэлтэс бий болж, 1967 оноос НАХЯ-ны Хязгаарын ба ДЦХЭГ-ыг байгуулж, 1979 оноос Хязгаарын ба ДЦУЕГ хэмээн нэрлэгджээ.

1990 онд НАХЯ татан буугдаж, УАБХЕГ байгуулагдан түүний харъяанд Хилийн цэрэг үйл ажиллагаагаа явуулав. 1993 онд "Хилийн тухай хууль" батлагдаж, Хилийн цэргийг удирдах газар байгуулагдав. ХЦУГ нь 1996 он хүртэл Засгийн газрын дэд бүтцийн байгууллага болсон.

Хил хамгаалах байгууллага нь 1996 оноос БХЯ-ны харъяа Засгийн газрын тохируулагч агентлаг, 2000 оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж Засгийн газрын тохируулагч агентлаг-Хилийн цэргийг удирдах газар нэртэйгээр тус тус ажиллаж ирсэн бөгөөд 2002 оноос одоог хүртэл Засгийн газрын тохируулагч агентлаг-Хил хамгаалах ерөнхий газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Орчин үеийн Хил хамгаалах алба анх үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөг хүртэлх бүх он жилүүдэд Монгол Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд **хугацаат цэргийн албан хаагчдыг** үүрэг гүйцэтгүүлсээр ирсэн.

Дэлхий нийтийн цэргийн хэргийн практик үйл ажиллагаанд цэргийн албыг **хугацаат болон хөлсний цэргээр** хаалгадаг, үндсэн 2 чиглэл байдаг ба Монгол Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд 1990 оны эцсээр **гэрээт цэргийн албан хаагчдыг** үүрэг гүйцэтгүүлж эхэлсэн байна.

Сүүлийн жилүүдэд төрөөс цэргийн албыг гэрээгээр хаалгахад анхаарч энэ

төрлийн олон арга хэмжээ авсаны нэг нь Монгол улсын Засгийн Газрын 1998 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам", Улсын Их Хурлын 2006 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн "Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчдийн эрх зүйн байдлын тухай хууль"-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд зэрэг баримт бичгүүд гарсан явдал юм.

ХЦУГ-ын даргын 1999 оны 04 дүгээр сарын 26 өдрийн 335 тоот тушаалаар Хилийн цэрэгт гэрээт цэргийн албанд орохыг хүссэн иргэдээс авах шалгалтын зааврыг батлаж 1999 оны 05 дугаар сарын 01 -ны өдрөөс эхлэн мөрдөж хилийн зарим анги салбарт гэрээт цэргүүдийг алба хаалгаж эхэлсэн түүхтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 194 дүгээр тогтоолоор "Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах" журам батлагдсан нь Хил хамгаалах байгууллагын "Гэрээт хилчин" төслийг хэрэгжүүлж эхлэх үндэс суурь болсон билээ.

Тайван цагт цэргийн албыг гэрээгээр хаалгана гэдэг нь тухайн албаны бэлэн байдлыг дээшлүүлэн тогтворжуулж, бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах ажиллагаа үр дүнтэй чанартай болж албаны ур чадвар дээшлэхээс гадна мэргэжлийн цэргийг бэлтгэх шилдэг арга зам болох юм.

Дэлхийн улс орнууд даяаршлын үйл явцад эрчимтэй шилжиж байгаа нь хүн төрөлхтөний нийтлэг эрх ашгийн нэг томоохон дэвшил боловч, үүнийг дагасан сөрөг үр дагавар ихээр үүсэн бий болсоор байна. Дэлхийн даяаршлыг дагаад зарим улс орнууд нэгдмэл холбоо үүсгэн улсын хилээр хялбарчилсан журмаар өөр хоорондоо зорчих, тэр зарчмаар бусад оронтой гэрээ хэлэлцээр хийн, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч, эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Хэдийгээр энэ асуудалд зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг улсын хилээр шуурхай нэвтрүүлэх гол зарчмыг баримталж байгаа боловч, нөгөө талаараа хилийн аюулгүй байдал алдагдахад хүргэж, цаашлаад олон улсын шинжтэй үндэстэн дамнасан гэмт үйлдлүүдийг даамжруулах шалтгаан болж байна.

Аюулгүй байдлын уламжлалт ойлголт хүрээгээ тэлж терроризм, халдварт өвчний тархалт, экологийн сүйрэл, байгалийн гамшиг болон зэвсэг, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хууль бусаар хилээр нэвтрүүлэх гэх мэт үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг өсөн нэмэгдэх магадлалтай байгаа энэ цаг үед Хил хамгаалах байгууллагын болон алба хаагчдын үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж байна.

Дээрх гэмт хэрэг, хууль бус үйлдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн үед таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах талаарх Хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг бодит цагийн байдал нь шаардаж байна.

Хууль зүйн салбарын эрх зүйн нэгдсэн бодлого, Хил хамгаалах байгууллагын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд "ХХЕГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын

төслийг боловсруулсан ба Хил хамгаалах байгуулага нь Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, Хил хамгаалах албыг бие даасан, мэргэжлийн чиг хандлагатай болгон шинэчлэх зорилгоор "Дархан хил хөтөлбөр", "Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр", "Гэрээт хилчин төсөл"-үүдийг хэрэгжүүлж байгаа билээ.

Хил хамгаалах байгууллагыг мэргэжлийн чиг хандлагатай болгоход чиглэгдсэн ***"Гэрээт хилчин төсөл"***-ийн хүрээнд Улсын хилийг дайчилгаагаар ирсэн хугацаат цэргийн албан хаагчдаар хамгаалуулдаг тогтолцоог өөрчилж, Улсын хилийг хамгаалах үүргийг "мэргэшсэн гэрээт хилчин"-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжиж байна.

"Гэрээт хилчин"-ий талаар авч үзэхийн тулд юуны өмнө "Гэрээт хилчин" гэсэн нэр томъёоноос эхлэх нь зүйтэй байх. Хил хамгаалах байгууллагад гэрээгээр алба хаахаар гэрээ байгуулсан иргэнийг "Гэрээт хилчин" гэдэг бөгөөд Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 194 дүгээр тогтоолыг удирдлага болгон Хил хамгаалах байгууллагад харуулын дарга, холбоочин, хөгжимчин, жолооч, тамирчин, мэргэн буудагч, нохой хөтлөгч, сантехникийн засварчин, малчин, гэрээт цэргийн албан тушаалд иргэдийг сайн дурын үндсэн дээр гэрээгээр алба хаалгаж байгаа юм.

"Төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХЕГ-ын даргын 2007 оны "Журам, заавар батлах тухай" А/66 тоот тушаалаар "Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг зохион байгуулах журам", "Гэрээт хилчдийн мөнгөн хангалтын заавар"-ыг баталж, туршилтын журмаар хилийн 0129 дүгээр ангийн "Үзүүр ус", 0243 дугаар ангийн "Хутаг-Өндөр"-ийн заставуудад "Гэрээт хилчин"-ий албыг хэрэгжүүлж эхэлсэн ба "Гэрээт хилчин" төслийн хүрээнд 2007 онд 2 застав, 2008 онд 17 застав, 2009 онд 14 застав, 2010 онд 9 застав, 2011 он 9 застав, 2012 онд 1 тусгай салбар /0303/, 2013 онд 2 застав, 2014 онд 2 заставыг тус тус гэрээт хилчний албанд бүрэн шилжүүлсэн. **"Гэрээт хилчин"-ий алба хаасан ГЦАХ-даас офицерийн бүрэлдэхүүнд 3, ахлагчийн бүрэлдэхүүнд 398 ГЦАХ улиран ажиллаж байгаа ба ОХУ-д 27, ХСИС-д 70 орчим ГЦАХ суралцаж байна.**

"Гэрээт хилчин"-ий албыг зохион байгуулах явцад гарч буй эерэг, сөрөг талуудад дүгнэлт хийж үзэхэд харуулын дарга, жолоочийн албан тушаалд алба хаалгаж буй гэрээт цэргийн албан хаагчдад тавих шалгуур үзүүлэлтийг өндөрсгөх шаардлагатай байна.

Хил хамгаалах байгууллагын гүйцэтгэх үүргийн онцлог, албаны ачаалал, бие бүрэлдэхүүний чадвар, чадамжийн түвшин, сүүлийн үед гарч буй хилийн зөрчлийн шинж чанар, цаашдын чиг хандлага зэрэг нь "Гэрээт хилчин"-ий албыг менежментийн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр удирдан зохион байгуулж, "Гэрээт хилчид"-ийг чанартай сургаж бэлтгэх, орон тоог бүрдүүлэх, нөхөн хангалтыг зохион байгуулах зэрэг асуудлуудыг зүй ёсоор шаардаж байна.

СУРГАЛТЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ

СУРГАЛТЫГ ИНТЕРАКТИВ БОЛОН ИДЭВХТЭЙ АРГА ХЭЛБЭРҮҮДИЙГ АШИГЛАН ЯВУУЛАХ АСУУДАЛ.

С.Оюунчимэг. ЭЗОТ-ийн ахлах багш, ахлах дэслэгч

Өнөөгийн нөхцөлд их, дээд сургуулийн сургалтыг шинэчлэх хэрэгцээ, хандлага өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан боловсрол, тэр тусмаа дээд боловсролыг шинэчлэх үйл явцын хүрээнд сургалтын бодлого, багшийн хөгжил, сургалтын стандарт, хөтөлбөр, агуулга, сургалтын орчин, сургалтын заах арга зүй, технологид шинэлэг байдлаар хандах асуудал улам бүр өргөн цар хүрээтэй хэрэгжиж байгааг багш нар мэдэрч ажиллах нь нэн чухал болсоор байна.

Дэлхийн даяарчлалын онцлогоос шалтгаалан сургалтын зорилго, агуулга, арга зүйн хэвшсэн сэтгэлгээ ч өөрчлөгдөж байна. Манай орны их, дээд сургуулиудад суралцаж байгаа оюутнуудын "Сурлагын чанар" өнөөгийн хөгжилд тавигдаж байгаа хэрэгцээг зохих төвшинд хангаж чадахгүй байна гэж судлаач багш нар, эрдэмтэд, олон нийт үзсэн хэвээр байна. Энэ байдал нь их, дээд сургуулийн сургалтанд инноваци хийх үндэслэл болж байна.

Сургалтанд инновац хийх чиглэлийг БШУЯ-аас дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1.Сургалтын бодлогын шинэчлэл

2.Багшийн сэтгэлгээ, ур чадварын шинэчлэл

3.Хичээлийн хэрэглэгдэхүүний шинэчлэл

4.Сургах арга, технологийн шинэчлэл

5.Сурах арга барил, заах арга зүйн шинэчлэл

6. Хичээлийн агуулга, хөтөлбөрийн шинэчлэл

7. Сургалтын материаллаг орчны шинэчлэл гэсэн чиглэлүүд хамаарч байна.

Эдгээрээс үндэслэн багшийн ур чадварын шинэчлэлийн асуудлыг хөндөж улмаар заах арга зүйн идэвхитэй, бүтээлч арга, хэлбэрийг ашиглан оюутнуудынхаа сэтгэлгээг хөгжүүлэхэд багшийн үүрэг, ролийг өөрчлөх асуудлыг гадаад, дотоодын арга туршлагаас судлан олж авсан мэдээллийг багш нартаа хүртээх нь нэн хэрэгцээтэй гэж үзлээ.

Сургалтын үйл ажиллагаанд хийгдэх инновацийг хэрэгжүүлэгч, үр өгөөжийг дээшлүүлэх гол эзэн нь багш юм гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Багш өөрийнхөө сэтгэлгээ, хандлага, мэдлэг боловсрол, хичээл заах арга зүйгээ байнга хөгжүүлж сэлбэж байх нь багшийн "амьдралын" үндсэн гол баталгаа мөн. гэжээ.

Орчин үеийн мэдээллийн нийгэмд мэдлэг, чадвар, чадамж нь боловсролын үйл явц дахь үнэт зүйлсийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж байдаг боловч хэрэгцээт төвшинд хүрэхгүй байсаар байна. Бидний өнөөгийн байдлаар хэрэглэж ирсэн уламжлалт сургалтын арга, хэлбэрүүд нь ихэнх тохиолдолд:

- Тайлбарлан үзүүлэх
- Үйлдлийг алгоритмчилсан аргуудыг ашиглах
- Томъёолох
- Дүрэм, журам, эрх зүйн актыг тайбарлах
- Шинж чанар, теорем, бэлэн өгөдсөн нотолгоо, баримт, баталгаанд үндэслэх зэрэгт тулгуурласан байдаг байна. Өөрөөр хэлбэл сургалтын техник хэрэгслийг ашиглан богино хугацааны дотор амжин асар их мэдээллийг хүргэхийг зорих болсон.

Энэ үйл явц нь оюутнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, эсвэл техникийн сэтгэлгээг хөгжүүлэх гэх зэргээр тэднийг аль болох идэвхитэй аргаар суралцуулах хандлага хоцорсон хэвээр байна.

Сургалтын үйл явц дахь танин мэдэхүйн идэвхитэй байх төвшингөөс хамааран сургалтыг хэд хэдэн хэв маягт хувааж үздэг байна.

1. Идэвхигүй
2. Идэвхитэй
3. Интерактив

Идэвхигүй сургалтын үед багш өөрийгөө мэдлэгийн эх булаг гэж үзэж мэдлэг бүтээх үндсэн гол үүрэг рольтойгоор ажиллаж ирсэн. Харин оюутан сургалтын "объект"-ын үүргийг хариуцдаг. Ийм сургалтын явцад оюутан идэвхигүй буюу агуулгын хүрээнд өгөдсөн материалыг эзэмшиж авах, цээжлэн тогтоох үүрэг хүлээнэ.

Идэвхитэй сургалтын үед оюутан сургалтанд субъектын үүрэг, рольд суралцах бөгөөд багш нартай харилцан санал, бодлоо чөлөөтэй хуваалцаж, харилцан ярилцаж мэдлэг бүтээх үйл явцад идэвхийлэн оролцож, улмаар эрэл хайгуул хийх, бүтээх, асуудал шийдвэрлэх үндсэн үүрэг рольтой ажиллана.

Идэвхитэй сургалтын нэг үндсэн хэв маяг интерактив сургалт юм. \ интер-харилцаа, актив-идэвхитэй үйл ажиллагаа\ гэсэн үгнээс үүдэлтэй бөгөөд суралцагсадын болон багш нарын байнгын идэвхитэй харилцан ажиллах нөхцөлд хэрэгждэг байна. Өөрөөр хэлбэл оюутан багш хоёр нэг ижил эрх зүйн субъект бүхий үүрэг рольтой байна.

Интерактив сургалтын арга нь орчин үеийн мэдээллийн хэрэгсэл, мэдээлийн технологийн орчинтой байнга харилцан хамааралтай байдаг байна. Интерактив хэв маягт багш мэдээлэл болон мэдлэг түгээх булаг байхаасаа илүү хичээлийг зохион байгуулагч, зохицуулан тохируулагч, туслагч, чиглүүлэгч, зөвлөх үүргийг гүйцэтгэнэ.

Тухайн хичээлийн судлах зүйлийн агуулгын хэсэгт болон даалгавар өгөх арга, хэлбэрт өөрчлөлт гарна. Даалгавар гүйцэтгэх зорилго, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх үйлдлийн явцад олж авсан мэдлэг чадвараа батжуулах үйл явц нэгэн зэрэг хийгдэж шинэ зорилго, зорилтуудыг дэвшүүлэх, шинэ агуулгыг судлах процесс нэг ижил төвшинд явагдана гэж үздэг байна.

Эрх зүйн сургалт нь онолын асуудлыг хэрэглэх , тэдгээрийн хоорондын уялдаа харилцааг амьдрал практикт тохиолдсон үйл явдалтай харьцуулан судлах аргаар ойлгоход тулгуурлан явагдах хандлага давамгайлдаг болохоор хууль эрх зүйн актуудыг судлан заах арга зүйг уламжлалт болон идэвхитэй сургалтын аргуудтай хослуулан оновчтой сонгох

нь багш нарын хувьд нэн хэрэгцээтэй байх болно.

Тиймээс нийгмийн ухааны суурьтай хичээлүүдэд сургалтын явцад дараах арга , хэлбэрүүд арай илүү зохимжтой байж болох юм. Үүнд:

- Интерактив лекц \асуудал дэвшүүлэн шийдвэрлүүлэх лекц, урьдчилан төлөвлөгдсөн алдаа бүхий лекц, хоёр багшийн хамтарсан лекц, үзүүлэн таниулах лекц, харилцан ярилцлага хийх лекц г.м.\

- Сургалтын ярилцлагын хэлбэр \оюутнуудыг маргаан мэтгэлцээнд уриалан дуудаж хөтөлж оруулах арга,чиглэсэн тодорхой зорилго бүхий асуултуудыг урьдчилан боловсруулж хариултыг эрэлхийлж шаардлагатай мэдээллийг бие даан олж хайж олох нөхцлийг бүрдүүлэх\

- Бүлгээр ажиллуулах хэлбэр \ хосоор нь бүлэглэх, эсвэл тусдаа жижиг бүлгүүдэд хуваах, ганцааарчилсан байдлаар хуваарилах замаар тодорхой бус асуудлыг шийдвэрлэхэд оюутнуудыг хамтран ажиллуулах, тодорхой бус үүрэг даалгаварыг судлуулан асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх аргуудыг хайж олох, олон хувилбаруудыг сонгон авч үзэх, стандарт бус \нэг хэв загварын бус\ нөхцлийг үүсгэх, магадлалтай байх олон талт хувилбаруудаас зөв оновчтой хариултыг олох, ямар нэг хязгаарлалтгүйгээр шийдвэрлэх аргуудын хувилбарыг хайж тогтоох г.м.\

- Дүрд тоглуулах дидактик аргачлал \өмнө нь судалсан материалуудыг системчлэх, бататгах, дахин давтах, оюутнуудыг хяналтын ажилд болон шалгалтанд бэлтгүүлэх, сургалтынхаа явцын үр дүнг үнэлэх, оюутнуудад мэдлэг, чадвар эзэмшүүлэх боломжийг багшид бүрдүүлж өгөхөд оршино.\

- Хэлэлцүүлэг \ ямар нэг асуудалд тулгуурлан үзэл бодол, хэлцэл, мэдлэг, санаа бодлоо харилцан солилцох маягаар мэтгэлцүүлэхэд чиглэгдэнэ.\

- Оюуны буюу сэтгэлгээний дайралт хийх арга. \ ямар нэг асуудлыг шийдвэрлэх, олон хувилбаруудыг дэвшүүлэн сөргөлдүүлж тавих байдлаар оролцогчдыг идэвхитэй хэлэцүүлэгт татан оруулах\

- Кейс судалгаа, дасгал бодлогын арга \ үйлдвэрлэлийн болон практик үйл ажиллагааны тодорхой нөхцөл байдпыг авч үзэх, нөхцөлдсөн цагийн байдлын үед үүрэг гүйцэтгүүлэх, тусгайлсан видео бичлэгийг сонгон хэлэлцэх, түүхэн үйл явдлаас сэдэвлэсэн баримтад тулгуурласан хэлэцүүлэг явуулж хариуг онож тогтоох , алдааг хайх, нотлох, үндэслэх, өөрийнхөө хувилбарт аргуудыг бичиж үзүүлэх г.м.\

Иймхүү идэвхитэй ба интерактив сургалтын арга, хэлбэрүүдийг сонгож хэрэглэх үйл явц нь юуны өмнө оролцогчдын чанарын төвшин, ур чадвар, идэвхи санаачлага, мэргэжлийн онцлог, сургалтын материалын агуулга зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг байна.

Энэхүү нийтлэлд өгүүлсэн асуудлыг уншигч та бүхэн урьд өмнө нь судласан байж болох авч цаашид өөрсдийн сурган заах арга зүйгээ хөгжүүлэхдээ тусган оруулж сургалтын үйл явцыг идэвхижүүлэхдээ ашиглана гэдэгт найдаж байна.

СЭТГЭХҮЙГЭЭ ӨӨРЧЛӨН АСУУДАЛД ХАНДАХ НЬ

В.Пүрэвбаасан. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Хүн төрөлхтөн үүсэж, байгаль дэлхийн хүчин зүйлийн өмнө хүчин мөхөсдөж, улмаар хамтран амьдарч, нийтийн хүчээр өөрсдийн таатай амьдрах орчин аюулгүй байдлаа хангахаас өөр гарцгүй болжээ.

Иймээс ч гэр бүл, овог аймаг улмаар төр бий болж бие биенээ удирдах, удирдуулах, удирдагчдыг хүлээн зөвшөөрөх хандлага бий болж, энэ нь хүлээн зөвшөөрөгдөж, өнөө үед удирдахуйн шинжлэх ухаан болтлоо хөгжжээ.

Түүхэн хөгжлийн ямар ч үед хүний сэтгэхүй, сэтгэлийг эзэмдэн, тэднийг өөртөө итгүүлэн манлайлж чадсан хүмүүс л дэлхийн хөгжил, хүн төрөлхтөний нийгмийн өөрчлөлтийг хийн, хөгжил дэвшлийг түргэтгэж байсан. Үүний хамгийн том жишээ бол Дэлхийн суут жанжин Их эзэн Чингис хаан билээ. Тэрээр "Биеийг эзэмдвээс нэгийг ялъю, сэтгэлийг нь эзэмдвээс мянгыг ялъю. Сэтгэлийг нь эзэмдвээс бие нь хаачих вэ" хэмээн сургасан байдаг.

Аль ч нийгмийн үед эрх мэдэл, манлайллын цаана санхүүгийн эрх чөлөө, сайхан амьдрах хүсэл зорилго байдаг ба энэ нь улс орон, бүлэг, байгууллага, гэр бүл, хувь хүнд ч гэсэн эрхэм зорилго нь болж байдаг. Энэ эрхэм зорилгод хүрэх үзэл бодол, тэмүүлэл, арга нь өөрөө зөв сэтгэлгээтэй байх ёстой. Дээрхээс дүгнэхэд энэ эрхэм зорилго нь үр хүүхэд, гэр бүл, садан төрөл, найз нөхөд, хамт олон, баг бүлэг цаашлаад хүн бүрийг хамаарах ба дээрх зорилго, үзэл бодол, тэмүүлэл, арга зэрэгт зөв сэтгэлгээгээр хандах хандлагатай болгох нь зүйтэй гэж бодож байна.

Үүний тулд хувь хүн би өөрөө үзэл бодол, зорилго, тэмүүлэл, түүнд хүрэх аргаа зөв тодорхойлж, эдгээрийн талаар шинжлэх ухааны мэдлэгтэй байж, үүнийгээ хэрэгжүүлэх оролдлого, дадал, зуршлыг бий болгож, үүнийгээ амьдралын хэвийн үзэгдэл мэт болгож хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл өөрийгөө ялан дийлэх сэтгэлийн хат буюу сэтгэхүй, зөв сэтгэлгээг өөртөө бий болгох ёстой. Ингээд дээрх ойлголтуудыг илэрхийлвэл:

1. Үзэл баримтлал гэдэг нь тухайн хүний энэ орчлонд төрөөд нас биед хүрэн нийгэмших явцад өөрт нь тогтсон ертөнцийг үзэх үзэл буюу амьдралд хандах хандлага гэж бодож байна. Энэ нь мэдээж бүх хүний хувьд сайхан амьдрах, байгууллага бол алсын хараа, Хил хамгаалах байгууллагын хувьд "Улсын хилийн халдашгүй байдал"юм.

2. Зорилго гэж юу вэ? Удирдлагын шинжлэх ухаанд зорилгыг "Байгууллага хамт олон, хувь хүний хүрч болох хамгийн дээд тоо болон чанарын үзүүлэлт" гэж тодорхойлжээ. Минийхээр бол зорилго бий болох үндэс нь үзэл баримтлал юм.

3. Тэгвэл хүн зорилгодоо хүрэхийн тулд түүнийгээ асар ихээр хүсэж, түүндээ тэмүүлдэг байх ёстой юм байна. Тэмүүлэл гэж "Зорилгодоо хүрэхийн тулд зогсолтгүй урагшлах хөдөлгөөн хөшүүрэг" гэж эрдэмтэн

багш нар тодорхойлсон. Энэ нь байнгын хөдөлгөөн ба сурах, сэтгэх, хөгжих ажиллагаа. Орчин үед үүнийг инноваци гэдэг ба товчхондоо шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явц гэж хуулинд тодорхойлсон.

4. Дараагийн асуудал бол хандлага. Орчин үед мэдлэг чадвартайгаас илүүтэйгээр тухайн ажилдаа хандах хандлагыг маш чухалд тооцдог болсон. Учир нь шинжлэх ухаан, мэдээллийн өнөөгийн нийгэмд аливаа байгууллага зорилгоо тодорхойлчихсон, хүрэх үр дүн, арга төлөвлөгөөгөө гаргачихсан байдаг.

Харин ажилдаа үнэнчээр хандах, аливаа зүйлд сэтгэлээсээ хандах хандлагыг тухайн хүнд бий болгоход асар хэцүү, орчин үед мотиваци буюу урамшуулал л гол хөшүүрэг болж байна. Энэ хандлагыг хүүхэд байхаас нь эцэг эхчүүд төлөвшүүлэх хэрэгтэй ба монголчууд "хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа", "эрхийг сурахаар бэрхийг сур" хэмээн өөрийгөө ялах, аливаад зөв хандах хандлагыг хөгжүүлж ирсэн тул эцэг эх бүр энэ асуудалд онцгой анхаарах хэрэгтэй.

5. Тав дах гол ойлголт бол зорилгодоо хүрэх арга юм. Монголчууд арга, билэг хосолж амьдрал урагшилна гэж гайхамшигтайгаар хэлсэн байдаг. Бидний өвөг дээдсийн хэлсэн зүйр үг, сургаалиудын үг бүрийг нь сэтгэн тайлбарлавал нэг үгийн цаана мянган утга буй за... Орчин үед удирдахуйн ухаанд хүнийг удирдах аргыг "**үүрэг**" гэсэн ойлголтоор илэрхийлсэн байдаг. Үүнд:

- Төлөвлөх
- Зохион байгуулах
- Манлайлах

Хяналт юм. Ер нь ямар ч ажил их бага гэлтгүй өөрийн гэсэн амьдралаар нотлогдсон аргуудтай байдаг ба тэр нь шинжлэх ухаан, технологийн хөгжлөө дагаад улам боловсронгуй болж байдаг.

6. Дараагийн ойлголт бол Эрэг сэтгэлгээтэй байх. Энэ ойлголтыг би зөв гэсэн үгээр илэрхийлж байна. Хүмүүс бид төрж өсөөд, хүмүүжиж, төлөвшихдөө сайн муу, сайхан муухайг хараад, ойлгоод, сонсоод ялгах төрөлхийн чадвартай байдаг. Эндээс хүмүүс бид зөв зүйл, сайн шинж чанараа хэвшүүлж, амьдралыг сайн сайхнаар харах нь ердөө л эрэг сэтгэлгээ.

7. Дээрх зургаан ойлголтыг нэгтгэн хэрэгжүүлэх буюу амьдралын дадал зуршил болгох. Амьдралын зуршил болгох үндэс нь оролдлого юм. Оролдлогыг 21 удаа давтахад тэр нь зуршил, зуршлыг 21 дахин давтахад тэр нь дадал болдог гэж Гобигийн "Бүтээлч хүний 7 зарчим" номонд бичсэн байдаг. Сэтгэлгээ бол биеийн хаан учир дээрх 6 ойлголтыг ойлгон амьдралын зуршил болгож сэтгэлгээндээ өөрчлөлт хийх зүйтэй.

Миний бие сэтгэлгээгээ өөрчлөх сэдвийн хүрээнд энэхүү "Сэтгэлгээгээ өөрчлөх 7 зарчим"-ыг гаргаж байна.

Иймд эцэг эх, анд найзууд минь дээрх 7 зарчимаар өөрийгөө хөгжүүлж, өөрийн сэтгэлгээгээ өөрчилж, улмаар бусдыг манлайлан тэдний сэтгэлгээг өөрчлөх хэрэгтэй болов уу гэж дүгнэж байна. Эцэст нь энэ дээрх 7 зарчим, арга нь ямарч ажил, асуудлыг шийдэхэд үндсийн үндэс болно гэдэг нь эргэлзээгүй бөгөөд улс эх орон, өрх гэр, хүн бүр хөгжиж, зөв амьдрахын үндэс юм.

ТУСГАЙ ТОМИЛГООТ БҮЛГИЙН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Н.Баяржаргал. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын хилийн тухай хуулийг удирдлага болгон Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрийг батлан гаргасан билээ. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Хил хамгаалах байгууллагын мэргэжлийн чиг хандлагыг төлөвшүүлэх, тусгай томилгоот салбарын бүтэц, зохион байгуулалт, сургалт зэвсэглэл, техникийн хангалтыг сайжруулна гэж тусгасан байдаг.

Энэхүү стратегийн зорилтийг хэрэгжүүлэхийн тулд хил хамгаалах байгууллага хилийн цэргийн тусгай хүчнийг үүсгэн байгуулж, чиг үүргийг тодорхойлж, хилийн отрядуудыг тусгай томилгоот бүлэгтэй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлээд хэдэн жил болж байгаа билээ.

Тусгай томилгоот бүлэг гэдэг үгийг монгол үг зүйн үүднээс судлаж үзэхэд Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь"-д тусгай гэдэг үгийг "тусдаа, өөр, ангид" гэсэн утгаар тайлбарласан бол "томилох" гэдэг үгийг ажил үүрэг гүйцэтгүүлэхээр хүнийг нэр зааж гаргах, тохоох, тохоон томилох гэсэн утгаар, хилийн нэр томьёоны тайлбар тольд "бүлэг" гэдэг үгийг "хязгаарлагдмал район, цаг хугацаанд байлдааны болон тусгай үүргийг бие даан биелүүлэх зориулалт бүхий хүч хэрэгсэл гэж тус тус тайлбарласныг үзэхэд "Тусгай томилгоот бүлэг" гэдэг нь тусгайлан оноож өгсөн үүргийг бие даан гүйцэтгэхээр тохоон томилогдсон бүлэг гэж ойлгож болохоор байна.

Байлдааны дүрэмд:

Жижиг бүлэг: "Хязгаарлагдмал район, цаг хугацаанд байлдааны болон тусгай үүргийг бие даан биелүүлэх зориулалттай хүч хэрэгсэл юм"[2] гэж тодорхойлсон байна. Жижиг бүлэг гэдэг ойлголтыг өнгөрсөн дайнуудын түүх, жижиг бүлгээр гүйцэтгэх үүргээс үндэслэн тодорхойлохоор "дайсны гүнд тусгай үүрэг гүйцэтгэх "тусгай томилгоот бүлэг", "мотобуудлагын салбаруудаас гарч дайсны арталд хорлон сүйтгэх, түйвээх болон бусад үүрэг гүйцэтгэх тактикийн жижиг бүлэг", "нэгтгэл, ангиудаас тусгай чиглэлд гарч бие даан байлдааны үүрэг гүйцэтгэж байгаа тактикийн жижиг салбарууд", "дотоодын хууль бус бүлгүүдтэй тэмцэх бүлэг, террорист ажиллагаатай тэмцэх тусгай бүлэг", "энхийг сахиулах хүчний бүлэг", "партизаны бүлэг" гэх мэт олон хэлбэрийн, өөр өөр үүрэг зориулалттай жижиг бүлгүүдэд хуваан авч үздэг. Эдгээрээс ерөнхий цэргийн байлдааны нөхцөлд зэвсэгт хүчний анги, салбаруудаас гарч үүрэг гүйцэтгэх жижиг бүлгүүдэд үндсэн хоёр хэлбэрийн бүлэг байна гэж үздэг. Үүнд:

1.Тусгай томилгоот бүлэг /тусгай үүрэг гүйцэтгэх/

[2] Байлдааны дүрэм 3/200

2.Тактикийн жижиг бүлэг гэх мэт.

Тусгай томилгоот бүлэг: Дайсны ар талд үүрэг гүйцэтгэх тусгай томилгоот бүлгийн давуу чанар нь байлдаанаа эхлэх хүртэл эсрэг талдаа илрэхгүй байх чадвараар тодорхойлогддог. Давуу хүчийг гэнэдүүлэн устгах, өндөр цэцтэй зэвсэг хэрэглэсэн орчин үеийн дайнд дайсны цохилтод өртөхгүй байх чанар нь жижиг бүлгийн үл илрэх чадвараар хэмжигдэж байна. Дайсанд илрэгдэхгүй байх энэ шинж чанар нь жижиг бүлгийн бүрэлдэхүүний тоо хэмжээний хязгаар болдог. Бүлэг хэдий хэмжээгээр томорно түүний илрэгдэх чанар тэр хэмжээгээр нэмэгдэж түүний давуу чанар алдагддаг байна.

Тусгай хэрэгсэл хэрэглэх бүлэг: Улсын хил дээрх нийгэм, улс төрийн будлиан самууныг дарах, улсын хилийн ойролцоох будлиан, самуунд оролцогч талуудын хууль бус ажиллагааг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцож буй, тусгай хэрэгсэл хэрэглэхээр байгуулсан хилийн отряд /анги/-ын салбар[3] гэж тодорхойлсон байдаг.

Түүх сөхвөл тусгай томилгоот бүлгүүдийг Вьетнамын дайн, Афганистаны дайн (1979-1989), Иракийн дайн, Югославын дайн, Чеченийн 1, 2-р дайн, Карабахын зэвсэгт мөргөлдөөн, Гүрж-Абхазын зэвсэгт мөргөлдөөн зэрэг томоохон тулаанд ашиглаж байжээ.

Сүүлийн үед улс орнууд өөрсдийн эсрэг аюул заналхийлэл халдлага явуулж буй зэвсэгт бүлэглэл, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн эсрэг тэмцэх маш өндөр сахилга бат, бэлтгэл сургуулилттай тулааны урлагийг өндөр хэмжээнд эзэмшсэн тусгай хүчнийг ашиглаж тэмцэх болсон билээ.

Хил хамгаалах байгууллагын хувьд ХХЕГ-ын даргын 20... оны Улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулж явуулах тухай..... тоот удирдамжид "...Цагийн байдлын үед ажиллахаар бэлтгэгдсэн тусгай томилгоот бүлгийг хилийн заставт 5 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэйгээр, отрядод 2 чиглэлд нэгэн зэрэг ажиллах тус бүр 10-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй зэвсэг, найдвартай холбоо, уналга, тусгай хэрэгсэлтэйгээр бэлэн болгох арга хэмжээ авах..." гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд хилийн отрядуудад орон тооны бус тусгай томилгоот бүлгийг байгуулсан.

Мөн ХХЕГ-ын даргын тушаалаар 2010 онд хилийн .... дугаар отрядод тусгай томилгоот бүлгийн үүрэг гүйцэтгэх журмыг батлуулан хэрэгжүүлж байгаа билээ.

Дээрх тушаал, шийдвэрээс өөр хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн эрх зүйн орчныг тодорхойлсон дүрэм, журам гараагүй байна.

Хилийн отрядуудын тусгай томилгоот бүлгийн үйл ажиллагааны талаар ХСИС-ын төрөл мэргэжлийн сургалтад хамрагдаж буй офицер, ахлагч нарын бүрэлдэхүүнээс авсан судалгааны дүнг нэгтгэж үзэхэд хилийн отрядуудад тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнийг томилохдоо захирагчийн тушаалаар байнгын томилдог, эсвэл албаны бэлэн байдлын томилгооны хэлбэрээр хэд хоногийн хугацаатай томилдог, бүлгийг хэн удирдах нь тодорхой бус /захирагч, штабын дарга, хилийн албаны дарга,сургалтын дарга/, бүрэлдэхүүн

[3] Хилийн нэр томьёоны тайлбар толь. –УБ. 2010. 208 х

нь байнгийн бус үе үе өөрчлөгдөж хөгжимчин, слесарь, операторчин гэх мэт албан тушаалтанаас бүрддэг, зэвсэг, техник, хангалтын байдал жигд бус, сургалт дадлага тогтмолжоогүй гэх мэт нэгдсэн бодлого, зохицуулалт хийх хэрэгтэй гэсэн дүн гарч байна.

Иймд хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн удирдлага, үйл ажиллагааг сайжруулах шаардлага урган гарч байна.

Энэ талаар бичихийн өмнө цэргийн байгууллага, цэргийн удирдлага, байгууллага гэсэн тодорхойлолтыг авч үзье.

1. Цэргийн байгууллага: Зэвсэгт хүчин, бусад цэрэг, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүргийг цэргийн аргаар биелүүлдэг байгууллагууд, тэдгээрийн удирдлага.

2. Цэргийн удирдлага: Хилийн анги, салбаруудыг байнгын бэлэн байдалд байлгах, тэднийг алба-байлдааны ажиллагаанд бэлтгэх, тавигдсан үүргийг биелүүлэхэд удирдах дарга /захирагч/, штаб, удирдлагын бусад нэгжүүдийн чиглэл зорилготой ажиллагаа.

3. Байгууллага: Менежментийн онолоор "байгууллага" гэдэг нь эрхэм зорилго, байгууллагын зорилго, зорилтуудаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаагаа ухамсартайгаар зохицуулсан, түүндээ хүрэх чин эрмэлзлэл бүхий бүлэг хүмүүсийн нэгдэл гэж тодорхойлсон байдаг.

Байгууллагад дараах шалгуурууд тавигддаг. Үүнд:

1. Хоёр ба түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй байх;

2. Бүлгийн гишүүд өмнөө тавьсан нийтлэг зорилго, зорилтыг хүлээн зөвшөөрсөн, түүндээ хүрэх хүсэл эрмэлзлэлтэй байх;

3. Нэгдмэл нэг удирдлагатай байх;

4. Тогтмол, тасралтгүй үйл ажиллагаа явуулах зэрэг болно.

Хил хамгаалах байгууллагын хувьд байгууллагын хэлбэрийг хангасан анхан шатны нэгж, салбарууд /хилийн манаа, хилийн харуул, хилийн застав, алба/ үйл ажиллагаа явуулж байгаа билээ.

Дээрх баримтуудад үндэслэн хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн удирдлагыг сайжруулах талаар дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийн шинэчилсэн найруулгад хилийн манааны төрөлд тусгай томилгоот бүлэг гэсэн төрөл нэмж оруулах.

2. Тусгай томилгоот бүлгийн бүтэц, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой болгох

а/ Говь цөлийн бүсийн тусгай томилгоот бүлгийн удирдлага, зохион байгуулалт

б/ Тал хээрийн бүсийн тусгай томилгоот бүлгийн удирдлага, зохион байгуулалт

в/ Уулын бүсийн тусгай томилгоот бүлгийн удирдлага, зохион байгуулалт

г/ Ой тайгын бүсийн тусгай томилгоот бүлгийн удирдлага, зохион байгуулалт гэж ангилж болох юм.

Хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн бүтэц нь өнөөгийн байдлаар орон тооны бус шаардлагатай үеүүдэд томилогддог байнгийн бус бүлэг байгаа нь учир дутагдалтай гэж үзэж дараах хувилбарыг дэвшүүлж байна.

а/ Хил хамгаалах байгууллагын

хилийн отрядуудын тусгай томилгоот бүлгийг бүсийн онцлогт тохируулан отрядын штабын орон тооны нэгж байхаар байгуулах.

Бүлгийн дарга: нь тусгай хүчний сургалтад хамрагдсан сэтгэл зүй, бие бялдарын шалгуур түвшинг хангасан штабын офицер байх

Бүрэлдэхүүнд: нь төрөл мэргэжлийн тусгай мэргэшсэн алба хаагчид байх. Үүнд:

- Мэргэн буудагч
- Жолооч /автомашин, усан завь, мотоцикол/
- Холбоочин
- Тагнуулчин
- Эмч
- Гранатмётчин
- Пулемётчин
- Хими, радиацын мэргэжилтэн
- Сапёрчин
- Нохой хөтлөгч
- Шүхэрчин
- Уулчин
- Онцгой байдлын мэргэжилтэн гэх мэт мэргэжлийн албан хаагчдаар бүрдэж тэд шаардлагатай арга хэмжээг нэн тэргүүн хэрэгжүүлж бүлгийн бүрэлдэхүүнийг сургаж дадлагжуулах юм.

б/ Тусгай томилгоот бүлэг дараах үндсэн үүрэг гүйцэтгэх талаар журамлаж болох юм. Үүнд:

-Хилийн застав, салбаруудад хүч нэмэгдүүлэх, хилийн тусгайлсан хэсгийг хариуцан хамгаалах;

-Хилийн хэсэгт хил зөрчигчийг илрүүлэх, түүнийг эрэх, саатуулах ажиллагаа явуулах;

-Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх;

-Улсын хил дээр үүссэн зэвсэгт халдлага, өдөөн хатгалга, хил дамнасан гэмт хэргийн бүлгийн үйл ажиллагааг таслан зогсоох;

-Хилийн хэсэгт болсон террорист халдлагийг таслан зогсоох;

-Гамшигт нөхцөл байдал үүссэн үед тэргүүн ээлжинд гамшигийн аюулыг бууруулах арга хэмжээг авч, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх;

-Хилийн хэсэгт гарсан эрүүгийн ноцтой хэрэг зөрчлийн үед хэргийн газрыг хамгаалалтад авах;

-Хилийн бүс орчимд эрэн сурвалжлагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагаанд оролцох;

-Тэсэрч дэлбэрэх бодис, хар тамхи илэрсэн үед хамгаалалтад авч тусгай мэргэжилтэн ирэхэд хүлээлгэн өгөх;

-Хилийн хэсэгт ажиллаж буй төр, засгийн газрын албан тушаалтны аюулгүй байдлыг хангах гэх мэт.

в/ Тусгай томилгоот бүлгийг удирдах:

Хилийн отрядын тусгай томилгоот бүлгийг удирдах гэдэг нь бүлгийн даргаас албаны бэлэн байдлыг хангах, отрядын даргаас өгсөн тусгай ажиллагааг зохион байгуулах, тусгай ажиллагааны явцыг хөтлөн жолоодох талаар явуулж байгаа харилцан уялдаа бүхий идэвхтэй үйл ажиллагааны цогцоор ойлгож болох юм.

Тусгай томилгоот бүлгийн дарга бүлгээ удирдахдаа захирагдсан бие бүрэлдэхүүнийхээ санал, сэтгэгдлийг харгалзан үзэж, хамтын удирдлагын зарчим дээр тулгуурлах нь зүйтэй.

Тусгай томилгоот бүлгийг тусгай ажиллагаанд удирдах үйл ажиллагааны зөрилго нь тавигдсан

үүргийг эрсдэлгүйгээр амжилттай биелүүлэхэд бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг ханган, сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулж, зэвсэг, тусгай хэрэгсэл, техникийн хүчин чадлыг хамгийн үр ашигтай бүрэн ашиглах, харилцан уялдаа холбоог хангах, тусгай ажиллагааны бүх төрлийн хангалтыг тасалдалгүй хэрэгжүүлэх, тэрчлэн бүлгийн аюулгүй байдлыг хангах, эсрэг талыг хууран мэхлэх, санаачлагыг гартаа авах нөхцлийг бүрдүүлэхэд оршино гэж үзэж байна.

г/ Тусгай томилгоот бүлгийн үйл ажиллагааг зохион байгуулах:

Тусгай томилгоот бүлэг тусгай ажиллагааг амжилтанд хүргэх нэг чухал нөхцөл нь үйл ажиллагааг цаг алдалгүй зөв зохион байгуулах явдал юм.

Удирдлагаас өгсөн тусгай үүргийг бүлгийн дарга зохион байгуулах бөгөөд тэр нь захирагдагсдынхаа санаа бодлыг сонсож, өөрийн шийдвэртээ харгалзаж үзэх ёстой.

Тусгай томилгоот бүлгийн дарга бүлгийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа өгөгдсөн үүрэг, цагийн байдлын онцлогоос шалтгаалан дараах арга хэмжээг хэрэгжүүлж болох юм.

- авсан үүргээ судлах;
- нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлж, холбогдох албан тушаалтанд заавар өгөх;
- цагийн байдлыг тогтоох;
- шийдвэрээ гаргах;
- бүлгийн бүрэлдэхүүнд үүрэг өгөх;
- бололцоотой үед туршуул явуулж тусгай үүргийг шийдвэр, газар орон дээр тодотгож, харилцан ажиллагааг зохион байгуулах;
- тусгай ажиллагааны хангалт, удирдлагыг зохион байгуулах гэх мэт арга хэмжээ байж болох юм.

Энэ нийтлэлдээ тусгай томилгоот бүлгийн удирдлагыг боловсронгуй болгох саналаа товчхон байдлаар дурьдаад цаашид дэлгэрүүлэн судлах асуудлууд байгаа болно. Үүнд:

- Тухайн бүлгийн аюулгүй байдал, бэлэн байдлыг хангах;
- Сургалт бэлтгэлийг зохион байгуулах;
- Сэтгэл зүйн бэлтгэлийг хангах;
- Хангалтыг зохион байгуулах;
- Техникийг бэлтгэх зэрэг асуудлуудыг задлан тодорхойлох нь зүйтэй юм гэж дүгнэж байна.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАНД ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ЗЭВСЭГГҮЙГЭЭР ТУЛАЛДАХ, МЭХ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГА

Б.Амартүвшин. ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн ахлах багш, хошууч
С.Нямжав. ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн ахлах багш, цагдаагийн хошууч

ТҮЛХҮҮР ҮГ: Улсын хил, Халдашгүй дархан байдал, Хилийн дэглэм, Галт зэвсэг, Аминд үл хүрэх зэвсэг, Тусгай техник, хэрэгсэл, Зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх

Монгол улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, улсын хилийн дэглэмийг сахиулах үндсэн чиг үүргийг хангуулахын тулд хил хамгаалах байгууллагад хуулийн хүрээнд үйл ажиллагааных нь чиг үүрэгтэй уялдуулан тодорхой эрх мэдлийг өгсөн байдаг. Тухайн төр нь ардчилсан ба ардчилсан бус дэглэмтэйгээс үл шалтгаалан хил хамгаалах байгууллагын алба хаагчдад төрөөс олгогдсон аливаа нэгэн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд гадаад орны болон өөрийн орны иргэдийн эрх, эрх чөлөөнд шууд буюу шууд бусаар халдах хууль зүйн хийгээд зүй ёсны шаардлага зайлшгүй гардаг. Энэхүү хуулиар олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд иргэдийн эрх, эрх чөлөөнд халдах хэлбэр үндэслэл журам нь Олон улсын хийгээд үндэсний эрх зүйн нийтлэг болон тусгай зарчмуудад үндэслэгдэж тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулагдаж байдаг.

Гадаадын зарим орнуудын жишиг хандлага, Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, үндэсний эрх зүйн зохицуулалтаас авч үзвэл нийтийн болон төр нийгмийн ашиг сонирхлын үүднээс хил хамгаалах байгууллагын алба хаагчдад хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд гадаадын болон өөрийн орны иргэдийн эрх, эрх чөлөөнд халдах дараах хэлбэрүүд байдаг.

- **Иргэдийн өмчийн халдашгүй дархан байдалд :** /хөдлөх, үл хөдлөх хөрөнгө эзэмших, өмчлөх/
- **Иргэдийн хувийн халдашгүй байдалд:** /орон байр, эрүүл мэндийн болон хувийн нууц /
- **Бие махбодийн халдашгүй байдалд:** /амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, халдашгүй чөлөөтэй байх /

Дээрхээс авч үзвэл галт зэвсэг, тусгай техник, хэрэгсэл, албаны нохой болон зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх тухай асуудал нь Үндсэн хууль, ЭБШХ, Эрүүгийн хууль, Хилийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл журмын хүрээнд зохицуулагдах ёстой бөгөөд тодорхой нөхцөл байдал хязгаарлалтын хүрээнд өөрөөр хэлбэл хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн болон хил орчмын дэглэм сахиулах, хил хамгаалалтад албан үүрэг гүйцэтгэхдээ галт зэвсэг, тусгай техник, хэрэгсэл, албаны нохой, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх эрх олгогддог байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд авч үзвэл хил хамгаалах байгууллага, алба хаагчдаас галт зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэслэл журмыг дараах хүрээнд авч

үзэж болохоор байна.

Эрүүгийн эрх зүйн зохицуулалт:

Эрүүгийн хуулиар тодорхойлон тогтоосон аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, тушаал захирамж биелүүлэх зэрэг гэмт үйлдлийг нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлын үед алба хаагчид галт зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой, мэх хэрэглэх эрх нээлттэй гэж үзэж болно. Тухайлбал:

Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 40,1-д "Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж халдсан этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй[4]" хэмээн тодорхойлсон бол

40,2-д "Хүн бүр албан тушаалын байдал, мэргэжил, хуулиар хүлээлгэсэн үүрэг, албаны бэлтгэлжилтээс хамаарахгүйгээр аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Хамгаалагч нийгэмд аюултай үйлдлээс зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй[5]" гэснээс энэ нь тодорхой харагдаж байна.

Мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41,1-д " гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй[6]"

42 дугаар зүйлийн 1-д "Энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөнд тулгарсан аюулыг зайлуулахын тулд учирч болох байсан хохирлоос бага бөгөөд уг аюулыг тухайн нөхцөл байдалд өөр аргаар зайлуулах боломжгүй байсан бол уг үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй[7]".

44 дүгээр зүйлийн 1-д "Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй, харин хууль бус тушаал, захирамж өгсөн этгээдэд гэм хор учруулсны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэн[8]" гэсэн хэм хэмжээнүүд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх эрүүгийн эрх зүйн зохицуулалт юм.

Хилийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актын зохицуулалт

Монгол улсын хууль тогтоох дээд байгууллагаас 1993 оны 10 дугаар сарын 21 өдөр батлан гаргасан "Хилийн тухай хуулийн" 4 дүгээр бүлгийн 37 зүйлийн /Улсын хил хамгаалахад зэвсэг хэрэглэх/ 1,2,3-д Хилийн цэргийн тусгай анги, салбар, хилийн манаа нь урьдчилан анхааруулахгүйгээр, урьдчилан анхааруулах дохио өгсний дараа болон зэрлэг амьтнаас өөрийгөө

[4] ЭБШХ 2002. 40.1 хэсэг
[5] ЭБШХ 2002. 40.2 хэсэг
[6] ЭБШХ 2002. 41.1 хэсэг
[7] ЭБШХ 2002. 42.1 хэсэг
[8] ЭБШХ 2002. 44.1 хэсэг

болон бусдыг хамгаалж галт зэвсэг хэрэглэж болох үндэслэл тохиолдлуудыг нэг бүрчлэн хуульчлан тогтоож өгчээ. Жишээлбэл: Хуулийн 37 дугаар зүйлийн 37,1-д "Хилийн цэргийн тусгай анги, салбар, хилийн манаа урьдчилан анхааруулахгүйгээр дараах тохиолдолд байлдааны зэвсэг техник хэрэглэх тохиолдол үндэслэлүүдийг

1. Монгол улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт халдлагыг няцаах

2. Улсын хил дээр үүссэн зэвсэгт өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоох

3. Хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг таслан зогсоох[9]" гэж заасан байдгийг бид мэдэх билээ.

Тэгвэл өнөөдөр Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод "Хилийн асуудлаар үүссэн зөрчил будлианыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх[10], улсын хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх[11] нь нэн тэргүүний асуудал" хэмээн заажээ. Зэвсэг, тусгай хэрэгсэл зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх нь хилийн зөрчил, хилийн дэглэм зөрчигчдийн үйлдлээс урьдчилан сэргийлэх тэдгээрийг таслан зогсоохтой шууд холбоотой бөгөөд өөр арга хэрэгслээр түүнийг таслан зогсоох боломжгүй үед хийгддэг хүний эрх, эрх чөлөөг ихээр хөнддөг онцгой арга хэмжээ боловч төрийн энэ бодлогыг хэрэгжүүлэхэд Хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас тусгай техник, хэрэгсэл, албаны нохой, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх эрх зүйн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт / тусгай техник, хэрэгсэл, албаны нохой, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх заавар, журам/-ыг хийх цаг болжээ. Өнөөдрийн хилийн тухай хуулинд /37,5-д / "Улсын хилийн хамгаалалтад албан үүрэг гүйцэтгэж байгаа хилчин нь тусгай техник, хэрэгсэл, албаны нохой, бие хамгаалах аргыг хэрэглэж болно[12]" гэж зааснаас өөр заалт алга.

Тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх нь галт зэвсэг, байлдааны зэвсэг хэрэглэхгүйгээр аливаа халдлага, довтолгоон үймээнийг таслан зогсоох боломжийг олгодог, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдлэх үзэл баримтлалд нийцсэн бусдын аминд үл хүрэх зорилгоор хэрэглэдэг хүмүүнлэг арга хэмжээ юм. Аминд үл хүрэх зэвсэг гэдэг нь хүний бие эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах хохирол, гэмтлийг багасгах замаар бие хүн болон материал хэрэгслийг чадамжгүй болгох зорилгоор бүтээгдсэн зэвсгийн цогцолбор систем юм. Зөв хуулийн дагуу заавар журмыг баримтлан хэргэлснээр амь насаа алдах, бэртэл гэмтлийг бууруулах ба сэтгэл зүйн хувьд тухайн байг устгаж буй хэрэг юм.

Аминд үл хүрэх зэвсгийг цэргийн ажиллагаандэсрэг талын үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, үхэлд хүргэх хүчийг хэрэглэх зохистой шийдвэр биш үед, бие бүрэлдэхүүнийг хамгаалах, техник тоног төхөөрөмжийг түр ажиллагаагүй болгох гэсэн үндсэн зорилгоор хэрэглэдэг байна. Тэгвэл төрийн тусгай албадын алба хаагчдын хэрэглэж байгаа зэвсэг, тусгай хэрэгсэл,

[9] МУХТХ 1993 4 бүлэг 37 зүйл

[10] Төрөөс хилийн талаар баримтлах бодлого 2002. Нэгдүгээр бүлэг 4-р зүйл

[11] Төрөөс хилийн талаар баримтлах бодлого 2002. Хоёрдугаар бүлэг 1.11

[12] МУХТХ 1993. 37.5 хэсэг

зэвсэггүйгээр тулалдах мэхийг ингэж тодорхойлжээ.

- Бусдын хөдөлгөөнийг хорих, өвтгөх зэргээр болзошгүй аюулаас сэргийлэх, эсэргүүцэл довтолгооныг зогсоох зорилготой
- Нөхцөл байдлыг хяналтандаа авах зорилгоор хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой амь насанд аюулгүй зэвсэг
- Тээврийн хэрэгслийн дугуй болон гинжний завсарт шигдэж эргэлтийг сааруулах зориулалттай төхөөрөмж
- Учирч болох нөхцөл байдал нэг бүрийн урьдаас тааварлаж, тодорхойлох боломжгүй тухайн нөхцөл байдалд аль болох үндэслэлтэй шийдвэр гаргаж бие хамгаалах урлагийн мэхээр тулалдах, довтлох, хамгаалах, няцаах, баривчлах, хүлэх, боох, тонгорох, өчих гэх мэтээр биеийн хүчээр гүйцэтгэх үйлдэл

Орчин үед техник, технологийн хөгжил өндөр хурдацтайгаар хөгжиж байгаатай холбоотой шинээр олон төрлийн тусгай хэрэгслүүд гарч ирж, цагдаагийн байгууллага болоод цэргийн салбарт хэрэглэгдэж, энэхүү хэрэгслийг хэрэглэх эрх зүйн актуудыг боловсронгуй болгох талаар ихээхэн хүч чармайлт гарган ажиллаж байна.

Гадаадын улс орнуудад хууль сахиулах байгууллагаас гадна батлан хамгаалах салбарт хүртэл аминд үл хүрэх зэвсэг нэртэйгээр тусгай хэрэгслийг нилээд өргөн хэрэглэх болсон байна. Батлан хамгаалах салбарт эсрэг талын дайтагчийг тодорхой хугацааны туршид байлдах чадваргүй болгох зорилгоор хэрэглэдэг бөгөөд амь насанд халгүй гэж үздэг байна. Мөн Монгол улсын Зэвсэг хүчний жанжин штабаас "Аминд үл хүрэх зэвсэг" нэртэй сургалтуудыг өнгөрөгч жилүүдэд зохион байгуулан явуулан эдгээр сургалтуудад хил хамгаалах болон цагдаагийн байгууллагууд оролцож байсан ба сургалтууд нь үр дүнтэй болж байсныг бид мэднэ. Эдгээр байдлууд нь сүүлийн жилүүдэд тусгай хэрэгслийг хэрэглэх талаар хууль сахиулах байгууллагаас гадна Батлан хамгаалах салбар ч гэсэн илүү их анхаарлаа хандуулан судлаж эрх зүйн орчинг нь боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээ явуулж, сургаж дадлагажуулж байгаагийн нэг хэлбэр юм.

Цагдаагийн байгууллагад ч гэсэн эрх зүйн орчинг нь илүү боловсронгуй болгох талаар 2013 онд Цагдаагийн албаны тухай хууль, 2014 онд Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг батлан гаргасан байна.

Эдгээр хуулиудад мэхийг хэрхэн хэрэглэх болон тусгай хэрэгслийг ангилан төрлүүдээд нь ялгаж, хэрэглэх үндэслэл журмыг нэлээд дэлгэрэнгүй тусгаж өгсөн байна. Үүнээс гадна хэрэглэх үндэслэл, анхаарах зүйлүүд болон арга тактикын ажиллагааг Хууль зүйн сайдын 2014 оны 07-р сарын 10-ны өдрийн А/126 тушаалаар баталсан зааварт нэлээд дэлгэрэнгүй тусгаж өгсөн байдаг. Сүүлийн жилүүдэд цагдаагийн алба хаагчдын зүгээс тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэн гэмт хэрэг, зөрчилд холбогдох байдал нь харьцангуй багасжээ. Энэ нь алба хаагчдын зүгээс тухайн хэрэгсэл, биеийн хүч хэрэглэхэд илүү их ойлгомжтой бөгөөд эрх зүйн баталгааг нь хангаж өгсөн журам болжээ гэж үзэж болох юм.

Үүнтэй адилхан төрийн тусгай алба болох болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрийн хуулиндаа /ШШГБТХ-ийн 137 дугаар зүйлийн 9-д "Бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.[13]" гэж зааснаар алба хаагчид нь албан үүрэг гүйцэтгэхдээ дан ганц галт зэвсэг биш тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх эрхээ баталгаажуулсан гэсэн үг юм.

Дээрхээс харахад тусгай техник, хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх зааврыг тухайн байгууллага өөрийн хуулинд заасан зүйл, заалтын үндэслэн хуульчлан боловсруулж Монгол улсын ерөнхий прокурор хянан зөвшөөрсний дараа алба хаагчид албан үүрэг гүйцэтгэхдээ ашиглаж, хэрэглэж болно.

Тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх, албаны нохой ашиглах, тээврийн хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэслэл, журмын тодорхой мэдлэггүй, техник арга барилыг буруу эзэмших нь ямагт сөрөг үр дагаврыг бий болгодог. Үүссэн цагийн байдлыг буруу үнэлж тусгай хэрэгсэл, мэхийг хэрэглэснээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулбал эрүүгийн хариуцлага хүлээх хэмжээнд тулгарч болзошгүй.

Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх нь ашиглаж буй өөрөөр хэлбэл зэвсэглэлд байгаа тусгай хэрэгслийн тактик техникийн өгөгдөхүүн, ашиглалтын зааварчилгаа, аюулгүйн арга хэмжээн дээр үндэслэнэ гэсэн буруу ойлголтоос гарах цаг болжээ. Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх асуудал нь тоглоом биш. Тодорхой мэдлэг, чадвар дадлага шаардсан тодорхой арга барил болно.

Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга барил гэж хилчдээс албан үүрэг гүйцэтгэх явцад гэмт үйлдлийг таслан зогсоох зорилгоор тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх оновчтой шийдэл, цагийн байдалд тохирсон үр дүнтэй үйлдэл, ёс зүйн цогц юм. Арга барилыг эзэмших, өөрийн болгож авах нь тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар, үндэслэл журмыг сайн судалж, ойлгож түүнийг хэрэглэх чадвар дадлага эзэмшихээс ихээхэн шалтгаална. Мөн түүнд тухайн тусгай хэрэгслийн тактик техникийн өгөгдөхүүн, үйлдвэрлэгчээс гаргасан ашиглах зааврын тухай мэдлэг нөлөөлнө гэдгийг мартаж болохгүй.

Тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх арга барилд хилчдийг сургах сургалтыг тодорхой нөхцөл байдалтай уялдуулан тусгай хөтөлбөрөөр сургах дадлагажуулах алба хаагчдыг бэлтгэхэд нэн түрүүнд тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар, журмыг хуульчлан гаргаж мөрдүүлэх явдал болж байна.

Ингэснээр улсын хил хамгаалалтад хилчид тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх онол эрх зүйн, чадвар дадлага арга барилыг чадамгай эзэмшсэнээр хил зөрчигч, хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг зөрчигчийг саатуулахад байлдааны зэвсэг хэрэглэхгүйгээр үүргээ биелүүлэх болон төрийн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг олгоно. Мөн хилчид өөрийгөө гадны довтолгооноос хамгаалах чухал ач холбогдолтой бөгөөд үүгээрээ дан ганц хилчдийн

[13] ШШГБТХ 2002, 137 дугаар зүйлийн 9-д

аюулгүй байдал, сэтгэл зүйн тогтвортой байдлыг биш хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, хилийн дэглэмийг сахиулахад онцгой ач холбогдолтой юм.

Тусгай хэрэгсэл, мэх хэрэглэн нөхцөл байдлыг хяналтандаа авах нь галт зэвсгээр хүний амь нас, эрүүл мэндэд халдахаас хамаагүй хүмүүнлэг зүйл биш гэж үү? Иймээс өнөөдөр амгалан тайван байгаа юм чинь гэсэн бодолтойгоор уг асуудалд тайвширсан байр суурьтай хандаж, нөхцөл байдал хурцадсан үеүүдэд хуучин арга барилаар хандах бодлого барьж болохгүй.

Гэтэл одоогийн хил хамгаалахад тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй хэрэглэх арга тактик тодорхой бус байна.

Иймд дээрх нөхцөл байдал бий болсон үеүүдэд хүний амь нас, эрүүл мэндэд хор хохирол илүү бага учруулдаг энэхүү хэрэгслийг хэрэглэн ажиллах зорилго тавьж, түүнийг зохицуулсан эрх зүйн актуудыг шинээр боловсруулах зайлшгүй хэрэгтэй гэж үзэж байгаа юм .Энэхүү шинэчлэн боловсруулсан эрх зүйн актуудад тусгай хэрэгслийн талаар тайлбарласан тайлбар, тодорхойлолтууд болон арга тактикын ажиллагаа дэлгэрэнгүй тусгаж өгөх шаардлагатай.

ХИЛИЙН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЦЭРГИЙН ХОЛБООГ ӨНДӨР ХУРДНЫ НЭГДМЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНД ТУЛГУУРЛАН ХӨГЖҮҮЛЭХ НЬ

В. Нарантуяа. БХИС-ийн багш, дэд профессор,
(хамтарсан: БХИС-ийн багш ахлах дэслэгч Л.Одмаа, багш О. Энхтуяа)

Түлхүүр үг. Удирдлага, холбоо,мэдээллийн технологи, нийцэл, LTE

Хураангуй. Мэдээлэл, холбооны технологиуд даяаршлагдаж, үйлчилгээнүүд нь зориулалтаараа, хэрэглээгээрээ улам бүр нэгтгэгдэж, бидний мэдэх дараа үеийн сүлжээ, түүний технологиуд нь интернет протокол ашиглан гурвалсан үйлчилгээ (телевиз, утас, интернет)-гээрээ улс орон, албан байгууллага, өрх гэрийн үр ашигтэй хэрэглээ болж, радио давтамжаар танин тогтоогчтой бичил элементүүдийг зэвсэг техник, орон сууц, эд хөрөнгө, тоног хэрэгслүүд, номын сан, дэлгүүр, машины зогсоол, орцны үүдэнд суурилуулан хяналтын тогтоолцоогоо сайжруулж, зайнаас удирдах технологиудаар цөмийн болон ердийн зэвсгийг, цаашилбал гэрийн цахилгаан машинуудаа удирдан ажиллуулж, үүлэн тооцоололын аргаар онц чухал объектуудын хоорондын сүлжээг виртуальчилж, "Сүлжээ төвт цэргийн ажиллагаа"-г явуулах боломжуудыг өргөтгөгдөж байна.

I. Оршил

XXI зууны мэдээллийн технологид гарсан өөрчлөлтүүдээс харахад мэдээлэл холбооны өндөр хөдөлгөөнтэй, их багтаамжтай, алс зайд дамжуулдаг шинж чанаруудыг ойрын зайд, суурин байдлаар, нарийн зурваст ажилладаг холбооны төрөл, хэрэгслүүдээр дэмжиж иж бүрэн, цогц систем, шинэ төрлийн үйлчилгээнүүдийг нэвтрүүлж байна.

Холбоо, мэдээллийн сүлжээний ажиллагааны давуу талууд, онцлог, тэдгээрийн хоорондын нийцэл, уялдаа холбоог тооцоолсон стратегийн болон тактикийн нэгжүүдийн удирдлагын болон цэрэг зэвсгийн системийн автоматжуулалтын цогц хэрэглээ нь цэргийн ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлтэд зарцуулах хугацааг багасгах, ажиллагааны талбаруудыг бүрэн хяналтандаа байлгах, мэдээллийн ажиллагаагаараа сөргөлдөгч талуудад ижил төрлийн ажиллагаа явуулах боломжуудыг олгохгүй байх, цэрэг, зэвсгийн удирдлагын системийг уналтад оруулах, орон зай, цаг хугацааны хамааралгүйгээр цэрэг, иргэний байгууламж, онц чухал дэд бүтцүүдийг зайнаас удирдах чадвартай мэдээллийн зэвсэг, хамгаалалтын хэрэгсэл болгох замаар цус урсахгүйгээр, байлдахгүйгээр өөрийн шийдвэрээ тулган хүлээлгэх, эрхшээлдээ оруулахад ашигладаг "Зөөлөн хүч" болгон хувиргаж байна.

Аюулгүй байдлын асуудлаа бүрэн шийдвэрлэсэн улс орон өнөөгийн нөхцөлд бараг байхгүй бөгөөд батлан хамгаалах салбарын хөгжилд анхаарал тавьж, зэвсэглэл техникээ шинэчлэн,

болзошгүй аюулын эсрэг сөрөн зогсох чадвартай, чадварлаг Зэвсэгт хүчинтэй байхад улс орнууд анхаарах болжээ. Үүний үндсэн дээр дэлхийн томоохон улсууд Батлан хамгаалах салбартаа хөрөнгө мөнгө ихээр төсөвлөх болсон.

II. Батлан Хамгаалах салбарын мэдээлэл, холбооны системийн өнөөгийн байдал

Зэвсэгт хүчний удирдлага, мэдээлэл, холбоо, автоматжуулалт, мэдээллийн аюулгүй байдлын системийн гол зорилго бол тогтоосон цагт, ажиллагааны газар орон дээрээс шаардлагатай бүх төрлийн мэдээллийг хүлээн авах, дамжуулахад оршино.

Гэтэл өнөөдөр Зэвсэгт хүчний удирдлага, холбоо, автоматжуулалт, мэдээллийн сүлжээг байгуулах үүрэгтэй анги салбаруудын зэвсэглэлд байгаа холбооны үндсэн техник хэрэгслүүд нь 1968-1982 онд ОХУ (хуучин нэрээр ЗХУ)-д үйлдвэрлэж, манай зэвсэглэлд 1978 оноос нэвтэрсэн, ашиглалтын явцад өөрийнх нь ажиллах нөөц дуусч байгаагаас гадна 30-40 гаруй жил ашиглагдаж, хадгалсан, мэдээлэл дамжуулах хурд, сувгийн багтаамж нь өнөөгийн мэдээллийн тоо хэмжээ өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагыг хангахгүй болж байгаа, нэн тэргүүний өргөн хэрэгцээний сэлбэг, материалын нөөц дууссан, түүнийг ОХУ-д үйлдвэрлэхээ больсон учраас олдоц хомсдож, үнэ нь эрс нэмэгдсэн хөрөнгө санхүү, материалын бололцоогүйгээс сүүлийн 20 жил их, дунд засвар болон сэргээн сайжруулах техникийн үйлчилгээг бүрэн хэмжээгээр хийгээгүй зэрэг олон төрлийн хүндрэл бэрхшээлүүдээс шалтгаалан, холбооны техник хэрэгслүүдийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадвар муудах хандлагатай байгаа талаар мэргэжлийн судлаач, эрдэмтэд ярьсаар байна.

Радио системийн хамгийн сүүлийн үеийн хэрэгслүүд нь тактикийн шатны радио хэрэгслийн хувьд 64кб/с-ээс доогуур, албаны холбооны сувгаар 2мб/с-ээс доош өгөгдөл дамжуулах харьцангуй бага хурдтай. Хэрэглээ нь уламбүрөсөнэмэгдэжбуймультимедиа ба видео конференц /хурал/-ийн шаардлага нь тактикийн сувгаар 500 кб/с-ээс дээш, албаны сувгаар 40 кб/с-ээс дээш өгөгдөл дамжуулах хурдыг шаардаж байна. Энэ шаардлага нь хязгаарлагдмал хурд бүхий тактикийн радио станцуудын хэрэглээнд хүндрэл учруулах нь тодорхой юм.

III. Батлан Хамгаалах салбарын мэдээлэл, холбооны системийг өндөр хурдны нэгдмэл үйлчилгээнд тулгуурлан хөгжүүлэх шаардлага

Асар хурдацтай хөгжиж буй энэ салбарыг хөгжүүлэх, түүний ололт амжилтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт үр ашигтай нэвтрүүлэхэд нарийвчилсан судалгаа, энэ салбарын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг зөв тодорхойлох явдал чухал үүрэгтэй.

Орчин үеийн байлдааны ажиллагааны цэргийн удирдлагын үндсэн хэрэгсэл нь холбоо, мэдээллийн сүлжээ, автоматжуулалтын техник хэрэгсэл болж байгаа бөгөөд байлдааны ажиллагааны явцад стратеги, оператив, тактикийн аль ч түвшинд байлдааны цагийн байдлын эрс өөрчлөлтийн үед байлдааны үүрэг гүйцэтгэж байгаа цэргийг тасралтгүй удирдах,

цагийн байдлын тухай мэдээллээр хангах, харилцан ажиллах, цагийн байдлын дүнг нэгтгэх, хамгийн оновчтой хувилбаруудыг боловсруулан гаргахад цэргийн холбоо, удирдлагын автоматжуулсан систем шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх хандлагатай байна.

Зэвсэгт хүчний удирдлагын суурь сүлжээ,түүний материаллаг үндэс нь Улсын холбооны нэгдсэн сүлжээ, цэргийн байнгын болон тусгай зориулалтын холбооны сүлжээ болж байгаа бөгөөд тэдгээрийн техник, технологийн шийдэл, ажиллагааны горим, програм хангамж, мэдээлэл дамжуулах хурд, өөр хоорондоо зохицон ажиллах боломжоос зэвсэгт хүчний удирдлагын үр нөлөө ихээхэн шалтгаалах болжээ. Манай улсын цахилгаан холбооны нэгдсэн суурь сүлжээ нь шилэн кабель, аналоги ба тоон технологийн радио релейний шугам, сансарын холбооны шугам, агаарын баганат шугам, холболтын байгууламжаас бүрдэж байна. Улсын холбооны нэгдсэн сүлжээ болон Батлан хамгаалах саслбарын холбооны сүлжээнүүдийн техникийн шийдэл, ажиллах боломж, аналоги тоон холбооны технологи, холбооны нууцлал, цахилгаан хангамж, тэжээлийн систем, радио давтамжын ашиглалт, ажлын горим зэрэг олон үзүүлэлтүүдээр нийцэн ажиллах боломжгүй байгаа нь улс оронд байгалийн гамшиг, осол, гоц халдварт өвчин, террорист ажиллагаа, хүмүүсийг барьцаалах, улсын хил орчимд үүсэх зэвсэгт мөргөлдөөн бүхий байдал үүссэн үед удирдлагыг холбоогоор ханган боломж нь хязгаарлагдмал байгаа нь өнөөгийн тулгамдсан зорилт болж байна. [4]

Хэдийгээр манай улсад мэдээлэл, харилцаа холбооны салбар дэлхийн жишигт хурдацтай хөгжиж байгаа ч Зэвсэгт хүчинд энэ нь төдийлэн шаардлага хангахааргүй, явц удаан байгааг олон шалтаг, шалтгаанаар тайлбарлаж болох ч "хэлж ирдэггүй, хийсч ирдэг" аюул гэнэт тулгарахад тэр бүхнийг зөвтгөх боломжгүй болно. Зүй нь тэр бүх болзошгүй аюул эрсдлийг урьдчилан тооцож, тэр бүхэнд бэлэн байх ёстой.

Иймээс дэлхийн бусад улс орнуудад технологийн дэвшлийг цэргийн хэрэгтээ хэрхэн ашиглаж байгаа талаар сонирхож судлах, ялангуяа мэдээлэл холбооны сүүлийн үеийн техник технологийг батлан хамгаалах салбарт хэрхэн нэвтрүүлж, ашиглаж байгаа туршлага-сургамжийг судалж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

LTE нь өндөр хурдны нэгдмэл үйлчилгээг хангасан технологи бөгөөд дэлхийн хөгжилтэй орнууд цэрэг армийн холбоондоо нэвтрүүлсэн нь ирээдүйд гарч болох болзошгүй аюулын эсрэг сөрөн зогсох чадвартай болж байгаагаагаас гадна LTE нь харилцаа холбооны сүлжээнд ашигладаг хамгийн сүүлийн үеийн технологи бөгөөд батлан хамгаалах, аюулгүй байдалд төгс нийцсэн арилжааны операторуудын сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ хэрэглээ хэв маягийг видео урсгал байдлаар өргөн зурвасыг бий болгож чадсан юм. Ингээд LTE технологийн талаарх мэдээллийг хүргэж байна.

IV. LTE технологи гэж юу вэ?

LTE технологи нь 2004 оны эцсээс албан ёсоор технологи болж хөгжсөн билээ. Судалгааны эхний шатны үндсэн

зорилго нь өгөгдлийг өндөр хурдтайгаар дамжуулж чадах физик түвшний сонголт байсан юм. 2009 оны дундуур LTE-д суурилсан анхны туршилтын системүүд (UMTS, E-UTRA,3GPP) хэрэглээнд гарч эхэлсэн ба 2009 онд анхны арилжааны сүлжээ буй болсон билээ.

Өмнө боловсруулсан 3G-системтэй харьцуулахад LTE-интерфейс нь техникийн үзүүлэлтүүд сайжруулагдсан байлаа. Тухайлбал LTE-д нэвтрүүлгийн зурвасын өргөн нь (2,4-20) МГц-ийн хооронд хэлбэлзэж байсан (илүү хуучин эх үүсвэрүүдэд 1,25-аас) нь нэвтрүүлэлтийн төрөл бүрийн зурваст ажилладаг сүлжээний олон операторуудын хэрэгцээг хангах бололцоог бүрдүүлж чадсан. Ингэхдээ LTE-нь нэгэн зэрэг 5МГц-ийн давтамжаар үүр тус бүрт 200-аас дээш идэвхтэй холболтыг (өөрөөр хэлбэл гар утасны 200 дуудлагыг) нэгэн зэрэг үйлдэх чадвартай байх ёстой гэсэн шаардлагыг хангаж чадсан. Түүнчлэн LTE-нь радио давтамжийн спектрын ашиглалтын үр ашгийг ихээхэн нэмэгдүүлэх ёстой байсан буюу өөрөөр хэлбэл тухайн давтамжаар дамжуулагдаж байгаа өгөгдлийн хэмжээ нэмэгдэнэ гэсэн үг билээ. LTE-нь өгөгдлийг дамжуулахдаа ирж байгаа мэдээллийг 50Мбит/с (хэрэглэгчээс станц руу ирж байгаа), гарч байгааг 100Мбит/с (станциас хэрэглэгч рүү) гэсэн нэн өндөр хурдаар хангаж чадаж байсан юм. Ингэхдээ 350км/цаг хурдтай хөдөлж байгаа харилцагчийн дуудлагыг хангаж байх ёстой байв. Нэг БС-ын хамаарах хүрээ нь ердийн горимд 30км байх ёстой бөгөөд шаардлагатай үед 100км-аас илүү радиуст ажиллах боломжтой байх шаардлага тавигдаж байжээ. Иймээс учраас олон антент MIMO-системийг ашиглах болжээ.

LTE-ийн үзүүлэлтийг дурьдвал:


✓ Олон цэгийн хүртэмжит технологи-OFDMA, SC-FDMA;
✓ Зурвасын өргөн 1.3, 3, 5, 10, 15, 20MHz;
✓ Хэрэглэгдэх модуляцын төрөл нь – QPSK, 16QAM, 64QAM;
✓ Сүлжээний бүтэц бүхэлдээ-ALL-IP;
✓ Яриа явагдах технологи нь-VoIP;
✓ Ярианы кодек-AMR-NB,AMR-WB;
✓ Антенны технологи-MIMO 2 буюу түүнээс дээш тооны антенн;
✓ Хөдөлгөөнт байдлыг дэмжих-120-350км/цаг;
✓ 200 хэрэглэгчийн үүр бүр 5 МГц;
✓ Өгөгдлийн дээд хурд;
➢ Нэвтрүүлэх талын хурд 300 Mbit/sec
➢ Хүлээн авах талын хурд 75 Mbit/sec
✓ Удирдлагын хэсгийн саатал 50-100 ms;
✓ Хэрэглэгчийн хэсгийн саатал нь 5 ms;
✓ UMTS, WCDMA, GSM/EDGE нийцэн ажиллах бүрэн боломжтой.

LTE-ийн давуу талууд:

✓ Өндөр хурд;
✓ Өргөн зурвас;
✓ Сүлжээ хоорондын шилжилт тасралтгүй байх;
✓ Олон хэрэглэгчийг үүсгэх;
✓ Зэрэгцээ болон цуваа холболт үүсгэх;
✓ Ухаалаг антеннтай;
✓ Алдаа засварлалтын кодтой;
✓ Бүх IP сүлжээг дэмжинэ;
✓ Нууцлал хамгаалалт сайн.


Mobily WiMax ч, LTE ч тэр (OFDMA

Orthogonal frequency-division multiplexing) модуляц буюу радио давтамжийг хуувиарлах аргыг ашигладаг. Энэхүү модуляцийн арга нь 4G технологид ч мөн адил ашиглагдана гэж шинжээчид болон стандартчиллын байгууллагууд үзэж байна. (Зураг 1.)



Зураг 1. 4G технологи руу чиглэсэн шилжилт, нэгдэн нийлэх үйл явц

ОУЦХБ-аас гаргасан зөвлөмжөөр 4G технологи нь модуляц болон мульти-антенны технологийг ашигласан байх ба хөдөлгөөнт нөхцөлд секундэд 100 Мбит, суурин байдлаар секундэд 1Гбит өгөгдөл дамжуулах хүчин чадалтай байх ба 40МГц хүртэлх зурвасыг ашиглах юм. 4G технологи нь бүхэлдээ IP проткол дээр суурилсан байх ба IP дээр суурилсан ярианы болон мультимедиа, өргөн нэвтрүүлэг, тоглоомын үйлчилгээг үзүүлэх боломжтой байх шаардлагатай. Бас нэг чухал шаардлага бол өмнөх үеийн технологийг дэмждэг байх явдал юм. (Зураг 2.)



Зураг 2. LTE технологийг хэрэгжүүлэх төлөвлөлт

Бодит амьдралд мобайл интернэтийг өргөн зурвасаар хүргэхийн тулд зөвхөн LTE-г дангаар нь ашиглах боломжгүй. HSPA, бүр EDGE технологийг ч ашиглах

LTE–гийн 800МГц зурвасын сайтуудыг хөдөө орон нутагт ашиглах төлөвтэй байна.

4G технологийн өмнөх үеийн өрсөлдөгч технологиудад LTE, Mobile WiMax 802.16e, Flash-OFDMA, UMB зэрэг багтана.

V. LTE технологийн хэрэглээний цар хүрээ

Утасгүй өргөн зурвасын стандартууд энэхүү 4G технологи руу нэгдэн нийлэх чиглэлээр хөгжиж байгаа ба эдгээрээс LTE болон WiMAX 802.16m стандартууд тэргүүлж байна. LTE технологийг анх Швед, Норвег улсуудад 2009 онд анх ашиглаж эхэлсэн бөгөөд улмаар Хойд Америк, Япон зэрэг технологийн өндөр хөгжилтэй улсуудад хэрэглээнд нэвтэрсэн ба цэргийн хэрэгтээ нэвтрүүлсэн анхны улсууд юм.

LTE технологийн цаашдын хөгжил нь 3GPP Release 10 (LTE Advanced) гэсэн шинэ стандартын ажиллагааны хүрээнд үргэлжлэх ажээ. Өнөөдөр LTE [Advanced]-ыг хангах ёстой үндсэн шаардлагууд аль хэдийн томъёологдчихсон байгаа юм. Чухамдаа эдгээр шаардлагууд нь (4G)-гэсэн дөрөв дэх үеийн гар утасны сүлжээний стандартад тавигдаж байгаа. Үүнд:


☐ Оролтын радио сувагт өгөгдлийн дамжуулалтын хамгийн их хурд 1Гбит/с хүртэл, гаралтынхад-500Мбит/с хүртэл (нэг хэрэглэгчийн нэвтрүүлэлтийн дундаж чадамж LTE-ийнхээс 3 дахин өндөр) байх ажээ.

☐ Оролтын радио суваг дахь нэвтрүүлэлтийн зурвас-70МГц, оролтынход-40 МГц байх аж,

☐ Спектрын ашиглалтын хамгийн их үр ашиг оролтын радио суваг дээр 30 бит/с/Гц, гаралтынх дээр 15 бит/с/Гц (LTE-ийнхээс хоёр дахин өндөр),

☐ LTE-ийн 3GPP-ийн бусад системүүдтэй бүрэн зохицон харилцан үйлчилдэг байх зэрэг нөхцлийг хангахад чиглэж байна.


☐ Фреймийн бүтэц нь:



Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад шинэ техник, технологийг хамгийн түрүүнд батлан хамгаалах салбарт буюу цэргийн хэрэгт ашиглаж, тодорхой хугацаанд технологийн нууц байдлаа хадгалах болон тухайн чиглэлээр бусад улс орноос давуутай байдлаа хадгалж, дараагийн шинэ техник технологи гарч ирмэгц өмнөхөө энгийн салбартаа шилжүүлэн ашигладаг байдал өнөөдөр ч зарим

хөгжингүй орнуудад хэвээрээ байна.

Хэдийгээр хүйтэн дайн эцэс болж, дэлхий нийтийг хамарсан том дайны бодит аюул занал байхгүй болсон ч бүс нутгийг хамарсан болон орон нутгийн шинжтэй дайн, байлдааны ажиллагаа, түүнчлэн терроризм, хууль бус зэвсгийн болон мансууруулах бодисын наймаа, байгаль экологийн сүйрэл, цаг уурын дулаарал, эрчим хүчний болон байгалийн баялгийн хомсдол зэрэг нь Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг улам бүр олон талтай болгож, зэвсэглэл, техникийг улам бүр боловсронгуй болгон хөгжүүлэх шаардлагыг нөхцөлдүүлж байна. /Зураг 3./



Зураг 3. LTE сүлжээг суурилуулах үеийн хэрэглэгчдийн тохиргооны сонголтууд

LTE нь харилцаа холбооны сүлжээнд ашигладаг хамгийн сүүлийн үеийн технологи бөгөөд батлан хамгаалах, аюулгүй байдалд төгс нийцэж байгаа юм. Зэвсэгт хүчний мэдээллийн системийн хэрэглээг нэмэгдүүлэх, харилцаа холбооны үйл ажиллагааны хэрэгцээг хангах гол өндөр хурдны технологи нь LTE юм. Гэхдээ иргэний технологийн үйл ажиллагаанаас нөхцөл байдал илүү хүнд, шаардлага хатуу цэргийн орчинд зохицсон байх ёстой.

Дүгнэлт

LTE технологи нь улс орнуудын цэргийн урлагт хүчтэй нөлөөлөх болсон ба кибер дайн, сүлжээ төвт цэргийн ажиллагаа явуулахад шийдвэрлэх технологиудын нэг болно. Технологиудын давуу талуудад дүгнэлт хийхэд дараах зүйлүүд гарлаа.

1. LTE технологи ЗХ-д нэвтэрсэн тохиолдолд олон төрлийн үйлчилгээ бүхий холбооны технологид нэгтгэгдэнэ. Жишээ нь: ВТХХ-ийн шинэ үйлчилгээний мультимедиа хэрэгслүүдийн чанар, үйлчилгээний цар хүрээ эрс нэмэгдэнэ.

2. Цэргийн ажиллагааны талбар дээрх удирдлага, холбоо, мэдээллийн системүүдээр дамжих сувгийн тоо багтаамж нэмэгдэх, нэгж хугацаанд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллүүдийн синхрон (динамик) байдал дээшилнэ.

3. Дараа үеийн болон өмнөх үеийн технологиудын хоорондын нийцлийн стандартууд тогтоогдоно.

4. Өгөгдөл, дуу дүрс дамжуулах багтаамжтай бөгөөд хээрийн хөдөлгөөнт хэрэгслүүдээр цэрэг нэг бүр хангагдаж удирдлагын шатласан тогтолцооны хамааралгүйгээр цэргийн ажиллагааны талбар дээрээс мэдээлэл солилцох боломжтой болно.

Эцэст нь дүгнээд хэлэхэд дэлхийн улс орны иргэний болон цэргийн холбооны системтэй бүрэн нийцэлтэй ажиллаж чадахуйц LTE технологийг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд нэвтрүүлэх нь нэн тэргүүний зорилт боллоо.

УЛСЫН АГААРЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАХ АЖИЛЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, БОЛОМЖ

Б.Энхзоргол. БХИС-ийн Цэргийн командын сургуулийн Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа

Түлхүүр үг: Хилийн цэрэг /ХЦ/, Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг /АДХЦ/, Агаарын хяналтын төв /АХТ/, улсын агаарын хил, хилийн агаарын бүс, агаарын орон зай, агаарын хилийн зөрчил, дэглэм сахиулах, нисгэгчгүй нисэх аппарат /ННА/, харилцан ажиллагаа, агаарын цагийн байдлын тухай мэдээ /АЦБТМ/, хилийн отряд, застав.

Нэг. Удиртгал

"Монгол Улсын Хилийн тухай" хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт *"Газар, усан дээрхи улсын хилийг хил хамгаалах байгууллага, **агаарын хилийг** агаарын довтолгооноос хамгаалах цэрэг хамгаална"*[14], 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын хил хамгаалахад Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хэрэгжүүлэх чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1/ *хилийн дэглэмийг **холбогдох байгууллагатай хамтран сахиулах***;

2/ агаарын хөлгөөр агаарын хилийг хууль бусаар нэвтрэхээс урьдчилан сэргийлэх;

3/ агаарын хөлөг агаарын хилийг хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд нислэгийг таслан зогсоох арга хэмжээ авах.

"Зэвсэгт хүчний тухай" Монгол Улсын хуулийн 4.2.2-д *"...улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх, агаарын хилийнхалдашгүйдарханбайдалдхяналт тавих"*[15] зэрэг хуулийн заалтуудаас дүгнэж үзэхэд Монгол Улсын агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах, хилийн дэглэмийг сахиулах нь Зэвсэгт хүчний, түүн дотроо Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хуулиар хүлээсэн үүрэг төдийгүй, энэхүү үүргээ Хил хамгаалах байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр эрх зүйн зохицуулалт

[14] "Монгол Улсын хилийн тухай хууль"-ийн 30,35 дугаар зүйл

[15] "Зэвсэгт хүчний тухай" Монгол Улсын хуулийн 4.2.2-дахь заалт

хийгдсэн байна.

Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь энэхүү үүргээ өөрийн харьяа анги, салбаруудын хүч хэрэгслээр, байлдааны жижүүрлэлт явуулах замаар зохион байгуулж байгаа хэдий ч Монгол Улсын өргөн уудам агаарын орон зайг, агаарын хилийн бүх хэсгийг, төрөл бүрийн өндөрт бүрэн хянаж чадахгүй байгааг анхааран үзэж, хяналтгүй байгаа эдгээр орон зайг радиолокацын бус аргаар хянах боломжийг судлаж, тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь бодит хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

1990 оны дунд үе хүртэлх хугацаанд улсын агаарын хил, хилийн агаарын бүсэд хяналт тавих, нислэгийн дэглэм сахиулах үүргийг Хилийн цэрэг, Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг хамтран, үр дүнтэй хэрэгжүүлж ирснийг тэмдэглэн хэлэхийг хүсч байна. Энэ хоёр цэргийн хооронд байгуулагдсан харилцан ажиллах төлөвлөгөө, агаарын цагийн байдлын мэдээ, мэдээлэл солилцох журам байсан төдийгүй эдгээр журам, төлөвлөгөөгөө жил бүр тодотгон, хэрэгжилтийг нь дүгнэж ирсэн байдаг.

Хилийн цэрэг, Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн энэхүү харилцан ажиллагааны үр дүнд улсын агаарын хилийг зөрчсөн цөөнгүй тохиолдлыг хилчдийн өгсөн мэдээллийн дагуу илрүүлж, зохих арга хэмжээ авч байсныг энэхүү илтгэлд жишээ баримт дурьдан өгүүлэх болно.

ХХЕГ, АДХЦ-ийн командлал гэсэн удирдах байгууллагуудын түвшинд энэхүү харилцан ажиллагааны төлөвлөгөөг сүүлийн жилүүдэд огт тодотгоогүй бөгөөд хэрэгжилтийг нь хангах чиглэлээр төдийлөн анхаарал хандуулалгүй явж иржээ. Зарим Радиотехникийн хороо, салбар болон хилийн отряд хооронд хэлбэр төдий тодотгож байгаа харилцан ажиллагааны төлөвлөгөө нь бодит үр дүнд хүрдэггүй, тэдгээрт тавих удирдах газрын бодлого, удирдамж, хяналт дутагдаж байгаа нь илэрхий байна.

Хэдийгээр харилцан ажиллагааны төлөвлөгөөгөө сүүлийн 20 гаруй жил тодотголгүй орхигдуулсан ч Хилийн цэргийнхэн маань улсын агаарын хилийн зөрчлийг илрүүлэх, түүнийгээ мэдээлэх үүргээ умарталгүй өдий хүрснийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Харилцан ажиллагааг доод нэгжид хэрхэн зохион байгуулсан нэг жишээг дурьдхад, 2008 онд улсын агаарын хил зөрчсөн нэгэн нислэгийн талаарх мэдээллийг Өмнөговь аймаг дахь Хилийн цэргийн 131 дүгээр ангиас Номгон суманд байрладаг Зэвсэгт хүчний 104 дүгээр салбарт утсан холбоогоор дамжуулж, мэдээлийн мөрөөр шалгахад уг бага оврын онгоц нь улсын хил зөрчсөн болох нь тогтоогдсон явдал юм.

Хоёр. Харилцан ажиллагааг дахин сэргээх, хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага

1990 оноос өмнө Монгол Улсын агаарын хилийг нэвтэрч байсан олон улсын агаарын хөлгийн тоо өнөө үетэй харьцуулахад эрс бага буюу жилд дунджаар 100[16] хүрэхгүй байсан ба Монголын иргэний агаарын тээврийн агаарын хөлгийн гадаад нислэг тухайн үеийн ЗХУ, БНХАУ, ХБНГУ


[16] ИНЕГ-ын түүхийн хуудас

гэсэн цөөхөн чиглэлээр л хязгаарлагдаж байв. Өмнөд хил дээр ч цагийн байдал тааГүй, Орос, Монголын цэргийн анги, салбарууд хилийн дагуу хүч хуралдуулан, дайсны болзошгүй ажиллагааны чиглэлийг өмнөд, зүүн өмнөд зүгт тооцон, Радиолокаторын рот /РЛР/-уудыг тухайн чиглэлүүдэд цувраажуулан, байрлуулж байсан үеүдэд нисэх хэрэгсэл улсын агаарын хилийг зөрчих, хил орчмын районд нислэг үйлдсэн тухай бүрт түүнийг илрүүлсэн хилийн манаа тухайн нислэгийн талаарх мэдээллийг заставтаа, застав нь отряд, отряд нь Хилийн цэргийн удирдах газрын шуурхай жижүүрээр дамжуулан Улсыг Агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах цэрэг /УАДЭХЦ/-ийн Төв командын байранд дамжуулах үүргийг хүлээдэг байсан[17].

Мөн түүнчлэн хилийн застав, отрядаас ойр байрлах, харилцан ажиллагаатай РЛР-д агаарын цагийн байдлын тухай мэдээг шууд дамжуулах тусгай радио торыг байгуулж, уг торын холбооны бэлэн байдлыг өдөр тутам шалгадаг журам, заавар мөрдөгдөж байлаа.

РЛР-уудын радиолокацын станц /РЛС/-ууд жижүүрлэлтийн горимд ажилладаг, нам өндөрт нисч буй нисэх онгоц, нисдэг тэрэгнүүдийг шаардлагатай алсад илрүүлэх техникийн хязгаарлагдмал боломжтойн улмаас агаарын хилийн тандалтанд хилийн манааг ***нүдэн харааны хянагч*** хэлбэрээр ашиглаж байсан нь тухайн үедээ үлэмж үр дүнтэй арга байсан төдийгүй өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй, харин ч улам ихээр хэрэгцээ, шаардлага нь өсөн нэмэгдэж байна.

2014 оны байдлаар Монгол Улсын агаарын 15 хаалга, 17 замаар хоногт дунджаар 240 орчим, жилд 95 мянга[18] гаруй нислэг үйлдэгдэн, нислэгийн нягтрал жилээс жилд өсөн нэмэгдэж, нислэг бүрийг радиолокацын аргаар хянах боломж хязгаарлагдмал болж байна. Үүнд ч РЛС-уудын техникийн элэгдэл, сэлбэг, хэрэгслийн хомсдол үлэмж нөөлж буйг дурьдах нь зүйтэй.



Зураг 1. Олон улсын агаарын хаалга, зам

[17] УАЭДХЦ-ийн байлдааны жижүүрлэлтийг зохион байгуулах заавар


[18] Зэвсэгт хүчний АДХЦ-ийн 2014 оны байлдааны жижүүрлэлтийн нэгдсэн дүнгийн тайлан

Үүнээс гадна хилийн агаарын бүсэд үйлдэгдэж буй орон нутгийн, хайгуулын, бизнесийн /хувийн/ нислэгүүд ч олшрох хандлагатай байгаа нь улсын агаарын хил орчмын нислэгийн дэглэм сахиулах үүргээ АДХЦ дангаараа гүйцэтгэхэд хүндрэл учруулж байгаа бас нэгэн шалтгаан болж байна.


"Агаарын зайг нисэхэд ашиглах тухай" Монгол Улсын хуулийн 4.1.2-д *"хилийн агаарын бүс" гэж улсын хилийн шугамаас дотогш 30 км-ын өргөнтэй нутаг дэвсгэр дээрх агаарын зайг хэлнэ"*, мөн хуулийн 8.1.3, 8.1.4, 8.1.6-д *"агаарын зайн зөрчил"-д ....тогтоогдсон журмыг зөрчин Монгол Улсын агаарын хаалгаар нэвтрэх; Монгол Улсын хилийн агаарын бүсэд зөвшөөрөлгүй нислэг үйлдэх; агаарын хилээр орж ирсэн тагнуулын зориулалттай нисэх хэрэгслүүдийн нислэг"* гэж заажээ. Мөн түүнчлэн "Монгол Улсын Хилийн тухай" хуулийн 16.3-т *"Агаарын хөлөг нь улсын хилийн тогтоосон агаарын хаалгаар нэвтэрч, зөвшөөрсөн агаарын замаар нисч, зөвхөн хилийн боомт бүхий нисэх буудалд бууж, хөөрнө..."*[19] гэж зааснаар агаарын зайн зөрчил, хил орчмын агаарын орон зайд мөрдөх дэглэм эрх зүйн хувьд тодорхой болж өгсөн.

Өдөр, шөнийн бүхий л цагт, улсын агаарын хилийн эдгээр олон хаалгаар олон улсын иргэний агаарын хөлгүүд ойр ойрхон давтамжтай нэвтэрч, хилийн агаарын бүсэд дотоодын иргэний тээврийн болон хувийн эзэмшлийн зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй нь үл мэдэгдэх олон нислэгүүд нисч байгаа өнөө цагт агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн агаарын бүсэд хуулийн дагуу дэглэм сахиулах үүргийг биелүүлэх боломж улам л хүндрэлтэй болж байна.

"Агаарын зайг нисэхэд ашиглах тухай" Монгол Улсын хуулийн холбогдо заалтанд дурдсан *"...агаарын хилээр орж ирсэн тагнуулын зориулалттай нисэх хэрэгслүүдийн нислэг"*-ийг агаарын зайн зөрчилд тооцно гэснийг тухайлан авч үзье. Тагнуулын зориулалттай нислэгийг зөвхөн нисэх онгоцоор үйлддэг байсан цаг үе улиран өнгөрч, энэ үүргийг бага оврын, оператив, тактикийн нисгэгчгүй нисэх аппарат /ННА/-уудын тусламжтайгаар гүйцэтгэх нь түгээмэл боллоо.



Зураг 2. Бичил нисдэг тэрэг



Зураг 3. Тактикийн, тагнуулын ННА

Бага оврын ННА нь цахилгаан соронзон долгион ойлгох талбай багатай учир РЛС-д илрэхгүй байх, илэрсэн ч маш ойроос илэрдэг, хурд багатай давуу талаа

[19] "Агаарын зайг нисэхэд ашиглах тухай" Монгол Улсын хуулийн 4.1.2, 8.1.3, 8.1.4, 8.1.6 дахь заалтууд

ашиглан нам өндрөөр, газрын хэвгий ашиглан нислэг үйлддэг зэрэг нь түүнийг илрүүлэхэд ихээхэн хүндрэл учруулж байна.

ННА ашиглан улсын агаарын хил зөрчин цэргийн /тагнуул/ болон эдийн засгийн эрх ашгийн /ашигт малтмал, байгалийн ховор элементийн эрэл хайгуул г.м/ зорилгоор нислэг хийж болзошгүй бөгөөд тэдгээрийн эсрэг тэмцэхэд хилчдийн хүч, бололцоог ашиглах нь үр дүнтэй аргын нэг байх болно.

Үүнээс гадна хил орчмын хориотой агаарын бүсэд хувийн нисдэг тэрэг, бага оврын нисэх онгоц ашиглан зөвшөөрөлгүй нислэг үйлдэх явдал ч өдрөөс өдөрт нэмэгдэж, тухай нислэгүүдийн хөдөлгөөнд хяналт тавих, нислэгийн дэглэм сахиулах нь улам бүр хүндрэлтэй болж буй бодит байдлыг хүлээн зөвшөөрч, нэн яаралтай арга хэмжээ авч эхлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Агаарын хилийн зөрчил харьцангуй цөөн, хил орчмын нислэгийн нягтрал эрс бага байсан он жилүүдэд Агаарын цагийн байдлын тухай мэдээ /АЦБТМ/ дамжуулах, солилцох чиглэлээр нягт харилцан ажиллагаатай байсан атал өдөрт дунджаар 300 гаруй нислэгтэй, улсын агаарын хилийн халдашгүй дархан байдалд тавих радиолокацын хяналт үлэмж буурсан энэ цаг үед өмнө бий болгосон харилцан ажиллагаагаа сэргээх, улам сайжруулж бэхжүүлэх талаар Зэвсэгт хүчний АДХЦ-ийн командлал, ХХЕГ аль аль талаасаа санаачлага гаргах цаг нэгэнт болжээ.

Гурав. Хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх санал, хувилбар

3.1. Харилцан ажиллагааны үндэс, тулгуур зарчим:

Хил хамгаалах Ерөнхий газар, Зэвсэгт хүчний АДХЦ-ийн командлал хоорондын харилцан ажиллагааны үндэс нь улсын агаарын хилийг захиалгагүй, зөвшөөрөлгүйгээр нэвтэрч буй болон хил агаарын бүсэд нислэг үйлдэж байгаа нисэх хэрэгслүүдийн талаарх мэдээллийг харилцан солилцоход оршино.

Юуны түрүүнд улсын агаарын хилээр нэвтрэх захилга бүхий олон улсын иргэний тээврийн болон улсын агаарын хөлөг, түүнчлэн хилийн агаарын бүсэд нислэг үйлдэхээр Зэвсэгт хүчний АДХЦ-ийн командлалаас зөвшөөрөл авсан нислэгийн тухай ***урьдчилсан мэдээллээр ХХЕГ-ыг хангах*** тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй. Зэвсэгт хүчний АДХЦ-ийн Агаарын хяналтын төв / АХТ/ нь дээрх нислэгүүдийн талаарх мэдээллийг ИНЕГ-ын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас өдөр тутам авдаг бөгөөд эдгээрээс улсын агаарын хилээр нэвтрэх болон хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх нислэгүүдийн мэдээллийг түүвэрлэн, ХХЕГ-ын Шуурхай удирдлагын төвд урьдчилан мэдээлснээр хангагдах болно.

Нислэгийн талаарх урьдчилсан мэдээллийг ХХЕГ-т өдөр бүр дамжуулах нууцлал бүхий тусгай цахим сүлжээг маш бага зардлаар бий болгох боломж бий. Олон улсын болон орон нутгийн агаарын зам, агаарын хаалгын байрлалыг газрын зураг оруулахдаа хилийн багана, тэмдэгтийн байрлалыг

ашиглах нь илүү нарийвчлалтай, ойлгомжтой байх болно.

Нэгэнт захиалга бүхий нислэгийн талаарх мэдээллийг ХХЕГ-ын Шуурхай удирдлагын төвөөс эхлэн хилийн отряд, застав, хилийн манаа хүртэлх нэгжүүд шат дараалан авснаар улсын хил зөрчиж байгаа болон хилийн агаарын бүсэд зөвшөөрөлгүй нислэг үйлдэж буй нисэх хэрэгслийг таньж, илрүүлэх боломж бүрдэж, үнэн зөв, шаардлагатай мэдээллээр АДХЦ-ийн АХТ-ийг хангах үндэс тавигдана.


Хилийн манаа, харуулын цэг, заставаа өгөх АЦБТМ-д дараах үндсэн шаардлага тавигдаж болно. Үүнд:

- Нислэгийн шинж чанар /нисэх хэрэгслийн хурд, өндөр, чиглэл, бүрэлдэхүүн, овор хэмжээ гэх мэт/-ийг зөв тодорхойлох;
- Нислэгийн байрлал /хилийн багана, тэмдэгттэй харьцуулсан байдлаар/-ыг аль болох ойролцоогоор тодорхойлох;
- Нисэх хэрэгслийг илрүүлсэн анхны цаг, минут болон нислэгийн үргэлжилсэн нийт хугацаа зэргийг багтаасан мэдээлэл байна.

Эдгээр шаардлагыг хангасан мэдээлэл дамжуулахын тулд хилийн манаанд гарч буй цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэх шаардлага зайлшгүй тавигдана. Хугацаат цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэх үүргийг улсын хил орчмын РЛР-ууд хүлээж болох ба цэргийн анхан шатны бэлтгэлийн явцад энэхүү сургалтыг богино хугацаанд чанартай явуулж, дадлагажуулах боломж бүрэн бий.

3.2. Агаарын цагийн байдлын тухай мэдээ, мэдээлэл дамжуулах тогтолцооны хувилбар:

А. Хилийн манаа, харуулын цэгээс АЦБТМ-ийг застав, отрядаар дамжуулан, ХХЕГ-ын Шуурхай удирдлагын төвд, уг төвийн жижүүр нь АДХЦ-ийн Агаарын хяналтын төвд дамжуулах гэсэн дарааллаар харилцан ажиллагааг зохион байгуулах хувилбар /босоо/.



Энэ хувилбараар харилцан ажиллагааг зохион байгуулахад дараах давуу болон дутагдалтай талууд үүснэ. Үүнд:


1. *Давуу буюу ололттой тал:*

- Нэмэлт зардал гаргалгүйгээр Хилийн цэргийн албаны харилцаа, холбооны сувгийг ашиглах боломжтой;
- Мэдээллийн нууцлалын байдал тодорхой хэмжээгээр хангагдана;
- Мэдээллийг хилийн отряд өөрийн харьяа харуулын бусад цэгүүдээс авсан мэдээлэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийх боломжтой.

2. *Дутагдалтай тал:*

- Цаг хугацааны хоцрогдол их гарна. 4-5 шат дамжиж АХТ-д мэдээлэл хүрэх учир хугацааны хоцрогдол 5-10 минут болж, уг мэдээллийн ач холбогдол тодорхой хэмжээгээр алдана.
- Мэдээллийг богино хугацаанд баталгаажуулах, тодруулахад хугацаа их орж, дээрх бүх шатаар дахин дамжуулах шаардлага гарна.

Б. Хилийн манаа, харуулын цэгээс АЦБТМ-ийг застав, отрядаар дамжуулан тухайн отрядын хариуцлагын бүсэд байрлах, харилцан ажиллагаатай РЛР-д шууд дамжуулах хувилбар. /Хэвтээ/



1. *Давуу буюу ололттой тал:*

- Хугацааны хоцрогдол харьцангуй бага, радиолокаторын ротын өөрийн РЛС-ыг ажиллуулж агаарын целийг шуурхай дагах боломж бүрдэнэ;
- Мэдээллийг богино хугацаанд баталгаажуулах, тодруулах боломж, нөхцөл хангагдана.

2. *Дутагдалтай тал:*

- Застав-РЛР, отряд-РЛР хоорондын нэмэлт радио, утсан холбооны суваг шинээр нээх, станц техникээр хангахад тодорхой зардал шаардагдана;
- Захиалгатай нислэгийн ерөнхий мэдээлэл ХХЕГ-т байгаа тул тухайн агаарын целийг улсын хил зөрчигч, нислэгийн дэглэм зөрчигч мөн эсэхийг АДХЦ-ийн командлалаас тодруулан тодорхойлох боломжийг ашиглаагүйн улмаас зөвшөөрөгдсөн нислэгийн мэдээлэл давхардуулан дамжуулж, цаг хугацаа, хүч хэрэгсэл дэмий үрэгдүүлж болзошгүй.

В. Дээрх 2 хувилбарын хосолсон хувилбар буюу шууд босоо болон застав, отряд, РЛР хоорондын харилцан мэдээлэл солилцох холимог тогтолцоог бүрдүүлэх. Тайван цагт болон улсын агаарын хилээр үл таних нисэх хэрэгсэл нэвтэрсэн тохиолдлоос бусад нислэгийн тухай мэдээллийг хилийн манаанаас ХХЕГ-АДХЦК-д дамжуулах буюу "А" хувилбараар; дайн бүхий цагийн байдлын үеийн зөвшөөрөлгүй бүх нислэгийн болон тайван цагт улсын агаарын хилээр үл таних нисэх хэрэгсэл нэвтэрсэн тохиолдолд "А", "Б" хувилбарын аль алинаар нь нэгэн зэрэг дамжуулах нь хамгийн оновчтой тогтолцооны хувилбар хэмээн үзэж байна.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын агаарын дархан хилийн аюулгүй байдлыг хангах үүргийг Хилийн цэрэгтэй хамтран хэрэгжүүлэхийгЗэвсэгтхүчнийАгаарын довтолгооноос хамгаалах цэрэгт хуулиар хүлүүлгэжээ. Энэхүү үүргээ биелүүлэх талаар бодлогын түвшинд ХХЕГ, АДХЦ-ийн командлалын хоорондхамтын ажиллагааны гэрээ,

харилцан ажиллагааны төлөвлөгөө байгуулж, зарчмаа тохирч, сургалт бэлтгэл, дадлага сургуулийг явуулан, салбар, нэгж хоорондын харилцан ажиллагааг эхлүүлэхийг өнөөгийн нөхцөл байдал шаардаж байна.

Улсын хилээр нэвтэрч буй олон улсын нислэг, хилийн агаарын бүсэд үйлдэгдэж буй орон нутгийн нислэгийн нягтрал жилээс жилд өгсөн нэмэгдэж, тэр хэрээр нислэгийн дэглэм зөрчигдөх, агаарын хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх зэрэг үр дагаврууд үүсч болзошгүйг анхаарч хоёр байгууллагын харилцан ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ажлын хэсэг гарган ажиллах цаг нэгэнт болжээ.

Энэхүү илтгэлд судлаачийн зүгээс оруулж буй харилцан ажиллагааны зарчмын хувилбарууд нь зөвхөн судлаачийн хувийн бодол, судалгааны үр дүнг бөгөөд харилцан ажиллагааг хөгжүүлэх тулгамдсан шаардлага байгааг, мөн түүнчлэн хүн хүч, зардал бага шаардагдах хамтын ажиллагааны боломж, нөхцөл байгааг илэрхийлэхийг зорилоо.

БАТЛАН ХАМГААЛАХ, ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙГ ХАМГААЛАХ ҮҮРЭГ, ТЭДГЭЭРИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНД ТАВИГДАЖ БУЙ ШИНЭ ШААРДЛАГА

Ө.Чингэс. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

НЭГ. Батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын Монгол Улсын хилийг хамгаалах үүрэг, тэдгээрийн харилцан ажиллагаанд тавигдаж буй шинэ шаардлага:

Улс орны аюулгүй байдлыг хангах , батлан хамгаалах ажиллагааны эхлэл нь улсын хилийн хамгаалалт юм.

Монгол Улсын хил хамгаалалт нь газрын болон агаарын хилийн хамгаалалт гэж хуваагдана.

Үүнээс агаарын хилийн хамгаалалт нь :

Батлан хамгаалах яам, түүний харьяа Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь агаарын хилийн хамгаалалтыг хариуцан хамгаалдаг. Хил хамгаалах байгууллага нь агаарын орон зайд өөрийн хүч хэрэгсэлээр агаарын орон зайд хяналт тавьж хил хамгаалалтыг зохион байгуулдаг.

Газрын хилийг хамгаалахад:

Ерөнхий зориулалтын цэрэг нь тайван цагт хил хамгаалах байгууллагад хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх;

Дайны цагт хилийг хориглон хамгаалахад үүрэг гүйцэтгэх гэсэн 2 төрлөөр улсын хил хамгаалалтад оролцохоор хуулиар хүлээсэн үүрэгтэй.

Хил Хамгаалах Ерөнхий Газар, Батлан хамгаалах яам хоёр нь:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хангах нэгдмэл үүргийг хүлээж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулан явуулж байна.

Энэ хоёр байгууллагын хамтран ажиллагаа болон харилцан ажиллагааг: боловсронгуй болгох нь практик ач холбогдолтой, бөгөөд энэ асуудал нь сүүлийн үед тулгамдсан асуудал болж байна.

Үүнийг дараах нөхцөл байдал, үндэслэл, тайлбар харуулж байна:

Нэгдүгээрт, хүн төрөлхтний хөгжлийн өнөө үеийн даяаршлын үзэгдэл нь хүн ам, хөрөнгө, мөнгө, мэдээллийн урсгал, хөдөлгөөнийг нэмэгдүүлж, улс, үндэстний хил, нутаг дэвсгэрт нэвтрэх, түгэх боломжийг эрс өсгөж байна.

Хоёрдугаарт, даяаршлыг дагаад улсын агаарын болон хилийн аюулгүй байдлыг хангах ажил, арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлж байна.

Гуравдугаарт, улсын агаарын болон хилийн аюулгүй байдлын эмзэг байдал ихсэж, урьд өмнө тааварлаж мэдээгүй аюул үүсэж гарах магадлал нь нэмэгдэж байна.

Дөрөвдүгээрт, улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хилийг найдвартай хамгаалах асуудал нь агаарын болон газрын хилийн аль алинд хамааралтай, нэгийг нь нөгөөгөөс салган авч үзэх боломжгүй нөхцөл байдлыг улам бүр бий болгож байна.

Тавдугаарт, БХЯ, ХХ байгууллагуудын улсын хил хамгаалах, аюулгүй байдлыг хангах үеийн харилцан ажиллагаа, мэдээлэл солилцоо нь онол, арга зүйн төвшинд ч, практик ажиллагааны хувьд ч хөрш улсуудын онол, практиктай харьцуулахад хоцрогдож хуучин харилцан ажиллаж байсан харилцаанд нь ахиц гарах бус улам бүр дордож байна.

Зургаадугаарт, бүрэлдэн буй болж буй нөхцөл байдалтай уялдуулан хил хамгаалах үүрэгтэй төрийн захиргааны төв болон аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хууль эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг тасралтгүй боловсронгуй болгохыг цаг үе өөрөө бид бүхнээс шаардаж байна.

Энэ бүхэн нь хил хамгаалах, батлан хамгаалах байгууллагуудын улсын хилийг хамгаалах, түүний аюулгүй байдлыг хангах нэгдмэл үүргийг хэрэгжүүлэх үеийн харилцан ажиллагааг боловсронгуй болгохыг шаардаж байна.

ХОЁР. Батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын улсын хилийг хамгаалж буй өнөөгийн нөхцөл байдал дахь харилцан ажиллагаа:

1. ХХБ, БХ байгууллагуудын харилцан ажиллагааны талаарх хууль эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж буй байдлын шинжилгээ хийж уламжилалт харилцан ажиллагааг сэргээх.

2. ХХБ, БХ байгууллагуудын үйл ажиллагааны харилцан ажиллагааны өнөөгийн байдлыг сайжруулах;

3. Хил хамгаалах, Батлан Хамгаалах байгууллагуудын харилцан ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх боломж, хүч хэрэгслийн байдлыг сайжруулах шаардлага байна гэж үзэж байна.

Харилцан ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэс, дүрэм журмыг авч үзье.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал нь монголын ард түмний хувьд анхдагч, тэргүүн зэргийн асуудал юм.

Хил хамгаалах, Батлан Хамгаалах байгууллагуудын харилцан ажиллагааг боловсронгуй болгоход: хууль, эрх зүйн заалтуудтай практик хандлага нь зөрчилдөж байгаа нь хүндрэл учруулж байна.

Юун түрүүнд, Агаарын хилийг Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг хамгаалж байгаа, түүний боломж, бодит болон жинхэнэ чадавхын талаар судалхад:

-Агаарын хилийн цагийн байдлын тухай мэдээлэлийг газрын хил хамгаалах байгууллагад өгөгддөггүй;

- Агаарын болон газрын хилийн цагийн байдлыг хянаж буй байгууллагууд хооронд харилцан ажиллагаа явагддаггүй асуудал нь сүүлийн үед эрдэмтэн судлаачдын судалгааны сэдэв болон гарч ирж байна.

Үүнээс үзэхэд урьд байсан харилцан ажиллагааны дүрэм, журамыг сэргээн ажил хэрэг болгон менежментийг шинэчилэн ажиллахад үл ойлголцолоос гарах боломж бий хэмээн үзэж байна.

Хил хамгаалах байгууллага, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг байгуулагууд нь стратегийн төлөвлөлтүүдийг хийдэг.

Энэ нь эдгээр байгууллагуудын ажиллагааны үеийн харилцан ажиллагааны ерөнхий удирдамж болж өгөх учиртай.

Нөгөө талаас тайван цагт:

"Шаардлагатай үед Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр ерөнхий зориулалтын цэргийн зарим анги, салбарыг улсын хил хамгаалах зорилгоор ашиглаж болно" гэсэн хуулийн заалтын дагууд ч гэсэн харилцан ажиллагааг зохион байгуулж явуулах учиртай.

Тайван цагт, дайн, байлдааны үеийн зарим арга хэмжээг тайван цагт хангаж байхыг хуулиар Батлан Хамгаалах, Хил Хамгаалах байгууллагуудад үүрэгжүүлсэн:

Батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын үндсэн хүч хэрэгсэл болох удирдлагын штабууд, нэгтгэл, анги, отрядуудад хэрэгжүүлж буй өнөөгийн ажил, арга хэмжээ нь салангид, мөр мөрөө хөөсөн, давхардсан, зэрэгцсэн байдалтай, нэгдмэл бус явагдаж байна.

Батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын Улсын хилийг хамгаалах үйл ажиллагаа дахь харилцан ажиллагааг боловсронгуй болгох арга зам:

Батлан хамгаалах, хил хамгаалах байгууллагуудын Улсын хил хамгаалах үйл ажиллагааны харилцан ажиллагааг боловсронгуй дараах арга зам байна:

1.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Төрийн батлан хамгаалах бодлого" болон "Батлан хамгаалах тухай", "Зэвсэгт хүчний тухай" зэрэг төрийн бодлого, хууль эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлтүүд оруулж, Батлан Хамгаалах, Хил Хамгаалах байгууллагуудын "... нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан" байдлыг хангах харилцан ажиллагааг дээшлүүлэх хууль, эрх зүйг боловсронгуй болгох.

2.Зэвсэгт хүчин гэдэг бол төрийн захиргааны төв нэг байгууллага биш байгууллагуудын тогтолцоо. Тиймээс энэхүү тогтолцоог бүрдүүлэгч хэсгүүдийн нэн чухал хэсэг, бусад бүрдүүлэгч хэсгүүдийн бүтэц, зохион байгуулалт, уялдаа холбоо, үйл ажиллагааны дэг журам нэгдмэл байх үндэсийг шинэчлэх. Ингэхдээ захиргааны бус төлөвлөлтийн, үйл ажиллагааны нэгдмэл байдлын хангах удирдлагын хэсэг (элемент)-ийг бий болгох; Тодруулж хэлбэл, стратегийн төлөвлөлт, удирдлагын баримт бичгийг

боловсруулж удирдах үүрэгтэй Зэвсэгт хүчний Жанжин штабыг өөрчлөн шинэчилж байгуулах. Өнөөгийн Зэвсэгт хүчний Жанжин штабыг цэргийн мэргэжлийн өдөр тутмын удирдлага, зохион байгуулалт, цэргийн захиргааны үүрэгт ажлаас чөлөөлж, энэ ажлыг төрөл, мэргэжлийн цэргийн удирдлага – штабуудад шилжүүлэх. Ингэснээр, Батлан Хамгаалах, Хил Хамгаалах байгууллагуудын "... нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан" байдлыг хангах харилцан ажиллагааг дээшлүүлнэ. Батлан Хамгаалах, Хил Хамгаалах байгууллагуудын удирдлагын өнөөгийн нөхцөл байдал дахь цэргийн мэргэжлийн удирдлагын тодорхойгүй байдлыг арилгаж, харилцан ажиллагаа сайжрах үндэс тавигдана.

3. Удирдлагын дэд тогтолцооны үйл ажиллагаа (функц)-г сайжруулахад саад бологч хэсэг – дэд тогтолцоо гэж байна. Үүнийг арилгахгүйгээр Батлан Хамгаалах, Хил Хамгаалах байгууллагуудын Монгол Улсын "... нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан" байдлыг хангах харилцан ажиллагааг дээшлүүлнэ гэж бодох, ажил, арга хэмжээ явуулах гэж оролдох нь бүтэшгүй асуудал юм. Иймээс энэхүү саад бологч дэд тогтолцоог шинэчлэх нь нэн чухал болно. Удирдлагын шинэчлэлийг өөрчлөх, хувьсгах хоёр арга замаар хийдэг. Хувьсгах арга зам бол хүнд, цаг хугацаа нэлээд шаарддаг хэдий ч бэлтгэгдсэн, туршлагатай боловсон хүчнийг цаашид үр өгөөжтэй ашиглах боломжийг олгодог. Харин өөрчлөх арга зам нь хөнгөн, цаг хугацааг бага шаарддаг. Гэхдээ өөрчлөлт оновчтой эсэхээс хамаарч үр өгөөж нь янз бүр байдаг. Манай практикаас харахад, сул тал нь давамгайлаад байдаг нь удирдлагын боловсон хүчнийг бэлтгэхэд ихээхэн хөрөнгө, цаг хугацаа шаарддагтай холбоотой, бас удирдлагын боловсон хүчний нөөц хангалттай бус байдагтай холбоотой байна.

4. Хууль, эрх зүй, удирдлагаас хамаарч Батлан Хамгаалах, Хил Хамгаалах байгууллагуудын харилцан ажиллагаа сул байгаа болохоос биш, эдгээр байгууллагын харьяа цэргийн анги, салбар, отрядуудаас хамаарал нь багаюм. Тэртусмаа харилцан ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх онол, арга зүйд бэлтгэгдсэн боловсон хүчин аль алинд хангалттай байгаа нь дээр дурдсан дутагдалтай талыг зассан байхад, харилцан ажиллагаа зохих төвшинд явагдах боломжтой гэсэн дүгнэлтийг хийж байна.

ХИЛ ДАМНАСАН ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Д.Баян-Эрдэнэ. ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн, онцгой байдлын хошууч

Хураангуй

Манай улсын нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Монгол оронд хур тунадас ерөнхийдөө бага ордог, Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэнд 250-300 мм, хээрийн бүсэнд 150-250 мм, говь цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унана. Тийм ч учраас байгалын болон хүний үйл ажиллагааны эх үүсвэртэй гал түймэрт экологи ихээхэн өртөж, багагүй хохирлыг эдийн засагт учруулдаг. Энэхүү өгүүллэгээр хил дамнасан ой хээрийн түймрийн өнөөгийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэж буй арга хэмжээ, цаашид авах арга хэмжээний талаар дурьдсан болно.

Түлхүүр үг. Түймэр, хохирол, урьдчилан сэргийлэх, мониторинг

Оршил

Монгол улс өнөөгийн байдлаар Төв Азийн төв хэсэгт улсын хилийн өмнөд цэг нь Өмнөговь аймгийн Орвогашууны Бор толгой, хилийн зүүн цэг нь Дорнод аймгийн Соёолж-Уул, хилийн хойд цэг Хөвсгөл аймгийн Монгол шарын даваа, Баян-Өлгий аймгийн Алтай таван богд уул бүхий 1564,100 км квадрат нутаг дэвсгэрийг эзлэн оршдог бөгөөд газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 17-д ордог нэг хүнд ноогдох газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 1-т орох бөгөөд дэлхийн хуурай газрын 1,16%-г эзэлнэ. Баруунаас зүүн тийш сунаж тогтсон. Монгол Улсын хилийн нийт урт 8252.658км, хуурай газраар 7348.5км, усаар 904.158км, ОХУ-тай 3543км, үүнээс хуурай газраар 2860км, усаар 683км, БНХАУ-тай 4709.658км, үүнээс хуурай газраар 4488.5км, усаар 221.158км тус тус хиллэдэг.

Монгол орны ургамлын аймаг нь эх газрын хуурай уур амьсгалын нөлөөнд багагүй хувирсан, нутаг дэвсгэр уудам, газрын гадарга өвөрмөц зэрэг учир шалтгааны улмаас сонирхолтой ургамлуудаар цөөнгүй бөгөөд одоогоор 208 овгийн 596 төрлийн 3906 зүйлийн ургамал бүртгэгдээд байна.

Монгол орны ойн сан 140 гаруй зүйлийн мод, бут сөөгөөс бүрдэх бөгөөд газар нутгийн 18592.4 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзэлж байна.

Монгол орны газар зүйн байрлал, экосистемийн онцлог, цаг агаарын дулаарал, байгалийн аюулт үзэгдэл, хүний буруутай үйл ажиллагаа, бусад хүчин зүйлийн нөлөөлөөс ой, хээрийн түймрийн гаралт, тоо, хохирол буурахгүй байна.

Нэг. Хил дамнасан ой хээрийн түймрийн өнөөгийн нөхцөл байдал

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4.9-д экологийн аюулгүй байдал гэж тусгаж өгсөн нь бид өөрийн нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байгаа билээ.

Монгол улсын хэмжээнд:


2012 онд 19 аймгийн 109 суманд 229 удаа гал түймэр гарснаас 0.35 сая/га ой, 4.7 сая/га хээр өртөж нийт 5.05 сая/га талбай хамарсан бөгөөд байгаль, эколгид 82.0 /тэрбум/төг, эд материалд 1.5 /тэрбум/төг, унтраасан зардал 263.8 /сая/төгрөг нийт 83.7 тэрбум төгрөгийн хохирол:

2013 онд 19 аймгийн 89 суманд 198 удаа ой хээрийн түймэр гарснаас 585.4 мян/га ой, 5.6 сая/га хээр хамарч нийт 5.6 сая/га талбай шатаж байгаль, экологид 4.9 /тэрбум/төг, эд материалд 1.5 /тэрбум/ төг, унтраасан зардал 173.3 /сая/төгрөгийн хохирол:

2014.10.15 өдрийн байдлаар 17 аймгийн 74 суманд 178 удаа ой хээрийн түймэр гарснаас 3491 мян/га нь ойд, 1.6 сая/га нь хээрт гарч нийт 1.6 сая/га талбай хамран, байгаль, экологид 1.3 /тэрбум/төг, эд материалд 51.5 /сая/төг, унтраасан зардалд 51.8 /сая/төгрөг шаардагдсан байна.

Хил дамнасан ой хээрийн түймэр 2012 онд 10 удаа гарч 140,7 мян/га талбай өртөж, байгаль экологид 365 сая төгрөгийн хохирол, унтраахад 21,9 сая төгрөгийн зардал, 2013 онд 5 удаагийн тохиолдлоор 96 мян/га талбай өртөж, байгаль экологид 5 сая төгрөгийн хохирол, унтраахад 1,4 сая төгрөгийн зардал, 2014 онд 4 удаагийн тохиолдлоор 841,1 мян/га талбай өртөж, байгаль экологид 340 сая төгрөгийн хохирол, унтраахад 31,2 сая төгрөгийн зардал тус тус гарсан байна.

2012-2014 онд гарсан гал түймрийн тоо



Эдгээр гал түймрээс жишээ татвал 2012 оны 05 сарын 19 ны өдөр БНХАУ-ны талаас хилийн торны өвс шатааж байгаад Наран сумын Хашаат гэдэг газраар түймэр орж ирэн 60 га талбай шатаж унтраах ажиллагаанд хилийн цэргээс 3 автомашин, 25 албан хаагч ажиллаж унтраасан. 2013 оны 04 сарын 23 ны өдөр Асгат сумын 2-р багийн нутаг Авдар бүдүүн гэдэг газраас хээрийн түймэр гарч Эрдэнэцагаан сумын 1-р застав орчмоор хилийн зогонд орж 1600 га талбай шатаж, хилийн цэргээс 3 техник, 25 албан хаагч ажиллаж унтраасан. 2013 оны 05 сарын 26 ны өдөр Эрдэнэцагаан сумын 7-р багийн нутаг Мөөгтийн заставын ойролцоо хээрийн түймэр гарч хилийн зогонд орж нийт хил орчмын 8000 га талбай шатаж, унтраах ажиллагаанд хилийн цэргээс 1 автомашин 5 албан хаагчтайгаар ажиллаж унтраасан.

Хоёр. Ой, хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

Хууль эрх зүйн шинэчлэлттэй холбоотой түймэртэй тэмцэх талаар хууль эрх зүйн хүрээнд Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй

байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулан батлуулахаар бэлэн болгосны зэрэгцээ 2012 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Ойн тухай хуулийг батлуулсан байна. Мөн түүнчлэн ой хээрийн түймэртэй тэмцэх зорилгоор дараах гэрээ, хэлэлцээр, уулзалтыг кохион байгуулсан байна.

- 1995 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Монгол Улсын Байгаль орчны яам, ОХУ-ын Ойн аж ахуйн улсын албаны хоорондбайгуулсан "Ойн аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай" хэлэлцээр;
- 1999 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн "Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг зохистой ашиглах салбарт хамтран ажиллах тухай" Монгол Улсын Байгаль орчны яам, Буриадын Экологи, байгалийн нөөцийн ашиглалтын улсын хорооны хоорондын хэлэлцээр;
- 2014 онд "Хил орчмын бүсийн ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр;
- 2014 онд Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын "Ойг түймрээс хамгаалах тухай" 9 зүйл бүхий хэлэлцээр зэргийг 2 улсын байгаль орчныг хамгаалах газар болон гамшгаас хамгаалах газартай хэлэлцээрийг зохион байгуулж ажилласан байна.

Эдгээр хэлэлцээрээр зөвхөн ой, хээрийн түймрийн тухай мэдээ мэдээлэл бус бүх төрлийн гамшгийн мэдээ мэдээллийг дамжуулах, солилцох, тэдгээрийг нэг сувгаар солилцож бүртгэснээр хоёр улсын хил дамнан гарсан түймрийн статистак тоон үзүүлэлт бодитой, нэгдсэн нэг тоон үзүүлэлтэй байх боломжийг бүрдүүлэх;

Хоёр улсын Онцгой байдлын алба, Хил хамгаалах алба, ой, хээрийн түймэртэй тэмцэх эрх, үүрэг бүхий байгууллага болон орон нутгийн мэргэжлийн ангийн хамтарсан сургалтыг жил бүр явуулж хэвшүүлэх;

Хоёр улсын хувьд өөрсдийн хууль тогтоомжийн хүрээнд хохирлын хэмжээг тогтоож байгаа ч үнэлгээний хувьд хэрхэн яаж үнэлэх, үнэлгээний процессын үйл ажиллагааг судлаж туршлага солилцох зүйтэй байна гэх мэт асуудлуудыг шийдвэрлэхээр хэлэлцээрийг хийсэн байна.

Ойн газраас ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар дараах ажлыг хийжээ. Тухайлбал;

- Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулинд мониторинг хийж, Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмэлт оруулж УИХ-аар батлуулсан,
- Ойн экологи-эдийн засгийн шинэчилсэн үнэлгээтэй уялдуулан "Ой хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам"-ын төсөл боловсруулж Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 254 дүгээр тогтоолоор батлуулсан,
- "Ойг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээний загвар төлөвлөгөө"-ний төсөл боловсруулж Монгол Улсын Шадар сайд, БОАЖС-ын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 48/А-267 дугаар тушаалаар батлуулсан,
- Ой бүхий 10 гаруй аймгийн БОАЖГ-ыг ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах

гар болон механик багаж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж, нийт 400 сая орчим төгрөгийн техник хэрэгслийг орон нутагт хуваарилсан,

- Хил дамнасан ой, хээрийн түймрээс хамгаалах ажлын хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Хөмөл нэртэй газраас Дадал сумын Хэрэйн гол хүртэл 50-100 м өргөн, 120 км урт зурвасыг зориудын шатаах аргаар байгуулжээ.

"Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай" Засгийн газар хоорондын гэрээг 2006 оны 12 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан байна. Энэ хэлэлцээрийн 19 дүгээр зүйлийн 3-т "талууд ойн болон хээрийн түймрийг улсын хил давуулахгүй байх арга хэмжээ авна. Ойн болон хээрийн түймэр улсын хилд ойртсон тохиолдолд эрх бүхий байгууллагууд энэ тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ", ...нөгөө талын нутаг дэвсгэрт түймэр тархсан тохиолдолд холбогдох байгууллага түүнийг унтраах хамтарсан ажиллагааг хэрэгжүүлнэ". Хэрэв түймэр хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт тархаж эд материалын хохирол учруулбал эрх бүхий байгууллага нь холбогдох байгууллагын төлөөлөгчдийн оролцоотойгоор түймрийн **хэмжээг тодорхойлж акт үйлдэнэ**" гэсэн заалтууд хоёр улсын хэмжээнд бүрэн хэрэгжээгүй байна.

Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Хэнтий, Дорнод аймгууд ОХУ-ын хилийн дагуух ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал;

Хэнтий аймаг

- Тус аймаг 2008 оноос эхлэн жил бүр ОХУ-тай хиллэдэг улсын хилийн дагуу 170 км газарт 50-100 м өргөнтэй хамгаалалтын харлуулсан зурвас байгуулснаар тухайн нутагт хил дамнасан түймэр байхгүй болжээ.

- Аймгийн ОБХ Биндэр сумын "Амгалант" гэдэг газар мансардтай дүнзэн байшинг Засаг даргын нөөц хөрөнгөөр бариулж, хуурайшилтын улиралд 12 албан хаагч, автомашин, түймэр унтраах багаж хэрэгслээр хангагдсан 2 шуурхай бүлгийг 2008 оноос эхлэн хилийн ойролцоо ажиллуулж байгаа нь түймрийн үеийн шуурхай байдал, шууд гарах зардал, цаг хугацааг хэмнэсэн үр дүнтэй ажил болсон байна.

- ОБХ Биндэр, Батширээт сумын малчидтай хамтран 46 км урт газар хагалж, хамгаалалтын зурвас байгуулан түймрийг тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан нь зохих үр дүнд хүрсэн байна.

Сэлэнгэ аймаг

- Аймгийн хилийн цэргийн заставууд, аймгийн ОБГ-тай хамтран "Хил хамгаалахад туслах орон тооны бус зөвлөл"-ийг байгуулан байнгын жижүүр, харуул, морьт эргүүлийг томилон ажиллуулж байгаа нь түймрийн гаралтыг бууруулах, гарсан түймрийг эрт унтраах, цурманд оруулахад эерэг нөлөө үзүүлж байна.

Хөвсгөл аймаг

- Аймгийн ОБХ, Хилийн цэргийн 0257 дугаар анги, БОАЖГ "Хилийн дагуух ойг хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах тухай" гурвалсан гэрээ 2012 оноос байгуулан ажиллаж эхэлсэн байна.

Булган аймаг

- Булган аймаг, ОХУ-ын Буриадын

Закаменск аймаг хооронд хамтран ажиллах гэрээг Засаг дарга нар 2009 онд 10, 2010 онд 11, 2011 онд 8 заалттай байгуулсан боловч тус гэрээнд хилийн дагуух байгаль орчин, ойг хамгаалах, түймрээс урьдчилан сэргийлэх, гол, мөрөн, усан сан, ховор ургамал, амьтны талаар заалт тусгагдаагүй байна.

- Мөн, сумын ЗДТГ, БОАЖГ-тай хамтран ажиллах талаар ажлын төлөвлөгөө гаргаж, гэрээ байгуулсан ч төлөвлөгөө, гэрээний биелэлтийг гаргаагүй, үйл ажиллагааны тайланд энэ талаар тусгаагүй байна.

Дорнод аймаг

- Дэлхийн байгаль хамгаалах сангаас санхүүжүүлсэн Онон-Балж төслийн хүрээнд Баян-Уул сумын Хэрийн голоос Баяндун сумын Нэмнэн гэдэг газар хүртэл Монгол Улс, ОХУ-ын хилийн дагуу 50-100 метрийн өргөнтэй 75 км урт түймрээс хамгаалах зурвас татсанаар хил дамнасан түймэр тухайн газарт гараагүй байна.

- Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНХАУ-ын Иргэний хэргийн яамтай 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод зохион байгууллагадсан уулзалтаар хоёр талаас 5 жилийн хугацаатай "Харилцан ойлголцолын санамж бичигт" гарын үсэг зурсан.

- Аймгийн Онцгой байдлын хэлтэс БНХАУ-н ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Зүүн барга хошууны Хайлаар хотын Ой шугуйны галаас сэргийлэх албатай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр зэрэг аажлуудыг аймгийн орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажиллаж байна.

Сүхбаатар аймаг

- Засаг даргын нөөц сангийн гамшигтай тэмцэх зардалд 119 сая төгрөгийг төвлөрүүлэх;

- Ой, хээрийн түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдан авахад орон нутгийн хөгжүүлэх сангаас 100.0 сая төгрөг

- Түймэр унтраах ажиллагаанд 19.5 сая төгрөг зарцуулсан

- ӨМӨЗО-ны зүүн үзэмчин хошуутай хиллэдэг Эрдэнэцагаан сумдын удирдлага, Цэргийн хэлтэс, Хилийн 0146 дугаар анги, Онцгой байдлын хэлтсийн холбогдох албан тушаалтан оролцсон албан ёсны хилийн уулзалтыг 2 жилд 1 удаа зохион байгуулж гамшгийн талаарх мэдээ, мэдээллийг харилцан солилцох, ой хээрийн түймрийг хил давуулахгүй байх, түймэр гарсан тохиолдолд хилийн бүс болон хил даваж түймэр унтраах бүлгийг хялбаршуулсан байдлаар хил нэвтрүүлэх тухай гэрээг байгуулсан байна.

Гурав. Дүгнэлт

ОБЕГ-ын мэдээнд үндэслэн Ойн газрын гаргасан судалгаагаар 2006-2009 оны хооронд Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл, Увс, Завхан зэрэг аймгийн улсын хилийн дагуух бүс нутгаар ой, хээрийн түймрийн экологи, эд материалд учруулсан хохирол, түймэр унтраахад гарсан нийт зардал 5,4 тэрбум төгрөг болсон байна. Хил орчмын бүс нутагт ой, хээрийн түймрээс экологи-эдийн засагт учруулсан хохирлыг өнөөг хүртэл бүрэн гүйцэд тооцоогүй байна. Тиймээс "Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ батлах тухай" БОАЖС-ын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 394 дүгээр тушаалаар батлагдсан үнэлгээг эргэн харж шинэчлэх, "ой хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох

журам"-ыг боловсронгуй болгох шаардлагатай байна. 2008-2011 оны байдлаар Ойн газраас зарцуулсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал:

№	Хийгдсэн ажил	2008	2009	2010	2011
1	Ойн хээрийн түймрээс хамгаалах, сургалт сурталчилгаа явуулах, багаж хэрэгсэл авах	11.0			
2	Ойн түймрийн хууль тогтоомжийг сурталчлах, сургалт, зөвөлгөөн, хяналт шалгалт хийх		12.5		
3	Орос-Монголын хил дагуух түймрээс хамгаалах хэлэлцээр, сургалт, шторк цацалт, багаж, тоног төхөөрөмж худалдан авах, БОАЖС-ын А-98 тоот тушаалын дагуу ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг амжилттай зохион байгуулсан аймаг, сумдыг шалгаруулж шагнаж урамшуулах			55.0	
4	Түймрийн харуулын цамхаг барих, зурагт хуудас, санамж бичиг хэвлэх, эх бэлтгэх, видео сурталчилгаа, богино хэмжээний нэвтрүүлэг, мэдээлэл солилцооны сүлжээ өргөтгөх, мэдээллийн самбар хэвлүүлэх				107.4
5	Ойн түймрийн механик багаж хэрэгсэл, машин механизм, РЛО худалдан авах				412.9
6	Түймрээс хамгаалах халз зурвас байгуулах				214.2
	Нийт	11.0	12.5	55.0	734.5

Хүснэгтээс харахад, 2008-2012 онд нийт 813.0 сая төгрөг зарцуулснаас 26.3 хувийг түймрээс хамгаалах зурвас байгуулах, 73.7 хувийг сургалт, сурталчилгаа, багаж хэрэгсэл авахад зарцуулсан байна.

Дээрхи үр дүнгээс харахад манай улсын хувьд хил дамнасан ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэхэд зарцуулсан хөрөнгө нь гарсан түймрийг унтраахад зарцуулсан зардлын хэмжээнээс илүү чухал ач холбогдолтой учир цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээнд илүү их хөрөнгө зарцуулах шаардлагатай байна.

Орон нутгийн түвшинд:

Хил залгаа бүс нутгийн хувьд ой хээрийн түймэр гарч хилийн бүс нутагт тулах үед хилийн бүрэн эрхэт төлөөлөгчөөрөө дамжуулан хялбаршуулсан байдлаар харилцан хилийн бүс нутгаар нэвтрэн түймрээ унтрааж байх. (Монгол хилийн албанаас зөвшөөрсөн байдаг)

Хилийн залгаа сумдыг ой хээрийн түймэр унтраах чадавхийг сайжруулахад техник, хэрэгслийн дэмжлэг үзүүлэх.

Хилийн цэргийн ангийн заставуудад хээрийн түймэр унтраахад зориулж техник, хэрэгслийн дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

ХИЛЧИН БА ХУУЛЬ

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Я.Түвшинбаатар. БХИС-ийн БХУА-ийн магистрант, дэд хурандаа

Өнөөдөр хөдөөгийн хүн амын ихэнх нь төврүүгээ нүүдэллэж олонх нь нийслэлд амьдрах болсноор хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч байна.

Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн эздрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяршил, нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна.

Сүүлийн үед гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитоор нөлөөлөх болов.

Өнөөгийн байдлаар улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд учруулж болзошгүй аюул занал, эдийн засаг, хүн амын түрэмгийлэл, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг хил дамнасан үндэсний шинжтэй аюул, зөрчил бүхэн хилийн орон зайд хуримтлагдаж байна.

Үүнтэй холбогдуулан дээр дурдагдсан аюулуудыг арилгах, саармагжуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа улс төр, нийгэм, цэргийн шинжтэй арга хэмжээнүүдийн зэрэгцээ "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд хилийн орчинд учруулж болзошгүй аюул занал"-ын ерөнхий тодорхойлолт, тэдгээрийн үндсэн шалгуур үзүүлэлтүүд түүн дотроос газар нутгийн маргаан, зэргэлдээ улсад гарч байгаа цэргийн үйл ажиллагааны идэвхжил, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж буй салан тусгаарлах бодлого, үйл ажиллагаа, нийгэм улс төрийн түгшүүртэй байдлын голомт үүсэх үндсийг судлан төрөөс хилийн аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулж албан ёсоор баталгаажуулах асуудал онцгой чухлаар тавигдаж байна.

Тиймээс төрөөс хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг шинэчлэн гаргаж, үүндээ тулгуурлан хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх, хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Нэг: Төрөөс хилийн аюулгүй байдлын талаар баримталж буй бодлого;

Төрөөс улсын хилийн талаар дараах эрх зүйн акт, хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийг боловсруулан баталсан. Үүнд:

- Монгол Улсын хилийн тухай хууль батлагдсан.
- БНХАУ, ОХУ-тай байгуулагдсан улсын хилийн гэрээнүүд, улсын хилийг газар дээр нь тогтоосон болон олон удаа дараа хамтарч шалгаж тодотгосон Засгийн газар хоорондын протоколууд гарсан.
- Монгол-Хятадын хилийн боомтууд тэдгээрийн дэглэмийн тухай БНХАУ-ын засгийн газартай, Монгол-Оросын хилийн дэглэм, хилийн будлианыг зохицуулах тухай ОХУ-ын засгийн газартай тус тус хэлэлцээр байгуулсан.
- Монгол Улсын Их хурлаас батлагдсан "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг баталан гаргасан.
- Монгол Улсын хил хамгаалах дүрмүүдийг баталсан.
- Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам баталсан.
- Бүсчилсэн хил хамгаалалтын үзэл баримтлалыг засгийн газраас баталсан.

"Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-д хилийн аюулгүй байдлын талаар огт хөндөлгүй орхигдуулсан байна.

"Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлын бүрэлдэхүүнд хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдлыг цогц байдлаар хамруулсан нь хилийн аюулгүй байдлын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход баримтлах төрийн бодлого юм.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Хил хязгаар нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал" 3-р зүйлийн 1.2-т:

1. Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

2 ..... Улсын хил хамгаалатад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна.

3. Гаднын дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээг авна.

4. Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

5. Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно.

6. Хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ.

7. Хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана гэж хилийн аюулгүй байдлыг хангах

төрийн бодлогыг тодорхойлон өгсөн байна.

Төрийн бодлогыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсон боловч тухайн заалтууд нь зөвхөн тунхаглалын чанартай болсон байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогод сүүлийн үед олон улсын хэмжээнд болон хил судлалын шинжлэх ухааны судалгааны категори болсон "Хилийн орон зай, **"Хилийн аюулгүй байдал"**, "Хилийн харилцаа", "Хилийн талаар баримтлах бодлого", "Хил орчмын нутаг дэвсгэр", "Хилийн орчин", "Хилийн хүрээ" зэрэг нэр томъёонууд, хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэгч объект, субъектууд, хилийн орон зайд Монгол улсын үндэсний аюулгүй байдалд учирч болох аюул заналын үндэс зэргийг тодорхойлоогүй байна. Тиймээс үндэсний аюулгүй байдал, тэр дундаа хилийн аюулгүй байдлын талаар үүрэг хүлээсэн субъектүүдэд хариуцлага тооцох эрх зүйн үндэс одоогоор байхгүй байна.

Нийгмийн болоод улсын хилийн орон зайн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичгийг шинэчлэн найруулах шаардлагатай байна.

2. Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь

Манай улс нь хилийн аюулгүй байдлаа хангах гадаадэрх зүйн орчныг НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болж хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гэрээ, коневцид нэгдэн орсоноор, Монгол Улс, ОХУ-ын хооронд, Монгол Улс, БНХАУ-ын хоорондбайгуулсан Хилийн дэглэмийн гэрээг УИХ-аар соёрхон батлснаар хэрэгжүүлж байна.

Харин дотоод Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг **"Үндсэн хууль", "Монгол Улсын хилийн тухай хууль", "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого", "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Хил хамгаалалтын дүрэм-I,II,III анги"**-иар тус тус хэргэжүүлж байна.

Түүнчлэн өнөөдрийн байдлаар хилийн дэглэмийн болон хилээр зорчигч, ачаа тээш, тээврийн хэрэгслийг харилцан нэвтрүүлэх, зорчих нөхцөл, боомтын асуудлаарх 50 гаруй Монгол Улсын Олон улсын гэрээ үйлчилж байна.

Харин хилийн аюулгүй байдал, түүнийг хангах талаар тусгайлан гаргасан хууль эрх зүйн акт өнөө хэр гараагүй ч хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын тухай Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичигт анх удаа дурдсан байна.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичигт **"Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно"** гэж заасан байна.

Дээрх эрх зүйн акт, бусад баримт бичгүүдэд хийсэн дүгнэлтээс харахад хилийн аюулгүй байдал гэж юу болох талаар томъёолол байхгүй, улсын хилийн хамгаалалт, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаар дээр дурьдагдсан хууль тогтоомжид өөр

өөрөөр тусгасныг харж болно.

Үүнээс үүдэн "Хилийн аюулгүй байдал"-ыг эрх зүйн хувьд хуульчлах ёстой гэж үзэж байна.

Монгол Улсын олон улсын гэрээгээр улсын хилийг хууль бусаар өөрчлөхгүй байх, түүний аюулгүй байдалд занал хийсэн аливаа үйлдлийн эсрэг тэмцэхийн тулд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, хилийн болон хил орчмын дэглэм, боомтод мөрдөх журам зэргийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын хууль, эрх зүйн үйлчлэх нутаг дэвсгэрийн зах хязгаараар улсын хилийг тодорхойлсон байдаг.

Тиймээс улсын хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал хадгалагдан хамаарах орон зайн хүрээний зах хязгаар дотор гарсан хуулиар тодорхойлогдох ёстой.

Хилийн аюулгүй байдлыг хуульчлах нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх субъектуудыг тодорхой болгох, төрийн бусад байгууллагуудын бүрэн эрхийг хуваарилахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх, тэдний хүчийг нэгтгэж хилийн аюулгүй байдлыг хангахад нэн чухал эрх зүйн үндэслэл болно.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх явцад буй болсон өнөөгийн байдал, өөрчлөлтүүдтэй холбон авч үзэх нь зүйтэй гэж үзнэ.

Нийгмийн хурдацтай хөгжлийг дагаад хилийн орон зайд өрнөж буй харилцааны бүх асуудлыг хуульчласан эрх зүйн баримт бичгээр шийдэх шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна.

Өнөөдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудад бага боловч дүн шинжилгээ хийж үзэхэд тулгуур ойлголтуудыг нэг мөр болгох, хилийн аюулгүй байдлын үндэслэлийг гаргах, Ерөнхийлөгч болон Засгийн газраас гаргаж буй баримт бичгүүдийг цэгцлэх, нэг мөр болгох, хуулийн заалтад нийцүүлэх асуудлууд байгаа нь харагдаж байна.

3. Дүгнэлт:

Хилийн аюулгүй байдлын талаар Монгол Улсын төрийн баримтлах бодлого, эрхэм зорилго бол улсын хил хязгаар нутагт аюулгүй байдлыг хангах явдал юм гэж тодорхойлж болох юм.

Иймийн тулд хил хязгаар, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэсэн асуулт зүй ёсоор урган гарч байгаа нь хилийн аюулгүй байдлыг хэрхэн хангахаас шалтгаалах болоод байна.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь бүхэлдээ үндэсний аюулгүй байдлыг улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт хангах ажиллагаа байх тул улс орныг батлан хамгаалах арга хэмжээний нэг хэсэг болж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоодын аюул, заналаас төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх, учирч болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх, арилгах тогтолцоо бүрдүүлэхэд оршиж байна.

Үүнээс үндэслэн хилийн аюулгүй

байдлыг хангах үндсэн зорилт бол

- газар нутгийн бүрэн бүтэн байдал,
- улсын тусгаар тогтнолыг хангах,
- улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэгдсэн, хилийг зөрчилгүй байлгах болон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг сахиулах,
- улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх,
- хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал гэж тодорхойлж болох юм.

Хилийн аюулгүй байдлын талаар өнөөгийн мөрдөж буй эрх зүйн актууд, хуулиудад бүрэн хэмжээгээр тусгагдаагүй байгаа ба цаашид түүнийг улам боловсронгуй болгох шаардлага урган гарч байна. Үүний тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

1. "Хилийн аюулгүй байдал"-ын үйл ажиллагааг боловсронгуй болгож тодотгох, хуульчлах;

2. Бидний одоо мөрдөж буй улсын хилийн тухай хуулийг шинэчлэн найруулах;

3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "хилийн аюулгүй байдал"-ын талаар нэмэлт өөрчлөлт оруулах, тайлбар өгөх;

4. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод хилийн аюулгүй байдлыг хангах талаар нэмэлт, тодотгол оруулах;

5. Хилийн аюулгүй байдлыг хангах төрийн удирдлагын үйл ажиллагааг нэгтгэн уялдуулах;

6. Олон улсын харилцааг сайжруулахад түлхэц болох улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд нийцсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

7. Хил хамгаалах байгууллагыг үе шаттайгаар хөгжүүлэх, бэхжүүлэх;

8. Хөрш улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын гэрээ, хэлэлцээрийг шинэчлэн боловсронгуй болгох санал болгож байна.

Монгол Улсын эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хуулиудад хилийн аюулгүй байдлыг хангах талаар тэр бүр бүрэн хэмжээгээр тусгаагүй учир тэдгээрт зохих хэмжээгээр нэмэлт оруулах шаардлагатай байна.

ГЭМТ ХЭРГИЙН ДАЯАРШИЛ МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

П.Баатарцогт. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, цагдаагийн хошууч

Оршил

Аливаа орны тусгаар тогтнол бүрэн эрхэт байдлыг улсын хилийн халдашгүй дархан байдалгүйгээр төсөөлөх боломжгүй.

Монгол улсын нутаг дэвсгэр гэсэн ойлголт нь явцуу утгаараа ОХУ, БНХАУ-ын дунд хууль, олон улсын гэрээгээр тогтоосон газар, ус түүнтэй паралель түвшинд байх газрын хэвлий, задгай сансрын орон зай хүртэлх агаар мандал зэрэг ухагдахуун ордог бол өргөн утгаараа хууль олон улсын гэрээнд заасны дагуу бусад улсын нутаг дэвсгэрт оршин суугаа Монгол улсын элчин сайдын яам тэдгээрийн эзэмшлийн газар нутаг,уналга байр орон сууц , задгай тэнгис, сансрын орон зайд яваа Монгол улсын төрийн далбаа бүхий нисэх болон хөлөг онгоц зэрэг нь монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүн хэсэг болж тэдгээрийн орон зайд Монгол улсын хууль үйлчилж байдаг.

Аливаа улс орон бүр өөрсдийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсынхаа хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйл ажиллагааг өөрсдийн орны хөгжил, дэлхийн даяаршилтай уялдуулан зохион байгуулсаар хилийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд онцлон авч үзэж байна.

Манай хойд хөрш болох ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин 2006 оны 02-р сард хэлэхдээ: ОХУ-ын гадаад, дотоод аюулгүй байдлыг хангахын тулд улсын хил хамгаалалтгүй байх боломжгүй бөгөөд тэнд гарсан аливаа алдаа нь үндэсний аюулгүй байдлын бүхий л тогтолцоонд илрэх учраас хилийн салбарт гаргаж буй бүх шийдвэрүүдийг сайтар эргэцүүлэн бодож тооцоолсон байх ёстой гэж онцлон тэмдэглэсэн.[20] Энэ нь улсын хилийн аюулгүй байдлыг их гүрэн ямар хэмжээнд авч үзэж бодлогоо тодорхойлж байгааг харуулж байна.

Манай улсын хувьд зөвхөн хилээр бичиг баримтгүй, хууль бус эд зүйлээ нууж, харуул манаанд баригдалгүйгээр орж ирэх гэмт этгээд, хил зөрчигч нартай уламжлалт арга барилаар тэмцсээр ирсэн ба одоо ч албан үүргээ хилчид маань нэр төртэйгээр биелүүлж байна. Гэхдээ дэлхий дахин даяаршиж, тэр дундаа гэмт хэрэг бүр илүү нарийн арга замаар хурдацтай даяаршиж байгаа энэ үед хилийн аюулгүй байдлыг дан ганц хил хамгаалах байгууллага хангах бололцоогүй болсон.

Аливаа зүйл нэгдэж томрох тусмаа хөгжил удааширч, хэсэг болж задрах тусмаа хөгжил нь хурдацтай нарийвчлалтай болдог ч хил хамгаалах үйл ажиллагааг үүний адил нэгж хэсэг болгон задалж алба хаагчийг дан ганц хил хамгаалах чиглэлээр мэргэшүүлж , хилийн цэрэг- хилийн алба гэж нэршиж тэдгээрээр бодлого чиглэлийг нь тодорхойлуулах нь нэг талдаа сайн мэт зүйл боловч даяаршиж буй дэлхийтэй хамт зэрэгцэн урсан ирж буй гэмт

[20] Хил судлал сэтгүүл, 2014 он, 39 дүгээр тал ,

хэрэгтэй тэмцэхэд хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хүчин мөхөсдөхөд хүрч байна.

Дээр хэлсэнчилэн улс орон бүр аюул заналтай өөрсдийн арга барил амссан туршлагаараа өвөрмөц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал: 2001 оны 09 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараа 2002 онд АНУ-ын Эх нутгийн аюулгүй байдлын департмент байгуулагдсан ба энэ департментийг урьд нь тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг тусдаа бүтэц удирдлагатай байсан 20 агентлагыг нийлүүлэн бий болгожээ. Энэ нь Эргийн хамгаалалт, Цагаачлал, Иргэншлийн алба, Гааль, Нууц алба, Хилийн харуул, Холбооны гамшгийн менежментийн агентлаг зэрэг ордог АНУ-ын гурав дах том департмент болжээ. Үүний дараа хилийн аюулгүй байдлыг хөндсөн судалгаанууд хийгдэж АНУ-ын хилийн аюул заналын түвшингээр нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал: Хилийн менежмент, хил хамгаалах, хил манах, хилийн аюулгүй байдал гэсэн ойлголтуудыг тус тусд нь тодорхойлжээ. Үүнээс хилийн аюулгүй байдал буюу Border Security гэсэн тодорхойлолтыг илтгэлтэйгээ холбон авч үзье.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь хилийн орон зайд гарсан хил дамнасан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох үйл ажиллагаа гэсэн бөгөөд хил хамгаалахыг ажил үүргийн хувьд улсын хил хамгаалалтад оролцуулахаар хуулиар үүрэг хүлээлгэсэн субьектүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж төрийн бодлогоор хэрэгжүүлдэг үйл ажиллагаа бөгөөд Хил хамгаалах байгууллага хилийн отряд заставуудынхаа хүчээр бие даан гүйцэтгэж байгаа өнөөгийн үйл ажиллагааг манах юм байна гэдэг дээр ойлголтоо нэгтгэх хэрэгтээ болжээ.

Хэрвээ хил хамгаалах байгууллага хилээ манана бас хамгаалах үйл ажиллагааг явуулж бүгдэд нь оролцох ёстой гэж үзвэл Монгол улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамны газар, задгай сансар болон тэнгист аялан яваа Монгол улсын төрийн далбаа мандуулсан нисэх болон хөлөг онгоцыг ч мөн л алба хаагчаараа хамгаалуулах шаардлагатай болно.

Гэмт хэргийн даяаршил ба хилийн аюулгүй байдал

Хүн төрөлхтөн үүссэн цагаас эхлэн гэмт явдал, гэмт хэрэг байсаар ирсэн бөгөөд хүний нийгмийн түүхийн хөгжлийн үе шат бүхэнд байсаар иржээ.

Гэмт явдал, гэмт хэрэг нь нийгмийн үе шат бүхэнд өөрийн гэсэн өвөрмөц агуулгаар хэлбэржсээр ирсэн нь түүнтэй тэмцэх арга хэлбэрийг улам боловсронгуй болгохыг улс орны төр засгаас шаардаж байна.

Төрт улс байгуулагдсан үеэс эхэлж өөрсдийн хил хязгаараа тогтоож хэрэгжүүлэх хууль дүрмээ гаргаж гэмт хэргийг ч мөн тодорхойлон авч үзсээр иржээ.

Германы нэрт сэтгэгч, гүн ухаантан Гегель хэлэхдээ: “Түүх бол гурван үе шатыг дамжина. Нэгдүгээрт түүхийг магтан дуулна, Хоёрдугаар үе шатанд түүхийг гажуудуулан муулна, хамгийн сүүлийн шатанд түүх бол жинхэнэ гүн ухаан болно ” гэжээ.

Үүнийг гэмт хэргийн даяаршил, хилийн аюулгүй байдалтай холбож Монгол улс, БНХАУ, ОХУын

хоорондын харилцааны талаарх түүхэн баримтуудыг товч дүгнэн үзье.

1911 онд Манж Чин улсын ноёрхол хятадуудын олон жилийн бослого тэмцлийн дүнд нуран унаснаар Хятад болон Монгол улс манжийн ноёрхолоос чөлөөлөгдсөн боловч Хятад улс нь Манж чин улсын залгамжлагч гэж өөрснийгөө тодорхойлж монгол улсыг өөрийн харъяат гэж үзэж ирсэн, харин манай монгол улсын зүгээс Ар өвөр монгол, барга зэрэг монгол угсаатныг нэгтгэх бодлого барьж байсан харин Орос улсын зүгээс төвийг сахисан байр суурьтай байсаар талууд олон уулзалт хийсний дараа 1915 оны Хиагтын буюу Орос Монгол Хятад гурван улсын гэрээг байгуулсан байдаг. Харин япончууд зүүн хойд азид ноёрхолоо тогтоох санаархалын дүнд хятад улсад түрэмгийлэн орж тэдний цэргийн жанжин Жан Кайшиг Манж Го улсын хаан хэмээн өргөмжилж, тоглоомын засгийн газар байгуулан ажиллаж байх үед ч хятадын зүгээс Орос улстай харилцаж, өөрсдийн үзэл бодлоороо Ар монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхгүй байх зүйлийг ч бас ярилцаж байжээ. Тухайлбал: Сталинтай Жан Кайши ярилцахдаа: Ар монголыг тусгаар тогтносон улс болгохгүй, манай улсын эрхшээлд байх ёстой гэхэд: Сталины зүгээс "Үнэндээ та нарын дэмий чалчаад байгаа шиг тийм хүч та нарт алга. Танд үнэнийг хэлэхэд би Монголыг бүхэлд нь цэрэг-стратегийн зорилгын үүднээс л авахыг хүсч байна" гээд уулзалтын төгсгөлд "Хэрвээ Хятад улс, ЗХУ-ын саналыг хүлээж авахгүй бол "Гадаад Монголын хил нь Өвөр Монголын газар нутгийг оруулан хамарч, хэмжээгээрээ бүүр ч том БНМАУ-ыг байгуулахад хүргэнэ" шүү хэмээн сүрдүүлсэн байна. /Энэхүү ярианы тэмдэглэлийн талаар Тайваны архивт хадгалагддаг байна/ .

Ингэж Сталины хэлснээр 1945 оны наймдугаар сарын 14-нд Хятадын ГХЯ-ны сайд Ван-Шице тусгай нот бичиг гаргажээ. Үүнд "Японыг бут цохисны дараа Монголын ард түмэн бүх нийтийн санал асуулгаар БНМАУ-ыг тусгаарлах нь зүйтэй гэж нотолбол Хятадын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоо байгаа хил хязгаараар нь хүлээн зөвшөөрнө гэж Хятадын Засгийн газар мэдэгдэж байна" гэсэн агуулгатай байв. 1945 оны 10 дугаар сарын 20 нд төрийнхөө тусгаар тогтнолын төлөө Монголын ард түмэн 100 хувийн санал өгсөнөөр 1946 оны 2 дугаар сарын 13-нд Хятадын хууль тогтоох танхим Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн билээ. Гэвч Сталины хэлснээр 1990 оныг хүртэл Оросын төрийн түрэмгийлэл манай улсад байсаар, орос цэргийн ангиуд нь манай нутаг дэвсгэр дээр байрласаар байсан билээ.

Цэрэг дайны байдлаар улс орны бүрэн эрхэд халдах эрсдэл нь өмнөх түүхийн адилаар одоо бага түвшинд байгаа ч үндэсний аюулгүй байдалд занал учруулахуйц гэмт хэргийн даяаршилтай тууштай төрийн бодлогоор тэмцэх шаардлага гарч байна.

Зохион байгуулалттай үндэстэн дамнасан гэмт бүлэглэлүүдийн сүлжээ дэлхийн хаана ч байж гэмт үйлдлээ цэцэглэн хөгжүүлсээр байна. Гадаадын хөрөнгө оруулагчид, шашны байгууллага, олон улсын тусламжийн байгууллагууд зэрэг халхавчилсан нэр үйл ажиллагааны дор ямар гэмт

хэрэгтэн гэмт бүлэглэлүүд орж ирж байгааг илрүүлэхэд цагдаа, тагнуул, хил хамгаалах зэрэг тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд тус тусдаа тэмцэх нь битгий хэл монгол улс ч дангаараа тэмцэж илрүүлэхэд ч бэрхшээлтэй байна. Мөн гадаадын улс орон нь жижиг буурай оронлуу төрийн бодлогоор гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагааг оруулдаг нь хэнд ч нууц биш юм.

Монгол улсын хувьд шинэ төрлийн гэж нэрлэгдэх зэвсгийн наймаа, хар тамхи мансууруулах бодисны хууль бус эргэлт, мөнгө угаах, хүн худалдаалах зэрэг зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйлддэг гэмт хэргүүд аль хэдийнээ Монгол улсад бүртгэгдэн шийдвэрлэгдсээр байна. Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж бүртгэхэд мэргэжлийн асар их өндөр ур чадвар шаардагдах нь ойлгомжтой. Харин манайд бүртгэгдэн шийдвэрлэгдэж байгаа дээрх гэмт хэргүүдийн шийдвэрлэлтээс буюу шийтгэгдэж буй этгээдүүдийг судлан үзэхэд зохион байгуулалттай гэмт бүлэглэлийг илрүүлэн бүртгэсэн тохиолдол байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй яаж тэмцэж байгаа нь ойлгомжтой байна. Нэг үгээр хэлбэл гэмт бүлэглэлийн жинхэнэ гишүүн нь биш харин тэдгээрийн гэмт үйл ажиллагаанд татагдан орсоор байгаа жирийн иргэд л шүүгдэгчийн ширээнд суусаар байна.

Дэлхийн хэмжээнд жилд 2 сая 450 мянган хүн ямар нэгэн байдлаар хүний наймаа, албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн золиос болж байна гэж хөдөлмөрийн олон улсын байгууллагын судалгаагаар гарсан байна. Дэлхийн хэмжээнд хүний наймаанаас олсон нийт орлого одоогийн байдлаар 44 сая америк долларааар үнэлэгдсэн байна. [21] Монгол улсын иргэнийг гадаад улсад хүчээр гаргаж худалдах, боолчлох гэмт хэргийг үйлдэх бол заавал 2 улсын хилийг ямар нэгэн байдлаар нэвтрэх асуудал гарна. Тэгтэл Монгол улсын хил нь ОХУ-тай 3543 км, БНХАУ-тай 4709.6 км бүгд 8252,6 км урт хил байна , үүний 9,6 хувийг буюу 767.4 км зөвхөн дохиолол хяналтын системээр хамгаалагдаж байна. Харин бусад байдлаар буюу хилийн харуул, гүйцэтгэх тагнуулын ажлаар үлдсэн хилийг манаж байна. Үүнд хилийн цэргийн харуулд гарч байгаа албан хаагчийн тоо, хэдэн километрийг хамгаалж байгаа, шөнө өвлийн цагт ямар байдлаар хилийг хамгаалж байгааг дурьдах шаардлагагүй нь ойлгомжтой. Захын нэг хар тамхины зөөвөрлөгч этгээд өөрийн дээд талынхаа зуучлагчтайгаа интернэтээр холбогдож, хурдан галт тэрэг, нисэх онгоц зэргээр зорчин явж байхад түүнтэй тэмцэж байгаа төрийн алба хаагч нар томилолтынхоо зардлыг ч бүрэн авч чадахгүй, хууль эрх зүйн болоод эдийн засаг техникийн хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулж байгаа нь харамсалтай.

Саяхан л Монгол улсаас Батаар нэртэй үлэг гүрвэлийн ясыг хулгайлан АНУ-д зарж борлуулсан гадаадын иргэний хэргийг илрүүлж эх нутагтаа дээрх олдворыг буцаан авчирлаа хэмээн гайхуулан ярьцгааж байлаа. Гэтэл одоо үүнийг дүгнэн үзвэл бүхэл бүтэн динозавор-үлэг гүрвэлийн ясыг хууль бусаар манай улсын хил гаалиар гаргаж тэрийг нь АНУ-н дуудлага худалдаанд гарахад нь л мэдсэн гэж үзэхэд улсын хилээр ямар ч зүйлийг хууль бусаар

[21] Хил судлал сэтгүүл, 2014 он. 17 тал

нэвтрүүлэх боломжтой байна гэдэг нь харагдаж байна. Шинжлэх ухаанд одоо ил мэдэгдсэн байгаагаар хүн нас барснаас хойш 72 цагийн дотор эд эрхтэнг нь бусдад шилжүүлэн суулгах боломжтой гэдэг нь тогтоогджээ. Сураггүй алга болсон хүн, хүүхэд нэг нь ч хүний эд эрхтэн худалдаалах гэмт хэргийн золиос болоогүй гэсэн баталгаа байхгүй л байна. Мөн манай улсад талийгаачийн биеийг оршуулахаас нь өмнө дотор эрхтэн нь бүрэн бүтэн байгааг шалгаж тогтоодог зүйл одоогоор үгүй л байна. Манай улсын хуулинд улсын нутаг дэвсгэрт хууль бусаар оршин суугаа гадаадын иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэхээр үл барам тэдний зүгээс гэмт хэрэг үйлдэх, төрийн алба хаагчийг эсэргүйцэх нь энгийн л нэг үзэгдэл болжээ. Уг нь манай улсын хууль тогтоомжинд гадаад улсын иргэдийн тоог хязгаарласан, үндэсний аюулгүй байдлаа хамгаалсан зохицуулалт байдаг хэдий ч амьдралд төдийлөн хэрэгжихгүй байна. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд хөрш орнууд болон бүс нутгийн хэмжээнд хууль эрх зүйн орчноо уялдуулан харилцан туслалцаа үзүүлэх эрх зүйн амьд гэрээ хэлэлцээр байхгүйгээс ганц нэг илэрсэн гэмт хэргүүдийн жинхэнэ толгойлогч нь баригдахгүй өөр бусад оронд нуугдаж, гэмт хэргийг нотлоход шаардлагатай баримт материалыг бусад орноор хийлгүүлэн авч чадахгүй байдалд хүрч байна.

Дүгнэлт

Монгол улс нь хилийнхээ халдашгүй дархан байдлыг хамгаалж, манах үүргээ одоогийн байгаа хууль эрх зүйн хүрээнд хангалттай хэмжээнд биелүүлж байна. Харин хилийнхээ аюулгүй байдлыг хангаж чадаж байна уу гэдэг эргэлзээ төрж байна. Ялангуяа үндэстэн дамнасан гэмт хэргүүд буюу хар тамхи, зэвсгийн наймаа, хүний наймаа, мөнгө угаах зэрэг гэмт бүлэглэлийн үйл ажиллагаатай тэмцэж чадахгүй байгаа нь хилийн аюулгүй байдал алдагдсан гэж үзэхэд хүрч байна. Энэ нь маш олон учир шалтгаантай ч гол хэдэн шалтгааныг дурьдвал:

1. Монгол улсын хууль эрх зүйн зохицуулалтыг хөрш зэргэлдээ болон бүс нутаг дэлхийн улс орнуудын эрх зүйн зохицуулалттай уялдуулах ажиллагаа хангалтгүй,

2. Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо байхгүй,

3. Төрийн алба хаагч нарын мэдлэг чадвар дутуу

4. Төрөөс баримтлах нэгдсэн бодлого чиглэлгүй зэргийг авч үзэж болохоор байна.

ХИЛ ОРЧМЫН АЛСЛАГДСАН БҮС НУТАГТ ЗАРИМ ТӨРЛИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭГ ХИЙХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

П. Цогбадрах. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, ахмад

Дэлхий нийт даяарчлагдаж иргэд чөлөөтэй зорчих болсны зэрэгцээ олон улс дамжсан гэмт хэрэг, террорист халдлага үйлдэгдэх болсон учир улс орнууд үндэсний аюулгүй байдлаа хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, үйл ажиллагаандаа ашиглаж буй техник хэрэгсэлээ төгөлдөржүүлэн харилцан мэдээлэл солилцох, шалгах ажиллагааг хуулийн хүрээнд, хугацаа алдалгүй үнэн зөвөөр шийдвэрлэх явдал юм.

Гэвч энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд цаг хугацаа, орон зай, техник технологи, мэдлэгийн хөгжлийн явц зэрэг олон хүчин зүйлстэй нүүр тулах хэрэгтэй болдог бөгөөд хэрвээ шийдлийг нь зөв олсон тохиолдолд гайхалтай үр дүн гаргах боломж байдаг.


Шүүхийн шинжилгээний тухай хуулинд заасанчлан Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж, бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий байгууллага хэмээн тодорхойлсон байдаг.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн хэлтэс, лабораториудын нэгдсэн байр 2008 оны 9-р сард ашиглалтад орсноор шүүхийн шинжилгээг хараат бус, бие даасан байдалд явуулах нэг нөхцөл болсон.

Монгол Улсын Засгийн газрын "Шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай" 2007 оны 270 дугаар тогтоолоор аймгийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, аймгийн нэгдсэн эмнэлгийн шүүх шинжээч эмч нарыг нэгтгэн **аймгийн Шүүхийн шинжилгээний алба**, нийслэлийн дүүргүүд, Замын цагдаагийн газар, Төмөр замын цагдаагийнхэлтсийнкриминалистикийн шинжээчдийг нэгтгэн **Нийслэлийн шүүхийн шинжилгээний албыг** тус тус байгуулсан.

2013 онд шүүхийн шинжилгээний байгууллагын нийт хийсэн шинжилгээ





Хил орчмын алслагдсан бүс нутагт зарим төрлийн шүүхийн шинжилгээг хийхэд тулгамдаж буй асуудлууд:

- Алслагдсан бүс нутагт гэмт хэргийн улмаас болон золгүй байдлаар хүний амь эрсдсэн тохиолдол бүрт мөрдөн байцаалтын ажиллагааг явуулж үхлийн шалтгааныг тогтоох цогцосны задлан шинжилгээг зайлшгүй хийх шаардлагатай. Хил орчмын бүс нутгууд нь аймаг болон сумын төвөөсөө хэдэн

зуун км-р алслагдмал зам, харилцаа сайн хөгжөөгүйгээс цогцсыг зөөвөрлөх боломж байхгүй тухайн нөхцөлд шинжилгээг хийх шаардлагатай болдог, аймгуудын шинжээч эмч нар эмэгтэй хүмүүс байдаг тул хүндрэлүүд их гардаг. Жишээ нь:

2010 онд Булган аймгийн Тэшиг суман дахь Хилийн цэргийн .... дугаар ангийн 3-р заставын байлдагч харуулд гарч байх үедээ өөрийгөө буудаж нас барсан,


2014 онд Дорнод аймаг Халхгол сум Буйрын заставын байлдагч адуундаа явж байгааж усанд живж нас барсан. Цогцосны задлан шинжилгээг автомашины гражид нь хийсэн, зарим тохиолдолд хээр, гадаа хийх ч асуудал гардаг.

Шинжилгээний үеэр эд эсийн шинжилгээнд авсан дээжийг Улаанбаатар хотруу ШШҮХ-д явуулж шинжлүүлэх шаардлагатай байдаг тул замдаа муудаж шинжилгээний шаардлага хангахгүй байх ч тохиолдол цөөнгүй гардаг.

- Монгол орны өргөн уудам нутагт уул уурхай, аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, ашигт малтмалыг хилээр зөөвөрлөн экспортлох ажилд өөрийн орны болон гадаад орнуудын иргэд олон тоогоор ажиллаж байгаагийн зэрэгцээ хил орчмын бүс нутагт малын хулгай, хууль бус ан агнуурын хэрэг болон хүний амь насыг санаатай хохироосон хэрэг буурахгүй байна.

Одоо ажиллаж байгаа Папилон 7.7.4 системийн ажлын станциуд нь ШШҮХ-ийн Криминалистикийн шинжилгээний хэлтсийн Гарын мөрийн шинжилгээний тасагт 4 станц, дүүрэг болон орон нутагт тавигдсан 29 станц, будагч хэрэглэхгүйгээр гарын алганы дардас авах амьд скайнерын иж бүрдэл станц 37, будагч бодис хэрэглэхгүйгээр шуурхай шалгах утаст иж бүрдэл / комплекс/ Папилон-М ажлын станц 2 гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

Аймгуудын ШШАлбадыг бүсчлэвэл



Дүүрэг орон нутагт суурьлагдсан станц нь суурин учраас алслагдсан бүс нутагт үйлдэгдсэн гэмт хэргийг газраас илрүүлж бэхжүүлсэн гарын мөрөнд шинжилгээг түргэн шуурхай хийх, гэмт этгээдийг халуун мөрөөр тогтоох, эрлийн чиглэл гаргах, хэн болох нь тогтоогдоогүй цогцосны нэр хаягийг тогтоох зэрэг шуурхай гүйцэтгэх шаардлагатай ажиллагааг түргэн хугацаанд хийж гүйцэтгэх боломжийг хязгаарладаг.

Учир нь хэргийн газраас илрүүлж, бэхжүүлсэн гарын мөр, дардсыг

1. Тухайн хэрэг гарсан аймгийн төвд байрласан Папилон системийн салбар станцад оруулж хайлт хийнэ.


2. Хэрэв хайлт үр дүнгүй бол УБ хотод байрлах Папилон системийн нэгдсэн санд кодлон оруулж хайлт хийхэд 7-10 хоног шаарддаг.

Энэ хугацаанд тухайн гэмт хэргийг үйлдсэн гэмт этгээд оргон зайлах, улсын хилээр нэвтрэн гарах, дахин гэмт хэрэг үйлдэх, өөрийн амь насыг хохироох зэрэг асуудал практикт байнга тулгарч байна. Иймээс зөөврийн ГМАМС хэрэглэж хэргийн газар дээр гарын мөрийн адилтгалын шинжилгээг шуурхай хийх нь олон талын ач холбогдолтой байна.

Манай улсад зөөврийн Папилон-М станц хоёр ширхэг байна. Эдгээр нь ШШҮХүрээлэнгийн криминалистикийн шинжилгээний хэлтэст гэмт хэргийн газрын үзлэгт ашиглаж байна. Монгол улсын хэмжээнд Папилон-М станц хоёрхон ширхэг байгаа нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтооход хүндрэлтэй байна.

Papillon-М зөөврийн ажлын станц





Папилон-М станцыг тухайн хэрэг гарсан газарт цаг алдалгүй ашигласнаар олон гэмт хэрэг илрэх боломжтой юм. Үүнээс дурьдвал: 2013 онд 04 сард Ховд аймгийн Булган суманд ажил үүргээ гүйцэтгэж явсан цагдааг буудаж амь насыг хохироосон гэмт хэрэг үйлдэгдсэн. Уг хэргийн газар УМБГ, ЭЦГ, ШШҮХ-

ээс бүрэлдэхүүн ажилласан ба хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн гарын мөрөөр зөөврийн Папилон-М ГМАМС-ийн ажлын станц ашиглан сэжигтэн этгээдийг хугацаа алдалгүй тогтоосон нь гарын мөрний адилтгал мэдээллийн зөөврийн систем буюу Папилон М станцын гүйцэтгэх үүрэг өндрөөр тавигдаж байгаа юм.

Зөвхөн гэмт хэрэгтэй холбоотой асуудлын хүрээнд зөөврийн Папилон-М станцыг ашиглах төдийгүй онгоцны сүйрэл, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, гоц халдварт өвчны хорио цээрийн үед ч ашиглах өргөн боломжтой гэдэг нь практик туршлагаас харагдаж байгаа юм.

ГМАМСистем нь зөвхөн ял шалгах төдийгүй захиргааны ямар нэгэн зөрчил гаргасан эсэхийг шалгаж байх бололцоог хангасан мэдээллийн бүрдэлтэй байдаг. Тухайн этгээд зөрчил гаргах бүрдээ бүртгэлд ордог бөгөөд эдгээрийг санд оруулж холболт хийснээр нэг сайн чанарын карт үүсэх төдийгүй гаргасан бүх зөрчлийг нь харах бололцоог олгодог. Мөн түүнчлэн дэлхийн улс орнууд төрийн тусгай алба хаагчид, гадаадын иргэд харьяалалгүй этгээдүүдийн хувийн байдлыг тогтоох, эрх зүйн чадваргүй этгээд, хэн болох нь тодорхойгүй цогцосыг хэн болохыг тогтоох зорилгоор гарын хээний дардасыг мэдээллийн картын хамт авч санд байршуулдаг байна. Жишээ нь ОХУ 1998 онд гарын хээний бүртгэлийн хууль батлан гаргасан ба уг хуулинд хувийн байдлыг нь тогтоох зорилгоор дараахь этгээдүүдийн гарын хээг авах заалт байдаг. Үүнд:

- Заавал авах этгээдүүд буюу цэргийн алба хаагч, цэрэг, цагдаагийн улирсан алба хаагч, гааль, татварын цагдаа, батлан хамгаалах, тагнуул, шүүхийн болон хуулийн алба, аюулгүй байдал, онцгой байдал, нисэхийн алба хаагчид, аврагчдын гарын хээг заавал авах ёстой байдаг[22].

- АНУ-ын энэ төрлийн системүүд өөр өөрийн чиг үүрэгтэй байдаг бөгөөд нэгдсэн сандаа мэдээлэл илгээж тодорхой мэдээллийг солилцсоноор мэдээллийн цогц үйлчилгээгээр төрийн албадыг хангадаг байна[23].

Дүгнэлт

Аймагт ажиллаж байгаа шинжээч эмч нарын ажиллах орчинг сайжруулж, шаардлагатай урвалж бодис, багаж хэрэгслээр хангах шаардлагатай байгаа юм.

Өнөөгийн байдлаар манай улсад гарын мөрийн адилтгалын автомат системийн иж бүрдэл болох ОХУ-д үйлдвэрлэгдсэн Папилон-7 хувилбарыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, нийслэлийн дүүргүүд, 21 аймагт суурилуулан ашиглаж байна. Эдгээр ажлын станцууд нь төвлөрсөн хот сууринд, тохилог орчинд ажиллах зориулалттай учир овор их, олон саланги эд анги, тогтмол цахилгаан үүсгэвэр, шилэн кабелийн болон өндөр хүчин чадал бүхий модем ашиглахыг шаарддаг. Биедээ ямар нэгэн бичиг баримтгүй, хэн болох нь тодорхойгүй цогцос олдох, гэмт хэрэг үйлдэгдсэн хэргийн газраас илрүүлсэн гарын мөрийг яаралтай газар дээр нь шинжлэн тогтоох, төвд дамжуулах, цаашид эрэн

[22] Федеральный закон от 25 июля 1998 г. Н 128-ФЗ "О государственной закон дактилоскопической регистрации в Российской Федерации"

[23] www. Fbibiospecs.org Federal bureau of investigation CJIS

сурвалжлах ажлыг шуурхай зохион байгуулах, мэдээллээр хангахад гарын мөрний адилтгал мэдээллийн зөөврийн систем буюу Папилон М станцын гүйцэтгэх үүрэг өндрөөр тавигдаж байгаа юм.

Санал

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 110 дугаар тушаалаар баталсан "Гарын хээний нэгдсэн сангийн журам", "Галт зэвсгийн хонгио хошууны нэгдсэн сангийн журам", 2012 оны 44 дугаар тушаалаар баталсан "Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам"-ийг тус тус шинэчлэн батлуулах.

Одоогоор улсын хэмжээнд ердөө 2 ширхэг ашиглагдаж байгаа зөөврийн Папилон М станцын тоог нэмэж Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, нийслэлийн дүүргүүд, 21 аймаг тус бүрт нэг буюу нийт 30-40 ширхэгийг худалдан авч яаралтай ашиглаж эхлэх,

ГМАМС-ийг зөөврийн байдлаар хэрэглэснээр Эрүүгийн процессын хувьд байцаан шийтгэх ажиллагааны хурд мэдэгдэхүйц нэмэгдэх, хэргийн газрын үзлэг хийж буй бүрэлдэхүүн газар дээр нь гэмт этгээдийг эрэн сурвалжлах чиглэл гаргах, нотлон тогтоох, хэн болох нь тогтоогдохгүй цогцосны нэр хаягийг газар дээр нь тогтоох, бусдыг хэлмэгдүүлэхгүй байх зэрэг өндөр ач холбогдолтойг дээр дурьдсан билээ. Иймээс одоо байгаа ГМАМАС-т тохирох зөөврийн ажлын станцыг алслагдсан бүс нутагт нэн тэргүүнд нэвтрүүлэх шаардлагатай гэсэн саналтай байна. Улмаар тэдгээр станцуудыг зөвхөн гэмт хэргийн газарт үзлэг хийх бүрэлдэхүүнд бус хэв журмын цагдаа буюу хөдөлгөөнт эргүүлийн автомашинд суурьлуулснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг шуурхай тогтоох мөн захиргааны шинжтэй үйл ажиллагаанд хэрэглэх зэрэг ач холбогдолтой юм.

Хүрээлэнгийн Гарын хээний нэгдсэн сангийн төв серверийг УБЕГ-ын мэдээллийн сантай шилэн кабелиар холбох талаар мөн ажлыг зохион байгуулах зэрэг болно.

ХИЛЧДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДАЛ

А.Амартайван. ХСИС-ийн Удирдлагын сургуулийн магистрант, дэд хурандаа

Монгол Улсад төрт ёс тогтсон үеэс иргэдийн нийгмийн хангамж үүссэн бөгөөд улс орны нийгмийн хангамжийн байгууллагаас хамаарч янз бүрээр шийдэгдэж ирсэн боловч Монгол улсад Ардын засаг тогтсоноос хойш улс орны эдийн засгийн хөгжлийн бололцоо нөхцөл бүрдэхийн хэрээр аажмаар хөгжиж ирсэн.

Монгол улсын нийгмийн хангамж нь иргэдэд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж төлбөр олгох, эмнэлгийн үйлчилгээ эмчилгээний зардлыг хариуцан гаргах нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох өндөр настан, тахир дутуу

иргэдэд халамжийн тэтгэвэр олгох, төрөл бүрийн нийгмийн үйлчилгээнд хөнгөлөлт үзүүлэх, жирэмсний болон амаржсаны, олон хүүхэдтэйн тэтгэмж, нярайн хүүхдийн арчилгааны тэтгэмж, өнчин хүүхэд асрамжлах эмчлэх сувилах зэргээр иргэдийн амжиргааг хангах эрүүл мэндийг хамгаалах талаар төрөөс авч хэрэгжүүлж буй нийгэм эдийн засгийн өргөн хүрээтэй асран тэтгэх шинжтэй нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ мөн.

Нийгмийн халамжийн эдийн засгийн үүргийн хувьд хөдөрмөр эрхэлж байсан иргэд өндөр настай болох хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болгох зэргээр хөдөлмөрийн хөлсгүй болох хүүхэд төрүүлэх асрах болон ахмад настан тахир дутуу иргэд амжиргаагүй буюу нийгмийн үйлчилгээ шаардлагатай болсон тохиолдолд асран тэтгэх гол зорилготой.

Монгол улсад иргэдийн нийгмийн хангамжийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомж иж бүрнээр системтэй хөгжиж иргэдийн эд мэтериалын хангамжийн нэгдсэн систем бүрэлдэн тогтсон байна.

Хилийн цэргийн бие бүрэлдэхүүний тохитой, тогтвортой ажиллах, өөрийгөө хөгжүүлэх орчин бий болгох, цэргийн албан хаагчдаас албаа сэтгэл хоёрдолгүй хаах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг хангах нь удирдлагын нэн чухал зорилт болох ёстой.

Цэргийн албан хаагчдын нийгмийн баталгааны хангалт болон нийгмийн хамгааллын түвшингийн байдал нь анги салбарын тавигдаж буй зорилго, зорилтыг ханган хэрэгжүүлэгч шинэчлэлийг хөгжүүлэх хөдөлгөгч хүч болно.

Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого болон Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "Цэргийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулах" талаар тусгагдсан.

Энэ асуудлыг шийдвэрлэхдээ 3 бүлэгт хуваан үзэж болно.



ЦАХ-ын нийгмийн хамгаалалд дараах асуудлуудыг хамааруулна.



Иймд офицер, ахлагч нарын амьжиргааны түвшин, эрүүл мэнд, орон сууцны хангамжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаатайгаар авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хил хамгаалах байгууллага албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1997-2008 онуудад "Цэргийн орон сууц-2000", 2001-2004 онд "Нийгмийн хангамж-2004", 2005 онд "Хилчдийн нийгмийн хамгаалал-2008", 2007 онд "Хилчдийн эрүүл мэнд" зэрэг хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлсэн.

Сүүлийн жилүүдэд /2008-2014/ он хүртэл хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулаагүй бөгөөд харин тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган ажилласан.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг судлах, шийдвэрлэх зорилгоор шинээр нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болсон.

Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнээс хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулахад тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх судалгааг эрүүл мэнд, боловсрол, өрхийн орлого, орон сууцны хүрээнд II үе шаттайгаар зохион байгуулсан.

"Хилчдийн нийгмийн хамгаалал" хөтөлбөрийг 5 жил хүртэлх хугацаанд орон сууц, эрүүл мэнд, гэр бүлийн хөгжил, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Нийгмийн хамгаалал нэр томъёоны цаана халамжийн бодлого биш, хилчдийн хөгжилд суурилсан ажлыг өрнүүлснээр цаг үеэ олсон үр дүнтэй ажил болно.

DDC
355.02
Г-21

ХИЛ СУДЛАЛ

ХСИС-ийн Хилийн Сургууль, Монголын Хил Судлалын Үндэсний нийгэмлэгийн онол-мэдээллийн сэтгүүл

Сэтгүүлийн эрхлэгч:
ОУМА-н академич, доктор,
тэргүүлэх профессор Г.Дагважамц

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
ОУМА-н академич, доктор,
профессор, хурандаа Ц.Ганболд

Үүсгэн байгуулагч:
ОУМА-н академич, доктор, тэргүүлэх профессор Г.Дагважамц

Гишүүд:
Доктор, д/х В.Жавхланцогт
Доктор, профессор А.Муратхан
Доктор, профессор Д.Нямдорж
Магистр Х.Гөлгөө
Магистр д/х Ё.Хадхүү
Магистр д/х Д.Баярсайхан
Магистр д/х Т.Баясгалан
Магистр д/х Г.Мөнх-Ертөнц
Магистр д/х Ж.Ганбаяр

Эхийг бэлтгэсэн:
Хошууч Д.Алтангэрэл
Хэвлэлийн дизайн: Х.Айжан

Хэвлэлийн хуудас: 17,2
Хэвлэсэн тоо: 300 ш

* Нийтлэлийн хариуцлагыг зохиогч өөрөө хүлээнэ.
* Нийтлэлээс иш татахдаа сэтгүүлийн нэрийг заана.
* Сэтгүүлийг хувилан олшруулахыг хориглоно.
* Сэтгүүлд ирүүлсэн болон нийтлүүлсэн зүйлийн эхийг буцаахгүй

Манай хаяг:
Баянзүрх дүүрэг Хилчний гудамж,
ХСИС-ийн Хилийн Сургууль
Утас: 70155010, 99145087, 99061374, 98145087
Факс: 976-70155010
И-мэйл: ganbold_bti@yahoo.com
ganbold.ts@leu.gov.mn

Улсын бүртгэлийн дугаар 921
Индекс 14921
Дансны дугаар
ХААН БАНК 5029511673-5

ISBN: 978-99973-41-65-5